



БОЛОВСРОЛЫН
ЯАМ



БОЛОВСРОЛЫН СУДАЛГААНЫ
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

БАГШИЙН ГАРЫН АВЛАГА

СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛ
БЭЛТГЭЛ БҮЛЭГ



УЛААНБААТАР ХОТ
2025 ОН

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАГШИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ	2
1.1 Багшийн гарын авлагын зорилго, бүтэц	2
1.2. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай танилцъя	2
1.3. Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх	5
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ	7
2.1. Бага насны хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох тухай	7
2.2. Сургалтын хөтөлбөрийн арга зүйтэй уялдах онол	8
2.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй	10
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- IX CAP	17
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ - X CAP	29
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- XI CAP	37
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- XII CAP	51
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- I CAP	62
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- II CAP	73
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- III CAP	85
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- IV cap	94
СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- V CAP	106

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАГШИЙН ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

1.1 Багшийн гарын авлагын зорилго, бүтэц

Энэхүү гарын авлага нь сургуулийн өмнөх боловсролын түвшний сургалтын хөтөлбөр болон долоон чиглэлийн сургалтын хөтөлбөрийг ойлгох, ухагдахуунуудыг тайлж уншихад дэмжлэг үзүүлэх, сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд багш нарт онолын мэдлэг, арга зүйн чиглэл, практик жишээ, зөвлөмжөөр дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжилд чиглэсэн чанартай сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх чадварын хөгжлийг дэмжих зорилготой.

Та бүхэн гарын авлагатай танилцахын зэрэгцээ сургуулийн өмнөх боловсролын түвшний сургалтын хөтөлбөрөөс философи, онол, арга зүйн үндэс, суурь зарчим, бүтцийг сайтар судлаарай. Мөн долоон чиглэлийн сургалтын хөтөлбөрөөс бүтэц, чадвар, суралцахуйн үр дүн, арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээний хэсгүүдийг уялдуулан харах хэрэгтэй.

Багшийн гарын авлагын Нэгдүгээр бүлгээс суралцахуйн үр дүн болон бусад гол ухагдахуунуудын талаар цэгцтэй, дэлгэрэнгүй ойлголт авахын зэрэгцээ сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ хэрхэн жил, сар, долоо хоногоор төлөвлөхийг харах боломжтой.

Хоёрдугаар бүлгээс сургалтын хөтөлбөрийн суралцахуйн онолын үндэс, хэрэгжүүлэх арга зүй нь сургалт, үйл ажиллагааны төлөвлөлттэй хэрхэн уялдаж байгаатай танилцана уу.

Гуравдугаар бүлгээс жил, сар, долоо хоногийн төлөвлөлтөд хэд хэдэн чиглэлийн суралцахуйн үр дүнг хэрхэн нэгдмэл байдлаар авч хэрэгжүүлж болох жишээтэй танилцаарай. Жишиг сарын төлөвлөлтөөс хичээлийн жилийн турш суралцахуйн үр дүнгүүдийг (НСХ 3.1а, МАТ3.2а гэх мэт) нэгтгэж харах, төлөвлөх, хянах боломжтой. Энэ бүлэг дэх нэгдмэл үйл ажиллагаанууд нь та бүлгийнхээ хүүхдүүдийг тодорхой суралцахуйн үр дүнд хүргэхийн тулд санаа авч хэрэгжүүлж болохуйц арга, ажиллагааны жишиг гэдгийг сайтар санаарай. Эдгээр жишиг үйл ажиллагааг сайжруулах, өөрчлөх, санаа авч өөрсдийнхөөр шинээр төлөвлөх боломжтой юм.

Мөн энэхүү гарын авлагаар хүүхдийн суралцахуйг анги танхимаас гадна эцэг эхтэй хамтран гэр бүлд нь хэрхэн үргэлжлүүлж болох талаар жишиг санааг тусгаж өгсөн.

Багш нар гарын авлагаа ашиглан хамтран төлөвлөх, харилцан хичээлд суух, эргэцүүлэх, туршлагаа хуваалцах замаар мэргэжлийн тасралтгүй хөгжлөө дэмжих боломжтой бөгөөд энэхүү гарын авлага нь шинэ, залуу багш нарыг сургах, чиглүүлэхэд тохиромжтойгоор боловсруулагдсан.

1.2. Сургалтын хөтөлбөр, гарын авлагатай танилцъя

Чадамжид суурилсан хөтөлбөр

Чадамж гэдэг нь 1. Мэдлэг (юуг мэдэх), 2. Чадвар (яаж хийх), 3. Хандлага (ямар үнэт зүйл, зан төлөвтэй байх) гурвын нэгдлийг хэлнэ. Хөтөлбөр чадамжид суурилна гэдэг нь хүүхэд ямар нэгэн мэдээллийг цээжлээд өнгөрөх төдий бус харин амьдралд хэрэглэх мэдлэг, чадвар, хандлага, зан үйл, сэтгэлгээний арга барил эзэмшихэд чиглэнэ гэсэн үг юм.

Сургалтын хөтөлбөр нь хүүхдийг оюун санааны дархлаатай, аз жаргалтай насан туршдаа суралцах чадамжтай болгохыг гол зорилгоо болгосон. Хөтөлбөрийн агуулга, арга зүй нь хүүхэд бүрийн оролцоонд суурилсан үйл ажиллагаагаар дамжуулан ирээдүйд суралцах суурь чадвар бүхий бие хүн болгож төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

Хөтөлбөр, гарын авлагын уялдаа

Багш нь сургалтын хөтөлбөр, багшийн гарын авлагыг хамтад нь хослуулан хэрэглэнэ. Ингэхдээ сургалтын хөтөлбөрөөс хүүхдүүдийн ямар чадамжийг хөгжүүлж ямар суралцахуйн үр дүнд хүргэхээр зорьж байгаагаа харна. Харин багшийн гарын авлага дээрх санал болгосон жишгүүдээс арга зүйн санаа авна.

Сургалтын хөтөлбөрөөс харах зүйлс	Багшийн гарын авлага дээр хэрхэн буусан бэ?
Хөтөлбөрийн үзэл баримтлалд тулгуурлан эзэмшүүлэх чадамж, суралцахуйн зорилт, хөгжлийн ай, дэд ай, суралцахуйн үр дүнг тодорхойлсон.	Хөтөлбөр дахь суралцахуйн зорилтод чиглэсэн нас, хөгжлийн онцлогт тохирсон жишиг арга зүй, өдөр тутмын үйл ажиллагаа санал болгосон.
Суралцахуйн үр дүн бүрээр 2-5 настай хүүхдэд хөгжлийн 4 түвшнийг тодорхойлсон.	Түвшин бүрд жишиг үйл ажиллагаа санал болгохын зэрэгцээ СҮД-үүдийн залгамж холбоог хангах арга зүйн дэмжлэг үзүүлнэ.
Сургалтын долоон чиглэлийн хүрээнд нэгдмэл арга зүй баримтлахаар боловсруулсан.	Сургалтын чиглэл дэх айнуудыг сэдэвт үйл ажиллагаагаар нэгтгэж болох жишээ санал болгосон.

Сургалтын хөтөлбөр, гарын авлагын бүтэц

Нэн түрүүнд сургалтын долоон чиглэл, эдгээрт тодорхойлсон хөгжлийн дөрвөн түвшин, суралцахуйн үр дүн, үнэлгээний шалгууруудыг нарийн танилцаж ойлгох нь чухал юм.

Сургалтын чиглэл. Сургалтын хөтөлбөрийг хүүхдийн хөгжлийн чиглэлд үндэслэн дараах 7 чиглэлээр боловсруулсан. Үүнд: 1) Нийгэм-сэтгэл хөдлөл; 2) Хөдөлгөөн, эрүүл мэнд; 3) Хэл яриа; 4) Байгаль, нийгмийн орчин; 5) Математик; 6) Зураг, урлал; 7) Хөгжим; зэрэг юм.

Хөтөлбөрийн сургалтын чиглэл бүр нь чадвар, тухайн чадварын ай, дэд айгаас бүтнэ. Дэд ай бүр 1-4 түвшинд тодорхойлогдсон суралцахуйн үр дүнтэй. Жишээ нь: Нийгэм-сэтгэл хөдлөлийн сургалтын чиглэл *"Хүүхэд сэтгэл хөдлөл, мэдрэмж, харилцаа, хүмүүнлэг байдлын талаар ойлголт мэдлэгтэй бусадтай эергээр харилцах, хамтрах, зан үйлээ хариуцлагатайгаар удирдан зохицуулах чадвартай, өөрт болон бусдад төдийгүй нийгэмдээ энэрэнгүй, эрх тэгш, хүндэтгэлтэй хандлагатай болж төлөвших"* чадварыг эзэмшүүлэхийг зорих бөгөөд үүний тулд 1. Өөрийгөө таних; 2. Бусадтай харилцах; 3. Харилцан хамаарал гэсэн гурван айтай, ай тус бүр гурван дэд айн хүрээнд нийт 36 суралцахуйн үр дүнг тодорхойлсон байна.

Суралцахуйн үр дүн (СҮД). Сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулгыг хэрэгжүүлснээр хүүхдийн хөгжлийн хувьд хүрэх үр дүнг "Суралцахуйн үр дүн" гэж нэрлэсэн. Тиймээс "Суралцахуйн үр дүн" нь мөн сургалтын хөтөлбөрийг амжилттай эзэмшсэн суралцагчийн мэдэх, ойлгох, хэрэглэх шаардлагатай хүрэх түвшний илэрхийлэл болно.

Суралцахуйн үр дүнгийн хүрэх түвшин. Сургалтын хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд эзэмшүүлэх чадварыг дөрвөн түвшинтэй боловсруулсан. Энэхүү хөтөлбөрөөр эзэмшүүлэх чадварын түвшин нь сургуулийн өмнөх боловсролын зохион байгуулалтын түвшин тусдаа ойлголт болно. Өөрөөр хэлбэл, хүүхэд бүрийн хөгжлийн хурд, явц ялгаатай учраас эзэмших чадварын 4 түвшин нь бага, дунд, ахлах, бэлтгэл бүлэгт дүйцэх албагүй юм.

Суралцахуйн үр дүн ба чадамж. Суралцахуйн үр дүнгүүд нь хүүхдийн ерөнхий болон суурь чадамж (мэдлэг, чадвар, хандлага)-д чиглэнэ. Ингэхдээ хүүхдийн өмнөх мэдлэг, төсөөлөл, амьдралын туршлагад тулгуурлан аливаа зүйлийг сонирхон судалж, эргэцүүлэн таамаглаж тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх чадамж хандлагыг хөгжүүлэх юм.

Нэгдмэл арга зүй. Суралцахуйн үр дүнд хүрэхийн тулд багш нэгдмэл арга зүйг хэрэглэнэ. Нэгдмэл арга зүй нь сургалтын хэд хэдэн чиглэлийг хамарсан, олон талт, нарийн нийлмэл, оролцоонд тулгуурласан хэлбэртэй байна. Нэгдмэл арга зүйд ямар сургалтын загвар, хэлбэрийг авч ашиглах нь багшийн өөрийн шийдэл боловч энэхүү гарын авлагын хүрээнд дараах дөрвөн арга зүйг жишээ болгон авч үзсэн. Үүнд: Тоглоомд суурилсан; Зохиолд суурилсан; Сонирхон судлахад суурилсан; Төсөлд суурилсан зэрэг болно. Эдгээр арга зүйгээр өдөр тутмын сургалт, үйл ажиллагааг төлөвлөж, өдрийн хуваарьт (хүлээн авалт, тойргийн цаг, чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа, төвийн үйл ажиллагаа, зугаалгын цаг, хөгжөөн баясах үйл ажиллагаа, номын цаг ... гэх мэт) цагуудад зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд сургалтын орчин, хэрэглэгдэхүүн, үнэлгээг цогцоор нь багтаасан.

Багш та төлөвлөлтөө хийхдээ өдрийн хуваарьт үйл ажиллагааг бүтцийн дагуу зохион байгуулахад анхаараарай. Өдрийн хуваарьт үйл ажиллагааны онцлогийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 1. Өдрийн хуваарьт үйл ажиллагааны онцлог

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны онцлог
Тойргийн цаг	<p>Өдрийг амжилттай эхлэхийн нэг үндэс нь өглөөний тойргийн цагт хийгдэж буй ажлын төлөвлөлт байдаг. Тухайн өдрийн судлах зүйлийн талаар суурь ойлголт авах боломж олгодог.</p> <p>Тойргийн цаг нь:</p> <ul style="list-style-type: none"> - Мэндчилгээ - Ярилцлагаас бүрдэнэ.
Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	<p>Багшийн заавар, тодорхой зорилго, аргачлалтайгаар танин мэдэхүй, хэл яриа, бие бялдар, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлдэг.</p> <ul style="list-style-type: none"> - Тоолох, ангилах, ялгах - Туршилт хийх - Сонсох, ярих, санаа бодлоо үйл явдлын дагуу үргэлжлүүлэн зохиох, - Зураг, наамал, барих, зохион бүтээх
Төвийн үйл ажиллагаа	<p>Бие даасан байдал, асуудал шийдвэрлэх, бүтээлч оролцоог дэмждэг. Багш чиглүүлэхээс илүү ажиглагч, дэмжигчийн үүрэгтэй. Хэдэн төвтэй, ямар тоглоомтой байхыг багш төлөвлөж тоглоомын аргачлал, тоглох заавар зэргийг зургаар илэрхийлж хайрцаг, саванд байрлуулж, хүүхэд аль төвд ажиллах сонголт хийнэ.</p> <p>Төв нь: Хүүхдийн хэрэгцээ, сонирхолд нийцсэн, сонголт хийх боломжтой байна.</p> <ul style="list-style-type: none"> - Туршилт танин мэдэхүйн төв - Математикийн төв - Хэл яриа-номын төв - Тоглоомын төв
Зугаалга	<p>Хүүхдийг байгальтай танилцуулах, орчноо ажиглах, туршин судлах, хөдөлгөөнийг дэмждэг өдөр тутмын үйл ажиллагааны хэлбэр юм.</p> <p>Зугаалга нь:</p> <ul style="list-style-type: none"> - Ажиглалт - Хөдөлмөр - Тоглоом
Номын цаг	<p>Хүүхдийн хэл яриа, уран дүрслэл, сонсох чадвар, анхаарал төвлөрөл, төсөөллийг хөгжүүлэх үлгэр, номын зохиол уншиж, ярилцана. Чиглүүлэх асуултаар баяжуулна.</p> <ul style="list-style-type: none"> - Үлгэр унших - Зурагт ном тайлбарлах - Дүрд тоглох - Үлгэрийг үргэлжлүүлэх
Өөртөө үйлчлэх цаг	<p>Хүүхдийг өдөр тутмын хувийн хэрэгцээг хангахад чиглэсэн. <i>Эх сурвалж: Бямбадорж.П., Гандолгор.Ш., (1994). "Бага насны хүүхдийн хөдөлмөр, зурагт сургах арга зүй"</i></p> <ul style="list-style-type: none"> - Гар, нүүр угаах - Хувцас өмсөх/эвхэх - Ор хураах, засах гэх мэт
Хөгжөөн баясах цаг	<p>Хүүхдийг хөгжөөн баясахад, чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаа, үлгэр зохиолын дүрд хувирах, хөгжилтэй хөдөлгөөн, хөнгөн дасгал, хөгжимт тоглоомоор сэргээнэ.</p> <p>Хөгжөөн баясах цаг:</p> <ul style="list-style-type: none"> - Үлгэр зохиол танилцуулах, дүрд хувирах - Хөгжмийн хэмнэлээр бүжиглэх - Хөгжөөнт тоглоом - Хөгжилтэй дасгал

1.3. Сургалт, үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх

1. Үйл ажиллагааны сэдэв сонгох

Гарын авлагад "Сэдэв" гэх ойлголтыг нэг сарын хугацаанд хэд хэдэн суралцахуйн үр дүнг нэгтгэх, арга зүйг нэгдмэл байдлаар хооронд нь уялдуулах зорилгоор оруулж ирсэн. Багш нар хүүхдүүдээ хөгжүүлэхээр зорьж буй суралцахуйн үр дүн, орон нутгийн онцлог, хүүхэд, эцэг эхийн хүсэл сонирхол, өөрийн боломж, давуу тал зэрэг хүчин зүйлсийг харгалзаж төлөвлөлтийн сэдвийг тодорхойлно. Сэдэв нь дотроо хэд хэдэн дэд үйл ажиллагааг агуулах бөгөөд нэгдмэл арга зүйгээр хэрэгжинэ. Өөрөөр хэлбэл, багш үйл ажиллагааг суралцахуйн чиглэл тус бүрээр салангид явуулах бус харин хүүхдүүдийн хувьд утга учиртай, нэгдмэл байдлаар төлөвлөх, зохион байгуулахад "сэдэв" чиглэгдэх юм.

2. Сэдэв, үйл ажиллагааны хүрээнд эзэмших СҮД-гүүдийг нарийвчлан уялдаа холбоог сайжруулах

Сэдвийн хүрээнд төлөвлөхдөө сургалт, үйл ажиллагааны СҮД-гүүдийн уялдаа холбоог шалгахын зэрэгцээ нийт жилийн сургалт, үйл ажиллагаанд нэг СҮД хэт олон давтагдах эсвэл орхигдож байгаа эсэхийг лавлаарай. Мөн нөгөө талаас бүх үйл ажиллагаанууд тухайн СҮД-д чиглэж байгаа эсэх, зорилтот СҮД-гүүд хангагдаж байгаа эсэхийг байнга нягталж байх хэрэгтэй. Тухайлбал, дараах үйл ажиллагаанд Нийгэм-сэтгэл хөдлөлийн есөн СҮД-гээс нэгийг нь эзэмшүүлэхээр төлөвлөсөн байна.

Бага бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Ангитайгаа танилцъя	НСХ1.1а. Биеийн зарим мэдрэмжээ нүүр, гар, биеийн хөдөлгөөн, дуу авиа, үгээр илэрхийлдэг болно. БНО1.1в. Ойр орчны эд зүйлс, тоглоомыг мэдэрч нэрлэнэ. МАТ1.1а. Гэр, цэцэрлэгийн орчин тойронд байх юмсаас 1 эсвэл 3 ширхэг тоглоом, юмсыг заах, нэг гэж хэлнэ.	Өөрт таатай, таагүй байгааг биеийн хэлэмж, үгээр хэлэх, заах Орчныхоо тоглоом, эд зүйлсийг сонирхон ажиглах, тоглох, нэрлэх Ангийн тоглоомоос нэг тоглоом сонгон тоглох

Дунд бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Олоорой	НСХ2.1а. Биеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлдэг болно. МАТ2.1б. Дараалан байрлуулсан тоглоом, юмсын зүй тогтлыг ажиглаж, дуурайна.	Таних тэмдэгтэй өрж байгуулах тоглоомоор тоглох Өөрийн таних тэмдгийг таних, бусдынхтай харьцуулах Ойр орчмын дуу чимээ танил үг, өгүүлбэрийг анхааралтай сонсох, дуурайх.

Ахлах бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Миний зуны амралт	ХЯ2.2а. Энгийн өгүүлбэрээр харилцан ярилцана. ЗУ2.2а. Зураас, дүрсээр өөрийн бодол төсөөллөө илэрхийлнэ. НСХ2.3в. Аливаа үйл ажиллагаанд бие даан дуртай оролцоно.	Өдөр тутмын үйл ажиллагааны явцад сэдвийн хүрээнд өөрийгөө илэрхийлэн, бусадтай харилцахдаа асуулт харилцан яриаг эхлүүлэх Дугуй дүрс, цэг зураасаар дүрсэлж зурах Өдрийн дэглэмийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох

Дээрх жишээнд ахлах бүлгийн эхний сарын зарим үйл ажиллагаануудыг хоёрдугаар түвшний СҮД-гийн хүрээнд төлөвлөсөн байна. Энэ нь хүүхэд бүлэг шилжих үед СҮД-гийн түвшнийг уусгах, шилжилтийг хүүхдэд хялбарчлах зорилготой. Мөн эндээс та бүхэн СҮД-гийн түвшин сургалтын зохион байгуулалтын түвшин буюу бүлэгтэй заавал тохирох албагүй байгааг харж болно.

Бэлтгэл бүлэг

Үйл ажиллагаа	Нэгдмэл байдлаар төлөвлөсөн суралцахуйн үр дүн (СҮД)	Суралцахуйн үйл ажиллагаа
Би-миний найзууд	БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана. НСХ4.3в Өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог болно.	Өөрийгөө болон гэр бүлийнхээ тухай танилцуулах Ангийн дүрмээ хэлэлцэхэд өөрийн саналаа хэлэх, хамтдаа зохиох

3. Сар, долоо хоногийн төлөвлөгөө зохиох

Гарын авлагад хичээлийн жилийн эхнээс буюу 9-өөс 5 дугаар сарын нийт есөн сарын жишиг төлөвлөлтийн загвар оруулсан. Ингэхдээ сар бүрийн эхний хоёр долоо хоногийн үйл ажиллагааны төлөвлөлтийг жишиг болгосон. Эндээс багш нар санаа авч тухайн сарын 2 долоо хоногийг үргэлжлүүлэн төлөвлөх зориулалттай юм. Сар бүр нэгдсэн сэдэвтэй бөгөөд цааш долоо хоногийн дэд сэдэв, үйл ажиллагаагаар төлөвлөгдсөн.

Жишээ нь: Бага бүлгийн 9 дүгээр сар *"Шинэ орчин"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал нэг, хоёрдугаар долоо хоногууд *"Ангитайгаа танилцъя"*, *"Миний хөөрхөн гар, нүүр"*, *"Дуулцгаая"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Дунд бүлгийн 9 дүгээр сар *"Хамтдаа тоглоё"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал, нэгдүгээр долоо хоног *"Зогсоорой"*, *"Олоорой"*, *"Алгаа ташаарай"*, *"Олсоор наадъя"*, *"Гараа угаацгаая"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Ахлах бүлгийн 9 дүгээр сар *"Миний танил орчин"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудаар төлөвлөгдсөн бөгөөд, тухайлбал, нэгдүгээр долоо хоног *"Миний зуны амралт"*, *"Миний нэг өдөр"*, *"Авхаалжтай хүүхэд"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Жишээ нь: Бэлтгэл бүлгийн 9 дүгээр сар *"Хөгжилтэй найзууд"* сэдэвтэй бөгөөд удиртгал хэсэгт сургалтын хөтөлбөрийн чадамжууд, СҮД-гүүдтэй хэрхэн уялдах байдал болон суралцахуйн үйл ажиллагааг тодорхойлсон. Энэ нь цаашаа долоо хоног, үйл ажиллагаануудад задрах бөгөөд тухайлбал нэгдүгээр долоо хоног *"Би-миний найзууд"*, *"Бид хамтдаа"*, *"Хамтдаа хийгээрэй"* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэж байна.

Дээрх жишиг төлөвлөлтүүдээс дараах асуултад хариулт авах боломжтой. Үүнд:

- Үйл ажиллагаа, арга зүйг хэрхэн сонгож сарын төлөвлөлт хийх вэ?
- Тухайн сард ямар СҮД-гүүдийг сонгон авч хэрхэн хооронд нь уялдуулах вэ?
- Долоо хоног, өдрийн төлөвлөлтийг хэрхэн хийх вэ?
- Сургалтын чиглэл хоорондын уялдааг хэрхэн хангах вэ?
- Шаардлагатай дасгал, үйл ажиллагааны давтамжийг хэрхэн тодорхойлох вэ?
- Сургалтын долоон чиглэлийн тэнцвэртэй байдлыг хэрхэн хангах вэ?

Сэдвийн хүрээнд тоглох, үлгэр, зохиол унших, турших, төсөл хэрэгжүүлэх, дуу, хөгжим, хөдөлгөөн, зурах, бүтээх гэх мэт бүх төрлийн үйл ажиллагааг хослуулахыг хичээгээрэй. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх бүх арга зүйн үндэс нь **тоглох үйл ажиллагаа** байгаа учраас бүлгээр, хамтран, зэрэгцэн, чөлөөт сонголттой хэлбэрүүдийг тэнцвэртэй оруулбал

зүйтэй. Эдгээр үйл ажиллагаа, тоглох үйл явцуудыг хүүхдийн сонирхол, хэрэгцээ, хөгжлийн түвшинд тохируулан сонгож төлөвлөнө.

4. Хэрэгжүүлэх, ажиглах, үнэлэх, эргэцүүлэх

Сургалтын хөтөлбөрийн үнэлгээний үндсэн хэлбэр нь тасралтгүй ажиглалтад суурилсан албан бус үнэлгээ юм. Зорилтот СҮД-д баримжаалан хүүхдийн ахиц, хөгжлийн хэрэгцээг тодорхойлох зорилгоор үнэлгээг хийнэ. Багш өөрийн хэрэгцээ, нөөц боломжид тулгуурлан улирал, жилээр үнэлгээг нэгтгэж хүүхдийн ахицыг тодорхойлж дараагийн төлөвлөлтөд тусгана. Ингэхдээ багш нар үнэлгээний шалгуурын хүрээнд ажиглалтын хуудас, эргэцүүлэл, шалгах хуудас зэрэг хэрэгсэл ашиглана.

Гарын авлага нь багшид мэргэжлийн хөгжлийн хөтөч болох давхар ач холбогдолтой. Үүний тулд багш нар сэдэв бүрийн төгсгөлд амжилттай хэрэгжсэн үйл ажиллагаа, шалтгаан, сайжруулах шаардлагатай үйл ажиллагааны талаар эргэцүүллээ бичиж хэвших хэрэгтэй. Мөн эргэцүүллийн хүрээнд бусад багш нартай хэлэлцүүлэг өрнүүлж санал бодлоо солилцвол илүү үр дүнтэй. Эдгээрт тулгуурлан багш үйл ажиллагаануудыг төлөвлөж цаашид хүүхдийнхээ хэрэгцээ, сонирхол болон орон нутгийн онцлогтой уялдуулан сайжруулахын зэрэгцээ өөрөө мэргэжлийн ур чадварын хувьд өсөж хөгжих юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨТӨЛБӨРИЙН ОНОЛ, АРГА ЗҮЙ

2.1. Бага насны хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох тухай

Хүрээлэн буй орчны өөрчлөлт, түүний зүгээс тавигдаж байгаа шаардлагад нийцэх нь дасан зохицох чадвар юм. Дасан зохицох чадвар нь сэтгэц-физиологи, гүйцэтгэх үйл ажиллагаа, хүрээлэн буй орчны нөхцөл байдал, хүмүүсийн харилцаа хандлагад дасах үйл явцыг агуулна. Тиймээс хүүхэд цэцэрлэгт дасан зохицох чадвар нь нийгмийн орчинд дасан зохицож буй нэг хэлбэр бөгөөд цэцэрлэгийн орчинд хүүхэд бие бялдар, сэтгэлзүйн хувьд аюулгүй тайван байх мэдрэмж юм.

Хүүхэд цэцэрлэгийн орчинд дасан зохицох чадварт тэдний сэтгэл хөдлөл, танин мэдэхүй, нийгэмшихүйн хөгжлийн онцлогоос гадна дараах хүчин зүйлс нөлөөлдөг.

- Хүүхдийн өөрийн туршлага
- Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдийн цэцэрлэгт итгэх итгэл
- Эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс хүүхдэдээ итгэх итгэл
- Цэцэрлэгийн багшийн хүүхдэд анхаарал хандуулах, итгэлцлийн харилцаа

Судлаачид дасан зохицохуйн гурван түвшинд авч үзсэн байдгийг дараах хүснэгтэд авч үзье.

Хүснэгт 2. Хүүхдийн дасан зохицох түвшин

Дасан зохицох чадвар сайн	Дасан зохицох чадвар дунд	Дасан зохицох чадвар сул
<ul style="list-style-type: none"> – 10-15 хоногийн дотор хүүхэд хэвийн байдалд орж хамт олны дотор биеэ чөлөөтэй авч явж, өвдөх, хямрах байдал бага байна. – Хичээлийн агуулга хөтөлбөрийг хялбархан бүрэн эзэмшинэ. – Төвөгтэй асуудлыг шийдвэрлэнэ. – Хичээнгүй, багшийн заавар тайлбарыг анхаарч сонсоно. Хяналт 	<ul style="list-style-type: none"> – Ахиц дэвшил нь сарын дотор хэвийн байдалд орж, жин нь түр зуур хасагдаж, “өвдөх” болон сэтгэл санааны бага зэргийн хямралаар илэрнэ. – Цэцэрлэгт явахдаа дургүйцдэггүй. – Багш хичээлийг дэлгэрэнгүй, дүрслэлтэй заахад ойлгож авна. – Томчуудын хяналт дор даалгаврыг 	<ul style="list-style-type: none"> – 2-6 сар үргэлжилдэг. Энэ үед хүүхэд байн байн өвдөх, дадал болсон зүйлээ мартаж, биеийн болон сэтгэл санааны хямралд ордог. – Цэцэрлэгтээ явах дургүй. – Сэтгэл зүйн хувьд дарамттай. – Ангийн дүрэм журмыг дагаж мөрдөхгүй. – Багшийн тайлбарласан зүйлийг хэсэгчлэн ойлгоно. – Бие дааж ажиллах чадвар сул, аливаа даалгаврыг хяналт дор гүйцэтгэнэ.

шаардлагагүйгээр үүрэг даалгаврыг биелүүлнэ. – Цэцэрлэгт явах дуртай, багшийн шаардлагыг зохистой хүлээж авна. – Бие даан ажиллах чадвар сайн. – Нийгмийн идэвх өндөр, хариуцлагатай уриалгахан байна.	анхааралтай хийж гүйцэтгэнэ. – Зөвхөн сонирхолтой зүйлд төвлөрнө. – Ангийн олон хүүхэдтэй нөхөрлөнө.	– Багш эцэг эхийн зүгээс тогтмол хяналт тавих, байнга сануулах, тусламж шаардлагатай. – Дотно найз нөхөдгүй, цөөн тооны хүүхдийн нэрийг мэднэ
-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Түүнчлэн хүүхдийн бие махбод, өөрийгөө илэрхийлэх, орчноо мэдрэх чадвар, гэр бүлдээ эзлэх байр суурь, гэр бүлийн уур амьсгал зэрэг нь дасан зохицолд нь нөлөөлдөг. Оюун ухааны хөгжил сайтай, сэтгэл хөдлөлийн хувьд тогтвортой хүүхдэд дасан зохицоход бэрхшээл тулгардаггүй бол сэтгэл хөдлөлийн тогтворгүй хүүхдүүдэд хүндрэлтэй байдаг.

Хүүхдийн хувийн онцлог, гэр бүлийн соёл, дадал зэргээс шалтгаалан шинэ нөхцөлд дасан зохицох чадвар нь харилцан адилгүй өөр өөр байдаг ч дасан зохицох тодорхой үе шатыг туулдаг. Тухайлбал, З.Фрейдийн онолоор хүүхэд хуучин байдлаа хадгалан үлдэхийг хичээдэг учраас шинэ нөхцөлд дасан зохицохдоо түгшүүрийн үе, дайчлах үе, дасан зохицох эсвэл үл дасан зохицох гэсэн 3 үе шатыг дамждаг бөгөөд дасан зохицохын тулд хичээж, тайван юм уу тэнцвэртэй байдлыг олж авахыг хичээдэг гэж үздэг байна. Үүнд:

Түгшүүрийн үе: Энэ үе шат нь айх, түгших, сандрах, зөрүүдлэх, зэрэг сэтгэл санааны тогтворгүй байдлаар илэрдэг. Энэ үед хүүхдэд дарамттай мэдрэмж зонхилж, жин нь хасагдах, хоолонд дургүй болох, ойр ойрхон өвдөх, дадал болсон зүйлээ мартаж, дүрэм журам зөрчих зэрэг шинж тэмдэг болно. Энэ үе шат хүүхдийн дасан зохицох чадвараас шалтгаалан харилцан адилгүй хугацаанд үргэлжилнэ.

Дайчлах үе: Энэ үе шат нь сэтгэл санаагаа тайвшруулах, айдсаа даван туулах, бусдыг дуурайх, өөрийгөө танин мэдэх, өөртөө итгэлтэй болох, бусдад итгэх зэрэгт хүчин чармайлт гаргах үе. Хүүхдийн өсөлт хөгжил удаашралтай тэнцвэрийн энэ үе шат 3-5 сар үргэлжилнэ. Энэ үед хүүхдүүд өөрийн бие махбодыг дээд зэргээр дайчилна.

Дасах эсвэл үл дасах үе: Энэ шатанд хүүхэд маш хурдтай хөгжиж, өмнөх удаашралыг нөхөж гүйцдэг. Хэрэв хүч нөөцөө хэчнээн дайчлаад нөлөөллийг даван туулж чадахгүй бол үл дасах байдалд орно. Ийм тохиолдолд хүүхдийн сурч, хөгжих боломжид саатал гарах магадлалтай. Харин дасан зохицлын хувьд хэвийн хүүхдүүд шинэ чадвар, дадал эзэмших авьяас билгээ хөгжүүлэх явцдаа асар их сэтгэл ханамж авч цэцэрлэгтээ дасан зохицож, суралцах чадвар нь илүү байдаг ажээ.

Цэцэрлэгийн бүлгийн багшаас хүүхдийн дасан зохицож буй чадварыг өглөөний хүлээн авалтын үед 14 хоногоос дээш хугацаанд хүүхдэд илрэх шинжийг ажиглан тэднийг орчинд нь дасгахад тусламж дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

2.2. Сургалтын хөтөлбөрийн арга зүйтэй уялдах онол

Сургалтын хөтөлбөрийг суралцахуйн загварын онол, бодит суралцахуйн онол болон конструктивист онолд суурилж боловсруулахыг Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд тусгасан.

Зан үйлийн болон танин мэдэхүйн онолууд нь хүүхдийн хувийн болон ялгаатай суралцахуйд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч хоорондоо ялгаатай хоёр хүчин зүйлийг илүү чухалчилж үздэг. Тухайлбал, зан үйлийн онолууд нь хүрээлэн буй орчны нөлөө, ялангуяа өдөөлт ба сэдэлжүүлэлтийн онцлог, түүний зохион байгуулалт, хэлбэр, мөн хүүхдийн үзүүлэх зан үйлд багшийн хариу үйлдэл, орчныг онцгой чухалчилдаг (Dale, 2012). Зан үйлийн онолын гол төлөөлөгчид нь Джон Ватсон (John Watson), Б.Ф.Скиннер (B.F. Skinner) нар бөгөөд тэд зан үйлийн зөв дадал төлөвшихөд дотоод сэтгэлгээ бус, орчны нөлөө чухал үүрэгтэй гэж үзээд нөхцөлт үйл, эерэг хариу үйлдлээр хүүхэд эерэг зан үйлд суралцана гэж

үзжээ. Энэ онолын үүднээс суралцах үйл, дадал нь орчноос ирэх хариу үйлдлийн үр дүн хэмээн үздэг ба эерэг, сөрөг хариу үйлдэл, давталт нь хүүхдийн суралцах зан үйлийг бэхжүүлэх ба энэ нь хүүхдийн сурах хандлага, оролцоонд шууд нөлөөлдөг (Schindler et al., 2019). Өөрөөр хэлбэл, хүүхэд орчноос ирэх нөлөөлөл буюу орцоор суралцах үйлд сэдэлждэг бөгөөд эдгээрийг хүүхэд хэрхэн боловсруулдаг үйл явцыг танин мэдэхүйн онол тайлбарладаг.

Танин мэдэхүйн онолууд нь хүрээлэн буй орчноос ирэх хариу үйлдэл нь хүүхдийн суралцахууд нөлөөлдөг гэдгийг хүлээн зөвшөөрдөг (Dale, 2012). Багшийн мэдээлэл, өдөөлт, сэдэлжүүлэлт, үйл ажиллагаа, зааварчилгаа, хүүхдийн асуулт, хүсэлтэд өгөх багшийн хариу үйлдэл зэрэг нь хүүхдэд орчноос ирж буй суралцахуйн орц юм. Эдгээр орцууд нь хүүхдэд суралцах чадварыг бүрэн өгдөггүй (David et al., 2015). Танин мэдэхүйн онолын гол төлөөлөгч нь Ж. Пиаже, Ж. Брунер нар бөгөөд хүүхэд орчноо хүртэж, танин мэдэхдээ оюуны идэвхтэй үйл хийдэг. Харин тэдгээрийг хүүхэд ажиглах, дуурайх, давтах, залруулах зэрэг идэвхтэй үйлээр боловсруулж байдаг нь суралцахууд хөтөлж, чиглүүлж байдаг. Хүүхэд орчноос ирж буй орцыг (багшийн мэдээлэл, өдөөлт, сэдэлжүүлэлт, үйл ажиллагаа, зааварчилгаа, хүүхдийн асуулт, хүсэлтэд өгөх багшийн хариу үйлдэл зэрэг) анхаарах, ажиглах, дүрслэх, хувиргах, кодлох, хадгалах, өөрт шинэ мэдлэгийг бүтээх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, танин мэдэхүйн онолууд нь хүүхдийн өөрийнх нь сонирхол, бодол санаа, итгэл үнэмшил, хандлага, үнэт зүйлсийн үүргийг чухалчилдаг.

Дээрх хоёр чиглэлийн онолоос гадна хүүхдийн сурах арга барил, хандлага төлөвшихөд чиглэсэн конструктивист (Constructivist) онолууд нь хүүхэд мэдээлэл хүлээн авагч бус, мэдлэгийг өөрийн үйл ажиллагаа, туршлагаар бүтээгч хэмээн үздэг, хүүхдийг идэвхтэй суралцагч хэмээн үздэг. Конструктивист онолчид шинжлэх ухааны цор ганц, туйлын үнэн байдаг гэсэн ойлголтоос татгалзаж, үнэн олон талтай, эргэлзээтэй үнэнийг олон янзаар нээж, баталж болно хэмээн үздэг (Dale, 2012). Энэ олон талт үнэнийг илрүүлэх арга зам нь асуулт тавих, ажиглах, асуудлыг олж харах, бодох, уялдаа холбоог олох, шийдвэр гаргах зэрэг идэвхтэй үйл ажиллагаа юм. Энэ идэвхтэй үйл ажиллагаа нь хүүхдийн тоглох үйл юм. Хүүхэд тоглонгоо ертөнцийг танин мэдэх, төсөөлөн бодох, нийгэмших, хэл ярианы чадвараа хөгжүүлдэг. Тоглонгоо юмс үзэгдлийн мөн чанар, логик уялдааг ойлгож, асуудлыг олж харах, шийдэх чадвартай болдог.

Аливаа үйл ажиллагааг хүүхэд өөрийн хүсэл сонирхлоор, зорилготой, сонголтоор хийх (үүнийг хүүхэд төвт үйл ажиллагаа гэж хэлдэг) ба багш орчныг сонирхолтой байдлаар төлөвлөж, зохион байгуулах, хүүхдийн үйл ажиллагааг ажиглах, чиглүүлэх, шаардлагатай дэмжлэгийг үзүүлнэ. Энэ нь хүүхэд өөрийн хурдаар тааваараа, сонирхолдоо хөтлөгдөн, учир утга зорилготой үйл ажиллагаанд оролцох, улмаар бие даасан байдал, шүүмжлэлт сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадварт суралцах боломжийг бүрдүүлдэг (Farquhar & White, 2014). Конструктивист онолын гол төлөөлөгчид нь Ж. Пиаже, Ж. Брунер, Л. С.Выготский нар юм. Тэд хүүхдийн идэвхтэй оролцоотой, бодит орчны утга учиртай үйл ажиллагаа, хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон үйл ажиллагаа, хүүхдийн суралцахууд нийгэм соёлын үзүүлэх нөлөө зэрэг дээр санаа нийлдэг.

Бага насны хүүхдийн суралцахууг дэмжих, хөтлөн чиглүүлэхэд багшийн анхаарах зүйлсийг суралцахуйн онолтой холбон үзье.

Хүснэгт 2. Суралцахуйн онол

Суралцахуйн онол	Зорилго	Багшийн үйл ажиллагаа
Зан үйлийн онол	Хүүхдийн суралцах үйл ажиллагааг сэдэлжүүлэх, нөлөөлөх (суралцахуйн орц)	Хүүхдэд эерэг зан үйл төлөвшихөд чиглэсэн давтамжтай, эерэг хариу үйлдэлт, чиглүүлэгтэй орчин бүрдүүлэх. Хүүхдийн зан үйлд тохирсон эерэг хариу үйлдэл (урамшуулал, чиглүүлэг, дэмжлэг гэх мэт) үзүүлэх, сөрөг зан үйлийг залруулах.

		Эерэг зан үйлийг давтах, бататгах үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, үр дүнг ажиглах, үнэлэх.
Танин мэдэхүйн онол	Хүүхдийн суралцахуйг идэвхжүүлэх, суралцахуйн дадалд хөтлөх (мэдээлэл боловсруулах, суралцах үйл явц)	Хүүхдийн сэтгэхүйн хөгжлийг дэмжих нээлттэй асуулт асуух, сорилттой дасгал даалгавар өгөх. Хүүхдийн анхаарах, ажиглах, дүрслэх, төсөөлөх, илэрхийлэх, дүгнэх үйлийг дэмжсэн үйл төлөвлөх. Суралцах үйл ажиллагаанд багш мэдээлэл дамжуулагч бус, чиглүүлэгч, хамтрагч байх.
Конструктивист онол	Хүүхдийн сурах арга барил эзэмшихэд чиглүүлэх, суралцах хандлага төлөвшүүлэх (суралцахуйг хөтлөх үйл, үр дүн)	Хүүхдийн идэвхтэй үйл ажиллагаа, оролцоог дээдэлсэн, бие даан мэдлэг бүтээх орчныг бүрдүүлэх (зохиолд суурилсан, тоглоход суурилсан, төсөлд суурилсан, судлан шинжлэх). Хүүхдийн хүсэл сонирхолд тулгуурласан, утга учиртай, зорилготой үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах. Хамт олонтойгоо харилцах боломжийг нэмэгдүүлэх, хамтын суралцахуйг дэмжих.

Бага насны хүүхдийн хөгжил, суралцахуйг дэмжихдээ багш зан үйлийн, танин мэдэхүйн, конструктивист онолуудад тулгуурлах нь багшлах үйл ажиллагаа үр дүнтэй болох шинжлэх ухааны үндэслэл болно. Хүүхдийн зан үйлд тохирох эерэг хариу үйлдэл үзүүлэх, оюуны болоод нийгэмшихүй, сэтгэл хөдлөл, бие даасан бүтээлч сэтгэлгээг дэмжих нь суралцах үйл ажиллагааг хүүхдийн хөгжлийн онцлогт нийцүүлэн үр дүнтэйгээр удирдахад чухал ач холбогдолтой. Иймээс суралцахуйн онолуудын уялдаа холбоог ойлгож, багшлах үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх нь багшийн мэргэжлийн чадамжийн нэг чухал бүрэлдэхүүн болдог.

2.3. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн талаарх дараах чиглэлийг тусгасан. Үүнд:

- Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд суралцагчийн хөгжлийн онцлогт нийцүүлэн суралцахуйн загварын, бодит суралцахуйн, конструктивист болон хувилбарт сургалтын онолын үндсэн дээр боловсруулсан сургалтын идэвхтэй аргыг хэрэглэнэ.
- Сургуулийн өмнөх насны хүүхдэд зориулсан сургалт, үйл ажиллагаанд тоглоом, зохиол, шинжлэн судлах, төсөлд суурилсан арга зүйг хүүхдийн насны онцлог, эзэмших чадамж суралцахуйн үр дүн, сургалтын чиглэлийн онцлогтой холбон бүтээлчээр хэрэглэнэ.
- Монгол суралцагчийн цогц чадамжийг төлөвшүүлэхэд суралцахуйн чиглэлийн онцлог бүрийн оруулах хувь нэмрийг тусгасан бөгөөд үүнийг нэгдмэл уялдаатай, хүүхэд төвтэй байхуйц суралцахуйн арга зүйгээр зохион байгуулна.

Сургуулийн өмнөх 4-5 настай хүүхэд буюу цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлэгт хэрэгжүүлэх арга зүйн онцлогийг авч үзье.

Тоглоомд суурилсан арга зүй: Бага насны хүүхэд, тэдний суралцахуйн талаарх үзэл онолын, судалгааны чиг хандлагын ихэнх бүтээлүүдэд, хүүхэд тоглонгоо суралцаж, бусадтай харилцах, ойлголтоо хөгжүүлэх зэрэг суралцахуйн ашиг тус үлэмж их талаар авч үзсэн байдаг. Тухайлбал, Жан Линда Гиллепси–ийн “хэзээ ч зүгээр тоглодоггүй” номонд тайлбарласнаар тоглох нь хүүхдэд суралцах, юмсыг таних, мэдрэх, хөгжлийн онцлогт тохирсон хамгийн үр дүнтэй арга гэсэн байна.

Тоглоомд суурилсан арга зүйн онцлог нь хөгжилтэй, сонирхолтой, бүтээлч, идэвхтэй оролцоотой, хамтын ажиллагаатай байх явдал.

Тоглоомын явцад дөрөв, таван настай хүүхдүүд идэвхтэй хөдөлгөөн хийж, оролцсоноор тэдний хүч чадал, хурд, тэнцвэр, авхаалж самбаа, уян хатан чанар хөгждөг. Тиймээс багш нь хүүхдүүдтэй хамт тоглохдоо тэдний оролцоо, бүтээлч байдлыг урамшуулж, тоглох явцдаа суралцах үйлийг дэмжинэ. Тоглоомд суурилсан арга зүйн суралцахуйн үйлийн явцад насанд хүрэгчид хүүхдийн өмнөөс асуудлыг шийдвэрлэхийн оронд тэднийг аливаа зүйлийн учрыг олоход нь тусалж үгээр урамшуулан дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Тоглоом, үйл ажиллагааны явцад багшийн тохиромжтой зөв урамшууллын дараа хүүхэд өөрийгөө үнэлэх сайн үйл хийснээрээ бахархах, өөртөө итгэх итгэл нь нэмэгдсэнээр “зөөлөн ур чадвар”-ын эх үндэс тавигдана.

Тоглоомд суурилсан арга зүй нь дөрөв, таван настай хүүхдэд насанд хүрэгчдийн зан үйлийг дуурайн тоглох, бусдыг халамжлах, аврах, зэмлэх боломжийг олгож, эдгээр зан үйлд тулгуурласан тодорхой дүр бүтээхийг дэмжинэ. Дөрөв, таван настай хүүхдүүд тоглоомын дүрийг сонгох, тухайн дүрд хувиран тоглохдоо түүний хэлдэг, үг хийдэг үйл, үйлдлийг дуурайх замаар үгийн баялаг нэмэгдэж, хүмүүсийн хийдэг үйлийг сурч, нийгмийн амьдралыг тоглоомоор дамжуулан ойлгож эхэлдэг.

Анхаарлын төвлөрөлт, зориудын анхаарал сайжирч дуу шүлэг, үлгэр богино өгүүллэгийн утгыг ойлгож, сэргээн ярьж чадах тул тоглоомд суурилсан суралцахуйгаар дамжуулан дэмжих боломжтой. Заримдаа өөрсдийн мөрөөдөж буй хүсэл, авах гэсэн зүйлээ илэрхийлэхдээ “худлаа, зохиож” ярих нь олонтоо. Гэхдээ сэтгэл судлаачид хүүхдийн энэ зан үйлийг “буруу” гэж үздэггүй. Учир нь энэ нь хүүхдийн сониуч зан, бусдыг дуурайх гэсэн хүсэл, гэнэн цайлган зантай холбоотой.

Түүнчлэн хүүхдийн дүрслэн бодохуй нэлээд хөгжсөн байх тул бэлэн тоглоом наадгайгаас гадна байгалийн материал, ахуйн хэрэглээний ахуйн ашиглан тоглож чадна. “Айл гэр”, “Дэлгүүр” зэрэг сэдэвт тоглоомын явцад ахуйн хэрэглээний эд зүйлсийг ашиглан тоглох, өрж байгуулах, эвлүүлж угсрах зэргээр тоглоомынх нь нэр төрөл, хүрээ өргөжнө. Тиймээс багш Та бүлгийн сургалт, үйл ажиллагаанд тоглоомд суурилсан арга зүйг зохион байгуулахдаа дээрх онцлогийг харгалзан үзэхээс гадна хүүхэдтэйгээ хамтран тоглохдоо тэд ямар төрлийн тоглоом сонирхож байгаа болон сонирхохгүй байгааг ажиглах, цаашид хэрхэн хөгжлийг нь дэмжих гарцаа ч олж харах боломжтой. Мөн бүлгийн сургалт, үйл ажиллагааг тоглоомыг бусад арга зүйтэй хослуулан, тухайлбал, зохиолд, шинжлэн судлахад, төсөлд суурилсан арга зүйтэй хослуулсан хэлбэрээр зохион байгуулж болно.

Зохиолд суурилсан арга зүй. Үлгэр ярих нь бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих үр дүнтэй үйл ажиллагааны нэг юм. Олон улсад бага насны хүүхдийг хөгжүүлэхэд зохиолд суурилсан (Story-based learning), үлгэр өгүүллэг ярих (Storytelling) гэсэн хоёр арга зүйг өргөн хэрэглэдэг. Эдгээр нь үлгэр, зохиол ашиглахаас гадна хүүхдийн өөрийн өгүүлэмж яриаг суралцах үйлийн эх сурвалж болгон ашигладаг онцлогтой. Зохиолд суурилсан арга зүй нь зөвхөн үлгэр, зохиол, хүүхдийн яриа, өгүүлэмжийг сонсож, ярихын дээр тэдгээрийн дүр, үйл явдал, юмс үзэгдлээр хүүхдийг сэдэлжүүлэх, суралцах үйлийг бодит амьдралтай уялдуулах гүүр болгож ашигладгаараа онцлог арга юм. Хүүхэд үлгэр, өгүүллийг сонсох үедээ анхаарлаа төвлөрүүлж, дүрүүдийг өөрөөрөө төсөөлж уран сэтгэхүйгээ хөгжүүлж, баярлах, гуниглах, санаа зовних зэрэг сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл гаргах, бусдын мэдрэмжийг ойлгох эхлэл болдог. Багш, хүүхэд үлгэр зохиол, өөрт тохиолдсон явдлаа ярихын зэрэгцээ асуулт асууж харилцан ярилцах, үлгэрийн дүрд тоглох, дүр үйл явдлыг урлан бүтээх, үлгэрийн төгсгөлийг өөрийнхөөрөө бодож бүтээх зэрэг идэвхтэй үйл ажиллагаанд оролцдог. Ингэснээр хүүхэд мэдээлэл хүлээн авах бус, мэдлэг “бүтээж” суралцах боломжтой болдог.

Зохиолд суурилсан арга зүйг хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан хэрэглэх нь багшлахуй, суралцахуйг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр зохион байгуулах гол нөхцөл

болдог. 4–5 настай хүүхэд нь үлгэр, зохиолын дүрийн зан үйл, сэтгэл хөдлөл, үйл явдлын учир шалтгааны холбоог ойлгох, баатрын үйлдлийг дуурайж туршиж үзэх, дүрийн гаргасан зан үйлийг судлах, тайлбарлах чадвартай болдог. Мөн үйл явдлын дэс дарааллыг ойлгож, таамаглах чадваруудыг эзэмшдэг. Зохиолын дүр ба үйл явдлаар дамжуулан хүүхэд танин мэдэхүй, хэл яриа, сэтгэл хөдлөл, нийгэмшихүй, харилцааны чадваруудаа сайжруулж байдаг. Мөн үлгэрийн үйл явдлыг өргөн хүрээтэй, учир шалтгааны уялдаатай ойлгож, дүрүүдийн зан үйлд дүгнэлт хийх, хамтдаа мэдлэг бүтээх чадвар эзэмшдэг.

Зохиол сонгоход анхаарах зүйлс

1. Зохиолын үйл явдал бага зэрэг ээдрээтэй байж, 2–3 үйл явдал болон үр дагаврын холбоог агуулсан байх.
2. Үйл явдал, үг хэллэгийн давтагдсан хэсэгтэй, шүлэглэл, ритмтэй хэсэгтэй байх нь хүүхдийн анхаарлыг татах, хэлний уран яруу хэллэгт суралцахад тустай.
3. Дүрийн сэтгэл хөдлөл тод илэрхийлэгдсэн, баатрын зан үйл, шийдвэр ойлгомжтой.
4. Дуу авиа, бие болон гарын хөдөлгөөн ашиглах боломжтой байх.
5. Ном сонгох бол дүрийн зураг илүү ойлгомжтой, үйл явдлын логик холбоо дүрслэгдсэн байх.

Хэрэгжүүлэх үе шат

4-5 насны ахлах бүлэгт зохиолд суурилсан арга зүйг дараах ерөнхий бүтцийн дагуу хэрэгжүүлж болно. Үүнд:

1. *Зохиолтой танилцах үе шат*: Зохиол сонсох, дүрүүд, үйл явдал, баатрын зан үйл, шалтгаан-үр дагаврыг ойлгож танилцах.
2. *Давтах үе шат*: Өөр хэлбэр, зохион байгуулалттайгаар (асуулт, хөдөлгөөн, дүрслэл) зохиолтой дахин танилцах.
3. *Дүрд тоглох, бүтээлчээр оролцох үе шат*: Хүүхэд зохиолын баатрын дүрд орж, үйл явдлын өөр хувилбар санал болгох, дүрийн зан чанар, шийдвэрийг туршиж үзэх.
4. *Суралцахуйн чиглэлийн интеграцчилал*: Зохиолтой танилцсан, дүр ба үйл явдлыг мэддэг болсон үед бусад сургалтын чиглэлтэй холбох. Дасгал даалгавар, зураг, тоо, хэл ярианы дасгалд зохиолын дүр, үйл явдал, юмс үзэгдлийг ашиглах.

Арга зүйн зөвлөмж

- **Зохиол ярих**: Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан, удаан, энгийн үгсээр, хүүхэд бүрийн **ойлгох түвшин, анхаарал төвлөрөх чадварт нийцүүлэн** ярина. Давтан ярихдаа жүжиглэх, орчин, хэрэглэгдэхүүнээр баяжуулах нь анхаарлыг нэмэгдүүлнэ.
- **Хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх**: Зохиолыг давтан ярих үйл ажиллагаанд хүүхэдтэй хамтарсан, хэсэгчилсэн байдлаар зохиолыг ярина. Зохиолын дүр, үйл явдал, юмс үзэгдлийн онцлог шинж байдлын талаар тойргийн цаг болон чөлөөт цагаар танин мэдэхүйг дэмжих ярилцлага хийх, асуудал дэвшүүлсэн эргэцүүлэл хийх зэргээр хүүхдийн логик сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх, эрэл хайгуул хийх чадварыг дэмжих боломжтой.
- **Хөдөлгөөнт тоглоом, үйл хөдлөлтэй хослуулах**: Амьтны дуу авиаг дуурайх, баатрын хөдөлгөөнийг дуурайсан дасгал тоглоомыг тоглуулах, ийм тоглоомыг хүүхдээр зохиолгох зэрэг нь хүүхдэд зохиолын агуулгыг ойлгоход дэмжлэг үзүүлэхээс гадна бүтээлч сэтгэлгээг хөгжүүлнэ.
- **Сургалтын чиглэлтэй интеграцчилал**: Зохиолын дүр, үйл явдал, юмс үзэгдлийг ашиглан бусад сургалтын чиглэлийн чадварыг уялдуулан дэмжих үйл ажиллагааг зохион байгуулах нь хүүхдийн танин мэдэхүйн хүрээг тэлж, дүр, үйл явдлыг эргэн санах, тэдгээрийн уялдаа холбоог ойлгоход тусална.

Шинжлэн судлахад суурилсан арга зүй: Бага насны хүүхэд орчиндоо буй эд зүйлс, ургамал, мал, амьтан, хүмүүс болон үйл явдлыг ажиглаж, мэдэрч, судалснаар байгаль, нийгмийн орчны холбоо хамаарал, учир шалтгааныг танин мэдэж, аливааг сонирхон шинжлэн судлах арга барилд суралцах суурь болдог.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд шинжлэн судлахад суурилсан арга зүйг "Суралцагч судлах зүйлийнхээ талаар асуулт асуух, таамаглал дэвшүүлэх, туршилтыг төлөвлөх, сорил туршилтыг гүйцэтгэх, юмс үзэгдлийн зүй тогтол, харилцан хамаарлын учир шалтгаан, сорил туршилтын үр дүнг илэрхийлэх, тайлбарлах, үнэлэх, үр дүнгээс дүгнэлт гаргах мэдлэг, чадварыг дэмжих системтэй арга зүй"¹ гэж тодорхойлсон.

Шинжлэн судлахад суурилсан (ШСС) арга зүй нь асуулт асуух, ажиглах, мэдээлэл цуглуулах, баримт нотолгоонд тулгуурлан хамтран дүгнэлт гаргах замаар эргэцүүлэн бодох сэтгэлгээг хөгжүүлж, хүүхдэд төрөлхийн сониуч зангаараа асуудлынхаа шийдлийг хайж, өргөн хүрээнд сэтгэн бодоход тусалж, суралцах үйл явцыг илүү сонирхолтой болгодог.

Сургуулийн өмнөх насны хүүхдэд тоглоомд суурилсан арга зүйтэй шинжлэн судлах арга зүйг хослуулан хэрэгжүүлэхэд тохиромжтой байдаг. Учир нь шинжлэн судлах арга зүй нь тоглоомд суурилсан арга зүйг баяжуулж, илүү сонирхолтой, идэвхтэй суралцах орчин бүрдүүлэхэд нөлөөлдөг. Шинжлэн судлахад суурилсан арга зүй нь цэцэрлэгийн бүх бүлэгт хэрэгжих боломжтой бөгөөд 2–3 насанд мэдрэхүйн орчин, тоглоомоор дамжуулан суурийг нь тавьж, 4–5 настайд өргөжүүлэн чиглүүлэгтэй болон бие дааж шинжлэн судлах үйл ажиллагаагаар хөгжүүлэх нь оновчтой.

Шинжлэн судлахад суурилсан **арга зүйн** онцлог

№	Онцлог	Жишээ
1	Хүүхдийн сониуч байдал, асуух, судлах, нээх, олох, төрөлх зан чанарт тулгуурладаг.	3 настай хүүхэд цэцэрлэгийн гадаа шувуу хараад "Яагаад шувуу нисдэг юм бол?" гэж асууж, багштайгаа хамт хариултыг хайдаг. Энэ нь хүүхдийн төрөлхийн сониуч занг дэмжиж байна.
2	Хүүхдийн шүүмжлэлт сэтгэлгээ, бүтээлчээр сэтгэх чадамж хөгждөг.	Хүүхэд навчсыг ажиглаж "Энэ навч яагаад хурдан унасан бэ? хоёр төрлийн навчны ялгааг ажиглаж, таамаг дэвшүүлэн өөр өөр нөхцөлд туршилт хийж үздэг.
3	Хүүхэд өөрөө асуулт тавьж, хариултыг олох үйл явцад идэвхтэй оролцсоноор бодит ойлголт, гүнзгий мэдлэг бий болдог.	Хүүхэд ус хэрхэн уур болж хувирдаг талаар өөрсдөө ус буцалгах туршилт хийж оролцсоноор илүү гүнзгий мэдлэгтэй болдог.
4	Хүүхдүүд өдөр тутмын амьдралд тулгардаг асуултуудад хариу олох замаар орчноо илүү сайн ойлгож сурдаг.	Хүүхэд "Яагаад унтраалгыг асаахад гэрэл гардаг вэ?" гэсэн асуултыг эцэг эх, багштайгаа ярилцан ойлголтоо нэмдэг.
5	Хүүхдэд бэлэн мэдлэг өгөхөөс илүүтэй өөрөө мэдлэг бүтээх суралцагч байхыг зорьдог.	"Шувуу нисдэг учир нь ..." гэж тайлбарлахын оронд, шувуудыг ажиглуулах замаар хүүхэд өөрөө мэдлэг бүтээх үйлийг дэмждэг.
6	Хүүхдийн ажиглах, харьцуулах, таамаг дэвшүүлэх, турших, дүгнэх чадвар хөгждөг.	Модны навчсыг янз бүрийн өнцгөөс ажиглаж, навчнуудын өнгө, хэлбэр, хэмжээг харьцуулан Энэ навч илүү нимгэн учраас хурдан хатна.
7	Хүүхдийг бие даасан, хариуцлагатай суралцагч болгон төлөвшүүлдэг.	Хүүхэд өөрийн ургуулж байгаа ургамлаа услах, арчлах ажлыг хариуцлагатай хийж, үр дүнг өөрөө анзаарч, тайлбарладаг.

Шинжлэн судлах арга зүйн төрлүүд

Шинжлэн судлахад суурилсан арга зүй нь дараах гурван төрлийн хэлбэртэй бөгөөд эдгээр нь хүүхдэд хэр зэрэг чиглүүлэг, бүтэцтэй орчин санал болгож байгаагаар ялгагдана.

- Бүтэцтэй шинжлэн судлах:** Тогтсон үе шаттай. Багш тодорхой асуудал, чиглэлийг өгч, хүүхдүүдийг алхам бүрд чиглүүлдэг. Ихэвчлэн байгаль, нийгмийн орчин сургалтын чиглэлд ихэвчлэн ашигладаг
- Чиглүүлэгтэй шинжлэн судлах:** Багш хүүхдүүдтэй хамт судлах асуултыг гаргаж, бодит асуудлын шийдлийг олоход хүүхдэд тусалдаг.

¹ Монгол Улсын Засгийн газар. (2024). Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал (2024-2036). Цахим холбоос:

<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140353213781>

3. **Нээлттэй шинжлэн судлах:** Хүүхдүүдэд өөрсдийн сонирхсон сэдвийнхээ талаар асуудал дэвшүүлж, судалгаа хийж, шийдэл олох боломжийг олгодог, илүү чөлөөтэй хэлбэр юм. Ихэвчлэн нийгэм-сэтгэл хөдлөл сургалтын чиглэлд ашигладаг.

Хүснэгт 3. Шинжлэн судлахад суурилсан арга зүйн үе шат

Үе шат	Хүүхдийн хийх үйл	Багшийн дэмжлэг
Оролцох үе шат Энэ нь хүүхдэд урам зориг өгөх үе бөгөөд тэдний өмнөх мэдлэгийг сэргээн сануулах зорилготой юм.	<ul style="list-style-type: none"> - Ажиглах - Асуулт асуух - Таамаглал дэвшүүлэх 	<i>Асуултаар эхлэх</i>
		Асуултаар сургалт, үйл ажиллагааг эхлүүлэх нь үр дүнтэй. Ингэснээр хүүхдүүд сэдвийн талаар эргэцүүлэн бодоход түлхэц өгч, хүүхэд өөрсдөө асуулт асуух, асуултад хариулахад дэмжлэг болно.
Шинжлэн судлах үе шат Хүүхдэд тодорхой суралцах туршлагыг өгч, идэвхтэй эрэл хайгуул хийх боломжийг олгодог.	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөх - Мэдээлэл цуглуулах - Туршилт хийх 	<i>Эрэл хайгуул хийхийг зөвшөөрөх</i>
		Сонирхол татсан асуулт, хариултын дараа хүүхдэд бие даан судлах, боломжийг олгох хэрэгтэй. Энэ нь тухайн зүйлээ сайтар ойлгоход тусална.
Тайлбарлах үе шат Хүүхэд ойлголтоо цэгцэлж, эргэцүүлсэн ойлголтоо илэрхийлэх боломжийг олгодог.	<ul style="list-style-type: none"> - Таамаглалаа нотлох - Мэдээллийг шинжлэх - Харилцан ярилцах 	<i>Туршилтын үр дүнг хэлэлцэх</i>
		Хүүхдүүд өөр хоорондоо санал бодлоо хэлэлцэхэд нь урамшуулж дэмжинэ. Ингэснээр хүүхэд тухайн зүйлээ гүнзгийрүүлж ойлгоход тусална.
Нарийвчлан судлах үе шат Сургалтын зорилгоо бусад агуулгатай нэгтгэн илүү сайн нарийвчлан боловсруулна.	<ul style="list-style-type: none"> - Үр дүнг таамаглалтай харьцуулах - Шийдвэр гаргах - Батлах, нотлох 	<i>Хэрэглэгдэхүүн, нэмэлт эх сурвалжаар хангах</i>
		Хүүхэд бие даан судлахад ашиглаж болох эх сурвалж, нэмэлт хэрэглэгдэхүүнээр хангах хэрэгтэй. Онлайн сургалтын платформууд хэрэглэх боломжтой ба хүүхдийн ойлголтыг бататгахад тусалдаг.
Үнэлэх үе шат Багш хүүхдийг үнэлэхээс гадна хүүхдүүд өөрсдийн ойлголтыг үнэлэх боломжийг олгодог.	<ul style="list-style-type: none"> - Ололтоо бусадтай хуваалцах - Үнэлэх - Сайжруулах санал гарах 	<i>Сурсан мэдсэнээ нэгтгэн дүгнэх</i>
		Сургалтын үйл ажиллагааны төгсгөлд сурсан зүйлээ дүгнэх хэрэгтэй. Энэ нь хүүхдүүдэд шинэ мэдээллийг эргэн санахад тусалдаг.

Хүүхэд 4-5 насандаа өөрсдийн сонирхсон зүйлийн талаар ярилцах, таамаглал дэвшүүлж, туршиж үзэх, бүтээлчээр сэтгэх, логик холбоог ойлгох, харьцуулах дүгнэлт гаргах чадварт суралцаж эхэлдэг. Түүнчлэн багаараа судалгаа хийх, дүрд тоглох зэргээр харилцах, хамтрах чадвар төлөвшиж, амжилт, саад бэрхшээлд сэтгэл хөдлөлөө зохицуулах чадвар нь хөгжиж эхэлдэг.

Тиймээс энэ наснаас эхлэн шинжлэн судлах үйл явцыг цогцоор нь буюу асуулт тавих-таамаглах-турших-дүгнэх шатлалаар төлөвлөж болно.

Хүүхдийн тавьсан асуултыг хүндэтгэн сонсож, тэдэнд чөлөөтэй туршиж, шинэ зүйлийг нээх орчныг бүрдүүлэх нь чухал. Туршилтын үр дүн зөв эсвэл буруу гарсан эсэхээс үл хамааран хүүхдийн оролдлого, сэтгэн бодох үйл явцыг урамшуулж дэмжих хэрэгтэй. Ийнхүү урам өгч дэмжлэг үзүүлснээр хүүхэд алдаанаасаа суралцах, дахин оролдож, шалтгааныг эрэлхийлэх сонирхолтой болно. Мөн хүүхдийг ажиглалтаа дүрсээр тэмдэглэж, бусдад өөрийн санаагаа ярьж тайлбарлах боломжтой байлгах нь тэдний сэтгэн бодох, харилцах чадварыг хөгжүүлнэ.

4-5 насанд шинжлэх ухаанч сэтгэлгээний суурь ойлголтуудыг бага багаар төлөвлөж, хүүхдийн сонирхсон асуудлаар жижиг төсөл, багийн судалгаа зохион байгуулж, дүгнэлтийг зураг, загвар, тайлбар хэлбэрээр илэрхийлэх боломжтой.

Шинжлэн судлах арга зүйг хэрэгжүүлэх хэлбэр:

- Жижиг төслүүд (жишээ: “ус цэвэршүүлэх арга”, “хамгийн бат бөх материал”)
- Өөрийн туршилт, дүгнэлтээ хуваалцах
- Шинжлэх ухаанч арга хэрэглээний суурь тавих (ажиглалт-таамаглал-туршилт хийх-дүгнэлт гаргах)

Хүүхдийн санаачилгыг дэмжиж, туршилт, ажиглалт хийх үйл явцыг олон өнцгөөс харах боломжтой орчин бүрдүүлэх нь чухал. Туршилтын үр дүнгийн зөв буруу байдлаас илүүтэй хүүхдийн сэтгэн бодох чадвар, судалгааны үйл явц, оролдлогыг үнэлж, урамшуулах хэрэгтэй.

Арга зүйн зөвлөмж

Шинжлэн судлахад суурилсан арга зүй нь сургалтын үндсэн үйл ажиллагааны цагт, гадаа тоглох ба байгальтай харилцах үед, чөлөөт тоглоомын цагуудад хамгийн үр дүнтэй хэрэгжих боломжтой байдаг.

Цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагааны дараах цагуудад хэрхэн хэрэгжих боломжтойг жишээгээр харуулбал:

1. Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа (Хамгийн тохиромжтой үе-10:00–11:30 орчим)

- Энэ цагт хүүхдийн анхаарал төвлөрөл, бие махбодын идэвх хамгийн өндөр байдаг.
- Багшийн төлөвлөсөн сургалт, үйл ажиллагаа, шинжлэн судлах ажиглалт, туршилт, туршлага хуримтлуулах үйлдэл хийхэд хамгийн тохиромжтой.

Жишээ үйл ажиллагаа:

- ✓ Ус, элс, гэрлийн материал ашиглан туршилт хийх
- ✓ Хүүхдийн санаачилгыг дэмжиж, байгаль орчныг ажиглах, туршилт хийх, тэмдэглэл хөтлөх, олж мэдсэн зүйлээ ярилцах, бусдад танилцуулах орчныг бүрдүүлэх
- ✓ Асуултын дагуу таамаглал дэвшүүлэх, үр дүн ажиглах
- ✓ “Хэрвээ ... бол яах вэ?” гэх асуудал шийдэх тоглоом тоглох

2. Гадаа тоглох, зугаалгын цаг (Шинжлэн судлах үйлд нээлттэй орчин-11:10–11:45 орчим/ 16:30–17:00 орчим)

- Хүүхэд байгалийн объект (ургамал, шавж, чулуу, салхи, сүүдэр, цас гэх мэт)-той шууд харьцаж, туршиж үзэх боломжтой.
- Бие даан ажиглаж, нээх, харьцуулах, сонирхсон зүйлийнхээ талаар асуух боломжтой.

Жишээ үйл ажиллагаа:

- ✓ “Шавж яагаад мөөгөн дээр суудаг юм бол?” гэх мэт байгаль дээр суурилсан ажиглалт
- ✓ Цэцэг, модны навчны хэлбэрийг харьцуулах
- ✓ Шавар, элсээр барилга, байгууламж хийх туршилт
- ✓ Цаг агаарын өөрчлөлтийг мэдэрч, дүгнэх, тэмдэглэх

3. Бие даан тоглох, бүтээх цаг (Хүүхдийн санаачилга, сониуч байдлыг дэмжих орон зай-чөлөөт тоглоомын үе – өглөө/өдөр/орой)

- Хүүхэд өөрөө санаачлан нээлт хийх, турших, оролдож үзэх боломжтой
- Багш хүүхдийг ажиглаж, хэрэгтэй үед бодит дэмжлэг үзүүлэх боломжтой.

Жишээ үйл ажиллагаа:

- ✓ Тоглоомын сүүдрүүд яагаад өөр өөр урттай байна вэ?” туршилт хийх
- ✓ Усыг янз бүрийн саванд хийгээд ялгаа ажиглах
- ✓ Гэр барих тоглоомын явцад байгууламжийн бүтцийг турших

Төсөлд суурилсан арга зүй: Иоганн Генрих Песталоццийн сургаснаар “Толгой, зүрх, гар”-аа нийлүүлэн оюуны болон биеийн хөдөлмөрийг хослуулан суралцахыг энэхүү арга зүйгээр эзэмшдэг. Төсөлд суурилсан арга зүй нь эцсийн бүтээгдэхүүнээс илүүтэй үе тэнгийнхэн эсвэл бусадтай харилцах, суралцах үйл явцад төвлөрдөг.

Төсөлд суурилсан аргазүй нь:

- Төслөөр дамжуулан мэдлэг, чадвар, компетенци бүтээх, эзэмших зорилготой.
- Хамтдаа суралцах, багаар ажиллах, харилцаа холбоог чухалчилдаг.
- Багш бүх үйл ажиллагаанд чиглүүлэн оролцдог.
- Бодит амьдрал дээрх сорилт, асуултууд дээр суурилдаг.
- Нээлттэй, үр дүн нь урьдчилан тодорхойлогдоогүй шинэ зүйл байдаг.

Төсөл нь хүүхдийн танин мэдэхүй, хөгжлийн түвшин, сонирхлыг харгалзан гарах бөгөөд дараах зарчмуудад тулгуурлан төсөлт ажлуудыг зохион байгуулах боломжтой.

1. Бодитой байх: Хүүхэд бодит амьдралд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх төсөл дээр ажиллана. Энэ нь хүүхдийн мэдлэгээ бодит байдалд ашиглах, шинжилгээ хийх чадварыг нэмэгдүүлдэг.
2. Нотолгоонд суурилсан байх: Хүүхдээс асуулт асуух, судлах, судлахад дэмжлэг үзүүлэхэд суурилдаг. Энэ нь сониуч зан, шүүмжлэлтэй сэтгэх чадварыг хөгжүүлдэг.
3. Хугацааг төлөвлөх: Төслийг богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх боломжтой. Ихэвчлэн урт хугацаанд хэрэгжүүлэх нь асуудлыг нарийвчлан судалж эрэл хайлт хийх, оновчтой шийдвэрлэхээс гадна багийн ажлын зохион байгуулалт, цагийн хуваарилалт зэрэг ур чадваруудыг хөгжүүлэх боломжийг олгодог.
4. Хүүхэд төвтэй байх: Хүүхдүүд хамтран төслөө сонгох, сэдвийг хэрхэн судлахаа шийдэх бие даасан эрхийг олгодог. Энэ нь тэдний сониуч занг өдөөж, аливаа юмыг мэдэх, хийх хүсэл эрмэлзлийг төрүүлж, оролцоо, урам зоригийг нэмэгдүүлдэг.
5. Нэгдмэл байх: Сургалт, үйл ажиллагааны зорилгод нийцүүлэн сургалтын чиглэлүүдийг нэг цогц болгон нэгтгэдэг.
6. Өөрийн суралцах үйл явцыг зохион байгуулах: Төслийн явцад өөрсдийн суралцах үйл явцыг удирдана. Энэ нь тэдний өөрийгөө хянах, хариуцлага хүлээх чадварыг нэмэгдүүлдэг.
7. Хамтын ажиллагаатай байх: Ихэвчлэн багаар хамтран ажилладаг бөгөөд хүүхдүүд үе тэнгийнхэнтэйгээ санаа бодлоо хуваалцаж, бие биетэйгээ хамтрах, туслах дэмжих замаар асуудлыг шийдэж, төслийг хэрэгжүүлдэг. Энэ нь тэдний багаар ажиллах болон харилцааны ур чадварыг сайжруулдаг.²

Эдгээрээс гадна, хүүхдүүдийн өөрсдийнх нь харилцан яриа, тоглоомын явцад гарч ирсэн санаануудыг баримжаалан төсөл гаргаж болно.

Төсөлд суурилсан суралцахуйн ач холбогдол:

ХҮҮХДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА	БАГШИЙН ДЭМЖЛЭГ
4 нас	4 настай хүүхдэд үзүүлэх дэмжлэг
Ажиглах: <ul style="list-style-type: none"> - Байгальд гарсан өөрчлөлт (ургамал, цаг агаар гэх мэт)-ийг ажиглах - Туршилт хийх - Амьтан, хүн, юмсын үйлдлийг ажиглах - Хүүхдүүд зураг, видео үзэж, юу харснаа ярилцаж, сонирхсон зүйлээ асууж, ойлгосон мэдээллээ хуваалцана. - Тоглох ба дүр бүтээх: <ul style="list-style-type: none"> - Дүрд тоглох - Дүрсэлж үзүүлж тоглох (амьтны хөдөлгөөн дуу авиаг дуурайх) - Барьж бүтээх тоглоом тоглох - Судалж буй агуулгад тохирсон хөдөлгөөнт, хөгжимт тоглоом тоглох 	Сонирхлыг өдөөж, сэдэлжүүлэх <ul style="list-style-type: none"> - Хүүхдийн сонирхлыг судалж, түүнд тулгуурлан төсөл төлөвлөх - Асуудал дэвшүүлж, “Яагаад?”, “Яаж?” гэх мэт асуултаар өдөөх - Сэдэвт тохирсон ном, зураг, бодит материал ашиглан сонирхлыг нэмэгдүүлэх Төслийн үе шат бүрд чиглүүлэх <ul style="list-style-type: none"> - Төсөл эхлэхээс өмнө зорилго, хийх ажлыг ойлгомжтой тайлбарлах - Ажлын үе шат бүрд тохирсон үүрэг өгөх - Цаг хугацаа болон орчныг зөв зохион байгуулах Хүүхдийн оролцоог дэмжих <ul style="list-style-type: none"> - Санал санаачилгыг сонсох, үнэлэх - Багаар ажиллах, ээлжээр оролцох, хамтдаа шийдвэр гаргахыг дэмжих - Хийсэн зүйлийг магтах, бүтээлч байдлыг нь дэмжих
Бүтээх, урлах: <ul style="list-style-type: none"> - Зурах, наах, зохион бүтээх 	

² <https://www.projectapproach.org/>

<ul style="list-style-type: none"> - Байгалийн болон дахин боловсруулах материалаар бүтээл хийх - Шавар, элсээр бүтээх <p>Ярилцах:</p> <ul style="list-style-type: none"> - “Яагаад?”, “Яаж?”, “Ямар?” гэх мэт асуулт асуух - Хамт тоглож буй найзуудтайгаа санаа солилцох - Өөрийн мэдсэн зүйлээ бусдад ярьж тайлбарлах <p>Дуулах, шүлэг унших:</p> <ul style="list-style-type: none"> - Төсөлтэй холбоотой дуу, шүлэгт суралцах <p>Төслийн үр дүнгээ танилцуулах:</p> <ul style="list-style-type: none"> - Хийсэн бүтээлээ бусдад танилцуулах - Хамтдаа үзэсгэлэн гаргах - Аав ээждээ үзүүлж тайлбарлах 	<p>Хэл яриа, харилцааг хөгжүүлэх</p> <ul style="list-style-type: none"> - Үг хэллэг, ойлголтыг нь баяжуулах шинэ үг тайлбарлаж өгөх - Асуулт асууж, ярилцах боломж олгох - Сургалтын хэрэглэгдэхүүн, ном, зураг ашиглан яриаг идэвхжүүлэх <p>Танин мэдэхүй ба хөдөлгөөний хөгжлийг дэмжих</p> <ul style="list-style-type: none"> - Туршилт, ажиглалт хийх орчин бүрдүүлэх (ус, элс, байгалийн материал) - Хөдөлгөөн оролцсон үйл ажиллагаа төлөвлөх - Зурах, барих, өрөх, хөдөлгөөн хийхэд дэмжих <p>Үнэлгээ, урамшуулал</p> <ul style="list-style-type: none"> - Хүүхдийг ажиглаж тэмдэглэх - Ажлын төгсгөлд хүүхдийн бүтээлүүдийг танилцуулах, үзэсгэлэн гаргах, эцэг эхтэй хуваалцах
--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

ГУРАВДУГААР БҮЛЭГ: СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- IX САР

ХӨГЖИЛТЭЙ НАЙЗУУД

Хүүхдийн эзэмших чадамж:

Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санааг бүтээлээр илэрхийлэх

Харилцах: Бусадтай ярилцах, сонсох, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах

Хамтрах: Бусадтай хамтран тоглох, дасгал хөдөлгөөн хийх, хамтын бүтээл хийх

Шүүн тунгаах: Сонирхсон зүйлээ ажиглах, асуултын хариултыг эрж хайх

Суралцахууд суралцах: Бие даан суралцах

Нийгэм, сэтгэл хөдлөл: Бусадтай харилцан хамааралтай ижил төстэй байдлаа тайлбарлах

Аюулгүй байдлын зөвлөмж:

Ангийн дүрмийг дагаж мөрдөх зурган тэмдэглэгээг танилцуулна. Цэцэрлэгийн дүрэм, болон гадна талбайд байгаа тэмдэг тэмдэглэгээг ажиглаж дүрмийг дагаж мөрдөхийг сануулна. Толины эргэн тойронд халтирах болон эвдрэлтэй тоглоом, жижиг зүйлс байрлуулахгүй байх, толь бол зөвхөн харах хэрэгсэл, толь руу эд зүйлс шидэж, цохиж болохгүй гэдгийг ойлгуулна. Толь хагарвал гэмтэл учруулж болзошгүйг тайлбарлаж өгнө.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Хүүхэд бүр гадна төрх, хүсэл сонирхлоороо бусдаас ялгаатай байгаа талаар асуултын хүрээнд харилцан ярилцана.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Хүүхдэд эд зүйлсийг зурах, барих, урлаж бүтээх зэргээр өөрийн бодит төсөөллийг бүтээлээр илэрхийлэхэд дэмжээрэй.
- Тоглож байх үед нь анхааралтай ажиглаж, тэд юу хийж байгаагаа тайлбарлахыг нь урамшуулан дэмжээрэй. Мөн тэдний ярианд оролцож, харилцан яриа өрнүүлээрэй.
- AI ашиглан хүүхдийн хийсэн бүтээлийг хөдөлгөөнд оруулж сонирхолтой болгоорой.

Төвийн үйл ажиллагаа:

- Сургалтын төвд бие даан гүйцэтгэх үйлийг ажиглаж, шаардлагатай бол нэмэлт чиглүүлэг өгч идэвхжүүлээрэй.
- Төвүүдэд байгаа тоглоом, ном, сургалтын хэрэглэгдэхүүнийг олон төрлөөр баяжуулаарай.

Номын цаг:

- Бусадтай юугаараа ижил болон ялгаатай болох талаарх [Let's Read | Children's Books | Free to Read Download Translate](#) цахим номыг танилцуулж ярилцаарай.
- Нүүрний хувирал, сэтгэл хөдлөлийн таатай таагүй мэдрэмжийг илэрхийлэх номыг ашиглан чанга уншлага аргаар уншилт хийгээрэй. Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөлийг таних үйлдлээр илэрхийлэхэд дэмжлэг үзүүлж урамшуулаарай.

Зугаалга:

- Ажиглалт, хөдөлмөр, тоглоом гэсэн бүтцийн дагуу үйл ажиллагааг чиглүүлээрэй.

Хөгжөөн баясах цаг:

- Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийж, хамтдаа тоглоход чиглүүлээрэй.

Боломжууд:

- Хүүхэд өөрийгөө болон найзаа ажиглах, хамтран ярилцах, тоглох боломжийг олгоорой.
- Хүүхдээс гарч буй санаа, бодож төсөөлөн хийсэн зүйлийг нь дэмжиж, үйл ажиллагаандаа тусган ашиглаарай.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана. НСХ4.3в Өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог болно.	<ul style="list-style-type: none"> - Өөрийгөө болон гэр бүлийнхээ тухай танилцуулах - Ангийн дүрмээ хэлэлцэхэд өөрийн саналаа хэлэх, хамтдаа зохиох 	Би-миний найзууд
ХЯ3.1а Асуултыг ойлгож хариулт өгнө. БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана.	<ul style="list-style-type: none"> - Асуултын дагуу, зургийн дагуу ярих - "Найзуудын ялгаатай болон ижил тал" тоглоом - "Бидний сонирхол өөр ч бид найзууд" тоглоом тоглох, өөрийн болон бусдын сонирхлыг ялгах; 	Бид хамтдаа
МАТ3.4б. Зурган зааварчилгааг ажиглан дарааллын дагуу дуурайж хийнэ. ХЭМ3.1е. Мөлхөлтийн төрлүүдийг (бөгсөөрөө гулсах өвдөг тохойны тусламжтай мөлхөх) хэрэглэл ашиглан гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"> - 4-5 үйлдэлтэй зурган зааврыг ажиглан бүтээл хийх, бүтээлээ бусдад тайлбарлах - Мөлхөлтийн төрлийг ашиглан хөдөлгөөнт тоглоомоор тоглох, дүгнэлт хийж ярилцах, урамшуулах. 	Хамтдаа хийгээрэй
ЗУ4.3б. Сэдвийн хүрээнд өөрийн бодол төсөөллөөр наамлын бүтээл урлана. ХЭМ3.2а. Хувийн ариун цэвэр сахих үйлийг насанд хүрэгчийн дэмжлэг сануулгатайгаар бие даан хийнэ.	<ul style="list-style-type: none"> - Сэдэвт наамал хийх, орчноо хамтдаа цэвэрлэх - "Цэвэр гар, бохир гар" ярилцлага хийх 	Миний эрүүл мэнд
НСХ3.1а. Сэтгэл хөдлөлөө таатай, таагүй байгааг илэрхийлдэг болно. ЗУ4.2а. Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон зурна.	<ul style="list-style-type: none"> - Баяртай, ууртай, уйтгартай, гомдсон зэрэг сэтгэл хөдлөлийг нэрлэх, ялгааг тайлбарлах - Хүн, амьтны дүр төрхийг илэрхийлж зурах 	Миний сэтгэл хөдлөл
МАТ3.3.б Дугуй гурвалжин дөрвөлжин дүрсүүдийг нэрлэж, дүрс, биетийг ялгана.	<ul style="list-style-type: none"> - Дүрсийг ажиглаж нэрлэж тоглох - Олсны хоёр талд нэг ба хоёр хөл дээр үсрэх 	Хамтдаа үсрээрэй

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана.</p> <p>НСХ4.3в Өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрийгөө болон гэр бүлийнхээ тухай танилцуулах - Ангийн дүрмээ хэлэлцэхэд өөрийн саналаа хэлэх, хамтдаа зохиох 	<p>Би-миний найзууд</p>
<p>ХЯ3.1а Асуултыг ойлгож хариулт өгнө.</p> <p>БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана.</p>	<ul style="list-style-type: none"> - Асуултын дагуу, зургийн дагуу ярих - "Найзуудын ялгаатай болон ижил тал" тоглоом - "Бидний сонирхол өөр ч бид найзууд" тоглоом тоглох, өөрийн болон бусдын сонирхлыг ялгах; 	<p>Бид хамтдаа</p>
<p>МАТ3.4б. Зурган зааварчилгааг ажиглан дарааллын дагуу дуурайж хийнэ.</p> <p>ХЭМ3.1е. Мөлхөлтийн төрлүүдийг (бөгсөөрөө гулсах өвдөг тохойны тусламжтай мөлхөх) хэрэглэл ашиглан гүйцэтгэх</p>	<ul style="list-style-type: none"> - 4-5 үйлдэлтэй зурган зааврыг ажиглан бүтээл хийх, бүтээлээ бусдад тайлбарлах - Мөлхөлтийн төрлийг ашиглан хөдөлгөөнт тоглоомоор тоглох, дүгнэлт хийж ярилцах, урамшуулах. 	<p>Хамтдаа хийгээрэй</p>
<p>ХЭМ4.1к. 30 см өндөртэй тавцан дээрээс үсэрч бууна.</p> <p>ХӨГ4.1г. Хэмнэл, хурд, өнгө аясад тохируулан хөдөлгөөнөө хийнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Дууны аяны хурд хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө зохицуулах; 	

9 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Энэ бол би	Тойргийн цаг	Хүүхэд бүр толинд өөрийгөө харж, нүд, үс зэрэг онцлог зүйлсээ ажиглан илэрхийлнэ.	Жижиг толь (хүүхдийн тоогоор)	Толинд хэн харагдаж байна вэ? Чи ямар харагдаж байна вэ? Чиний үс урт уу? Богино уу?	Харилцах: Өөрийгөө болон гэр бүлийнхээ тухай танилцуулах, юу бодож байгаагаа илэрхийлэх Суралцахууд суралцах: Өөрийгөө ажиглах, өөрийн онцлог зүйлсийг нэрлэх	Өөрийгөө танилцуулдаг.
Энэ бол миний найз	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өөрийгөө зураад, бүтээлүүдийг хамтдаа эвлүүлж, бүтээлдээ нэр өгч найзууддаа танилцуулна.	Цаас, усан будаг, гуаш, эсгий бал	Бүтээл хийж, ярина.	Шүүн тунгаах: Зурсан бүтээлээ нэгтгэж, ямар бүтээл болсон тухай дүгнэх, нэр өгөх талаар ярилцах Хамтран ажиллах: Зурсан бүтээлүүдийг хамтдаа эвлүүлж, нэгэн бүтээл болгох, бүтээлдээ нэр өгөх тухай хамтдаа ярилцах	Өөрийнхөө тухай танилцуулдаг.
Ангийн дүрмээ зохиоцгооё	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ангид мөрдөх дүрэм, хуваарийг хэлэлцэн, саналаа хэлж, зурагт хуудаснаас тохирохыг сонгон хамтдаа зохионо.	Хүүхдийн үйлдлийг харуулсан зураг, зөв буруу тэмдэглэгээтэй зурагт хуудас	Та нар ангидаа ямар байхыг хүсэж байна вэ? Хэрэв бид үүнийг хийвэл юу болох вэ?	Шүүн тунгаах: Зурагт хуудсаар зөв, буруу үйлдлийн сонголтыг хийх Суралцахууд суралцах: Дүрмийг тайлбарлаж, дахин үргэлжлүүлэн тоглох	Тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог.
Миний найз	Тойргийн цаг	Хүүхдүүд эвлүүлсэн зургаас өөрийгөө болон найзыгаа харж, юугаараа ижил болон ялгаатай байгааг тайлбарлана. Гэрээс авчирсан дуртай тоглоомоо танилцуулж,	Эвлүүлдэг зураг, төрөл бүрийн тоглоом	Чи бусад хүүхдүүдтэй адилхан байна уу? Юугаараа өөр байна вэ?	Шүүн тунгаах: Ижил болон ялгаатай байгаа зүйлийг (зурагт, тоглоомоор) ажиглаж тайлбарлах Нийгэм, сэтгэл хөдлөл: Бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, бусдын сонирхлыг ялгах, өөр	Бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг.

		бусдын сонирхол өөр байгаа талаар ярилцана.			өөр тоглоомтой ч хамтдаа тоглох боломжтойг ойлгох	
Бидний сонирхол	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд өөрийн дуртай тоглоомыг (бамбарууш, машин, хүүхэлдэй, ном амьтан гэх мэт) авчирна. Өөрийн сонгосон тоглоомоо найзууддаа танилцуулж яагаад энэ тоглоом надад таалагддаг тухай ярилцана.	Төрөл бүрийн тоглоом	Чи яагаад энэ тоглоомыг сонгосон бэ?	Шүүн тунгаах: Ижил болон ялгаатай байгаа зүйлийг (зурагт, тоглоомоор) ажиглаж тайлбарлах Нийгэм, сэтгэл хөдлөл: Бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, бусдын сонирхлыг ялгах, өөр өөр тоглоомтой ч хамтдаа тоглох боломжтойг ойлгох	
Найзтайгаа хамтдаа	Хөгжөөн баясах цаг	Бөмбөгийг дамжуулж тоглохдоо хүүхдүүд өөрийн дуртай зүйлээ хэлнэ. Дуртай зүйлсийг дүрсэлсэн зураг руу сонголт хийж зогсоно.	Бөмбөг, төрөл бүрийн эд зүйлсийн зураг	Чи яагаад энэ зургийг сонгосон бэ? Чи юунд дуртай вэ? Чиний сонирхол бусад хүүхэдтэй ижил байна уу? Өөр байна уу?	Харилцах: Өөрийн дуртай зүйлээ (хоол, тоглоом, үлгэрийн баатар) хэлэх, багшийн асуултад хариулах Хамтран ажиллах: Тойрог болон зогсож бөмбөг дамжуулах тоглоомыг хамтран эхлүүлэх, сонголт хийж хамтдаа зогсох	Асуултыг ойлгож хариулт өгдөг.
Амьтдын хөдөлгөөн	Тойргийн цаг	Амьтдын зураг үзэж хэрхэн хөдөлдгийг ярилцана.	Амьтдын зурагтай карт,	Мөлхөж тоглоно.	Шүүн тунгаах: Амьтдын зурагтай карт үзэж, тухайн амьтан хэрхэн хөдөлдөг болохыг ярилцаж ажиглах	Мөлхөлтийн төрлүүдийг гүйцэтгэдэг.
Сонсоод мөлхөөрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжмийн хэмнэлд тохируулан өвдөг дээр мөлхөнө.	саадтай зам, бөмбөг, жижиг саваа	Буухиа тоглоом	Суралцахууд суралцах Багшийн зааврыг ойлгож, хэмнэл, хурдад тохируулан хөдөлгөөнөө зохицуулах	Зурган зааварчилгааг дарааллын дагуу дуурайж хийдэг.
Цэвэр гар	Тойргийн цаг	Цэвэр бохир гарыг харуулсан зурагт үзүүлэн ашиглан гарын ариун		Бид гараа яагаад цэвэрхэн байлгах ёстой вэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Хувийн ариун цэвэр сахих	Хувийн ариун цэвэр сахих

		цэврийн тухай ярилцлага өрнүүлнэ.		Гараа ямар үед угаах вэ?	үйлийг бие даан хийхэд суралцах Суралцахууд суралцах: Гар угаах аргачлалын зурагт үзүүлэн (зургийг) ашиглан дарааллыг ойлгох	үйлийг гүйцэтгэдэг.
Миний гар	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Миний гар" сэдвийн хүрээнд наамал хийнэ. Бээлий дээр цэвэр, бохир гарыг дүрсэлж, үлээж тоглох тоглоом хийнэ.	Нэг удаагийн бээлий, цаасан аяга, соруул, өнгийн цаас, цавуу	Чи ямар гар хийсэн бэ? Гараа угаахгүй байвал юу болох вэ?	Гараа угаахгүй байвал юу болох тухай (үр дагаврын) асуултад хариулж, дүгнэлт хийх (Шүүн тунгаах) Бүтээлчээр сэтгэх: Бээлий дээр цэвэр, бохир гарыг дүрсэлж наамал хийх	Сэдвийн хүрээнд өөрийн бодол төсөөллөөр урлаж, бүтээдэг.
Дагаад хийгээрэй	Хөгжөөн баясах цаг	"Гар угаацгаая" хөгжимт хөдөлгөөнийг хамтран хийж давтана.	Хөгжимт хөдөлгөөн бүхий бичлэг	Хөгжимт хөдөлгөөн хийнэ.	Хамтран ажиллах: "Гар угаацгаая" хөгжимт хөдөлгөөнийг хамтран хийх Суралцахууд суралцах: Хөдөлгөөнийг давтан хийх замаар гар угаах үйлийг бататгах	Гар болон шүд угаах дарааллыг дагаж биелүүлдэг.
Найзтайгаа мэндлээрэй	Тойргийн цаг	Төрөл бүрийн мэндчилгээний зурагтай картаар мэндэлж, нүүрний хувирлыг ярилцана.	Мэндчилгээний зурагтай карт,	Ярилцлага	Сонгосон мэндчилгээний үйлдлээр харилцах, найзыгаа ямар нүүрний хувирал гаргаж байгааг ярилцах (Шүүн тунгаах)	Сэтгэл хөдлөлийг ялгадаг.

Зургаар илэрхийлье	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дугуй хөвөн дээр сэтгэл хөдлөлийг (ууртай, инээсэн) дүрсэлж, толинд харж дуурайж тоглоно.	нүүр цэвэрлэдэг хөвөн, маркер, шилэн сав, гуаш	Хэн ямар нүүрний хувирлыг сонгож зурсан бэ? Нүүрний хувирлаас аль нь таатай (таагүй) байна вэ?	Харилцах Зургаар илэрхийлье Зурсан нүүрний хувирлынхаа тухай ярих Суралцахууд суралцах: Толинд харж ажиглалт хийх, өнгөт ус дусаах үйлдлийг гүйцэтгэх	Сэтгэл хөдлөлөө нэрлэж, таатай/таагүй байгаагаа хэлдэг.
Нүүрний хувирал	Төвийн үйл ажиллагаа	Өнгө өнгийн шааран дээр нүүрний хувирлыг зураад шаарны дотор гурил хийж амсрыг боогоод базаж тоглоно. Хүүхэд зургийг авч үйлдлээр нүүрний хувирлыг хийж үзүүлнэ.	Нүүрний хувирлыг харуулсан зурагт үзүүлэн, шаар, гурил, маркер	чи баяртай байна, чи уурлаж байна уу?	Харилцах: Зургаар илэрхийлье Зурсан нүүрний хувирлынхаа тухай ярих	Сэтгэл хөдлөлөө баяртай гунигтай байгаагаа нүүрний хувирлаар үзүүлдэг.
Дүрс рүү үсрээрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжим зогсоход багшийн нэрлэсэн дүрс рүү (дугуй, гурвалжин, дөрвөлжин) хөгжмийн хэмнэлд тохируулан (хурдан/удаан) нэг эсвэл хоёр хөл дээр үсэрнэ.	Цагариг, хөгжим	Хөдөлгөөнт тоглоом	Шүүн тунгаах: Хөгжим зогсоход багшийн нэрлэсэн дүрс рүү чиглэж очих, хөгжмийн хэмнэлд тохируулан үсрэх Суралцахууд суралцах: Хөгжмийн хэмнэл, хурдад тохируулан хөдөлгөөнөө зохицуулах чадварыг хөгжүүлэх	Дүрс биетийг ялгаж нэрлэдэг. Үсэрч, буудаг.
Сонсоод үсрээрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжим эхлэхэд хэмнэлд тохируулан үсэрнэ. Хөгжим түр зогсоход зурган тэмдэглэгээг харж (баруун, зүүн, байрандаа) хөдөлгөөнийг гүйцэтгэнэ.	Олс, төрөл бүрийн дүрс	Хамтдаа тоглоно.	Хамтран ажиллах: Урт олсны дагуу цуварч зогсох, хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө хамтдаа эхлүүлэх	Хоёр хөлөөр зөв техниктэй үсэрч, өвдгөө нугалж буудаг.

					Суралцахууд суралцах: Багшийн тайлбарласан тэмдэглэгээг ойлгож, түүнийг хөдөлгөөнөөр гүйцэтгэх	
Хэмнэлд тохируулан үсрээрэй	Хөгжөөн баясах цаг	Хөгжмийн хэмнэлд тохируулан байрандаа үсэрч хөдөлнө (удаан аянд хоёр хөлөөр, хурдан аянд нэг хөлөөр). Багшийн заасан дүрс рүү үсэрнэ.	Цагариг, хөгжим	Ямар аянд хурдан үсэрсэн бэ? Ямар аянд удаан үсэрсэн бэ?	Шүүн тунгаах: Ямар аянд хурдан, удаан үсэрсэн тухай дүгнэж ярилцах. Харилцах: Дүрсийг нэрлэж ярих Суралцахууд суралцах: Хөгжмийн хурд, чиглэл, дүрсийг зөв ойлгож хэрэглэх	Хэмнэл, хурд, өнгө аясад тохируулан хөдөлгөөнөө зохицуулдаг.

Албан хэрэг

9 дүгээр сарын I долоо хоног

БИ- МИНИЙ НАЙЗУУД

Шинэ үг: Найз, дүрэм

Үйл ажиллагаа 1. Энэ бол би (Тойргийн цаг)


Хэрэглэгдэхүүн: Жижиг толь (хүүхдийн тоогоор)

Аргачлал: Хүүхэд бүр толинд өөрийгөө харж, нүд, үсний өнгө, урт богино хэмжээ зэрэг онцлог зүйлсээ ажиглаад хэлнэ. Жишээ нь: Миний үс богино, буржгар, би том нүдтэй гэх мэт юу бодож байгаагаа ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Толнд хэн харагдаж байна вэ?
- Чиний үс урт уу? Богино уу?
- Чиний нүд том байна уу? Жижиг байна уу? гэх мэт.

Үйл ажиллагаа 2. Энэ бол миний найз (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цаас , усан будаг, гуаш, эсгий бал

Аргачлал: Өөрийгөө зурна. Зурсан зургийг хамтдаа эвлүүлж, бүтээлдээ нэр өгнө. Хийсэн бүтээлээ найз нартаа танилцуулна. Хамтдаа ямар бүтээл болсон бүтээлдээ ямар нэр өгөх тухай ярилцана.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 68, дасгал №65](#)

Үйл ажиллагаа 3. Ангийн дүрмээ зохиоцгооё. (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүүхдийн үйлдлийг харуулсан зураг, зөв буруу тэмдэглэгээтэй зурагт хуудас (найзтайгаа хамтарч тоглож байгаа, хогоо саванд хийж байгаа хүүхэд гэх мэт)

Аргачлал: Хүүхдүүд ангидаа ямар дүрэм хуваарийг мөрдөж болох тухай асуулт асууж саналаа хэлнэ. Ангийн дүрмийг зурагт хуудаснуудаас тохирохыг сонгож, ангидаа мөрдөж болох дүрмийг зохионо. Зохиосон дүрмийн аль аль нь зөв болохыг Жишээ нь: багш зурагт хуудсыг харуулахад хүүхдүүд болно, болохгүй үйлдлийн сонголт хийж цуваагаар алхана. Хүүхдийн сонголтыг ажиглаад тохирох дүрмийг тайлбарлана. Тоглоомыг дахин үргэлжлүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хэрэв бид үүнийг хийвэл юу болох вэ?
- Хэрэв бид үүнийг хийхгүй бол юу болох вэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 1, дасгал №1](#)

БИД ХАМТДАА

Шинэ үг: Ижил, ялгаатай, сонирхол

Үйл ажиллагаа 1. Миний найз (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Эвлүүлдэг зураг

Аргачлал: Хамтдаа эвлүүлсэн зургаас өөрийн болон найзынхаа зургийг харж бусад найзуудтайгаа юугаараа ижил болон ялгаатай байгааг ажиглаж тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи бусад хүүхдүүдтэй адилхан байна уу?

Үйл ажиллагаа 2. Бидний сонирхол (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Төрөл бүрийн тоглоом

Бэлтгэл хангах: Багш урьдчилан хүүхэд бүрийг өөрийн дуртай тоглоомыг гэрээсээ авчрахыг санал болгоно.

Аргачлал: Хүүхдүүд өөрийн дуртай тоглоомыг (бамбарууш, машин, хүүхэлдэй, ном амьтан гэх мэт) авчирна. Өөрийн сонгосон тоглоомоо найзууддаа танилцуулж яагаад энэ тоглоом надад таалагддаг тухай ярилцана. Багш хүүхэд бүрийн авчирсан тоглоомоос бусдын сонирхол өөр өөр байгаа талаар тайлбарлаж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи яагаад энэ тоглоомыг сонгосон бэ?
- Найзын чинь тоглоом чиний тоглоомоос ижил байна уу? өөр байна уу?
- Найзуудын тоглоомоос чамд ямар тоглоом таалагдсан бэ?
- Бүх хүүхдүүд ижил зүйлд дуртай байж болох уу?
- Яагаад хүмүүсийн дуртай зүйл өөр өөр байдаг гэж бодож байна вэ?.
- Өөр өөр тоглоомтой ч бид бүгд хамтдаа тоглож чадна.

Үйл ажиллагаа 3. Найзтайгаа хамтдаа (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Бөмбөг, төрөл бүрийн эд зүйлсийн зураг

Аргачлал: Хүүхдүүд тойрог болон зогсоно. Багш ба хүүхэд бөмбөгийг дамжуулж тоглоомыг эхлүүлнэ. Бөмбөгийг авсан хүүхэд өөрийн дуртай зүйлээ (хоол, тоглоом, үлгэрийн баатар гэх мэт) хэлнэ. Багш хүүхдүүдийн дуртай өнгө, тоглоом, үлгэрийн баатруудыг дүрсэлсэн зурагт хуудсыг ангийн орчинд байрлуулна. Хүүхдүүдээр сонголт хийлгэж дуртай зүйлээ илэрхийлсэн зураг руу очиж зогсохыг чиглүүлнэ. Багш хүүхдүүдээс асуулт асууж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи яагаад энэ зургийг сонгосон бэ?
- Чи юунд дуртай вэ?
- Чиний сонирхол бусад хүүхэдтэй ижил байна уу? Өөр байна уу?

ХАМТДАА ХИЙГЭЭРЭЙ.

Шинэ үг: Ажиглах, чиглэл

Үйл ажиллагаа 1. Амьтдын хөдөлгөөн (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Амьтдын зурагтай карт

Аргачлал: Хүүхдүүд амьтдын зурагтай карт үзэж, тухайн амьтан хэрхэн хөдөлдөг болохыг ярилцана. (жишээ нь: мэлхий, могой, туулай)

Үйл ажиллагаа 2. Сонсоод мөлхөөрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: саадтай зам, бөмбөг, жижиг саваа

Аргачлал: Хүүхдүүдийг 3 баг болгон хуваана. Багийн эхний хүүхэд зурган зааврын дагуу мөлхөж бөмбөгийг авч байг тойроод бөмбөгийг өнхрүүлж саадыг сүлжиж мөлхөөд барианд ирнэ. Хүүхдүүд саадыг сүлжин өвдөг дээр мөлхөхдөө бөмбөгийг гараараа өнхрүүлнэ. Бөмбөгийг өнхрүүлж барианд ирээд дараагийн хүүхдийн гарт хүрэхэд тоглоомыг үргэлжлүүлнэ. Багаараа бүх үйлдлийг хийсэн баг ялагч болно. Багш тоглоомын эхэнд биечлэн үйлдлийг хийж үзүүлнэ. Урамшуулж дэмжинэ.

9 дүгээр сарын II долоо хоног

МИНИЙ ЭРҮҮЛ МЭНД

Шинэ үг: Цэвэр, бохир

Үйл ажиллагаа 1. Цэвэр гар (Тойргийн цаг)

Аргачлал: Цэвэр, бохир гарыг харуулсан зурагт үзүүлэн (бичлэг) ашиглан гарын ариун цэврийн тухай ярилцлага өрнүүлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Бид гараа яагаад цэвэрхэн байлгах ёстой вэ?
- Гараа ямар үед угаах вэ?

Үйл ажиллагаа 2. Миний гар (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Нэг удаагийн бээлий, цаасан аяга, соруул, эсгий бал, өнгийн цаас, цавуу

Аргачлал: “Миний гар” сэдвийн хүрээнд наамал хийнэ. Бээлий дээр цэвэр болон бохир гарыг дүрсэлж бүтээж, нэг удаагийн аяганд бээлийг резинээр бэхэлж аягыг цоолсон нүхэнд соруулыг хийж үлээж тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Цэвэр бохир гарын зургаас алыг нь сонгож хийсэн бэ?
- Гараа угаахгүй байвал юу болох вэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 5, дасгал №5](#)

Үйл ажиллагаа 3. Дагаад хийгээрэй (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжимт хөдөлгөөн бүхий бичлэг

Аргачлал: Дагаад хийгээрэй хөгжимт хөдөлгөөнийг хамтран хийж хөдөлгөөнийг давтана. Хүүхдүүд найзтайгаа хамтран хийнэ.

<https://www.youtube.com/watch?v=a1IWWXZkHzy>

[Дасгал ажлын дэвтэр хуудас 2, дасгал №2](#)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 3, дасгал №3](#)

МИНИЙ СЭТГЭЛ ХӨДЛӨЛ

Шинэ үг: Таатай, таагүй

Үйл ажиллагаа 1. Найзтайгаа мэндлээрэй (Тойргийн цаг)

Аргачлал: Төрөл бүрийн мэндчилгээний зурагтай картуудыг хольж нэгийг сонгож найзтайгаа мэндэлнэ. Зурагт байгаа мэндчилгээг үйлдлээр хийгээд найзыгаа ямар нүүрний хувирал илэрхийлж байгааг ярилцана.

Үйл ажиллагаа 2. Зургаар илэрхийлье (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Нүүр цэвэрлэдэг хөвөн, арилдаггүй маркер, гуаш, шилэн сав, пепитик

Аргачлал: Дугуй хөвөн дээр ам, нүдийг уурласан, инээсэн, уйтгартайгаар төсөөлөн дүрсэлж зурна. Усыг өнгө оруулж шилэн саванд бэлтгэнэ. Бэлтгэсэн өнгөтэй усыг нүүрний хувирал бүхий хөвөн дээр дусаана. Өөрийн хийсэн нүүрний хувирлыг дуурайж толинд харж тоглоно. Нүүрний хувирлуудын таатай, таагүй тухай ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт

- Хэн ямар нүүрний хувирлыг сонгож зурсан бэ?
- Нүүрний хувирлаас аль нь таатай (таагүй) байна вэ?
- Уурласан хүүхдийг яаж тайвшруулах вэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 4, дасгал №4](#)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 7, дасгал №7](#)

Үйл ажиллагаа 3. Нүүрний хувирал (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Нүүрний хувирлыг харуулсан зурагт үзүүлэн, шаар, гурил, маркер

Аргачлал:

Зураг урлалын төв: Өнгө өнгийн шааран дээр нүүрний хувирлыг зураад шаарны дотор гурил хийж амсрыг боогоод базаж тоглоно. Хүүхдүүд өөрийн болон найзынхаа нүүрний хувирлыг ажиглаж дуурайж тоглоно.

Математикийн төв: Дүрсүүдийг нэрлэж төрөл биет эд зүйлсийг зохиомжлон зурна.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 8, дасгал №8](#)

Хэл ярианы төв: Хүүхдүүд ээлжээр хайрцгаас нэг зураг сонгож, харуулалгүйгээр дараагийн хүүхдэд өгнө. Хүүхэд зургийг авч үйлдлээр нүүрний хувирлыг хийж үзүүлнэ.

Бусад хүүхэд (чи баяртай байна, чи уурлаж байна уу?” гэх мэт) үйлдлийг ажиглаж нүүрний хувирлыг таамаглаж хэлээд зурагтай холбоотой үйл явдал зохиож ярина.

ХАМТДАА ҮСРЭЭРЭЙ

Шинэ үг: Дүрс, үсрэлт, хэмнэл

Үйл ажиллагаа 1. Дүрс рүү үсрээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цагариг, хөгжим (удаан ба хурдан хэмнэлтэй ая)

Аргачлал: Танхимд дүрс бүхий цагаригийг тарааж тавина. Хөгжим эгшиглэхэд хүүхдүүд чөлөөтэй алхаж, гүйж хөдөлнө. Хөгжим зогсоход багш дүрс нэрлэнэ. Хүүхдүүд тухайн дүрс рүү хоёр хөл дээр болон нэг хөл дээр хөгжмийн хэмнэлд тохируулан (хурдан/удаан) үсэрч очно. Дараагийн дүрсийг хэлэхэд тоглоомыг үргэлжлүүлнэ.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 14, дасгал №14](#)

Үйл ажиллагаа 2. Сонсоод үсрээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Олс, төрөл бүрийн дүрс

Аргачлал: Хүүхдүүд урт олсны дагуу цуварч зогсоно. Хөгжим эхлэхэд хүүхдүүд хэмнэлд тохируулан гар, хөлөө хөдөлгөн, хөнгөн үсэрнэ. Хөгжим түр зогсоход хүүхдүүд баруун, зүүн, байрандаа гэсэн зурган тэмдэглэгээг харж хөдөлгөөнийг хийж гүйцэтгэнэ. Хөдөлгөөнийг хийж чадаагүй тохиолдолд тоглоомоос хасагдаж хамгийн сүүлд үлдсэн хүүхэд ялагч болно.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 35, дасгал №36](#)

Үйл ажиллагаа 3. Хэмнэлд тохируулан үсрээрэй (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Цагариг, хөгжим (удаан ба хурдан хэмнэлтэй ая)

Аргачлал: Талбайд дүрс бүхий цагаригийг тойруулж байрлуулна. Багш ая тавьж, хүүхдүүд хэмнэлд тохируулан байрандаа үсэрч хөдөлнө. Удаан ая тавихад хоёр хөл дээр хэмнэлд тохируулан үсэрнэ. Хурдан ая тавихад нэг хөл дээр хурдан үсэрнэ. Хөгжмийн хэмнэл өөрчлөгдөхөд багш чиглэл зааж өгнө. “Дугуй руу үсрээрэй”, “Гурвалжин руу үсрээрэй” гэх мэт. “Ямар аянд хурдан, ямар аянд удаан үсэрсэн бэ?” хэмээн ярилцана.

Сонсъё, дэмжье

- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг идэвхтэй оролцуулахын тулд ажиглах, сонсох, барьж тэмтрэх, хөдөлгөөн гүйцэтгүүлэх аргыг ашиглан ангийн дүрмийг танилцуулж, найзтайгаа хамтран гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.
- Зурган болон үгэн зааварчилгаа үзүүлж, хамтын үйл ажиллагаанд оролцох, бусадтай зэрэгцэн гүйцэтгэх боломжийг олгоно. Мөлхөлтийг дасгалыг хийхдээ багш болон насан хүрэгчдийн дэмжлэгийг авахад анхаарч хүүхдийн мэдрэхүй, хөдөлгөөний оролцоог дэмжинэ.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Эцэг эх та хүүхэдтэйгээ хамтран “Ижилхэн үү” сэдэвт зураг зурна. Зурсан зургаа ажиглаад нүд, хамар, үсний өнгө ижил болон ялгаатай байгаа талаар ярилцаж санаа бодлоо солилцоно.
- Гэрийн дүрэм зохиож, хэн юу хийж “болно, болохгүй” зүйлийг ярилцаад дагаж мөрдөхөд чиглүүлж эерэг харилцааг урамшуулах зөвлөгөөг өгнө.
- Хүүхдийн хөдөлгөөнийг дэмжсэн мөлхөлтийн дасгалыг анги бүлэгт цахим хуудсанд байрлуулж хийгээрэй.

Багшийн эргэцүүлэмж

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

МИНИЙ ЭРҮҮЛ БИЕ

Хүүхдийн эзэмших чадамж:

Суралцахууд суралцах: Алдаа хийсэн ч дахин оролдох, тууштай байхыг хичээх

Бүтээлчээр сэтгэх: Тодорхой асуудлыг олон хувилбараар шийдэх оролдлого хийх, дүгнэлт хэлж сурах

Харилцах: Бусадтай ярилцах, сонсох, тоглох

Хамтрах: Эрүүл ахуйн дадлыг мөрдөх, хамтран хэрэгжүүлэх, хамтран тоглох, дасгал хөдөлгөөн, хамтын бүтээл хийх

Шүүн тунгаах: Биеийн хүрч болох болохгүй хэсэг болон эрүүл мэндэд эерэг, сөрөг нөлөөтэй зүйлийг ялгаж таних

Аюулгүй байдлын зөвлөмж:

Эрүүл ахуйн зөв дадлыг өдөр бүр үлгэрлэх, цавуу, хайч, харандаа, савх зэрэг хэрэглэгдэхүүнийг аюулгүй ашиглах заавар өгөх

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Эргэн тойронд юу байгааг ажиглуулж, юмсын ерөнхийлсөн нэр, ямар дүрстэй ижил төстэй байгааг асууж харилцан ярилцаж санаа бодлыг сонсоорой.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Эд юмсыг бүтээх, өөрийн тухай бяцхан ном хийхэд дэмжлэг үзүүлээрэй.
- Хүүхдийг анхааралтай сонсож, юу хийж байгаагаа тайлбарлахыг нь урамшуулан дэмжээрэй.

Өөртөө үйлчлэх цаг:

- Өөрийн хэрэглэдэг ариун цэврийн хэрэгслээ цэвэр байлгахыг зөвлөөрэй.

Хөгжөөн баясах цаг:

- Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийхэд дэмжлэг үзүүлээрэй.

Боломжууд:

- Хамтран тоглох үед зөрчилдөөн үүсвэл өөрсдөөр нь эергээр шийдвэрлүүлэхэд дэмжлэг үзүүлээрэй.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуун үр дүн	Суралцахуун үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
ХЯ4.2в. Ерөнхийлсөн нэрийг яриандаа ашиглана. ЗУ4.2а. Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон зурна ХЭМ 4.1г. Алхалт, гүйлтийг хөгжмийн хэмнэлд тохируулан чиглэл, хурдаа өөрчилж гүйнэ.	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий нэрийг хэлэх тоглоом тоглох, ярилцах - Эд юмсыг дүрсэлж зурах; - Алхалт, гүйлтийг гарын янз бүрийн хөдөлгөөнтэй хослуулан гүйцэтгэх (зүгээ өөрчлөн, чиглэлээ өөрчлөн, хэмнэлээ өөрчлөн); 	Бидний бүтээл
МАТ4.3б. Дүрс, биетийг ялгаж, савх, харандаа зэргийг ашиглан дүрсийг бүтээх, зохиомж хийнэ. ХӨГ4.1в. Дуу, аялгууны хэмнэлийг хөгжмийн энгийн зэмсгээр хамтран хөгжимдөнө.	<ul style="list-style-type: none"> - Гурвалжин, дөрвөлжин, дугуй, зууван дугуй дүрстэй ижил төстэй зүйлийг орчноос олох - Савх, харандааг ашиглан дүрс бүтээж тоглох; - Зураглалын дагуу алга таших, хуруу имрэх, хөлөө дэвсэх, өвдөг цохих зэргээр чимээ гаргаж хэмнэлийг илэрхийлж тоглох; 	Хамтдаа тоглоцгооё

<p>ХЭМ4.2д. Хувийн аюулгүй байдлаа хамгаалах дүрмийг өдөр тутмын амьдралд дагаж мөрдөнө.</p> <p>БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана.</p>	<ul style="list-style-type: none"> - Биеийн нууц хэсэгт хүрч болох, болохгүй хүнийг мэдэх, ялгах дасгал ажиллах - “Миний тухай” зурагт хуудас, бяцхан ном (нэр, нас, дуртай өнгө, хоол, тоглоом, гэр бүл зурах гэх мэт) хийж, өөрийнхөө тухай танилцуулах; 	<p>Миний тухай</p>
<p>ХЭМ4.2а. Хувийн ариун цэвэр сахих үйлийг өөрийн санаачилгаар бие даан хийнэ.</p> <p>НСХ4.3б Өөрөө хүмүүсээс олон талаараа ялгаатай, ижил төстэй байгааг тодорхойлдог болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Хүүхэд бүр өөр өөрийн самтай байх, цэвэрхэн байлгах, бусадтай солихгүй байх талаар ярилцана. - “Би ч бас адилхан” өөрийн болон найзуудынхаа хувцас, үсний өнгө зэргийг харж ижил төстэй байгааг ажиглаж олох хөгжөөнт тоглоомууд тоглох 	<p>Цэвэрч хүүхэд</p>

10 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Хамтдаа нэрлээрэй	Тойргийн цаг	Анги танхимд байгаа зүйлсийг ажиглаж, эд юмсын ерөнхий нэрийг юу гэж нэрлэдэг талаар ярилцана. Жишээ нь: тараг, ерөм, ааруул зэргийг цагаан идээ гэж ерөнхийлөх	Амьтан, хүнсний ногоо, цагаан идээ, тээврийн хэрэгсэл бүхий зурагт хуудас	Зураг дээр юу юу байна вэ? Эдгээрийг нийтэд нь юу гэж нэрлэх вэ?.	Харилцах: Хүүхдүүд эргэн тойрон дахь зүйлсийг ажиглаж, тэдгээрийн ерөнхийлсөн нэрийг асууж, харилцан ярилцах Шүүн тунгаах: Эд юмсын ерөнхий нэрийг ялган таньж, асуултын хариултыг эрж хайх	Ерөнхийлсөн нэрийг яриандаа хэрэглэдэг.
Хамтдаа зураарай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд цифрүүдийг (1-4) сонгон авч багт хуваагдан амьтан, цагаан идээ, хүнсний ногоо, тээврийн хэрэгсэл зурна. Зурсан зүйлээ нэрлэж, тохирох ерөнхий нэрийн (цифр) дор байрлуулна.	Өнгийн харандаа, зургийн дэвтэр	Эд юмсын ерөнхий нэрийг асуултаар чиглүүлнэ. (Сонголт хийх боломжийг олгох).	Бүтээлчээр сэтгэх: Хүүхдүүд төсөөллөө зургаар илэрхийлэх, тайлбарлах Харилцах: Багт хуваагдаж, юу зурснаа нэрлэж, тайлбарлаж, бусадтай ярилцаж хамтын ажлын үр дүнгээ танилцуулах	Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон зурдаг.
Алхаарай, гүйгээрэй	Хөгжөөн баясах цаг	Хөгжмийн хэмнэлд тохируулан, чиглэлийн дагуу (баруун, зүүн, урагш, хойш) хөдөлгөөнөө зохицуулж, алхалт, гүйлтийг гарын янз бүрийн хөдөлгөөнтэй хослуулан хийнэ.	Хөгжим, ая, чиглэл заасан сум	“Одоо гараа даллаарай!”, “Одоо өвдгөө өндөр өргөж гүйгээрэй” гэх мэтээр чиглүүлнэ.	Суралцахууд суралцах: Хөдөлгөөний уялдаа, хэмнэл мэдрэмж, анхаарлаа төвлөрүүлж, хөгжмийн хэмнэл, чиглэлд тохируулан бие даан гүйцэтгэх	Алхалт, гүйлтийг хөгжмийн хэмнэлд тохируулан чиглэл, хурдаа өөрчилж гүйцэтгэдэг.
Тойрог больё	Тойргийн цаг	Ангид байгаа эд зүйлсийг ажиглаж, гурвалжин, дөрвөлжин,	Ярилцлага	Гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрстэй төстэй юу	Шүүн тунгаах: Ангид байгаа эд зүйлсийг ажиглах, гурвалжин,	Дүрс, биетийг ялгаж, савх, харандаа зэргийг

		дугуй, зууван дугуй дүрстэй ижил төстэй зүйлийг олж ярилцана.		юу байна вэ?	дөрвөлжин, дугуй дүрстэй ижил төстэй зүйлийг олж, ялгаж нэрлэх Харилцах: Ажигласан зүйлсийн талаар бусадтай ярилцаж, санаа бодлоо хуваалцах	ашиглан дүрсийг бүтээх, зохиомж хийдэг.
Дүрс бүтээе	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Зурагт карт дээрх дүрсийг савхаар бүтээх. Хамтдаа өөрийн бүтээсэн дүрсүүдээр хамтын бүтээл хийж, танилцуулж тайлбарлана.	Зурагт карт, савх	Та нар хамтдаа юу бүтээсэн бэ? Хэн хэн ямар дүрс ашиглан эд зүйлс бүтээсэн бэ? Та нарын мэддэг өөр ямар дүрс байна вэ?	Хамтран ажиллах: Хүүхдүүд савх, харандаа ашиглан дүрс бүтээж тоглохдоо, хамтдаа өөрийн бүтээсэн дүрсүүдээр хамтын бүтээл хийх Бүтээлчээр сэтгэх: Хийсэн бүтээлээ танилцуулж, тайлбарлах.	Дүрс, биетийг ялгаж, савх, харандаа зэргийг ашиглан дүрсийг бүтээх, зохиомж хийдэг.
Дуурайж хийгээрэй	Хөгжөөн баясах цаг	Зурагт хуудас дээрх дарааллаар (алга таших, хуруу имрэх, хөл дэвсэх, өвдөг цохих) чимээ гаргах. Багш болон хүүхдүүдийн зохиосон хөдөлгөөний дарааллыг дуурайж хийнэ.	Дараалал бүхий зурагт хуудас	Хүүхдүүдийг багшийн оронд хөдөлгөөний дарааллыг зохион хийхэд чиглүүлнэ.	Хамтран ажиллах: Зураглалын дагуу алга таших, хөл дэвсэх зэрэг үйлдлээр бусадтайгаа хамтран чимээ гаргаж хэмнэлийг илэрхийлэх Шүүн тунгаах: Зурагт хуудас дээрх дарааллыг ажиглан үйлдлийг гүйцэтгэх, мөн эргээд өөрсдөө хөдөлгөөний дарааллыг зохион тоглох	Дуу, аялгууны хэмнэлийг хөгжмийн энгийн зэмсгээр хамтран хөгжимддөг.

Миний биеийн дүрэм	Тойргийн цаг	Биеийн нууц хэсэг, хүрч болох/болохгүй хүнийг мэдэх, ялгах талаар ярилцлага хийнэ.	Дасгал ажлын дэвтэр хуудас 26, дасгал №26	Биеийн нууц хэсэг гэж аль хэсгийг хэлэх вэ? Хэн хэн хүрч болох вэ? Хэн хүрч болохгүй вэ? Хэрхэн хамгаалж болох вэ?	Шүүн тунгаах: Хүүхдүүд аюулгүй байдлын зөвлөмжийг дагаж мөрдөхдөө, биеийн нууц хэсэгт хүрч болох, болохгүй хүнийг мэдэж, ялгах дасгал хийж, өөрийгөө хамгаалах тохирсон аргыг сонгож, тайлбарлах	Хувийн аюулгүй байдлаа хамгаалах дүрмийг өдөр тутмын амьдралд дагаж мөрддөг.
Миний тухай бяцхан ном	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өөрийн тухай (зураг, нэр, нас, дуртай өнгө, хоол, тоглоом, гэр бүл) мэдээллийг агуулсан бяцхан ном бүтээж, танилцуулна.	Загвар хуудас, өнгийн харандаа, эсгий бал, наадаг стикер	Энэ номд юуны талаар зурсан бэ? Бусад номоос юугаараа онцлог ялгаатай вэ? Хүүхэд бүр хооронд юугаараа ижил төстэй, ялгаатай байна вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хүүхдүүд өөрийн санааг төрөл бүрийн аргаар илэрхийлж, өөрийн тухай бяцхан номыг бүтээх Харилцах: Хүүхдүүд өөрийн бүтээсэн номыг бусдад танилцуулж, ярилцах	Өөрийнхөө тухай танилцуулж бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй ханддаг.
Бидний хэрэглэдэг зүйлс	Тойргийн цаг	Өөрийн хэрэглэдэг ариун цэврийн хэрэгслийн талаар ярилцана.	Ярилцлага	Ямар ямар ариун цэврийн хэрэгсэл хэрэглэдэг вэ? Сам ямар ач холбогдолтой вэ? Самыг хэрхэн хэрэглэх вэ?	Суралцахууд суралцах: Хүүхэд бүр өөрийн самтай байх, самыг зөв хэрэглэх, цэвэр байлгахын ач холбогдлыг ойлгож, хувийн ариун цэвэр сахих дүрмийг ухамсарлан суралцах	Хувийн ариун цэвэр сахих үйлийг өөрийн санаачилгаар бие даан хийдэг.
Хүүхэлдэйн үс самная	Өөртөө үйлчлэх цаг	Хүүхэд бүр өөрийн самаар үсээ самнах. Самыг савантай усаар угааж, цэвэрлэнэ. (Урт, богино үсийг самнах зөв хөдөлгөөнийг заах).	Сам, ус, саван, жижиг сав (самаа угаахад)	Хүүхдүүд хүүхэлдэйнхээ үсийг самнаж тоглоно.	Шүүн тунгаах: Самнахдаа “самыг үснээс нь зөөлөн татах” хөдөлгөөнийг зөв хийх, урт, богино үсийг ялгаж тохирох чиглэлээр самнах зэрэгт анхаарлаа төвлөрүүлж, дүрмийг баримтлах	Хувийн ариун цэвэр сахих үйлийг өөрийн санаачилгаар бие даан хийдэг.

Би ч бас адилхан	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Үс, хувцас, өнгө зэргээрээ хүмүүс олон талаараа ижил төстэй болон ялгаатай байдгийг ажиглах. Ижлээ олох тоглоом тоглоно.	Зурагт хуудас	Хэн шар самтай вэ? Хэн улаан цамцтай вэ? Хэний үс хүрэн өнгөтэй вэ?. (Ижил төстэй хүүхдүүд гараа өргөх).	Нийгэм, сэтгэл хөдлөл: бусадтай харилцан хамааралтай ижил төстэй байдлаа тайлбарлах Шүүн тунгаах: Ижил төстэй байдлыг тодорхойлох	Өөрөө хүмүүсээс олон талаараа ялгаатай, ижил төстэй байгааг тодорхойлж хэлдэг.
------------------	-------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------------------------------------------------------------

Албан хэрэгцээ

БИДНИЙ БҮТЭЭЛ

Шинэ үг: Ерөнхий нэр

Үйл ажиллагаа 1. Хамтдаа нэрлээрэй (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Амьтан, хүнсний ногоо, цагаан идээ, тээврийн хэрэгсэл бүхий зурагт хуудас

Аргачлал: Хүүхдүүдэд амьтан, хүнсний ногоо, цагаан идээ бүхий зурагт хуудсыг үзүүлж дараах асуултын дагуу ярилцана.

- Зураг дээр юу юу байна вэ? Нэрлээрэй.
- Эдгээрийг нийтэд нь юу гэж нэрлэх вэ?"

Хүүхдүүдийн хариултыг сонсоод “тараг, өрөм, ааруул, аарцыг нэгтгээд цагаан идээ гэж ерөнхийлдөг” гэх мэтээр тайлбарлана. “Амьтан” гэдэг үг нь ерөнхий нэр болох талаар харилцан ярилцана.

Үйл ажиллагаа 2. Хамтдаа зураарай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн харандаа, зургийн дэвтэр

Аргачлал: Хүүхдүүд 1, 2, 3, 4 гэсэн цифрүүдийг сонгон авч, багт хуваагдаж сууна. 1-р баг амьтан, 2-р баг цагаан идээ, 3-р баг хүнсний ногоо, 4-р баг тээврийн хэрэгсэл зурна. Хүүхдүүд юу юу зурснаа тайлбарлаж, тохирох ерөнхий нэрийн (цифр) дор байрлуулна, ерөнхий нэрийг хэлнэ.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 9, дасгал №9](#)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 10, дасгал №10](#)

Үйл ажиллагаа 3. Алхаарай, гүйгээрэй (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, ая, чиглэл заасан сум

Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөнийг чиглэлийн дагуу хийнэ. Удаан хэмнэлтэй ая тавихад удаанаар алхана гэх мэт. Багшийн өргөсөн сумын дагуу чиглэлээ (баруун, зүүн, урагш, хойш) өөрчилж алхана. “Одоо гараа даллаарай!”, “Одоо өвдгөө өндөр өргөж гүйгээрэй” гэх мэтээр тоглуулна.

ХАМТДАА ТОГЛОЦГООЁ

Шинэ үг: Хөл дэвсэх, баруун зүүн

Үйл ажиллагаа 1. Тойрог больё (Тойргийн цаг)

Аргачлал: Хүүхдүүд тойрог хэлбэртэй зогсоод ангид байгаа эд зүйлсийг ажиглана. Ажигласан зүйлсээ ямар дүрстэй төстэй байгаа талаар ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт

- Ангид гурвалжин, дөрвөлжин, дугуй дүрстэй төстэй юу юу байна вэ? Нэрлээрэй.

Үйл ажиллагаа 2. Дүрс бүтээе (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зурагт карт, савх

Аргачлал: Хүүхдүүд эхлээд өмнөө байгаа картаас сонгон авч, дүрсийг савхаар бүтээнэ. Юу бүтээснээ нэрлэж, картаа дараагийн хүүхдэд дамжуулна. 2 дахь карт дээрх дүрсийг бүтээх гэх мэтээр үргэлжлүүлэн тоглоно. Хамтдаа өөрийн бүтээсэн дүрсүүдээр хамтын бүтээл хийнэ. Хийсэн бүтээлээ танилцуулж тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Та нар хамтдаа юу бүтээсэн бэ?
- Хэн хэн ямар дүрс ашиглан эд зүйлс бүтээсэн бэ?
- Та нарын мэддэг өөр ямар дүрс байна вэ?

Үйл ажиллагаа 3. Дуурайж хийгээрэй (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Дараалал бүхий зурагт хуудас

Аргачлал: Хүүхдүүд багштай хамтран зурагт хуудас дээрх дарааллаар үйлдлийг хийж чимээ гаргана. Жишээ нь: алга таших - хуруу имрэх - хөл дэвсэх - өвдөг цохих

Багш өөр хувилбараар хийж харуулна. Хүүхдүүд дуурайна. Дараа нь хүүхдүүд нэг нэгээрээ гараад багшийн оронд хөдөлгөөний дарааллыг зохион хийж, тоглоомыг удирдаж болно.

10 дугаар сарын II долоо хоног

МИНИЙ ТУХАЙ

Шинэ үг: Удаан, хурдан, түргэн

Үйл ажиллагаа 1. Миний биеийн дүрэм (Тойргийн цаг)

Миний биеийн нууц хэсэг сэдвээр дараах асуултын дагуу ярилцлага өрнүүлнэ.

- Биеийн нууц хэсэг гэж аль хэсгийг хэлэх вэ?
- Хэн хэн хүрч болох вэ?
- Хэн хүрч болохгүй вэ?
- Хэрхэн хамгаалах вэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 26, дасгал №26](#)

Үйл ажиллагаа 2. Миний тухай бяцхан ном (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Миний тухай загвар хуудас (зураг, нэр, нас, дуртай өнгө, хоол, тоглоом, гэр бүлийн зураг зурах хэсэгтэй), өнгийн харандаа, эсгий бал, наадаг стикер

Аргачлал:

Өөрийн тухай бяцхан ном бүтээнэ. Бяцхан номд өөрийн зураг, нэр, нас, дуртай өнгө, хоол, тоглоом, гэр бүлийн зургийг харуулсан дарааллаар зурна. Хүүхдүүд өөрийн бүтээсэн номыг танилцуулж, ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ном бүтээхдээ юу ашигласан бэ?
- Бусад номоос юугаараа онцлог ялгаатай вэ?
- Хүүхэд бүр хооронд юугаараа ижил төстэй, ялгаатай байна вэ?

ЦЭВЭРЧ ХҮҮХЭД

Шинэ үг: Самнах

Үйл ажиллагаа 1. Бидний хэрэглэдэг зүйлс (Тойргийн цаг)

Аргачлал: Өөрийн хэрэглэдэг ариун цэврийн хэрэгслийн тухай ярилцана.

- Ямар, ямар ариун цэврийн хэрэгсэл хэрэглэдэг вэ?
- Сам ямар ач холбогдолтой вэ?
- Самыг хэрхэн хэрэглэх вэ?

Багш хүүхдүүдэд өөрийн самтай байх, самыг зөв хэрэглэх, цэвэр байлгахын ач холбогдлыг товч тайлбарлана.

Үйл ажиллагаа 2. Хүүхэлдэйн үс самная (Өөртөө үйлчлэх цаг)

Хэрэглэгдэхүүн: Сам, ус, саван, хүүхэлдэй, жижиг сав (самаа угаахад)

Аргачлал: Хүүхэд бүр өөрийн самаар үсээ самнана. Багш “самыг үснээс нь зөөлөн татах” хөдөлгөөнийг хийж үзүүлнэ. Урт үсийг дээрээс доош, богино халимаг үсийг урагш, арагш, хажуу тийш самнахыг сануулна. Дараа нь хүүхдүүд хүүхэлдэйн үсийг самнаж тоглоно. Хүүхэд бүр самаа савтай усанд хийж, савангаар угааж, усаар зайлна.

Үйл ажиллагаа 3. Би ч бас адилхан (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зурагт хуудас

Аргачлал: Хүүхэд бүр 1 ширхэг самны зурагт хуудас сонгож авна. Багш “Хэн шар самтай вэ?”, “Хэний цамц улаан өнгөтэй вэ?” гэхэд тухайн өнгөтэй, төстэй хүүхдүүд гараа өргөнө. Багш хүүхдүүдэд ижлээ олж зогсох тоглоомын дүрмийг танилцуулна. Хүүхдүүд дүрмийн дагуу тоглоно. Тухайлбал: Шар сам, улаан цамц гэхэд шар сам, улаан цамцтай хүүхдүүд хамт зогсоно. Урт үс, богино үс гэх мэтээр үргэлжлүүлэн тоглоно. Тоглоомын төгсгөлд хүүхэд бүр өөрийгөө бусдаас ялгаатай, ижил төстэй байгаагаар тодорхойлж ярина. Мөн өөр өөрийн самтай байх, цэвэрхэн байлгах талаар ярилцана.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 13, дасгал №13](#)

Сонсьё, дэмжье

- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг идэвхтэй оролцуулахын тулд багш ажиглалтаар, хөдөлгөөн, тэмтрэх, сонсох аргаар хүртээмжтэй орчин бүрдүүлж, хүүхдийн хэрэгцээнд

тохирсон дасгал, тоглоом, дүрс тэмдэглэгээтэй хэрэгсэл ашиглан аюулгүй, хүртээмжтэй дэмжлэг үзүүлнэ.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Гэр бүл хүүхдийн хөгжил, соёлын хэрэгцээнд нийцсэн үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, бүтээлч тоглолт, дасгал хийх, шинэ дуунуудыг давтах, бүтээлд нь магтан урамшуулал үзүүлэх, харилцан мэдээлэл солилцох, аюулгүй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Багшийн эргэцүүлэмж

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:.....

Цаашид сайжруулах:.....

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- XI САР

ӨНГӨ

Хүүхдийн эзэмших чадамж:

Бүтээлчээр сэтгэх: Зурах урлах үйл хийх явцад шинэ санаагаа турших, бүтээлээр илэрхийлэх

Шүүн тунгаах: Орчин болон юмсыг ажиглах, асуултын хариулыг эрж хайх, юмсын ялгаа, ижил төстэй байдлыг харьцуулах, ангилах, тэмдэглэх

Хамтрах: Бусадтай хамтран тоглох, дасгал, даалгавар гүйцэтгэх, дүрэм баримтлах

Харилцах: Санаа бодлоо илэрхийлэх, ярилцах, сонсох, тоглох

Суралцахуйд суралцах: Алдаа хийсэн ч дахин оролдох, тууштай байхыг хичээх, өөрийгөө үнэлэх, бие даан суралцах

Нийгэм сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох, тайлбарлах чадамжийг дэмжихэд хувь нэмрээ оруулна.

Аюулгүй байдлын зөвлөмж:

- Аюулгүй, цэвэр орчин бүрдүүлж, хүүхдийн хувцсыг будаг болохоос хамгаалах
- Баримлын шавар, гуаштай хэрхэн зөв харьцахыг харуулж, зааварчилгаа өгөх, бүтээл болон туршилт хийж байх үед ам, нүд, нүүрэндээ гар хүрэхгүй байхыг сануулах, хэрэглэж дууссаны дараа гараа угаах, хэрэгслүүдийг цэвэрлэх
- Хуучин, хадгалалтын хугацаа дууссан хэрэглэгдэхүүн ашиглахгүй байх

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Ажигласан зүйлээ ярилцах, хийх, судлах зүйлийн талаар мэдээлэл солилцох, бусдын санаа бодлыг сонсох, өөрийн сэтгэгдлээ хэлэхэд нь дэмжээрэй.

Чиглүүлэгтэй, тоглоом, үйл ажиллагаа:

- Юмсыг ижил ялгаатай шинжээр нь ангилах, тоолох, дүнг тэмдэглэх, хийсэн зүйлээ тайлбарлах,
- Хөгжим сонсож сэтгэгдлээ илэрхийлэх, сэтгэл хөдлөлийг бүтээл болон үгээр илэрхийлэх,
- Ухаалаг төхөөрөмж зөв ашиглах, туршилтыг зааврын дагуу хийхэд нь дэмжлэг үзүүлээрэй.

Зугаалга:

- Цэцэрлэгийн орчинд ажиглалт хийх, өнгийн эд юмсын зураг авах, тэмдэг тэмдэглэгээг таних, ойлгох, дүрмийн дагуу тоглох, энгийн зааврыг дагах чадварыг дэмжээрэй.

Төвийн үйл ажиллагаа:

- Багаар ажиллан ном бүтээх, зааврын дагуу ажлын хуудаст зурж тэмдэглэл хийх, хийсэн зүйлээ бусдад танилцуулж сонирхлоороо ажиллах боломжийг бүрдүүлээрэй.

Хөгжөөн баясах цаг:

- Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, тоглоомд бүтээлчээр оролцох, хөгжилтэй, баяртай байхад нь туслаарай.

Боломжууд:

Хамтран тоглох, бие биеэсээ суралцах, алдаагаа олж засах, асуудлаа шийдвэрлэх боломж олгоорой.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>ХЯ4.26. Харилцан яриаг асуулт тавьж эхлүүлж, хариултын хүрээнд үргэлжлүүлж ярилцана.</p> <p>МАТ4.3а. Тоглоом юмсын ижил ялгаатай шинжийг нэрлэж, ангилж, тайлбарлана.</p> <p>ЗУ4.26. Өөрийн бүтээлээ үндсэн болон үүсмэл өнгөөр зохиомжлон будна.</p>	<ul style="list-style-type: none">- Санаагаа илэрхийлж ярилцлагыг үргэлжлүүлэх- Олон төрлийн эд зүйлийг өнгө, хэлбэрээр нь (бөмбөг, машин, аяга, хүүхэдэй зэрэг) хүүхдэд өгч, ижил өнгөтэй болон ялгаатайг ангилж байрлуулаад “Яагаад энэ хоёр ижил вэ?”, “Ямар зүйл нь ялгаатай вэ?” гэдгийг тайлбарлах гэх мэт) ангилах- Үндсэн ба үүсмэл өнгийг гаргах	Өнгө яагаад олон янз байдаг вэ?
<p>БНО4.1в. Ойр орчны эд юмс, тоглоомын материалын шинж чанарыг (төмөр, цаас, шил, даавуу, мод, чулуу) ялгаж, нэрлэнэ.</p> <p>ЗУ4.26. Өөрийн бүтээлээ үндсэн болон үүсмэл өнгөөр зохиомжлон будна.</p>	<ul style="list-style-type: none">- “Миний эргэн тойрон” аялал хийх эргэн тойронд байгаа эд зүйлсийг- Үндсэн ба үүсмэл өнгийг өнгөний дугуй ашиглаж тайлбарлах, зурах	Өнгө хэрхэн үүсдэг вэ?
<p>ХЭМ4.1а. Гарын сарвуу, хөлийн тавхайн хэсгээр хийх зохиомжит дасгалыг босоо, суугаа байрлалд дэс дарааллын дагуу гүйцэтгэнэ.</p> <p>ХЭМ4.26. Хувцасны цэвэр, бохир байдлыг ялгаж ойлгон, бохирдсон үед өөрийн санаачилгаар цэвэр хувцсаар сольж өмсдөг болно.</p>	<ul style="list-style-type: none">- Гар хөлийн нарийн хүндэвтэр хөдөлгөөн (уяа зангидах, зангилаа тайлах, шүр, жижиг зүйлсийг утсаар сүвлэх, хэлхэх)-ийг ойлгож гүйцэтгэх- “Хувцасны дэлгүүр” сэдэвт тоглоом тоглох.	Хамтдаа тоглоцгооё
<p>МАТ4.4а. Ухаалаг төхөөрөмжийн дүрс, тэмдэг, тэмдэглэгээг таньж, зориулалтаар хэрэглэж, тайлбарлана.</p> <p>ХЭМ4.2з. Ухаалаг төхөөрөмжийн хэрэглээний эерэг, сөрөг нөлөөг тайлбарлан, зохистой хэрэглэх цаг, дүрмийг мөрдөж, бусдад сануулна.</p> <p>ХЯ4.2г. Үзсэн, оролцсон, болсон явдлыг нийлмэл өгүүлбэрээр ярина.</p>	<ul style="list-style-type: none">- Зургийн дагуу тохирох дүрсийг самбараас олж, (аппаратын зургийг олж, зураг авах үйлдэл хийх гэх мэт) дүрсийг ашиглан тоглоод, тайлбарлах- Зурагт карт ашиглан дэлгэцтэй хэрэгслийн эерэг, сөрөг нөлөөг тайлбарлах, Ухаалаг төхөөрөмж хэрэглэх санамжийг зохиох- Өөрийн үзсэн, харсан, оролцсон үйл явдлыг нийлмэл өгүүлбэрээр ярих.	Миний эргэн тойрон дахь өнгө
<p>ЗУ4.3а. Баримлын шаврыг байгалийн материалтай хослуулж сэдэвт баримал барина;</p> <p>НСХ4.26. Бусдын нөхцөл байдалд тохируулан энэрэх үйлдэл үзүүлдэг болно.</p> <p>ХӨГ4.1а. Хөгжмийн энгийн зэмсгийг дуугаралтаар ялгаж, өнгө аясыг тодорхойлно.</p>	<ul style="list-style-type: none">- Өөрийн бодол, төсөөллөөр хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон барих;- “Миний найз баяртай байна. Учир нь ...” гээд хүүхдүүд цааш өгүүлбэрийг гүйцээж зохиож ярих;- Аялгуу нь өнгө аяс, сэтгэл хөдлөлтэй байдгийг ойлгох. Багш ая тоглоход “хөгжилтэй байна”, “гунигтай байна” гэх мэтээр мэдрэмжээ илэрхийлж нүүрний хувирлын зурагт картаас сонгох.	Найзтайгаа хамт

11 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Ажиглаад ярилцаарай	Тойргийн цаг	Туузыг ажиглан, ижил ялгаатайгаар нь ялгаж, өнгөний талаар ярилцана.	Урт, богино өнгө өнгийн даавуун тууз (хүүхэд бүрд 2 ширхэг)	Туузууд бүгд ижил байна уу? Юугаараа ижил, юу нь өөр юм бол? Хэрвээ бид улаан, шар, хөх өнгийг бусад өнгөтэй нийлүүлж үзвэл ямар өнгө гарах бол?	Шүүн тунгаах: Туузыг ажиглаж, өнгө, урт, богино зэрэг ижил болон ялгаатай шинжүүдийг харьцуулах Бүтээлчээр сэтгэх: Улаан, шар, хөх өнгийг бусад өнгөтэй нийлүүлбэл ямар өнгө гарах талаар таамаглал дэвшүүлэх	Харилцан яриаг асуулт тавьж эхлүүлж, хариултын хүрээнд үргэлжлүүлж ярьдаг.
Ижлийг олж тэмдэглээрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Туузаа урт богино, өнгөөр нь ангилж тоолох, ажлын хуудаст тэмдэглэл хийх, ижил өнгө байхгүй бол туршилт хийж өнгө гаргана.	Даавуун тууз, ажлын хуудас, харандаа, гуаш, усан будаг, бийр	Урт (богино) тууз хэд байна вэ? Аль аль тууз ижил өнгөтэй байна вэ? Туузын өнгөтэй ижил өнгийн будаг байхгүй бол яаж тэмдэглэж болох вэ?	Шүүн тунгаах: Туузыг өнгө, урт, богино, өнгөөр нь ангилж тоолон тэмдэглэх. Ижил өнгө байхгүй тохиолдолд туршилт хийж өнгийг гаргах арга замыг хайх	Тоглоом юмсын ижил ялгаатай шинжийг нэрлэж, ангилж, тайлбарладаг.
Сонирхолтой туршилт	Төвийн үйл ажиллагаа	Үндсэн өнгийг хольж, хэрхэн өөрчлөгдөхийг туршин, үр дүнг танилцуулна. (Ус болон слайд, гэрэл ашиглан туршилт хийх, өнгөний дугуй дээр тэмдэглэх)	Гуаш, бийр, хөвөн, будаг хийх сав, шилэн савтай ус, өнгөгүй слайд, эсгий бал, цагаан цаас, гар чийдэн, дугуй дүрс зурсан цаас	Ямар ямар өнгийг сонгож авсан бэ? Энэ хоёр өнгө нь өөрчлөгдөх болов уу? Ангид өнгөгүй, тунгалаг зүйлс байна уу? Ямар ямар өнгийг холиход энэ өнгийг гаргаж болох вэ?	Бүтээлчээр сэтгэх: Үүсгэсэн өнгөөрөө урлан бүтээж туршилтын үр дүнг өнгийн дугуй ашиглан тайлбарлах Шүүн тунгаах: Тунгалаг зүйлсийн шинж чанарыг тодорхойлох	Өөрийн бүтээлээ үндсэн болон үүсмэл өнгөөр зохиомжлон буддаг.
Өнгө өнгийн хөшөө	Хөгжөөн баясах цаг	Өнгөний талаарх туршилт, үйл ажиллагааг бататгах тоглоом	Өнгийн туузууд, өнгө өнгийн дүрс, хөгжмийн	Өмнө хийсэн туршилтаар өнгийг	Нийгэм, сэтгэл хөдлөл: Өгөгдсөн өнгийн дагуу нийлж хөшөөг дүрсэлсэн	Гарын сарвуу, хөлийн тавхайн хэсгээр хийх

		тоглоно. (Хөгжмийн аянд бүжиглэж, хөшөө болж, ижил өнгөөр нийлэх, үр дүнгээ өнгөний дугуй ашиглан тайлбарлах)	бүтээлийн бичлэг	хэрхэн үүсгэж байсан бэ? Юу сурсан бэ?.	хөдөлгөөн хийж хөдөлгөөнгүй зогсох, тоглох явцдаа баярлах Шүүн тунгаах: Өмнө хийсэн туршилтаар өнгийг хэрхэн үүсгэж байсныг эргэн санаж ашиглах	зохиомжит дасгалыг босоо, суугаа байрлалд дэс дарааллын дагуу гүйцэтгэдэг.
Хувцас ч бас өнгөтэй	Тойргийн цаг	Хувцас өнгөтэй, чимэглэлтэй байдгийг ярилцах, хувцасны загвар зохион бүтээх талаар ярилцлага хийнэ.	Фото зураг, төрөл бүрийн хувцас, шүр, тууз	Бидний өмссөн хувцасны өнгө ижилхэн байна уу? Чи ямар өнгийн хувцсанд дуртай вэ? Хэрвээ бид загвар зохион бүтээгчид байсан бол ямар өнгийн хувцас хийхийг хүсэж байна вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Хувцасны загвар зохион бүтээгч байсан бол ямар өнгийн хувцас хийхийг хүсэж байгаагаа ярилцах, санаа бодлоо илэрхийлэх Харилцах: Найзуудын өмссөн хувцасны өнгийг ажиглаж ярилцах Шүүн тунгаах: Хувцасны өнгө, чимэглэлийг ажиглаж, харьцуулах	Харилцан яриаг асуулт тавьж эхлүүлж, хариултын хүрээнд үргэлжлүүлж ярьдаг.
Бид зохион бүтээгчид	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хувцасны дэлгүүрт хэрэгтэй зүйлсээ бэлтгэх, даавууны өнгийг хослуулж, хувцас урлан, туузад шүр хэлхэх, тууз зангидах, бүтээлээ тайлбарлана.	Тууз, даавуу, том шүр, хавчаар, малгай, ороолт, хувцасны өлгүүр, мөнгө	Хувцасны дэлгүүрт ямар ямар өнгийн хувцас байвал хүмүүс худалдан авах бол? Хувцсыг гоё болгохын тулд ямар өнгийн туузаар чимэглэх вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хайчлахгүйгээр даавууны өнгийг хослуулан хувцас урлах Суралцахууд суралцах: Шүр хэлхэх, тууз зангидах зэргээр бүтээлч чимэглэл хийх Шүүн тунгаах: Даавууны өнгийг хэрхэн хослуулах, хувцасны дэлгүүрт хэрэгтэй зүйлсийг багаар ярилцаж шийдэх	Ойр орчны эд юмс, тоглоомын материалын шинж чанарыг (төмөр, цаас, шил, даавуу, мод, чулуу) ялгаж, нэрлэдэг.

Манай дэлгүүр	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Худалдагч, худалдан авагчийн харилцааны талаар ойлголттой болж, дүрд орж тоглох, хувцасны онцлог шинжийг өнгөтэй холбон тайлбарлана.	Хүүхдийн бүтээсэн хувцаснууд, мөнгө	Чи ямар дүрд тоглосон бэ? Хэрвээ чи худалдан авагч байсан бол ямар өнгийн хувцас худалдаж авах вэ? Дэлгүүр болж тоглоход юу нь хамгийн сонирхолтой байв?	Харилцах: Худалдагч, худалдан авагчийн дүр, харилцааг ойлгож, тоглох Суралцахууд суралцах: Хувцасны онцлог шинжийг (өнгийг) холбон тайлбарлах	Хувцасны цэвэр, бохир байдлыг ялгаж ойлгон, бохирдсон үед өөрийн санаачилгаар цэвэр хувцсаар сольж өмсдөг.
Ухаалаг төхөөрөмжтэй танилцъя	Тойргийн цаг	Гар утас, зургийн аппарат зэрэг хэрэгслийн нийтлэг зүйлийг ярилцах, зургийн тэмдэглэгээтэй танилцах, зөв хэрэглэх санамжийг хамтдаа зохионо.	Гар утас, зургийн аппарат, дасгал ажлын дэвтэр	Гар утас, аппаратаар зураг авч байсан уу? Гар утсаар яаж зураг авах вэ? Гар утсыг удаан хугацаагаар хэрэглэвэл яах вэ?	Шүүн тунгаах: Гар утсыг удаан хугацаагаар хэрэглэх сөрөг нөлөөг шинжлэн ярилцах Суралцахууд суралцах: Гар утас, аппаратын тэмдэглэгээг тайлбарлах Бүтээлчээр сэтгэх: Гар утас ашиглах санамжийг хамтдаа зохиох	Ухаалаг төхөөрөмжийн дүрс, тэмдэг, тэмдэглэгээг таньж, зориулалтаар хэрэглэдэг.

Миний эргэн тойронд	Зугаалга	Цэцэрлэгийн орчмын юмсыг ажиглах, сонгосон өнгөтэй ижил эд юмс болон тэмдэг тэмдэглэгээний зургийг гэр бүл/багштай хамтран гар утас ашиглан авах. "Бөмбөг дамжуулъя" тоглоом тоглоно.	Гар утас, өнгө өнгийн дүрс, өнгийн бөмбөг	Хэрвээ дэлхий дээр нэг л өнгө байсан бол ямар байх бол? Ямар өнгө хоорондоо адилхан харагддаг вэ?.	Хамтран ажиллах: Гэр бүлийнхэнтэйгээ хамтран сонгосон өнгийн эд юмс, тэмдэглэгээний зургийг гар утас ашиглан авах Шүүн тунгаах: Цэцэрлэгийн хашаанд байгаа юмсын өнгийг ажиглах Харилцах: Тоглоомын дүрмийг өөрчлөхөд дагаж тоглох	Үзсэн, оролцсон, болсон явдлыг нийлмэл өгүүлбэрээр ярьдаг. Ухаалаг төхөөрөмжийн дүрс, тэмдэг, тэмдэглэгээг таньж, зориулалтаар хэрэглэдэг.
Миний дуранд	Төвийн үйл ажиллагаа	Авсан зургаа ярилцах, ажлын хуудсанд тэмдэглэл хийх (ямар өнгийн, хэдэн зураг авснаа), хөх өнгө яагаад өөр өөр байгаа учир шалтгааныг ярилцана.	Проектор, компьютер, дэлгэц, телевизор, ажлын хуудас, хүүхдийн сонгосон 2-3 зураг	Ямар хэрэгслээр зураг авсан? Яагаад үүнийг сонгож авсан бэ? (Хэл яриа төв). (Багшийн дэмжлэг: Хөх өнгө яагаад өөр өөр байгаа тухай асуух)	Суралцахууд суралцах: Авсан эд юмсын зургийг ажлын хуудсанд дүрсэлж зурах Шүүн тунгаах: Авсан зургаа ажлын хуудас дээрх өнгөтэй харьцуулан харах, тэмдэглэх Харилцах: Хөх өнгө яагаад өөр өөр байгаа тухай учир шалтгааныг ярилцах	Үзсэн, оролцсон, болсон явдлыг нийлмэл өгүүлбэрээр ярьдаг. Ухаалаг төхөөрөмжийн дүрс, тэмдэг, тэмдэглэгээг таньж, зориулалтаар хэрэглэдэг.
Өнгөт тэмдэглэгээ	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өнгөт тэмдэглэгээний зургийг тайлбарлах, ухаалаг төхөөрөмжийг зөв ашиглах (тод болгох, томруулах) туршилт	Ажлын хуудас, хүүхдийн сонгосон 2-3 зураг, гар утас	Зургийг яаж авсан, зураг авахад ямар санагдсан.	Шүүн тунгаах: Зургийн цомогт орсон зургийн тоо болон хамгийн олон өнгийг тоолж, дүнг нэгтгэх	Ухаалаг төхөөрөмжийн хэрэглээний эерэг, сөрөг нөлөөг тайлбарлан,

		хийх. Эрүүл мэндээ хамгаалах талаар хэлэлцэнэ.			Бүтээлчээр сэтгэх: Илтгэгч, зохиолч болж цомгоо бүтээлчээр танилцуулах	зохистой хэрэглэх цаг, дүрмийг мөрдөж, бусдад сануулдаг.
Би зураг авч сурлаа	Төвийн үйл ажиллагаа	Гэрэл зургийн цомог бүтээх, хавтасжуулж нэр өгөх, хуудсыг дугаарлах, цомгоо танилцуулна.	Хэвлэмэл зураг, цаас, эсгий бал, хайч, цавуу, өнгийн цаас	Гар утас удаан хугацаагаар үзэх нь сайн уу, муу юу? Хэдэн ширхэг зураг цомогт орсон байна? Зургийн цомогт ямар өнгө хамгийн олон байсан бэ?.	Бүтээлчээр сэтгэх: Сонгож хэвлүүлсэн зургаа ашиглан гэрэл зургийн цомог хамтран бүтээх Харилцах: Илтгэгч, зохиолч болж тоглохдоо цомгоо танилцуулах	Санаа бодлоо илэрхийлж, тайлбарладаг.
Би өнөөдөр	Тойргийн цаг	Мэдрэмж гэж юу болохыг ярилцах, өөрийн мэдрэмжтэй тохирох зургийг сонгож тайлбарлах, бусад нь хөдөлгөөнөөр илэрхийлнэ.	Мэдрэмж харуулсан зургууд	Өнөөдөр чи ямар мэдрэмжтэй байна вэ? Яагаад энэ зургийг сонгосон бэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Мэдрэмжийн нэрийг хэлэх, бусад нь түүнийг хөдөлгөөнөөр илэрхийлэх Харилцах: Мэдрэмж гэж юуг хэлж байгааг ярилцах. Өөрт тохирох зургийг сонгоод, яагаад сонгосноо тайлбарлах	Бусдын нөхцөл байдалд тохируулан энэрэх үйлдэл үзүүлдэг.
Өнгийн бөмбөлөг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Баримлын шавар (улаан, шар, хөх) ашиглан өнгө хольж, үүсмэл өнгө гаргах туршилт хийх, үр дүнгээ хуваалцана.	Баримлын шавар, ажлын хуудас	Баримлын шавраар өнгө үүсгэж болох уу? Баримлын шавраар өнгө үүсгэхэд усан будаг, гуашаар өнгө	Шүүн тунгаах: Улаан, шар, хөх өнгийн баримлын шаврыг хольж шинэ өнгө үүсгэх туршилт хийх Бүтээлчээр сэтгэх: Баримлын шавар болон будгаар өнгө үүсгэх ялгааг	Баримлын шаврыг байгалийн материалтай хослуулж сэдэвт баримал хийдэг.

				үүсгэхээс ямар ялгаатай байна вэ?.	харьцуулах Хамтран ажиллах: Хэрхэн өөр өнгө үүсэж байгааг найзууддаа тайлбарлах	
Өнгөөр дүрслээрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжмийн бүтээл сонсож, төсөөллөө өнгө, үгээр илэрхийлэх, үүсмэл өнгөтэй баримлын шавраар сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн бүтээл хийх. "Би (миний найз) баяртай байна. Учир нь..." гэж өгүүлбэрийг гүйцээж тайлбарлана.	Хөгжмийн бүтээл, баримлын шавар, мэдрэмж харуулсан зургууд	Юуг дүрсэлсэн байна вэ? Энэ аялгууг ямар өнгөөр дүрсэлж илэрхийлж болох вэ?.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Хөгжмийн аялгууны өнгө аясыг мэдэрч, тохирох мэдрэмжтэй холбож тайлбарлах Бүтээлчээр сэтгэх: Хөгжим сонссон төсөөллөөр баримлын шавраар сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн бүтээл хийх Харилцах: Багшийн эхэлсэн өгүүлбэрийг гүйцээж, өөрийн бүтээлтэй холбон тайлбарлах	Хөгжмийн энгийн зэмсгийг дуугаралтаар ялгаж, өнгө аясыг тодорхойлдог.

11 дугаар сарын I долоо хоног

ӨНГӨ ЯАГААД ОЛОН ЯНЗ БАЙДАГ ВЭ?

Шинэ үг: Урт, богино

Үйл ажиллагаа 1. Оролцох үе шат - Ажиглаад ярилцаарай (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Урт, богино өнгө өнгийн даавуун тууз (хүүхэд бүрд 2 ширхэг)

Аргачлал: Хүүхэд бүр 2 ширхэг тууз сонгож авна. Туузыг ажиглаж ярилцана. Ижил болон ялгаа гэсэн үгийг туузын өнгө, хэмжээг ярилцах явцад тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Туузууд бүгд ижил байна уу?
- Тэгвэл юугаараа ижил, юу нь өөр юм бол?
- Та нарын мэддэг ямар өнгө байна вэ?
- Бусдаас ялгаатай өөр өнгийн тууз байна уу?
- Хэрвээ бид улаан, шар, хөх өнгийг бусад өнгөтэй нийлүүлж үзвэл ямар ямар өнгө гарах бол?

Үйл ажиллагаа 2. Шинжлэн судлах үе шат - Ижлийг олж тэмдэглээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Урт, богино өнгө өнгийн даавуун тууз, ажлын хуудас, харандаа, гуаш, усан будаг, бийр

Аргачлал: Багт байгаа хүүхэд бүр сонгож авсан 2 ширхэг туузаа зэрэгцүүлж тавиад дараах чиглэлийн дагуу үйлдлийг гүйцэтгэж, ажлын хуудаст тэмдэглэгээ хийнэ.

1. Урт болон богино тууз хэд байгааг ангилж тоолоод, дүн тоог урт богино зураас зурж тэмдэглэнэ.
2. Өнгөөрөө ижил тууз байгаа эсэхийг харьцуулан ижилсүүлж, тоолоод дүнг тоог илэрхийлнэ.
3. Урт, богино туузын өнгөтэй ижил өнгийн гуаш, усан будаг сонгож, өнгийг нэрлээд тэмдэглэнэ. Ижил өнгө байхгүй тохиолдолд туршилт хийж өнгийг гаргана. Баг бүрээс хүүхдийн хариултыг сонсоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Урт (богино) тууз хэд байна вэ?
- Аль аль тууз ижил өнгөтэй байна вэ?
- Туузын өнгөтэй ижил өнгийн будаг байхгүй бол яаж тэмдэглэж болох вэ?

ӨНГӨ ХЭРХЭН ҮҮСДЭГ ВЭ?

Шинэ үг: Үндсэн, үүсмэл

Үйл ажиллагаа 1. Тайлбарлах ба нарийвчлан боловсруулах үе шат - Сонирхолтой туршилт (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Гуаш, бийр, хөвөн, будаг хийх сав, шилэн савтай ус, өнгөгүй слайд, эсгий бал, цагаан цаас, гар чийдэн, дугуй дүрс зурсан цаас

Аргачлал: Үндсэн 3 өнгийг нэрлэж хэлнэ.

Туршилт, танин мэдэхүйн төв: Өнгө өөрчлөгддөг болов уу? асуулт тавьж ярилцана. Улаан, шар, хөх 3 өнгийг хольж шинэ өнгө үүсгэх туршилт хийнэ. Хөвөнг бөөрөнхийлж хоёр өөр өнгөөр будаад, шилэн савтай усанд дүрж авна. Усны өнгө хэрхэн өөрчлөгдөхийг ажиглаж, ямар өнгө үүссэнийг ярилцаад, өнгөний дугуй дээр тэмдэглэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ямар ямар өнгийг сонгож авсан бэ?
- Энэ хоёр өнгө нь өөрчлөгдөх болов уу?
- Ямар өнгө болж хувирах бол?

Зураг урлалын төв:

Ангид байгаа тунгалаг зүйлсийг олж нэрлээд (гялгар уут, хуванцар сав, шилэн аяга, цонхны шил) шинж чанарыг тодорхойлж хэлнэ.

Өнгөгүй слайд дээр хэв ашиглан 2 дугуй дүрс зурж, хайчилна. Хоёр дүрсний нэгийг өнгийн эсгий балаар будаад, хоёуланд нь бариул хийнэ.

Өнгөтэй ба өнгөгүй 2 слайдаар юмсыг харж, ялгааг харьцуулна.

Цагаан цаас ба ханан дээр өнгөтэй, өнгөгүй слайдыг барьж, гэрэл тусган туршиж, ажиглана. (цонхоор тусах нарны болон гар чийдэнгийн гэрэл ашиглана.)

Хоёр өөр өнгийн слайдыг давхцуулж, шинэ өнгө үүсгэж тоглоно. Ялгааг харьцуулж, тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ангид өнгөгүй, тунгалаг зүйлс байна уу?
- Бусад зүйлсээс юугаараа ялгаатай байна вэ?
- Өнгөтэй ба өнгөгүй слайдаар юмсыг харахад ямар байсан бэ?
- Гэрэл тусахад өнгө өөрчлөгдөж байна уу?

Математикийн төв:

Ангийн орчноос ногоон (хөх, улбар шар, улаан, нил ягаан, саарал, бор) гэх мэт өнгийн зүйл олох даалгавар өгнө. Олсон зүйлсийг үндсэн, үүсмэл өнгөөр ангилна. Үүсмэл гэж ангилсан эд зүйлсээс нэгийг сонгож, ижил өнгө үүсгэх туршилт хийнэ. Туршилтын үр дүнг өнгөний дугуй дээр тэмдэглэж тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ямар ямар өнгийг холиход энэ өнгийг гаргаж болох вэ?

Дасгал ажлын дэвтэр: хуудас 18, дасгал №18

Үйл ажиллагаа 2. Үнэлэх үе шат - Өнгө өнгийн хөшөө (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн туузууд, өнгө өнгийн дүрс, хөгжмийн бүтээлийн бичлэг (багшийн урын санд байгаа бүтээлээс сонгож ашиглах), өнгөний дугуй

Аргачлал:

1. Өнгийн туузаас сонгож гартаа, энгэртээ уяж тогтооно. Хөгжим эхлэхэд анги дотор бүжиглэж явна. Тоглоом чиглүүлэгч өнгийн дүрсээс нэгийг сонгож өргөхөд ижил өнгийн туузтай хүүхдүүд нийлж ямар нэг хөшөөг дүрслэн хөдөлгөөнгүй зогсоно. Жишээлбэл: Улаан өнгө өргөвөл бүх улаан туузтай хүүхдүүд нийлж зогсох гэх мэт
2. Дахин хөгжим эгшиглэхэд тарж бүжиглээд, чиглүүлэгчийн өргөсөн өнгийг үүсгэх байдлаар 3 өнгө нийлж хөшөө болж зогсоно. Жишээлбэл: Ногоон өнгө өргөвөл шар, хөх, ногоон гурав нийлж зогсох гэх мэтчилэн тоглоомыг үргэлжлүүлнэ.
3. Тоглоом эхлэхийн өмнө туршилтын үр дүнг тэмдэглэж байсан өнгөний дугуйг хананд хоорондоо зайтай байрлуулсан байна. Ая эхлэхэд дахин бүжиглэж, ая зогсоход нэрлэсэн өнгийг үүсгэсэн өнгөний дугуйг олж очоод хөшөө болж зогсоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өмнө хийсэн туршилтаар өнгийг хэрхэн үүсгэж байсан бэ?
- Юу сурсан бэ?

ХАМТДАА ТОГЛОЦГООЁ

Шинэ үг: Уях, зангидах

Үйл ажиллагаа 1. Хувцас ч бас өнгөтэй (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: фото зураг, төрөл бүрийн хувцас, хувцасны бодит чимэглэл

Аргачлал: Найзуудаа ажиглаж ямар хувцас өмссөн болохыг хэлнэ. Тусгайлан бэлтгэж тавьсан хувцаснуудыг харж үндсэн болон үүсмэл өнгө, чимэглэлийг ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Бидний өмссөн хувцасны өнгө ижилхэн байна уу?
- Та нар ямар ямар өнгө харж байна?
- Үүсмэл өнгөтэй хувцас байна уу?
- Хувцсанд ямар чимэглэл хийсэн байгааг анзаарсан уу?
- Хэрвээ бид хувцасны загвар зохион бүтээгчид байсан бол ямар өнгийн хувцас хийхийг хүсэж байна вэ?

Үйл ажиллагаа 2. Бид зохион бүтээгчид (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: өнгө өнгийн тууз, төрөл бүрийн даавуу, том шүр, хавчаар, малгай, ороолт зэрэг тоглоомд ашиглаж болох хувцас, хувцасны өлгүүр, мөнгө

Аргачлал: Баг болж /нэг багт 4 хүүхэд/ ажиллана.

1. Дэлгүүр болж тоглоход хэрэгтэй зүйлсээ бэлтгэж, хэн юу хийхээ ярилцаж шийднэ.
2. Даавууны өнгийг хослуулж, хайчлахгүйгээр хувцас урлана.
3. Туузад шүр хэлхэх, тууз зангидах зэргээр хийсэн хувцас бүрийг туузаар чимэглэнэ. “Энэ бол бидний хийсэн ороолтын чимэглэл” гэх мэтээр бүтээлээ тайлбарлана.
4. Бүтээлээ дэлгүүрийн лангуун дээр байрлуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хувцасны дэлгүүрт ямар ямар өнгийн хувцас байвал хүмүүс худалдан авах бол?
- Хувцсыг гоё болгохын тулд ямар өнгийн туузаар чимэглэх вэ?

Үйл ажиллагаа 3. Манай дэлгүүр (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүүхдүүдийн бүтээсэн хувцаснууд, мөнгө

Аргачлал:

1. Хамтдаа ярилцаж, хэн ямар дүрд тоглохоо сонгоно.
2. Худалдагч, худалдан авагч болж тоглоно. Жишээлбэл:
Худалдагч: Сайн байна уу? Та ямар хувцас сонирхож байна вэ?
Худалдан авагч: Би ягаан өнгийн туузтай малгайг авъя. /нэг болон хэд хэдэн хувцас өмсөж үзээд сонголт хийж болно..гэх мэт/
Худалдагч: Манай дэлгүүрээр дахин үйлчлүүлээрэй. Баярлалаа.
3. Тоглоомын дараа юу хийсэн талаар санаа бодлоо хуваалцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ хувцас чамд таарах болов уу?
- Чи ямар дүрд тоглосон бэ?
- Хэрвээ чи худалдан авагч байсан бол ямар өнгийн хувцас худалдаж авах вэ?
- Дэлгүүр болж тоглоход юу нь хамгийн сонирхолтой байв?

Багшийн дэмжлэг: Хувцас худалдаж авахдаа өмсөж үзэх, толинд харж өнгөө сонгох хэрэгтэй талаар зөвлөгөө өгнө.

11 дүгээр сарын II долоо хоног

МИНИЙ ЭРГЭН ТОЙРОН ДАХЬ ӨНГӨ

Шинэ үг: Ухаалаг төхөөрөмж, дүрс тэмдэг тэмдэглэгээ

Үйл ажиллагаа 1. Оролцох үе шат - Ухаалаг төхөөрөмжтэй танилцъя (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Гар утас, зургийн аппарат, дасгал ажлын дэвтэр

Аргачлал: Зургийн аппарат, гар утас зэрэг хэрэгслийн нийтлэг зүйл нь юу болохыг асууна.

1. Гэрэл зургийн тухай яриа эхлүүлж асуултын дагуу ярилцана.
2. Гар утас, аппаратын ямар тэмдэглэгээ дээр дарж асааж унтраах, яаж зураг авах талаар таамаглалаа хэлнэ. өөрсдөө туршиж үзнэ.
3. Гар утас ашиглахдаа анхаарах санамжийг хамтдаа зохионо.
 - Гар утсыг хоёр гараараа барьж, болгоомжтой авна.
 - Зааврын дагуу зөв тэмдэг тэмдэглээ дээр дарж асааж, унтрааж, зураг авна.
 - Авсан зургаа ээж аавдаа үзүүлж, ямар өнгөтэй юуны зураг авснаа ярилцана гэх мэт

Багшийн чиглүүлэх асуулт:

- Эдгээр зүйлс юугаараа адилхан юм бол?
- Гар утас, аппаратаар зураг авч байсан уу?
- Гар утсаар яаж зураг авах вэ?
- Утасны зураг авахаас өөр тэмдэглэгээ дээр дарчихвал юу болох бол?
- Гар утсыг удаан хугацаагаар хэрэглэвэл яах вэ?

Дасгал ажлын дэвтэр: хуудас 19, дасгал №19

Үйл ажиллагаа 2. Шинжлэн судлах үе шат - Миний эргэн тойронд (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: гар утас, өнгө өнгийн дүрс /хүүхдийн тоогоор/, өнгийн бөмбөг

Аргачлал: Өмнөх өдөр нь эцэг эх, асран хамгаалагчдад зугаалгын цагт оролцохыг урьсан зар хүргүүлнэ.

1. Цэцэрлэгийн хашаанд алхаж байхдаа эргэн тойрны юмсын өнгийг анхааралтай ажиглаарай. Хэсэг хугацааны дараа ажигласан зүйлээ ярилцана.
2. Багшийн урьдчилж бэлтгэсэн өнгийн дүрсээс хүүхэд бүр нэгийг сонгож авна. Сонгож авсан өнгөтэй ижил өнгийн 5 ширхэг эд юмс болон тэмдэг тэмдэглэгээний зургийг гэр бүлийнхэнтэйгээ хамтарч гар утас ашиглан авна.

Хэрэв хүүхдийн гэр бүлийн гишүүдээс ирээгүй тохиолдолд дараах хувилбаруудаас сонголт хийж болно.

Хувилбар 1: Бүлгийн багш, багшийн туслахын гар утсыг ашиглан хүүхдийн сонгосон өнгөтэй зүйлсийн зургийг авна.

Хувилбар 2: Цэцэрлэгтээ ирэх, гэртээ харих замдаа гэр бүлийн гишүүдтэй хамтран сонгосон өнгийн эд юмсын болон тэмдэг тэмдэглэгээний зураг авч ирэх даалгавар өгнө. Зураг авахдаа гар утас, зургийн аппаратаас сонгож болно.

“Бөмбөг дамжуулъя” тоглоом тоглоно. Тоглоомд оролцогчдын хувцасны өнгөө шалтгаалж өнгийг нэрлэнэ.

- Улаан өнгийн бөмбөгийг зөвхөн улаан хувцастай хүүхэд рүү дамжуулна.
 - Даалгаврыг өөрчилнө. Жишээ нь: шар бөмбөгийг зөвхөн хөх хувцастай хүүхэд барина гэх мэтээр дүрмийг өөрчилнө.
 - Ногоон бөмбөгийг бүх хүүхдүүд толгой дээгүүрээ арагш дамжуулна.
 - Тоглоомын дараа модны унасан жижиг мөчир түүж ангидаа авч орно.
3. Цэцэрлэгээс гэртээ харьсан үед гар утас ашиглан /таблет, зургийн аппаратаар зураг авсан байж болно/ авсан зургийг гэр бүлийн гишүүд хамтдаа үзэж, хүүхдийн сонгосон 2-3 зургийг файлаар багшид илгээж, хүүхдэд хэвлэж өгнө.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хэрвээ дэлхий дээр нэг л өнгө байсан бол ямар байх бол?
- Ямар өнгө хоорондоо адилхан харагддаг вэ?
- Ногоон өнгөтэй ямар зүйлс мэдэх вэ?

Дасгал ажлын дэвтэр: хуудас 23, дасгал №23

Үйл ажиллагаа 3. Тайлбарлах үе шат - Миний дуранд (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Проектор, компьютер, дэлгэц, телевизор, ажлын хуудас (нэг ажлын хуудсанд тодоос бүдэг рүү уусгасан нэг төрлийн өнгө байна.) хүүхдийн сонгосон 2-3 зураг (файл болон хэвлэмэл)

Аргачлал:

1. **Хэл яриа-Номын төв:** 3-5 хүүхэд нэг баг болж, авсан зургаа харуулж “Ямар хэрэгслээр зураг авсан?”, “Ямар ямар зураг авсан бэ?”, “Яагаад үүнийг сонгож авсан бэ?” зэрэг асуултын дагуу ярилцана.
2. **Зураг урлалын төв:** Хэл яриа-Номын төвийн үйл ажиллагаатай зэрэгцээд өөрийн авсан эд юмсын зургийг ажлын хуудсанд зурна. /1, 2, 3, 4, 5 цифрийн дараагийн хүснэгтэд гэрэл зургийг нь авсан эд юмсыг дүрсэлж зурна./
3. **Математикийн төв:** Ажлын хуудас дээр ямар өнгийн, хэдэн эд юмсын зураг авснаа тэмдэглэнэ.

Ажлын хуудас. /өнгө бүрээр гаргасан байна./

№	Өнгө				
1					
2					
3					
4					
5					

-Улаан, шар, хөх өнгийг дасгал ажлын дэвтрийн 10 дугаар хуудасны дасгал №5-тай харьцуулан хараарай.

Өөрийн авсан эд юмсын зургийг тухайн өнгө бүртэй зэрэгцүүлэн харж, өнгө нь тохирч буй хүснэгтэд тэмдэглэнэ.

- Авсан зургаа тоолж, дүн тоог цифр эсвэл зураасаар зурж тэмдэглэнэ.

Багшийн дэмжлэг: Хүүхдийн авсан зургийн хөх өнгө яагаад өөр өөр байгаа тухай асууж, учир шалтгааныг ярилцана.

Үйл ажиллагаа 4. Нарийвчлан боловсруулах үе шат - Өнгөт тэмдэглэгээ (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ажлын хуудас, хүүхдийн сонгосон 2-3 зураг (файл болон хэвлэмэл), гар утас

Аргачлал:

1. Бие биеийнхээ тэмдэглэсэн ажлын хуудсыг үзэж зургийг хэрхэн авсан, зураг авахад ямар санагдсан талаар ярилцана.

2. Хүүхдийн авсан өнгөт тэмдэглэгээний зургийг дэлгэцээр (телевизор, проектор) харуулж, ямар төрлийн зураг болохыг тайлбарлана. (замын тэмдэглэгээ...гэх мэт) Гар утас, аппаратаар зураг авахдаа дэлгэцдээ бүтэн оруулах, тухайн дүрс дээр тогтоож тод болгох, зургийн хэмжээг томруулахыг багш хүүхэд хамтран туршиж найзууд болон ангийн орчны зургийг авна.

3. Ухаалаг төхөөрөмжийг удаан хугацаагаар үзэхгүй байх, дасгал хөдөлгөөн хийх, гадаа тоглох, зугаалах гэх мэт эрүүл мэндээ хамгаалж болох талаар хэлэлцэнэ.

Үйл ажиллагаа 5. Үнэлэх үе шат - Би зураг авч сурлаа (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: хүүхдийн сонгосон 2-3 хэвлэмэл зураг, цаас, эсгий бал, хайч, цавуу, өнгийн цаас

Аргачлал: Нэг багт 6-8 хүүхэд байна.

Зураг урлалын төв: Сонгож хэвлүүлсэн 2-3 зургаа ашиглан гэрэл зургийн цомог хамтран бүтээнэ.

Хэл яриа-Номын төв: Зургийн цомгоо хавтасжуулж, нэр өгнө.

Математикийн төв: Зургийн цомгийн хуудсыг дүрс (цэг, зураас)-ээр дугаарлана.

Тоглоомын төв: Илтгэгч, номын зохиолч болж тоглохдоо гэрэл зургийн цомгоо харуулж (хэдэн ширхэг зураг орсон, ямар өнгө хамгийн олон байна, зураг хэрхэн авсан болон зургийн аппарат, гар утсыг хэрхэн ажиллуулж сурсан) танилцуулна.

Дараагийн үйл ажиллагаанд ашиглахаар, зургийн цомгоо хэл яриа-номын төвд байршуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- “Гар утас удаан хугацаагаар үзэх нь сайн уу, муу юу?
- Хэдэн ширхэг зураг цомогт орсон байна вэ?
- Зургийн цомогт ямар өнгийн эд зүйлсийн зураг хамгийн олон байсан бэ?

Дасгал ажлын дэвтэр: хуудас 21, дасгал №21

НАЙЗТАЙГАА ХАМТ

Шинэ үг: Мэдрэмж, ичих, айх, тэнцүү

Үйл ажиллагаа 1. Би өнөөдөр (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Мэдрэмж харуулсан зургууд

Аргачлал: Мэдрэмж гэж юуг хэлж байгааг ярилцана (баярлах, гуниглах, айх, уурлах, инээх, ичих зэрэг нь бүгд мэдрэмж). Мэдрэмжийн зургуудыг ажиглаж, өөрт тохирох нэг зургийг сонгоно. Өнөөдөр ямар мэдрэмжтэй байгаа талаар тайлбарлаж ярилцана. Хүүхэд мэдрэмжийн нэр хэлнэ, бусад нь хөдөлгөөнөөр (инээх, уурлах..) илэрхийлнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өнөөдөр чи ямар мэдрэмжтэй байна вэ?
- Яагаад энэ зургийг сонгосон бэ?

Үйл ажиллагаа 1. Өнгийн бөмбөлөг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Баримлын шавар, ажлын хуудас

Аргачлал:

1. Улаан шар /шар, хөх, болон хөх улаан/ өнгийн баримлын шаврыг тэнцүү хэмжээтэй 5-6 хэсэг болгоно.
2. Улаан өнгийн баримлын шавар дээр шар өнгийн жижиг баримал хольж, үүссэн өнгийн баримлаас таслан тэмдэглэсэн цаасан дээр наана.
3. Үүссэн өнгийн баримал дээр дахин жижиг шар баримлыг хольж, үүссэн өнгийн баримлаас таслан тэмдэглэсэн цаасны хоёр дахь нүдэнд наана. Үргэлжлүүлэн 3 удаа шар өнгө холино.
4. Хоёр өөр өнгийн баримлын шавар ашиглан хэрхэн шинэ өнгө үүсгэсэн талаар туршилтын үр дүнгээ хуваалцана. Баримлын шавраа хэрхэн тааруулбал өөр өнгө үүсэж байгааг тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Баримлын шавраар өнгө үүсгэж болох уу?
- Баримлын шавраар өнгө үүсгэхэд усан будаг, гуашаар өнгө үүсгэхээс ямар ялгаатай байна вэ?

Үйл ажиллагаа 2. Өнгөөр дүрслээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн бүтээл, баримлын шавар, мэдрэмж харуулсан зургууд

ЗУ4.3а	Эд юмсыг зохиомжлон барьдаг.						+
ХЯ4.2г	Харилцан уялдаатай нийлмэл өгүүлбэрээр ярьдаг			+			

Аргачлал: Хөгжмийн бүтээл сонсоно. Сонссоноо өнгө болон үгээр илэрхийлж ярилцана. Хөгжим сонссон төсөөллөө бодож, өнгө үүсгэсэн баримлын шавраар сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн бүтээл хийнэ. Бүтээлээ танилцуулна. Өгүүлбэрийг багш эхэлнэ. “Би (миний найз) баяртай (гунигтай, хөгжилтэй, ууртай гэх мэт) байна. Учир нь ...”. Хүүхэд өгүүлбэрийг гүйцээж, өөрийн бүтээлтэй холбон тайлбарлана. Асуултын дагуу ярилцаж, анх сонгосон мэдрэмжтэйгээ харьцуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Юуг дүрсэлсэн байна вэ?
- Энэ аялгууг ямар өнгөөр дүрсэлж (илэрхийлж) болох вэ?
- Сая бидний хийсэн мэдрэмжийн зургуудаас аль нь энэ аялгуунд тохирох

Сонсьё, дэмжье

- Хүүхдэд өнгийг таних боломж олгож үүсмэл өнгө үүсгэх дасгалыг чөлөөтэй гүйцэтгүүлээрэй.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Үзсэн, харсан, оролцсон үйл явдлынхаа тухай ойлгомжтой логик дараатай, төсөөлж зохиомжлох, бодол санаагаа нийлмэл өгүүлбэрээр илэрхийлж сурахад нь багштай хамтран ажиллана.
- Хөгжимдөх боломжийг олгож, дэмжиж, зоригжуулах
- Хүүхэдтэй хамт өнгө үүсгэж тоглох
- Хамтдаа баримал, наамлаар урлаж бусдад бэлэглэх

Багшийн эргэцүүлэмж

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн:</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p>

ХӨГЖИМЧИН НАЙЗУУД

Хүүхдийн эзэмших чадамж:

Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санаа, төсөөллийг зургаар илэрхийлэх

Шүүн тунгаах: Юмсын ялгаа, ижил төстэй байдлыг ажиглах, харьцуулах, ангилах, асуудал шийдэх

Харилцах: Сэдвийн хүрээнд ярилцаж, санаа бодлоо илэрхийлэх

Суралцахууд суралцах: Сонирхсон зүйлээ асуух, төвлөрөх

Нийгэм, сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох, зөрчилдөөнийг шийдэх

Хамтран ажиллах: Багаар ажиллаж, бусдадаа хүлээцтэй хүндэтгэлтэй хандах

Аюулгүй байдлын зөвлөмж:

- Төмөр, мод, чулуу зэрэг эд зүйлсийг ашиглахдаа хамгаалалтын бээлий, хормогч, ханцуйвч бэлтгэн ашиглаарай.
- Цахим ном ашиглаж байгаа тул хүүхдийг дэлгэцээс зайтай суулгаарай.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Тухайн өдөр, долоо хоногт юу хийх, өөрийн болон бусдын сэтгэлийн мэдрэмж ямар байгаа талаар ярилцаарай.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Зохиолын дүр, үйл явдлын дарааллыг барих, урлаж бүтээх зэргээр өөрийн төсөөллийг бүтээлээр илэрхийлэх
- Юмсыг шинж чанараар нь ангилж тоолох, зохион бүтээх, турших, ярилцахад нь дэмжээрэй.

Төвийн үйл ажиллагаа:

- Хүүхдийн хийх зүйлийг ажиглаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт чиглүүлэг өгч идэвхжүүлээрэй.

Номын цаг:

- Цахим номыг [Let's Read | Children's Books | Free to Read Download Translate](#) ашиглан зохиолыг уншиж өгөөрэй. Зохиолын дүрүүдийн сэтгэлийн мэдрэмжийг таатай, таагүй байгааг онцолж ярилцаарай.

Хөгжөөн баясах цаг:

- Зохиолоор жүжигчилсэн тоглолт бэлдэхэд нь дэмжлэг үзүүлж, хүүхэд бүрийг оролцуулахад анхаараарай.

Боломжууд:

- Зохиолын эхлэл, өрнөл, төгсгөл гэсэн байдлаар загвар гаргаж хөгжүүлээрэй.
- Хүүхдээс гарч буй санаа, бодож төсөөлөн хийсэн зүйлийг нь дэмжиж, үйл ажиллагаандаа тусган ашиглаарай.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>ХЯ4.2а. Тодорхой сэдвээр санаа бодлоо илэрхийлж, идэвхтэй ярилцана.</p> <p>НСХ4.2а. Бусдын сэтгэлийн мэдрэмж нь таатай, таагүй байгааг тайлбарладаг болно.</p> <p>ЗУ4.3а. Баримлын шаврыг байгалийн материалтай хослуулж сэдэвт баримал барина.</p>	<p>- Сэдвүүдээс чөлөөтэй сонгуулан, ярилцлага өрнүүлэх, харилцан яриаг үргэлжлүүлэн ярилцах тоглоом тоглох</p> <p>- Найзуудын хооронд таатай, таагүй зүйлс нь ялгаатай байгаа талаар ярилцах</p> <p>- Үлгэр, өгүүллэг сонсоод өөрийн сонгосон дүрийг баримлаар бүтээх</p>	Хөгжийн наадам

<p>ХЯ4.2а. Тодорхой сэдвээр санаа бодлоо илэрхийлж, идэвхтэй ярилцана.</p> <p>ХӨГ4.1в. Аялгуу, хэмнэлийн дагуу хамтран хөгжимдөнө.</p>	<p>- Сэдвүүдээс чөлөөтэй сонгуулан, ярилцлага өрнүүлэх, харилцан яриаг үргэлжлүүлэн ярилцах тоглоом тоглох</p> <p>- Аялгуунд тохируулан 2-3 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр багаараа хөгжимдөх</p>	<p>Үлгэр ба хөгжим</p>
<p>БНО4.1в. Ойр орчны эд юмс, тоглоомын материалын шинж чанарыг (төмөр, цаас, шил, даавуу, мод, чулуу) ялгаж, нэрлэнэ.</p> <p>ЗУ4.3в. Тоглоом болон байгалийн материал, дахин ашиглах материалаас сонгож шинэ загвар бүтээнэ.</p> <p>МАТ4.1а. 20 хүртэлх тоог цээжээр тоолох, 10 хүртэлх тооны юмсыг оноож тоолох, тоог таних, өгсөн тооноос эхэлж 1-ээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, тоог жишнэ. (бодит юмсын олон, цөөнийг ялгаж жиших)</p>	<p>- Бүлгийн орчноос төмөр, цаас, шил, даавуу, мод, чулуу зэрэг янз бүрийн материалаар хийгдсэн эд зүйлс (Жишээ нь: Түлхүүр, цаасан аяга, жижиг шилэн сав, даавуун алчуур, модон блок, жижиг чулуу)-ийг цуглуулах, материалын шинж чанарыг тодорхойлох, ангилан ялгах тоглоом тоглох</p> <p>- Зохион бүтээх үйлд ашиглах материал, багаж хэрэгсэл, тоглоомоо бие даан сонгож хэрэглэх</p> <p>- 10 хүртэлх юмсыг (модон савхыг өрж байрлуулах, бөмбөгийг дамжуулахдаа 1, 2, 3, 4... тоолох гэх мэт) оноож тоолох</p>	<p>Харилцуур утас</p>
<p>ХЯ4.2д. Үйл явдлыг төсөөлж, зохиож ярина.</p> <p>НСХ4.2в. Үүссэн зөрчилдөөнийг багшийн чиглүүлэгтэйгээр тустай зан үйлээр шийддэг болно.</p> <p>ЗУ4.2а. Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон зурна.</p>	<p>- Ном, үлгэр зохиолын үйл явдлын төгсгөлийг үргэлжлүүлэн төсөөлж, зохиож ярих</p> <p>- Уур ямар хор уршигтайг үлгэр, зохиол, сургамжит өгүүллэг, зүйр цэцэн үг сонсож (уул морийг зовооно, уур биеийг зовооно) ярилцах</p> <p>- Үлгэрийн үйл явдлыг зохиомжлон зурах</p>	<p>Шоо ба амьтад</p>
<p>ХӨГ4.1в. Аялгуу, хэмнэлийн дагуу хамтран хөгжимдөнө.</p> <p>БНО4.1в. Ойр орчны эд юмс, тоглоомын материалын шинж чанарыг (төмөр, цаас, шил, даавуу, хуванцар, мод, чулуу) ялгаж, нэрлэнэ.</p>	<p>- Аялгуунд тохируулан 2-3 хүүхдийн бүрэлдэхүүнтэйгээр багаараа хөгжимдөх</p> <p>- Анги доторх эд зүйлс (ширээ, сандал, харандаа, ном, цонх, хаалга)-ийг зааж, "Энэ юугаар хийсэн бэ?" гэсэн асуултын хүрээнд ээлжлэн асууж тоглох</p>	<p>Ямар чимээ гарсан бэ?</p>
<p>НСХ4.2а. Бусдын сэтгэлийн мэдрэмж нь таатай, таагүй байгааг тайлбарладаг болно.</p> <p>МАТ4.1б. Тоглоом, дүрсүүдээр зүй тогтол үүсгэн тайлбарлана. 10 хүртэлх тооны дарааллаас орхигдсон тоог тодорхойлно.</p> <p>ХЭМ4.1м. Бөмбөгийг хана руу шиднэ, барьж авна.</p>	<p>- Найзуудын хооронд таатай, таагүй зүйлс нь ялгаатай байгаа талаар ярилцах</p> <p>- Зүй тогтол зохиож тайлбарлах</p> <p>- Гар, хөлийн нарийн хүндэвтэр хөдөлгөөнүүдийг ойлгож гүйцэтгэх</p> <p>- Босоо болон хэвтээ бай руу 2м зайнаас бөмбөг шидэх</p>	<p>Хөгжилтэй царай</p>

12 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Бидний 7 хоног	Тойргийн цаг	Тухайн 7 хоногт юу хийх, сэтгэлийн мэдрэмж, найзыгаа гомдоохгүй байх, гомдоовол уучлал гуйх тухай ярилцана.	Самбар	Та нар цэцэрлэгтээ юу хийхийг хүсэж байна вэ? Найзуудтайгаа эвтэй, найртай байж чадаж байгаа юу? Хэрэв найзыгаа гомдоовол яах хэрэгтэй вэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох, зөрчилдөөнийг шийдэх Харилцах: Тодорхой сэдвийн хүрээнд ярилцаж, өөрийн санаа бодлоо илэрхийлэх	Тодорхой сэдвийн хүрээнд харилцан ярианд оролцож, өөрийн санаагаа илэрхийлдэг. Зөрчилдөөнийг эерэг аргаар шийдэх шийдлийг багшийн чиглүүлэгтэйгээр гаргадаг.
Хамтдаа сонсьё	Номын цаг	“Хөгжмийн наадам” зохиолыг уншиж, дүрүүдийн сэтгэлийн мэдрэмж (таатай, таагүй) ямар байсан талаар ярилцана. Шинэ үгсийн утгыг (Гомдох, таатай/таагүй мэдрэмж, уучлалт гуйх) зурагт картаар тайлбарлана.	Дэлгэц, зохиол, зурагт карт	Яагаад мэлхий уурласан бэ? Галуу найзаасаа уучлалт гуйж чадсан уу? Найзууд эвлэрэхийн тулд юу юу хийсэн бэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Бусдын сэтгэлийн мэдрэмжийг тодорхойлж, таатай, таагүйг ангилан тайлбарлах Суралцахууд суралцах: Зохиолыг анхааралтай сонсох, сонирхсон зүйлээ асууж, төвлөрөх	Бусдын сэтгэлийн мэдрэмжийг тодорхойлж, таатай, таагүй гэж ялгадаг.
Амьтад бүтээж ярилцъя	Чиглүүлэгтэй тоглоом	Зохиолын дүрүүдээс сонгож, баримлын шавар болон бусад материалаар зохиомжлон бүтээх. Бүтээсэн дүрийнхээ талаар мэдрэмж төсөөллөө дүрслэн ярина.	Баримлын шавар, хулдаас, хутга, хормогч, ханцуйвч, аргачлал	Бүтээл хийж тайлбарлана.	Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санааг янз бүрийн аргаар илэрхийлэх Харилцах: Бүтээсэн дүрийнхээ талаарх төсөөлөл, мэдрэмжээ дүрслэн ярих	Баримлын шаврыг байгалийн материалтай хослуулан амьтны дүр төрхийг зохиомжилдог.
Найзуудын адал явдал	Чиглүүлэгтэй тоглоом	Зохиолыг сонсоод, хүүхэд бүр ажлын хуудсанд зохиолын эхлэл, өрнөл, төгсгөлийг өөрийн бодол	“Хөгжмийн наадам” том ном, ажлын хуудас, балын/өнгийн/тосон харандаа.	Бодол төсөөллөө дүрсэлж зурна, ярина..	Бүтээлчээр сэтгэх: Үлгэрийн үйл явдлыг зохиомжлон зурж, бодит	Сэдвийн хүрээнд уялдаатай, зохиомжид байгаль, цаг агаарын

		төсөөллөөр дүрсэлж зурна.			төсөөллөө бүтээлээр илэрхийлэх Харилцах: Үйл явдлыг бүтээлчээр төсөөлж, зохиож ярих, зурсан зургаа тайлбарлах	нөхцөл байдлыг тодорхой тусгаж зурдаг. Үйл явдлыг бүтээлчээр төсөөлж, эхлэл-өрнөл-төгсгөлийг харуулж, зохиож ярьдаг.
Зохиолын дүрүүдийг хэмнэлээр илэрхийлье	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд үлгэрийн дүрээр баг болж, багшийн дохионы дагуу мэлхий-бөмбөр, туулай-шигшүүр, баавгай-дуут мод, галуу-гурвалжин төмрөөр хэмнэл тоглоно.	Шигшүүр, бөмбөр, дуут мод, шагшуур, дүрүүдийн зурагт карт, наалтууз	Хэмнэл тоглоно.	Хамтран ажиллах: Багаараа ажиллаж, бусдадаа хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах Суралцахууд суралцах: Багшийн чиглүүлгээр хэмнэлийг тоглохдоо анхааралтай сонсох, төвлөрөх	Дууг дуулахдаа хөгжмийн хамсраатай зэрэг эхэлж зэрэг төгсгөдөг. Хамтлагаар хөгжимдөх үедээ бусдадаа хүлээцтэй, хүндэтгэлтэй ханддаг.
Бидний эргэн тойронд	Чиглүүлэгтэй тоглоом	Орчны эд зүйлсийг (төмөр, цаас, шил, даавуу, мод, чулуу) цуглуулж, юугаар хийснийг нэрлэх, таамаглах, ангилах. 3 хүүхэд нийлүүлж, хэд байгааг оноож тоолно.	Төрөл бүрийн жижиг эд зүйлс, ангилж хийх хайрцаг	Бидний эргэн тойронд юу байна вэ?; Эд зүйлсийг юугаар хийсэн болохыг таамаглаж, нэрлэнэ.	Шүүн тунгаах: Эд зүйлсийн ялгаа, ижил төстэй шинж чанарыг (материалыг) ажиглах, харьцуулах, ангилах Суралцахууд суралцах: Сонирхсон зүйлээ асуух	Эд юмсын материалыг таньж нэрлэдэг. 20 хүртэл юмсыг тоолж, хоёр бүлэг юмсыг жишиж харьцуулдаг.
Байна уу?	Чиглүүлэгтэй тоглоом	Цаасан аяга, ноосон утсаар харилцуур утас зохион бүтээх. Хосоороо харилцан ярилцаж тоглохдоо, хол, ойр зай, утсыг чангалах/суллах үед дуу хэрхэн сонсогдож буйг туршина.	Цаасан аяга, 2-3м ноосон утас, хуванцар зүү, скоч, амьтдын зурагт карт	Бүтээл хийнэ.	Бүтээлчээр сэтгэх: Дахин ашиглах материалаас сонгож шинэ загвар бүтээх Харилцах: Хийсэн бүтээлээ ашиглан хоорондоо ярилцаж тоглох	Дахин ашиглах материалаас сонгож шинэ загвар бүтээдэг. Эд юмсын материалыг ижил болон ялгаатай шинжээр нь ангилдаг.
Эд зүйлсийг олоорой	Чиглүүлэгтэй тоглоом	Хуванцар, төмөр, мод, шил, даавуу гэх мэт материал бүхий зурагт картыг ашиглан, ангидаа	Зурагт карт (эд зүйлс, материал), наалтууз	Эд зүйлсийг материалыг олж наана.	Шүүн тунгаах: Эд зүйлсийг материалаар нь ялгаж нэрлэх, ижил болон	Эд юмсын материалыг ижил болон ялгаатай шинжээр нь ангилдаг.

		хайгуул хийж, тохирох эд зүйлсийг олж наана. Олсон зүйлээ хэд байгааг тоолно.			ялгаатай шинжээр нь ангилах Суралцахууд суралцах: Хийсвэр бодит зүйлстэй ижилсүүлэн байрлуулах, тооцоололд төвлөрөх	20 хүртэл юмсыг тоолдог.
Сонирхолтой шоо	Чиглүүлэгтэй тоглоом	Шоо хийх загварын дагуу хайчилж, наах (тэгш хэмтэй наахад дэмжлэг үзүүлэх). Шоог орхиж буулгаад, амьтны дүрийн онцлог шинжийг тодорхойлж ярилцана.	Шоо хийх загвар, хайч, цавуу, үлгэр/амьтдын зураг	Шоо хаяж тоглоно.	Бүтээлчээр сэтгэх: Загвар ашиглан шинэ загвар бүтээх Харилцах: Шоо буусан дүрийн онцлог шинжийг тодорхойлон, идэвхтэй ярилцлагад оролцох	Үйл явдлыг бүтээлчээр төсөөлж, утга уялдаатай зохиож ярьдаг. Сэдвийн хүрээнд зохиомжлон зурдаг.
Хамтдаа үлгэр ярьцгаая	Номын цаг	“Хөгжмийн наадам” зохиолыг цахим болон хуруун хүүхэлдэй ашиглан хүүхдүүд үргэлжлүүлэн зохиож ярина. (Эхлэл, өрнөл, төгсгөлийг нь гаргах)	Хуруун хүүхэлдэй (туулай, баавгай, галуу, мэлхий), аяга, халбага, лааз, хувин, мөчир	Үлгэрт ямар үйл явдал гарсан бэ? Найзууд муудалцахгүй байж болох байсан уу? Үлгэр цаашаа хэрхэн үргэлжлэх бол? Амьтдаас асуулт асуух боломж олдвол ямар асуулт асуух байсан бэ?	Харилцах: Үлгэрийн үйл явдлыг бүтээлчээр төсөөлж, утга уялдаатайгаар зохиож ярих Бүтээлчээр сэтгэх: Зохиолын төгсгөлийг хэрхэн өөрчлөх талаар бодож, төсөөлөн зохиох	Үйл явдлыг бүтээлчээр төсөөлж, утга уялдаатай, эхлэл-өрнөл-төгсгөлийг харуулж, зохиож ярьдаг.
Номын тэмдэглэл	Чиглүүлэгтэй тоглоом	Зохиолын үйл явдлаас хамгийн таалагдсан хэсэг болон сурч авсан зүйлээ ажлын хуудсан дээр зурж дүрсэлнэ. Зургийнхаа учир шалтгааныг тайлбарлаж ярина.	Ажлын хуудас, өнгийн харандаа, балын харандаа	Зурсан зүйлээ тайлбарлана.	Бүтээлчээр сэтгэх: Зохиолын үйл явдлыг зургийн аргаар илэрхийлэх Харилцах: Зурсан зургийнхаа учир шалтгааныг тайлбарлан ярих	Сэдвийн хүрээнд зохиомжлон зурдаг. Үйл явдлыг бүтээлчээр төсөөлж, зохиож ярьдаг.

Юунаас чимээ гардаг вэ?	Чиглүүлэгтэй тоглоом	Зохиолд гарсан эд зүйлсээс (хувин, лааз, халбага, аяга, мөчир) ямар дуу чимээ гарч байсныг дуугаргаж үзэх. Хос хосоороо хаалтын 2 талд зогсож, эд зүйлийн дуу чимээг таалгаж тоглоно.	Хувин, модны мөчир, лааз, халбага, аяга, энгийн хөгжмийн зэмсгүүд, картон хаалт	Гарсан чимээнүүд хоорондоо ялгаатай байсан уу? Яагаад?	Шүүн тунгаах: Эд зүйлсийн дуу чимээний ялгааг харьцуулан ярилцах Суралцахууд суралцах: Чимээнд анхааралтай төвлөрч, дуу чимээг таних, ажиглах	Эд юмсын материалыг ижил болон ялгаатай шинжээр нь ангилдаг.
Миний сонгосон дүр	Хөгжөөн баясах цаг	“Хөгжмийн наадам” зохиолоос дүрээ сонгож, маск/шуум ашиглан жүжигчилсэн тоглолт бэлдэж, жүжигчлэн тоглоно.	“Хөгжмийн наадам” зохиолын дүрүүдийн маск, шуум	Жүжигчилсэн тоглолт бэлдэнэ.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Дүрийн сэтгэл хөдлөл, дуу хоолойн өнгийг гаргаж, мэдрэмжийг тайлбарлах Хамтран ажиллах: Баг болон дүрийн хувиар хамтран ажиллаж, жүжигчилсэн тоглолт зохион байгуулах	Бусдын сэтгэлийн мэдрэмжийг таатай, таагүй гэж ангилдаг. Хамтлагаар хөгжимдөх үедээ бусдадаа хүлээцтэй ханддаг.
Сэтгэл хөдлөл	Төвийн үйл ажиллагаа	Хэл яриа- Номын төв: Сэтгэл хөдлөлийн зурагт картаар ярилцах, ижил/ялгаатай сэтгэл хөдлөлийг тодорхойлно. Зураг, урлалын төв: Сэтгэл хөдлөлийн хүрд бүтээж, нүүрний хувирлаар илэрхийлнэ. Математикийн төв: 10 хүртэлх тооны дарааллаас орхигдсон тоог нөхөж бичих ажлын хуудас бөглөнө.	Сэтгэл хөдлөлийн зураг, хүрд хийх хэрэглэгдэхүүн, зүй тогтлын карт, ажлын хуудас	Төвүүдэд ажиллана.	Нийгэм, сэтгэл хөдлөл: Бусдын сэтгэлийн мэдрэмжийг тодорхойлж, өөрийн сэтгэл хөдлөлөө удирдан зохицуулах Шүүн тунгаах: Орхигдсон тоог нөхөж, зүй тогтол үүсгэн тайлбарлах	Бусдын сэтгэлийн мэдрэмжийг тодорхойлж, таатай, таагүй гэж ялгадаг. Юмсын зүй тогтлыг үүсгэж, орхигдсон тоог нөхдөг.
Байг онож тоглоё	Хөгжөөн баясах цаг	Бөмбөгөөр байг онож тоглоно. Бөмбөгийг шидэх, барьж авах.	Бөмбөг, бай.	Бөмбөгөөр тоглоно.	Суралцахууд суралцах: Бөмбөг шидэх аргачлал	Бөмбөгийг бие бие рүүгээ шиднэ, газарт ойлгож барьж авдаг (1.5-2м зайд).

					болон байг оноход анхаарлаа төвлөрүүлэх Хамтран ажиллах: Тоглоомын талбайд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, ээлжээ хүлээх	
Үлгэрийн баатрууд	Хөгжөөн баясах цаг (Жүжиг)	Дүр сонгосон хүүхдүүд үлгэрийн үйл явдлын дагуу дүрээ бүтээн, жүжигчилсэн тоглолт хийнэ. Бусад хүүхдүүд үзнэ.	Хувцас (туулай, баавгай, галуу, мэлхий), хөгжмийн зэмсэг хийх зүйлс, ая шуум.	Жүжигчилсэн тоглоно.	Хамтран ажиллах: Дүрээ бүтээх, тоглолтыг зохион байгуулах явцад бусдадаа хүлээцтэй, хүндэтгэлтэй хандах Нийгэм, сэтгэл хөдлөл: Зохиолоор дамжуулан зөрчилдөөний талаар ярилцах	Сэтгэлийн мэдрэмжийг тодорхойлж ялгадаг. Хамтлагаар хөгжимдөх үедээ бусдадаа хүлээцтэй ханддаг.

12 дугаар сарын I долоо хоног

ХӨГЖМИЙН НААДАМ

Шинэ үг: Гомдох, уучлалт гуйх

Үйл ажиллагаа 1. Бидний 7 хоног (Тойргийн цаг)

Аргачлал: Тухайн өдрийн он, сар, өдрийг ярилцаж самбарт тэмдэглэнэ. Бид энэ 7 хоногт юу хийх вэ? сэдвийн хүрээнд ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Та нар цэцэрлэгтээ юу хийхийг хүсэж байна вэ?
- Найзуудтайгаа эвтэй, найртай байж чадаж байгаа юу?
- Хэрэв найзыгаа гомдоовол яах хэрэгтэй вэ?

Үйл ажиллагаа 2. Хамтдаа сонсьё (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Дэлгэц, зохиол, зурагт карт

Аргачлал: “Хөгжмийн наадам” зохиолыг уншиж өгнө. Зохиолын дүрүүдийн сэтгэлийн мэдрэмж ямар байсан бол, таатай, таагүй аль нь болох талаар ярилцана. Шинэ үгсийн утгыг зурагт карт ашиглан тайлбарлаж өгнө.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Яагаад мэлхий уурласан бэ?
- Галуу найзаасаа уучлалт гуйж чадсан уу?
- Найзууд эвлэрэхийн тулд юу юу хийсэн бэ?

Үйл ажиллагаа 3. Амьтад бүтээж ярилцъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Баримлын шавар, хулдаас, хутга, хормогч, ханцуйвч, баримлаар амьтан бүтээх аргачлал

Аргачлал: “Хөгжмийн наадам” зохиолын дүрүүдээс сонгож баримлаар зохиомжлон бүтээнэ. Бүтээсэн дүрийнхээ талаар мэдрэмж төсөөллөө дүрслэн ярина.

ҮЛГЭР БА ХӨГЖИМ

Шинэ үг: Эхлэл, өрнөл, төгсгөл

Үйл ажиллагаа 1. Найзуудын адал явдал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: “Хөгжмийн наадам” том ном, ажлын хуудас, балын харандаа, өнгийн харандаа, тосон харандаа

Аргачлал: Хүүхэд бүр зохиолын эхлэл, өрнөл, төгсгөлийг зурах ажлын хуудас авсан байна. Багш зохиолыг уншиж өгөх явцдаа хүүхдийн асуултад хариулна. Номын үйл явдлыг төсөөлүүлэн урьдчилан асууна. Хүүхдүүд зохиолыг сонссоны дараа ажлын хуудсанд зохиолын эхлэл, өрнөл, төгсгөлийг өөрийн бодол төсөөллөөр дүрсэлж зурна. Зурсан зургаа тайлбарлаж ярина.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 99, хавсралт №99](#)

Үйл ажиллагаа 2. Зохиолын дүрүүдийг хэмнэлээр илэрхийлье (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Шигшүүр, бөмбөр, дуут мод, шагшуур, үлгэрийн дүрүүдийн зурагт картууд, наалтууз (скоч)



Дууны бичлэг: <https://www.youtube.com/watch?v=7SwA9o3jBJc>



Дууны фонограмм <https://www.youtube.com/watch?v=GXjnlpnPgDU> :

Аргачлал: Хүүхдүүд үлгэрийн дүрээс сонгож энгэртээ наана. Ижил дүр сонгосон хүүхдүүд нэг баг болно. Багшийн дохионы дагуу мэлхий-бөмбөр, туулай-шигшүүр, баавгай-дуут мод, галуу-гурвалжин төмрөөр хэмнэл тоглоно.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 25, дасгал №25](#)

ХАРИЛЦУУР УТАС

Шинэ үг: Эд зүйлсийн материал (шил, мод, хуванцар, даавуу гэх мэт)

Үйл ажиллагаа 1. Бидний эргэн тойронд (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Төмөр, цаас, шил, даавуу, мод, чулуугаар хийсэн янз бүрийн жижиг эд зүйлс, ангилж хийх хайрцаг

Аргачлал: Бидний эргэн тойронд юу байна вэ? асуулт асууж, орчны эд зүйлсийг ажиглаж нэрлэнэ. Хүүхэд бүр бүлгийн орчноос 2-3 төрөл бүрийн эд зүйлс (халбага, сэрээ, түлхүүр, цаасан аяга, шилэн сав, алчуур, модон блок, жижиг чулуу, харандаа, тоглоом гэх мэт)-ийг цуглуулна. Эд зүйлсийг юугаар хийсэн болохыг таамаглаж, нэрлэнэ. 3 хүүхэд өөрсдийн сонгосон зүйлсийг нийлүүлж, хэд байгааг оноож тоолно. Дараа нь цаас, мод, төмөр гэсэн тэмдэг бүхий тусгай саванд хийж ангилна.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 20, дасгал №20](#)

Үйл ажиллагаа 2. Байна уу? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цаасан аяга, 2-3 метр ноосон утас, хуванцар зүү, скоч, галуу, мэлхий, баавгай, туулайн зурагт карт

Аргачлал: Хүүхдүүд хос хосоороо 2 ширхэг цаасан аяга ашиглан харилцуур утас хийж тоглоно. 1. Багш аяганы ёроолд жижиг нүх гаргана. Хүүхдүүд аяганы ёроолд гаргасан жижиг нүхээр ноосон утас оруулан зангидаж, 2 аягыг утсаар холбон, харилцуур утас хийнэ. Дараа нь зохиолын дөрвөн амьтны зургаас сонгож наагаад, хоорондоо харилцан ярилцаж тоглоно.

2. Хүүхдүүд хос хосоороо ярилцаж тоглох явцдаа хол, ойр зайнаас, утсыг чангалах, суллах зэргээр хэрхэн сонсогдож байгааг туршина. Утсыг чанга татаж ярилцвал дуу чимээ илүү чанга, тод сонсогдож байгааг туршина. (Гадаа гарч тоглож болно.)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 31, дасгал №31](#)

Үйл ажиллагаа 3. Эд зүйлсийг олоорой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зурагт карт (хичээлийн хэрэгсэл, тоглоом, эд зүйлс), төрөл бүрийн материалын зурагт карт (хуванцар, мод, төмөр, даавуу...), наалтууз (скоч)

Аргачлал: Багш хуванцар, төмөр, мод, шил, даавуу гэх мэт материалаар нь ялгаж нэрлэх зурагт картыг ээлжлэн өргөнө. Хүүхдүүд эд зүйлсийг материалаар нь ялгаж нэрлэх тоглоом тоглоно. Жишээ нь: Модны зурагт карт өргөхөд модоор хийсэн эд зүйлс буюу харандаа, модон тоглоом, эв долоо зэрэг зурагт картыг өргөнө. Хуванцар, төмөр, мод, шил, даавуу гэх мэт зурагт картыг хүүхэд бүрд тарааж өгнө. Хүүхдүүд ангидаа хайгуул хийж, зурагт тохирох материал бүхий эд зүйлсийг олж наана. Юу хэдэн ширхэг байгааг тоолно.

ШОО БА АМЬТАД

Шинэ үг: Дараалал, зүй тогтол

Үйл ажиллагаа 1. Сонирхолтой шоо (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Шоо хийх загвар, хайч, цавуу, үлгэрийн болон бусад амьтдын зураг

Аргачлал: Шоог дэлгээсний дагуу хайчилж, ирмэгийн дагуу наана. Дасгал ажлын дэвтрээс бэлэн загвар авч ашиглах бөгөөд шаардлагатай бол хүүхдэд дэмжлэг үзүүлнэ. Бүтээсэн шоог орхиж буусан амьтны дүрийн онцлог шинжийг тодорхойлж ярилцана. Хоосон буувал шоог дахин орхино.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 109, хавсралт №14](#)

Үйл ажиллагаа 2. Хамтдаа үлгэр ярьцгаая (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Хуруун хүүхэлдэй (туулай, баавгай, галуу, мэлхий), аяга, халбага, лааз, хувин, мөчир

Аргачлал: Хүүхдүүд “Хөгжмийн наадам” зохиолыг цахим хэрэглэгдэхүүн ашиглан ярина.

Үлгэрийг эхлүүлэх хүүхдийг сонгоно. Оролцогч хүүхдүүд үргэлжлүүлж зохиож ярина.

Хамгийн сүүлийн оролцогч хүүхэд зохиолыг төгсгөнө.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Үлгэрт ямар ямар үйл явдал гарсан бэ?
- Найзууд хоорондоо муудалцахгүй байж болох байсан уу?
- Үлгэр цаашаа хэрхэн үргэлжлэх бол?
- Үлгэрт гарч буй амьтдаас асуулт асуух боломж олдвол чи ямар асуулт асуух байсан бэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 28, дасгал №28](#)

Үйл ажиллагаа 3. Номын тэмдэглэл (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ажлын хуудас, өнгийн харандаа, балын харандаа

Аргачлал: Зохиолын үйл явдлаас хамгийн таалагдсан хэсэг болон зохиолоос сурч авсан зүйлээ зурах ажлын хуудсан дээр өөрийн бодол төсөөллөөр зурж дүрсэлнэ. Хүүхэд өөрийн зурсан зургийн учир шалтгааныг тайлбарлаж ярина.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 33, дасгал №33](#)

ЯМАР ЧИМЭЭ ГАРСАН БЭ?

Шинэ үг: Шагшуур, шигшүүр

Үйл ажиллагаа 1. Юунаас чимээ гардаг вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хувин, модны мөчир, лааз, халбага, аяга, энгийн хөгжмийн зэмсгүүд, картон хаалт

Аргачлал: “Хөгжмийн наадам” зохиолд ямар эд зүйлсээс ямар дуу чимээ гарч байсныг эргэн санаж, ярилцана. Дуугаргаж үзнэ.

- Хувинг гараараа хүчтэй нүдэхэд пан пан
- Модны мөчрөөр лааз товшиход пон пон
- Халбагаар аяга цохиход дин дин гэх мэт

Хүүхдүүд хос хосоороо картон хаалтын 2 талд зогсож, бие биедээ эд зүйлийн дуу чимээ гаргаж таалгаж тоглоно. Эд зүйлсийн дуу чимээ ямар байсныг харьцуулан ярилцана.

Үйл ажиллагаа 2. Миний сонгосон дүр (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: “Хөгжмийн наадам” зохиолын дүрүүдийн маск, шуум

Аргачлал: Хүүхэд “Хөгжмийн наадам” зохиолоос дүрээ сонгоно. Зохиолын дагуу жүжигчилсэн тоглолтод бэлдэж жүжиглэнэ.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 36, дасгал №36](#)

ХӨГЖИЛТЭЙ ЦАРАЙ

Шинэ үг: Гуниглах, гайхах

Үйл ажиллагаа 1. Сэтгэл хөдлөл (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Сэтгэл хөдлөл харуулсан стикер эсвэл зургууд, балын харандаа, өнгийн харандаа, хайч, цавуу, сэтгэл хөдлөл харуулсан зургууд, 20 см диаметртэй дугуй хэлбэртэй хатуу цаас, зүй тогтлыг харуулсан карт, амьтдын зурагт карт, шоо

Аргачлал:

Хэл яриа-номын төв: Сэтгэл хөдлөлийн зурагт картуудаас өөрт байдаг сэтгэл хөдлөлийг сонгож энгэртээ наана. Хэн хэнтэй ижил эсвэл ялгаатай сэтгэл хөдлөлтэй байгааг ярилцана.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 30, дасгал №30](#)

Зураг урлалын төв: Сэтгэл хөдлөлийн хүрд бүтээж, голын зүүг эргүүлнэ. Зүү таарсан сэтгэл хөдлөлийг царайгаараа илэрхийлж үзүүлнэ. Тухайлбал, баяр хөөртэй сэтгэл хөдлөл таарвал баярласан царай гаргаж үзүүлнэ.

Математикийн төв: 10 хүртэлх тооны дарааллаас орхигдсон тоог нөхөж бичих ажлын хуудсыг бөглөнө. Ажлын хуудсыг бөглөж дуусаад сэтгэл хөдлөл харуулсан стикерээс сонгон авч наана. Хэн ямар стикертэй болсноо ярилцана.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 56, дасгал №56](#)

1		3		5	6		8		10
---	--	---	--	---	---	--	---	--	----

1			4	5		7		9	
---	--	--	---	---	--	---	--	---	--

Үйл ажиллагаа 2. Байг онож тоглоё (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Бөмбөг, бай

Аргачлал: Хүүхэд бөмбөгөөр 1.5-2м зайтай байг онож тоглоно. Бөмбөгийг шидэх: Бөмбөгтэй гарыг тохойгоор нугалсан байдлаас шидэх зүг рүү чиглүүлж, бөмбөгийг сарвуугаар түлхэж хөдөлгөөнд оруулан, бөмбөгийн хурдыг нэмнэ. Бөмбөгийг бай руу шиднэ, барьж авна. Хүүхдүүд хөгжилдөн тоглоход хоорондын зайг анхаарч үзнэ.

Үйл ажиллагаа 3. Үлгэрийн баатрууд (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хувцас (туулай, баавгай, галуу, мэлхий), хөгжмийн зэмсэг хийх зүйлс (аяга, халбага, мөчир, хувин, лааз гэх мэт), ая шуум

Аргачлал: Дүр сонгосон хүүхдүүд үлгэрийн үйл явдлын дагуу дүрийг бүтээнэ. Бусад хүүхдүүд жүжигчилсэн тоглолт үзнэ.

Сонсьё, дэмжье

Хүүхэд үлгэрт гарсан амьтнаас өөр амьтан зурах, хөгжмийн зэмсгийг өвөрмөц байдлаар дүрслэх зэрэг нь тэдний бүтээлч байдлыг илэрхийлж байгаа тул урамшуулж, чиглүүлээрэй.

Эцэг эхтэйгээ хамтаръя

Бусадтай сайхан сэтгэлээр хандаж туслах, хуваалцах, уучлалт гуйх, энэрэх зэрэг үйл гаргахад нь дэмжиж урамшуулаарай.

Ангидаа төрөл бүрийн материалаар хийгдсэн эд зүйлс бүрдүүлэхэд туслалцаа хүсээрэй.

Дахин ашиглах материал цуглуулах хэсэг байгуулж, ирсэн зүйлсийг сургалт, үйл ажиллагаандаа ашиглаарай.

Багшийн эргэцүүлэмж

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./ Амжилттай хэрэгжүүлсэн: Сул хэрэгжүүлсэн:..... Цаашид сайжруулах:..... Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

МОНГОЛ НААДГАЙ

Хүүхдийн эзэмших чадамж:

Үндэсний болон дэлхийн өв соёл: Монгол уламжлалт тоглоомоор тоглож, түүний нэршил, дүрмийг таньж мэдэх, суралцах;

Бүтээлчээр сэтгэх: Дүрс, хээгээр бүтээл хийж шинэ санааг илэрхийлэх

Шүүн тунгаах: Юмсын ялгаа, ижил төстэй байдлыг ажиглах, харьцуулах, ангилах, таамаглах, алдаагаа олж засах замаар асуудал шийдвэрлэх

Хамтрах: Бусадтай хамтран тоглох, дасгал, даалгавар гүйцэтгэх, ээлжээ хүлээх, дүрэм баримтлах, бусдад туслах, хуваалцах, хүндлэх, хүлээцтэй байх

Харилцах: Санаа бодлоо илэрхийлэх, ярилцах, сонсох, тоглох, тайлбарлах чадамжийг дэмжихэд хувь нэмрээ оруулна.

Аюулгүй байдлын зөвлөмж:

Шагайг амандаа хийх, бусад руу шидэхээс сэргийлж, тоглоомын төгсгөлд гараа угаахыг сануулаарай.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Үндэсний тоглоом, наадгайтай холбоотой нэвтрүүлэг үзэж, асуултын дагуу харилцан ярилцах, өөрийн санаа бодлоо илэрхийлэх, тайлбарлах боломж олгоорой.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Шагайн дөрвөн талыг нэрлэх, ижил ялгаатай байдлаар нь ангилах, тоолох, дүн тоог хэлэх, тохирох тооны цифрээр тэмдэглэх, өөрийн санаа бодлоо үгээр илэрхийлэх, асуудлаа шийдвэрлэх боломжийг олгоорой.

Төвийн үйл ажиллагаа:

- Сургалтын төвд шагай няслах, шагай таалцах, Гэр, Зургаадай, Намсрай, Бөгж нийлүүлэх зэрэг үндэсний тоглоом наадгайгаар тоглох орчин бүрдүүлээрэй.

Зугаалга:

- Улирал, цаг агаарын онцлогоос хамаарч цэцэрлэгийн орчинд ажиглалт хийх, тоглох боломж бүрдүүлээрэй.

Хөгжөөн баясах цаг:

- Бусадтай хамтран бүжиглэх, жүжиглэх, хөгжимдөх, богино жүжиг найруулж тоглох зэргээр сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, баяр баясгалантай оролцох, хөгжилтэй байх боломж бүрдүүлээрэй.

Боломжууд:

- Уламжлалт наадгайгаар тоглох явцад тоглоомын нэр төрлийг таньж нэрлэх, асуулт асууж харилцан ярилцах боломж олгоорой.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>БНО4.2д. Өөрийн үндэсний өв соёлыг бусад үндэстний соёлоос ялган таньж, уламжлалт зан үйл, ёс заншлаар бахархана.</p> <p>ХЯ4.2а. Тодорхой сэдвээр санаа бодлоо илэрхийлж, идэвхтэй ярилцана.</p> <p>ХЭМ4.2е. Хүрээлэн байгаа орчин дахь анхааруулах, болгоомжлох дүрмийг хамтдаа зохиож, өдөр тутам мөрдөнө.</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусад үндэсний хувцас, баяр ёслол, тоглоом наадгайг танин мэдэх - Монгол ардын тоглоом наадгай, баяр ёслол, уламжлалт соёлын талаар ярилцлага өрнүүлж өөрт тохиолдсон үйл явдлын тухай харилцан ярианд оролцох - Ангийн сургалтын төвд тохирох аюулгүй ажиллагааны дүрэм зохиож, мөрдөх 	Өв соёлоо дээдэлье

<p>МАТ4.1а. 20 хүртэлх тоог цээжээр тоолох, 10 хүртэлх тооны юмсыг оноож тоолох, тоог таних, өгсөн тооноос эхэлж 1-ээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, тоог жишнэ.</p> <p>НСХ4.3в. Өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог болно.</p>	<ul style="list-style-type: none"> - 10 хүртэл юмсыг оноож тоолох - 0-9 хүртэл цифрийг таних тоглоом тоглох; - Төрөл бүрийн дүрэмтэй тоглоомоор тоглох, дүрэм зөрчвөл ямар үр дагавартай талаар ярилцах; 	<p>Шагайн тоглоом</p>
<p>МАТ4.1а. 20 хүртэлх тоог цээжээр тоолох, 10 хүртэлх тооны юмсыг оноож тоолох, тоог таних, өгсөн тооноос эхэлж 1-ээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, тоог жишнэ.</p> <p>ХӨГ4.1в. Дуу, аялгууны хэмнэлийг хөгжмийн энгийн зэмсгээр хамтран хөгжимдөнө.</p>	<ul style="list-style-type: none"> - 10 хүртэл юмсыг оноож тоолох 0-9 хүртэл цифрийг таних тоглоом тоглох; - “Найрал хөгжимчид” сэдэвт тоглоом тоглох. Жишээ нь: 2 ба 3 хувьт хэмнэлтэй аялгуунд зураглалын дагуу, хөгжмийн энгийн зэмсгээр хэсэг хэсгээрээ ээлжлэн, хамтарч тоглох; 	<p>Хамтдаа тоглоё</p>
<p>БНО4.2д. Өөрийн үндэстний онцлогийг бусад үндэстнээс ялгаж. Уламжлалт зан үйл, ёс заншлаар бахархана.</p> <p>ХЭМ4.1д. Алхалт, гүйлт бүхий хөдөлгөөнт тоглоомыг дүрд орж хамтран тоглоно.</p> <p>ХЯ4.3в. Дармал үсгийг дуурайж бичнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Өөрийн болон бусад үндэстний хувцас, баяр ёслол, тоглоом наадгайг танин мэдэх - Хүүхдүүд тоглоомын дүрмийг зохиож тоглох, дүгнэж ярилцах, урамшуулах - Уяа, олс, савх, байгалийн материал ашиглан, үсэг бүтээж дүрсэлж тоглох; 	<p>Монгол наадгай</p>
<p>МАТ4.1б. Тоглоом, дүрсүүдээр зүй тогтол үүсгэн тайлбарлана. 10 хүртэлх тооны дарааллаас орхигдсон тоог тодорхойлно.</p> <p>ЗУ4.2в. Зураг бүтээлээ хээ угалзаар чимэглэнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Зүй тогтол зохиож тайлбарлах - Үндэстний болон орчин үеийн хувцас, хэрэглэлийн бэлэн загвар ашиглах, шинээр бүтээж тэдгээрийг хээлж чимэглэх; 	<p>Бид чадна</p>
<p>ЗУ4.2а. Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон зурна.</p> <p>ХЯ4.2в. Ерөнхийлсөн нэрийг яриандаа ашиглана.</p> <p>НСХ4.3а. Хүмүүс хоорондоо хэрхэн харилцан хамааралтай байдгийг тайлбарладаг болно.</p>	<ul style="list-style-type: none"> - Багаараа өгөгдсөн нэг сэдвээр хамтарч зурах, бүтээлээ тайлбарлах - Сэдэвт зураг зурах, хамтын бүтээл хийсний дараа ерөнхийлөн нэрлэсэн үгсийг ойлгон бүтээл хийх эсвэл хийсэн бүтээлдээ нэр өгөх - Баг болж хамтын бүтээл хийж, хэн юуг нь хийсэн тухай тайлбарлах; 	<p>Бидний бахархал</p>

1 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Монгол өв соёлоо дээдэлъе	Тойргийн цаг	“Өв соёлоо дээдэлъе” нэвтрүүлэг үзэж, шагай болон үндэсний тоглоомын талаар ярилцана.	Нэвтрүүлгийн холбоос, шагай, олбог, шагайн уут	Шагайг юунд хэрэглэдэг вэ? Яагаад хүндэтгэн дээдэлдэг юм бол? Хэрхэн хадгалдаг вэ?.	Үндэсний болон дэлхийн өв соёл: Монгол үндэсний ахуй амьдралын онцлогоос танин мэдэх, суралцах, бахархах Харилцах: Тодорхой сэдвийн хүрээнд харилцан ярианд идэвхтэй оролцох	Өв соёл, ёс заншлаар бахархдаг. Санаа бодлоо илэрхийлэх, харилцан ярьдаг.
Шагайн нэр	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Шагайн 4 талыг ажиглаж, ижил ялгаатай талыг олно. Шагайн буултад тохируулан нэрлэнэ. Шагай орхих дээдлэх талаар ярилцана.	Шагай, таван хошуу малын зурагт үзүүлэн	Шагайг яагаад эрхийн чинээ гэж нэрлэсэн бэ? Шагай хэдэн талтай вэ? Орхихдоо юу анхаарах вэ?	Шүүн тунгаах: Шагайн 4 талыг ажиглан харьцуулж ялгааг олох, нэрлэх Хамтран ажиллах: Хосоор ажиллах, дүрэм зааврыг хамтран зохиож мөрдөх	Аюулгүйн дүрэм зохиож мөрддөг. Тодорхой дүрэм баримталдаг.
Тоолоорой	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Шагай орхих тоглоно. Буусан шагайг ижлээр нь ялгаж, тоолж дүн тоог зураасаар тэмдэглэж тайлбарлана. Шагай няслах дүрэм, аргачлалыг туршина.	Ханын ажлын хуудас, ууттай шагай	Шагайг аль хуруугаар няслах вэ? Шагай нясалж тоглоход юуг хориглох вэ?	Шүүн тунгаах: Алдаагаа олж засах замаар асуудал шийдвэрлэх Хамтран ажиллах: Багаар тоглох, тоглоомын дүрэм баримтлан хамтран оролцох	10 хүртэл юмсыг оноож тоолдог. Дүрэм баримталдаг.
Тоолоод олоорой	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Гарын бугуйд хийх цэг бүхий үзүүлэн (1-10) болон сандал дээрх цифрийг (1-10) тохируулж олох хөдөлгөөнт тоглоом тоглоно.	Цэг бүхий үзүүлэн, 1-10 хүртэл цифр тус бүр 2 ширхэг	Чиний тоонд тохирох сандал хаана байна вэ? Нэгийн дараа ямар тоо ирэх вэ?	Шүүн тунгаах: Цэгээр илэрхийлсэн тоог тоолж, тохирох цифрийг таних Суралцахуйд суралцах: Дараалал болон зааварчилгааг баримтлан үйлдлийг гүйцэтгэх	20 хүртэл тоолдог. 0-9 цифрийг таних, тоон дарааллаар зогсдог.

Шагайн наадгай	Төвийн үйл ажиллагаа	Шагай няслах тоглоомын дүрмийг танилцуулж тоглоно. Авсан шагайгаа тоолж, тохирох цифрийг сонгоно. Шагай таалцах тоглоом тоглоно. Дүн тоог таамаглаж хэлнэ. 3 дахь хүүхэд таасан тоог тэмдэглэж бичнэ.	Шагай, олбог, ажлын хуудас	Дүрэм зөрчвөл юу болох вэ? Найзын чинь гарт хэдэн шагай байж магадгүй гэж бодож байна вэ?	Шүүн тунгаах: Тоолж, дүн тоог таамаглах, ажлын хуудас дээр тэмдэглэн бичих Хамтран ажиллах: Шагай няслах, шагай таалцах тоглоомуудын дүрмийг баримтлан ээлжлэн тоглох	Тоо тоолох, цифр таньдаг. Тоглоомын дүрэм баримталдаг.
Зурган даалуу	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Дөрвөн бэрх орхиж хэн эхлэхийг тогтооно. Даалуу бүрийн зургийг харж нэрлэнэ. Эхлээд шагайн тоогоор, дараа нь буултын зургаар ижилсүүлэн байрлуулж тоглоно.	Шагайн буултыг харуулсан зургаар хийсэн даалуу	Одоо хэдэн шагайтай даалуу хэрэгтэй байна вэ?	Шүүн тунгаах: Шагайн буулт болон тоогоор ижилсүүлж байрлуулах замаар харьцуулах, ангилах үйлийг гүйцэтгэх Үндэсний болон дэлхийн өв соёл: Шагайн нэршил болон тоогоор нийлүүлж тоглох	Тоо тоолох, ижилсүүлдэг. Дүрэм баримтлан хамтран оролцдог.
Хэмнэлт хөгжим	Хөгжөөн баясах цаг	Төрөл бүрийн сав, уутанд хийсэн шагайг хөдөлгөж сонсон, хэдэн шагай байгааг таамаглана. Шагайг хэлхэж, өөрийн сонгосон дууны хэмнэлд тохируулж хамтран хөгжимдөнө.	Нүхэлсэн шагай, уяа, үдээс, төрөл бүрийн сав, уут	(Хөгжмийн хэмнэл, дууны сонголттой холбоотой)	Хамтран ажиллах: Дуу, аялгууны хэмнэлд тохируулж, шагайгаар хамтран хөгжимдөх Нийгэм, сэтгэл хөдлөл: Хөгжөөн баясах цагаар сэтгэл хөдлөлөө илэрхийлэх, баяр баясгалантай оролцох	Дуу, аялгууны хэмнэлийг энгийн зэмсгээр хамтран хөгжимддөг.
Монгол үндэсний тоглоомтой танилцъя	Тойргийн цаг	Монгол үндэсний олон төрлийн хөлөгт, оньсон тоглоом (Гэр, Зургаадай, Намсрай)-ын талаар ярилцаж, Бөгж нийлүүлэх тоглоомын	Дөрвөн төрлийн тоглоомын бичлэг (Гэр, Зургаадай, Намсрай, Бөгж нийлүүлэх)	Өмнө ямар тоглоомоор тоглож сурсан бэ? Ямар тоглоом хамгийн сонирхолтой	Үндэсний болон дэлхийн өв соёл: Монгол үндэсний олон төрлийн тоглоомтой танилцах, уламжлалт зан үйл, ёс заншлаар бахархах	Тоглоом наадгайг танин мэддэг. Сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлдэг.

		бичлэг үзэж, нэр, тоглох аргын талаар ярилцана.		санагдсан бэ? Хөлөгтэй ямар тоглоом байсан бэ?	Харилцах: Тоглоомын төрөл, нэр, тоглох аргыг тайлбарлаж, харилцан ярилцах, ярилцлагаа дүгнэнэ.	
Тоглоцгооё	Төвийн үйл ажиллагаа	Намсрай тоглоомын дүрсийг дуурайн эвлүүлэх, үсэг бичсэн цаасан дээр уяа, шагай, элс зэрэг материал ашиглан үсэг бүтээж дүрслэх, бөгж нийлүүлэх тоглоом, Зургаадай тоглоомоор тоглоно.	Үсэг бичсэн цаас, уяа, тууз, шагай, элс, хүүхдийн будаа, гэр, Зургаадай, Намсрай, бөгж нийлүүлэх тоглоомууд	Энэ яаж тоглодог тоглоом бэ? Тоглоом сонирхолтой байна уу?.	Хамтран ажиллах: Тоглоомын зааврыг дахин танилцуулж, сонголтоор тоглох Суралцахууд суралцах: Тоглоомын дүрмийг дагаж мөрдөх, дүрмийг зохиож тоглох, дүгнэж ярилцах	Хөдөлгөөнт тоглоомын дүрэм барьдаг. Дармал үсгийг дуурайж бичдэг.
Намсрай	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Намсрай тоглоомын дүрсийг харж дуурайн өрөх, төрөл бүрийн дүрс, хээ, амьтан зохион бүтээх. Бүх дүрсийг ашиглан шинэ зүйл өрөх. Дүрсүүдийг ашиглан үсэг бүтээж тоглоно.	Намсрай тоглоом, үсэг бичсэн цаас	Өөрөөр яаж шийдэж болно гэж бодож байна вэ?.	Бүтээлчээр сэтгэх: Дүрсийг дуурайн өрөх, янз бүрийн дүрс, хээ, амьтан зохион бүтээх Шүүн тунгаах: Асуудлыг өөрөөр шийдвэрлэх боломжийг эрэх	Дүрсүүдээр зүй тогтол үүсгэн тайлбарладаг.
Дарааллыг ол	Төвийн үйл ажиллагаа	Төрөл бүрийн хэрэглэгдэхүүн (бөглөө, дүрс, шагай, цифр) ашиглан загвар харж дуурайх, эсвэл бие даан тоо, өнгө, дүрс, хээ, хөдөлгөөний зүй тогтол үүсгэнэ. Үүсгэсэн зүйлээ	Бөглөө, дүрс, чүдэнзний мод, савх, шагай, цифрүүд	Энэ дараалалд ямар дүрс хамгийн олон байна вэ? Хэрвээ дараагийн дүрсийг нэмбэл ямар дүрс байх ёстой вэ?	Шүүн тунгаах: тоо, өнгө, дүрс, хөдөлгөөнөөр зүй тогтол үүсгэх Харилцах: Үүсгэсэн зүй тогтлоо найзууддаа үзүүлж, тайлбарлаж ярилцах	Зүй тогтол үүсгэн тайлбарладаг.

		найзууддаа үзүүлж тайлбарлана.				
Хувцасны хээ	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Үндэсний хувцасны өнгө, хээний талаар ярилцана. Дээл, малгай, бүсний бэлэн загварыг дүрс ашиглан хээний зүй тогтол үүсгэж чимэглэнэ.	Монгол дээл, бүс, малгай, цүнхний зураг (бэлэн загвар), өнгийн цаас, тууз, цавуу, хайч, зураг загварууд	Чиний дээлийн хээ ямар зүй тогтлоор хийгдсэн бэ?	Бүтээлчээр сэтгэх: Дүрс ашиглан хээний зүй тогтол үүсгэж чимэглэх Үндэсний болон дэлхийн өв соёл Үндэсний хувцасны өнгө, хээний талаар ярилцах	Зураг бүтээлээ хээ угалзаар чимэглэдэг.
Загварын үзүүлбэр	Хөгжөөн баясах цаг	Чимэглэж зохион бүтээсэн хувцсаар, загварын үзүүлбэр хийнэ.	Зурж чимэглэсэн монгол дээл, бүс, малгай, цүнх, хөгжим, ая	Энэ өнгийг яагаад сонгосон бэ? Ямар хээ ашиглаж чимэглэсэн бэ?	Нийгэм, сэтгэл хөдлөл: Чимэглэж зохион бүтээсэн хувцсаа барьж, тайзан дээр үзүүлж алхах, баяр баясгалантай, хөгжилтэй оролцох Харилцах: Багшийн асуултад хариулж, сонгосон өнгө, хээнийхээ талаар тайлбарлах	Бүтээлээ тайлбарладаг. Хөгжимдөн, бүжиглэдэг.
Бидний бүтээл	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Баг болж “Монгол наадгай” сэдвийн хүрээнд хамтарч зураг зурна. Бүтээлээ тайлбарлаж, ерөнхий нэрээр нэрлэнэ. (Жишээ нь, шагайн тоглоом)	Усан будаг, бийр, эсгий бал, цаас	Танай бүтээл юуг илэрхийлж байна вэ? Ерөнхий нэр нь юу вэ? Яагаад энэ нэрийг өгөх болсон бэ?.	Хамтран ажиллах: Баг болж “Монгол наадгай” сэдвийн хүрээнд зураг зурах, хамтын бүтээл хийх, тайлбарлах Харилцах: Бүтээлээ тайлбарлаж, ерөнхийлсөн нэрээр нэрлэх	Сэдвийн хүрээнд зохиомжлон зурдаг. Ерөнхийлсөн нэрийг яриандаа хэрэглэдэг. Хамтын харилцан нөлөөллийг тайлбарладаг.

Манай тоглолт	Хөгжөөн баясах цаг	Багаар ажиллаж, тоглоомын баатрыг зохион бодож, дүрсэлж, маск урлана. "Тоглоомын уулзалт" нэртэй богино жүжиг найруулж тоглоно.	Зургийн хэрэгсэл	Хэн ямар дүр бүтээсэн бэ? Тэр баатар ямар наадгайд оролцдог вэ? Багаараа хамтдаа яаж зохиолоо бодсон бэ?.	Бүтээлчээр сэтгэх: Баг болж тоглоомын баатрыг зохион бодож, маск урлах, богино жүжиг найруулж тоглох Нийгэм, сэтгэл хөдлөл: Баатрууд өөрийгөө танилцуулж, бие биетэйгээ найзлах	Санаа бодлоо илэрхийлдэг.
---------------	--------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------	-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------

Албан хэрэгсэл

1 дүгээр сарын I долоо хоног

ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛЬЕ

Шинэ үг: Өв соёл, үндэсний тоглоом

Үйл ажиллагаа 1. Монгол өв соёл (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн:

Нэвтрүүлгийн

холбоос

https://www.youtube.com/watch?v=ShzfmT1VE0Y&list=PLGw3zRL0qoL0fmVtGnM9hC_0j3T5KfyN8&index=1, шагай, олбог, шагайн уут

Аргачлал: “Өв соёлоо дээдэлье” нэвтрүүлэг үзэж, шагай болон шагайн тоглоомын талаар ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Монголчууд шагайг юунд хэрэглэдэг вэ?
- Шагайн талуудыг юу гэж нэрлэдэг билээ?
- Шагайгаар тоглохдоо юуг анхаарах вэ?
- Малын шагайг яагаад хүндэтгэн дээдэлдэг юм бол?
- Шагайг хэрхэн хадгалж хамгаалдаг вэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 46, дасгал №46](#)

Үйл ажиллагаа 2. Шагайн нэр (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Шагай, таван хошуу малын зурагт үзүүлэн

Аргачлал: Хосоор ажиллана. Хос бүр 1 шагай авч, ээлжлэн орхиж, буулт бүрийг ажиглаж харьцуулан ялгааг олно. Таван хошуу малын зургийг шагайн буултад тохируулан байрлуулж нэрлэнэ. Шагай орхих үед мөрдөх аюулгүйн дүрэм зохиож тайлбарлана. (зөөлөн цацаж тараах, амандаа үмхэхгүй гэх мэт). “Эрхийн чинээ биетэй, Эрхэм дөрвөн нэртэй” оньсогыг цээжилнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Шагайг яагаад эрхийн чинээ гэж нэрлэсэн бэ?
- Шагай хэдэн талтай вэ?
- Яагаад эрхэм дөрвөн нэртэй гэсэн юм бол?
- Шагайг орхихдоо юу анхаарах билээ?

Үйл ажиллагаа 3. Тоолоорой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ханын ажлын хуудас, ууттай шагай

Аргачлал: Нэг багт 4-5 хүүхэд байна. Баг бүр 10 ширхэг шагай авч, орхиж тоглоно. Тоглоомын өмнө дүрмийг ярилцаж гаргана (ээлжилж орхино, бие бие рүүгээ шагай шидэхгүй гэх мэт). Орхисон шагайг ижлээр нь ялгаж тавиад морь, хонь, ямаа, тэмээ хэд буусныг тоолж дүн тоог зураасаар тэмдэглэж, тайлбарлана. Буруу тоолсон бол дахин тоолж алдаагаа олж, засна. Шагайг хэрхэн няслахыг туршиж, мөрдөх дүрмийг (нясалсан гараар авахгүй, 2 шагайг няслахдаа бусад шагайнд хүрэхгүй гэх мэт) ярилцана. Үйл ажиллагаа 1-ийн бичлэгийг дахин үзүүлж болно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Шагайг аль хуруугаар няслах вэ?
- Ямар шагайг хооронд нь нясалж болохгүй вэ?
- Шагай нясалж тоглохдоо юуг хориглох билээ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 40, дасгал №40](#)

ШАГАЙН ТОГЛОМ

Шинэ үгс: Оноох

Үйл ажиллагаа 1. Тоолоод олоорой (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цэг бүхий үзүүлэн, 1-10 хүртэлх цифр тус бүр 2 ширхэг

Аргачлал: Гарын бугуйд томоор 1-10 хүртэл тоог илэрхийлэх цэг бүхий үзүүлэн, сандал дээр 1-10 хүртэл цифрийг бичиж энд тэнд байрлуулж тавьсан байна. Тоог хэлэхэд гарт байгаа цэгийг тоолж, ижил тоог илэрхийлсэн үзүүлэнтэй хүүхдийг олоод, тохирох цифр бичсэн сандалд сууна. Хоёр хүүхэд сандлаа олж суусны дараа хоёр дахь тоог хэлэх гэх мэтчилэн тоглоомыг үргэлжлүүлнэ. Бүгд сандлаа олж дууссаны дараа тэднийг 2 хэсэг болгоно. Эхний хэсгийг “Дарааллаараа зогсоорой” гэхэд тоогоо бусдад сонсогдохоор “Нэг” гэж хэлээд эхний

хүүхэд зогсох байдлаар 10 хүртэл тоолж байраа олно. Үлдсэн 10 хүүхдийг дээрх дарааллын дагуу тоог хэлүүлж суулгах зэргээр хөдөлгөөнийг өөрчилж тоглоно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чиний тоонд тохирох сандал хаана байна вэ?
- Тоон дарааллаар зогсох гэж байна, эхний тоо хэд байх вэ?
- Нэгийн дараа ямар тоо ирэх билээ?

Үйл ажиллагаа 2. Шагайн наадгай (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Шагай, олбог, шагай, ажлын хуудас

Аргачлал:

Хэл яриа-Номын төв: Шагай няслах тоглоомын дүрмийг танилцуулж, тоглоно.

Бүх шагайг олбог дээр тараан орхиж хонийг хониор, морийг мориор гэх мэтчилэн ижил шагайг хооронд нь нясална. Тоглогч шагайг хөндөхгүй, нясалсан гараар авахгүй. Аль нэг дүрмийг зөрчвөл дараагийн хүнд тоглох эрх шилжих маягаар бүх шагай хэн нэгэнд нь хураагдах хүртэл үргэлжлүүлэн тоглоно. Няслаад авсан шагайгаа хүүхэд бүр өмнөө тавиад тоолж 1-10 хүртэл тохирох цифрийг сонгон байрлуулна. Тоглоомын дүрмийг яагаад баримтлах талаар ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Шагайг яаж тараах ёстой билээ?
- Дүрэм зөрчвөл юу болох бол?

Математикийн төв: Хосоор тоглоно. Хүүхэд бүр 5 шагай тоолж аваад, 2 гартаа атгаж, хойноо нууна. Таалгах шагайгаа 1 гартаа атгаад, нэгэн зэрэг урагш гаргана. “Бидний гарт нийлээд хэдэн шагай байна вэ? Мэргэн юм бол мэдээд таагаарай, Цэцэн юм бол цээжлээд хэлээрэй.” гэж харилцан хэлэлцээд, дүн тоог таамаглаж хэлнэ. Хоёр тоглогч шагай атгасан гараа дэлгэн харуулж, нийлээд хэдэн шагай атгасан байгааг тоолж, таасан тоглогчид өгнө. Хамгийн олон шагай цуглуулсан тоглогч ялагч болно. 3 дахь хүүхэд тааж авсан тохиолдол бүрд шагайны тоог тэмдэглэж бичнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Найзын чинь гарт хэдэн шагай байгаа гэж бодож байна вэ?

ХАМТДАА ТОГЛОЁ

Шинэ үг: Дөрвөн бэрх

Үйл ажиллагаа 1. Зурган даалуу (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Шагайн буултыг (морь, хонь, тэмээ, ямаа) харуулсан зургаар хийсэн даалуу

Аргачлал: Даалуу бүрийн зургийг харж морь, хонь, тэмээ, ямааг нэрлэнэ. Хоёр хүүхэд тус бүр 6 ширхэг даалуугаар тоглоно. Дөрвөн бэрх орхиж хэн эхлэхээ тогтоно. Эхлээд зөвхөн шагайны тоогоор, дараа нь шагайн буултын зургаар ижилсүүлж байрлуулан тоглоно. Эхний хүүхэд өөрт байгаа 6 даалуунаас нэгийг сонгож тавина. Хоёр дахь хүүхэд тухайн даалуу дээрх шагайн тооноос хамааран эхнийхтэй ижил тоотойг үргэлжлүүлэн байрлуулна. Хэрэв хүүхдэд ижил тоотой даалуу байхгүй тохиолдолд өнжих буюу дараагийн хүүхэд дүн тоотой тохирох даалуугаа байрлуулна. Хоёр хүүхэд ээлжлэн байрлуулсаар эхэлж даалуу нь дууссан хүүхэд хожно.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Одоо хэдэн шагайтай даалуу хэрэгтэй байна вэ?

Үйл ажиллагаа 2. Хэмнэлт хөгжим (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Нүхэлсэн шагай, уяа үдээс, төрөл бүрийн сав, уут

Аргачлал: Даавуун уут, гялгар уут, хуванцар сав, цаасан болон төмөр хайрцагт янз бүрийн тоотой шагай хийж бэлтгэнэ. Бүх уут, савыг хөдөлгөж сонсоно. Аль саванд хэдэн шагай байгааг таамаглаж хэлээд шагайг гаргаж тоолон, таамаглалтайгаа харьцуулж хэлнэ.

Шагайнаас өөрийн сонголтоор авч хэлхэнэ. Хүүхдийн сонгосон дууны хэмнэлд тохируулж, хэлхсэн шагайгаа дуугарган хэсгээр болон хамтарч хөгжимдөнө.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 44, дасгал №44](#)

1 дүгээр сарын II долоо хоног

МОНГОЛ НААДГАЙ

Шинэ үгс: Онцлог, уламжлал

Үйл ажиллагаа 1. Монгол үндэсний тоглоомтой танилцъя (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: “Гэр”, “Зургаадай” хөлөгт, “Намсрай” өрж эвлүүлэх тоглоом, “Бөгж нийлүүлэх” оньсон тоглоомын бичлэг <https://www.facebook.com/watch/?v=527701124520838>

Аргачлал: Монгол үндэсний “Бөгж эвлүүлэх” тоглоомыг хэрхэн тоглох бичлэг үзүүлж, тоглоомын төрөл, нэр, тоглох аргыг тайлбарлаж харилцан ярилцана. Хүүхдүүд ярилцлагаа дүгнэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өмнө нь бид ямар тоглоомоор тоглож сурсан билээ?
- Бичлэг дээр ямар тоглоомын тухай гарсан бэ?
- Ямар тоглоом хамгийн сонирхолтой санагдсан бэ?
- Хөлөгтэй ямар тоглоом байсан бэ?

Үйл ажиллагаа 2. Тоглоцгооё (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Үсэг бичсэн цаас, уяа, тууз, шагай, элс, хүүхдийн будаа, шигшүүр, Гэр, Зургаадай, Намсрай, Бөгж нийлүүлэх тоглоомууд

Аргачлал: Тоглоомын зааврыг дахин танилцуулж, сонголтоор тоглуулна.

Зураг урлалын төв: Намсрай тоглоом 4 ижил адил талт гурвалжин, 2 ижил квадрат дүрс, 2 том, 4 ижил жижиг адил талт гонзгой дөрвөлжин дүрс бүхий 11 ширхэг хэсгээс бүрдэнэ. Эхлээд өнгөөр ялган будсан янз бүрийн дүрс бүхий даалгаврыг харж дуурайн эвлүүлнэ.

Хэл яриа-Номын төв: Үсэг бичсэн цаасан дээр уяа, шагай, савх, элс, хүүхдийн будаа ашиглан үсэг бүтээж дүрсэлж тоглоно.

Туршилт, танин мэдэхүйн төв: Бөгж нийлүүлэх тоглоом. Бог малын чөмгөний ясны хоёр талын гогцоонд тус тусдаа байгаа шагайг нэг утсанд оруулна.

Математикийн төв: Зургаадайн 7 буудлыг шалан дээр тоглох байдлаар бэлтгэнэ. 2 хүүхэд гурав гурван хүү авч хөлөг дээр ээлжлэн тавина. Ингэж ээлжлэн тавьж гүйцсэний дараа ээлжээр нүүнэ. Нүүдэлгүй болсон тоглогч нь хожигдоно.

Тоглоомын төв: Гэрийн хөлөг монгол гэрийн хэлбэртэй бөгөөд 12 буудалтай. Хоёр хүүхэд дөрөв дөрвөн хүүгээр тоглоно. Нүүхдээ зураасны дагуу хаашаа ч нүүж болно. Идэхдээ дундах зурааснуудын дагууд (бусдын зэргэлдээ хүүг) зөвхөн давж иднэ. Нэг идэш байвал нэг, хоёр идэш байвал хоёр иднэ. Идэх боломж байхад идэхгүй өнгөрөөж болохгүй. Тоглоомыг дүгнэж хийсэн зүйлээ ярилцаад, бие биеэ баяр хүргэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ тоглоом ямар дүрэмтэй вэ?
- Тоглоом сонирхолтой байна уу?

Үйл ажиллагаа 3. Намсрай (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Намсрай тоглоом (хүүхдийн тоогоор), үсэг бичсэн цаас

Аргачлал: Намсрай тоглоомыг үргэлжлүүлэн тоглоно.

1-р хэсэг: Дүрсийг харж дуурайн өрөөд, дүрсээ хүрээгээр нь тойруулан зурж будна.

2-р хэсэг: Янз бүрийн дүрс, хээ, амьтан өрж зохион бүтээгээд, зурж будна.

3-р хэсэг: Хүрээлэн зурсан дүрс зургаас харж, бүх дүрсийг ашиглан шинэ зүйл өрж эвлүүлнэ.

4-р хэсэг: Өөрөө санаачлан янз бүрийн сэдвээр дүрс эвлүүлэн зурна. Өрж байгуулах явцад ярилцаад тоглоомын дүрэмд өөрчлөлт оруулж дүрсүүдийг ашиглан үсэг бүтээж тоглоорой. Бүтээсэн зүйлээ найз нөхдөдөө харуулж тайлбарлана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өөрөөр яаж шийдэж болно гэж бодож байна вэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 27, дасгал №27](#)

БИД ЧАДНА

Шинэ үгс: Зүй тогтол

Үйл ажиллагаа 1. Дарааллыг ол (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Бөглөө, дүрс, чүдэнзний мод, савх, шагай, цифрүүд

Аргачлал: Эхлээд загвар харж дуурайн хийнэ. Дараа нь өгөгдсөн хэрэглэгдэхүүнээр бие даан зохионо.

Математикийн төв: Өнгө, шагай, 1–10 хүртэл цифрийг ашиглан тооны зүй тогтол үүсгэнэ.

Зураг урлалын төв: Том, жижиг дүрс, савх ашиглан шинэ хээ бүтээнэ.

Хэл яриа-Номын төв: Бөглөө, чүдэнзний модоор хөдөлгөөн илэрхийлсэн зүй тогтлыг үргэлжлүүлнэ. Үүсгэсэн зүй тогтлыг найзууддаа үзүүлж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ дараалалд ямар дүрс хамгийн олон байна вэ?
- Аль өнгө давтагдаж байна вэ?
- Хэрвээ дараагийн дүрсийг нэмбэл ямар дүрс байх ёстой вэ?

Үйл ажиллагаа 2. Хувцасны хээ (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Монгол дээл, бүс, малгай, цүнхний зураг (бэлэн загвар), өнгийн цаас, тууз, цавуу, хайч, 0-10 хүртэлх цифр бичсэн үзүүлэн, хувцас загварын сэтгүүл, зураг, зүй тогтол бүхий загварууд, эсгий бал, усан будаг, бийр

Аргачлал: Хувцас загварын сэтгүүл, зураг үзнэ. Хувцсанд хээ, дүрс зураг байдаг, үндэсний хувцасны өнгө, хээний талаар ярилцана. Дээл, малгай, бүсийг дүрс ашиглан хээний зүй тогтол үүсгэж чимэглэнэ. Өөрийн урласан дээл, малгай, бүс, цүнхийг ямар дүрсээр чимэглэсэн талаар танилцуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чиний дээлийн хээ ямар зүй тогтлоор хийгдсэн байна вэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 49, дасгал №49](#)

Үйл ажиллагаа 3. Загварын үзүүлбэр (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурж чимэглэсэн монгол дээл, бүс, малгай, цүнх, хөгжим, ая

Аргачлал: Тайзан дээр гарах дарааллыг урьдчилан тогтоно. Чимэглэж зохион бүтээсэн хувцсаа барьж, тайзан дээр үзүүлж алхана. Хөтлөгч загвар бүтээсэн хүүхдийг товч танилцуулна. Бүх хүүхэд загвар үзүүлсний дараа хамтдаа дахин гарч алхана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ өнгийг яагаад сонгосон бэ?
- Ямар хээ ашиглаж чимэглэсэн бэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 41, дасгал №41](#)

БИДНИЙ БАХАРХАЛ

Шинэ үгс: Зохиомж, ерөнхий

Үйл ажиллагаа 1. Бидний бүтээл (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Усан будаг, бийр, эсгий бал, цаас

Аргачлал: Баг болж “Монгол наадгай” сэдвийн хүрээнд сонгосон тоглоомын төрлөөр бүтээл хийнэ. Зураг зурж дууссаны дараа бүтээлийнхээ тухай, хэн юуг хийсэн талаар тайлбарлаж, ерөнхий нэрээр (шагайн тоглоом гэх мэт) нэрлэнэ.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Та нар ямар бүтээл хийсэн бэ?
- Та нар бүтээлдээ яагаад энэ нэрийг өгөх болсон бэ?

Үйл ажиллагаа 2. Манай тоглолт (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: цаас, гуаш, бийр, баримлын шавар, өнгийн цаас, хайч

Аргачлал: Багаар ажиллана. Нэг тоглоомын баатрыг өөрөө зохион бодож (шагайн морь, ..гэх мэт) сонгоно. Сонгосон баатраа дүрслэн зурах, барих эсвэл цаасан маск хэлбэрээр урлана. “Тоглоомын уулзалт” нэртэй богино жүжиг найруулж (хийх үйлдэл, хэлэх үгээ өөрсдөө тохирно) тоглоно. Тоглоомын баатрууд бүгд нэгэн онцгой уулзалтад иржээ. Тэд хэн болохоо танилцуулж, бие биетэйгээ найзалж гэнэ. Ая эгшиглэж, баатрууд нэг нэгээрээ тайзнаа гарч ирэн өөрийгөө танилцуулна. (Би бол Шагайн морь. Би уралдаанд хамгийн хурдан нь.)

Баатруудыг танилцуулж дуусаад хамт бүжиглэж, “Тоглоомын ертөнцөд эвтэй найртай байгаарай” гээд баяр хүргэнэ.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Та нар хамтдаа ямар зохиол гаргасан бэ?
- Хэн ямар дүр бүтээсэн бэ?
- Тэр баатар юу хийдэг, ямар наадгайд оролцдог вэ?

Сонсьё, дэмжье:

Зурагт ном, тоглоомоос ардын уламжлалт тоглоом наадгайг таньж нэрлэх, тоглох аргачлал, дүрмийг тайлбарлах, танин мэдэхүйн нэвтрүүлэг, видео бичлэг үзэж, үйл явдлын талаар өөрийн санаа бодлоо илэрхийлэх боломж олгоорой. Тоглоомын явцад хүүхдийн хэлж буй үг, хийж буй үйлдлийг ажиглаж, сонсох, танин мэдэхүйн түвшинд тохирсон асуулт асууж, ярих чадварыг дэмжээрэй.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Гэр бүлийн орчинд шагай цуглуулах, хамтдаа тоглох гэртээ шагайн буултыг нэрлэх хэд байна вэ? бүлэглэх, ангилах, харьцуулах, шагайг хүндэтгэх дээдлэх, шагайн уут оёж хадгалах, хамгаалах, угаах, цэвэрлэх үйлд оролцох боломж олгоно.
- Хүүхдийнхээ бусдаас зөвшөөрөл хүсэх, найзтайгаа хуваалцаж хэрэглэх, бусдад туслах, урам зориг өгөх зэрэг ач тустай үйлийг нь дэмжиж урамшуулахыг зөвлөөрэй.
- Шагай таалцах, шагай шүүрэх, шагай няслах, дөрвөн бэрх зэрэг шагайн наадгайг гэр бүлээрээ хамтдаа тоглохыг дэмжээрэй.
- Хүүхдэдээ цаг гаргаж ном унших, үйл явдлын талаар асуулт асууж ярилцах, өөрийн үндэсний эд хэрэгслийг таньж нэрлүүлэх, тайлбарлан ярилцах талаар зөвлөөрэй.
- Эцэг эх, асран хамгаалагчдад шагай цуглуулах, шагайн уут, олбог хийх үйлд хамтран оролцох, гэр бүлийн орчинд хамтдаа тоглохыг санал болгох, тоглоомын дүрэм, аргачлал илгээж дэмжлэг үзүүлээрэй.

Багшийн эргэцүүлэл

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн:</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p>

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- II САР
ЭРҮҮЛ ХҮНС

Хүүхдийн эзэмших чадамж:

Үндэсний болон дэлхийн өв соёл: Үндэсний өв соёлын онцлогийг танин мэдэх, суралцах,

Бүтээлчээр сэтгэх: Сэдвийн хүрээнд зохиомжлон зурах, чимэглэх

Шүүн тунгаах: Эрүүл хооллолтын талаар мэдлэгээ бататгах, туршилт хийх, ажиглах, таамаглал дэвшүүлэх, харьцуулах, тэмдэглэх

Харилцах: Сэтгэл хөдлөлөө илэрхийлэх

Хамтран ажиллах: Бусдын санаа бодлыг сонсох, дүрэм дагаж мөрдөх

Аюулгүй байдлын зөвлөмж:

Туршилтын өмнө гараа угаах, бээлийн өмсөх, хийсэн хугацааг тэмдэглэх, ашиглах хэрэглэгдэхүүнийг угааж ариутгаарай.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Хүний биед хэрэгтэй хүнсний бүтээгдэхүүний талаар ярилцахад нь дэмжээрэй.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- “Ааруулын амт” зохиолыг танилцуулах, өөрийн хийж чадах, чадахгүй зүйлийг илэрхийлэн ярих, зохиолын төгсгөл хэсгийг зохиож зураад ярих боломжийг олгоорой.

Төвийн үйл ажиллагаа:

- Туршилт хийхдээ аарцанд ямар өнгө, амт оруулахад нь дэмжлэг үзүүлээрэй. Хийсэн уутаа чимэглэхэд нь хүүхэд бүтээлчээр зохиож урлах боломжийг өгч чиглүүлээрэй.

Номын цаг:

- “Ойлгоё, хайрлая” номыг урьдчилан судалж, чанга уншлагын санал болгосон хувилбарыг хэрэгжүүлээрэй.

Хөгжөөн баясах цаг:

- Тоглоомоор дамжуулан хүний биед хэрэгтэй хүнсний бүтээгдэхүүн сонгох хөгжөөнт үйл ажиллагаа зохион байгуулаарай.
- Зохиолын дүрд хувирч тоглохдоо чаддаг зүйлийг дэмжиж тохирсон дэмжлэгийг өгөөрэй.

Боломжууд:

- Ааруулын амт зохиолоор дамжуулан Монгол өв уламжлалыг танилцуулж, ,
- Чанга унших зориулалт бүхий “Ойлгоё, хайрлая” номын 34-35 дугаар хуудсан дээрх “Бусдыг ойлгоё” тоглоомуудыг дараагийн 14 хоногийн сургалт, үйл ажиллагаанд хэрэгжүүлж болно.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>ХЯ4.1а. Зохиолын агуулгыг сонсоод ойлгосноо өөрийн үгээр илэрхийлнэ.</p> <p>НСХ4.1б. Өөрийн дуртай дургүй, чадах чадахгүй зүйлсийг тайлбарлаж сонголт хийдэг болно.</p> <p>ХЭМ4.1в. Гараа алдлан нэг хөлөө арагш шулуун өргөн тэнцвэр хадгалан (хараацай) зогсоно.</p>	<ul style="list-style-type: none">- Сонссон зүйлээ дахин давтан ярих, агуулгыг онцолж ярих, шинэ үгийг тайлбарлах зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцох- Чадахгүй байгаа зүйлээ чаддаг болох, өөртөө итгэх итгэл, тууштай байдал бүхий агуулгатай ном зохиол уншиж ярилцах.- Нэг хөл дээр тэнцвэрээ хадгалан зогсож гарын хөдөлгөөнийг янз бүрээр хөдөлгөн зогсох	Би чадна
<p>БНО4.2д. Өөрийн үндэсний өв соёлыг бусад үндэстний соёлоос ялган таньж, уламжлалт зан үйл, ёс заншлаар бахархана.</p> <p>МАТ4.2а. Юмсын урт, хүнд, багтаамжийг таамаглаад, харьцуулж, тайлбарлана.</p> <p>ЗУ4.3в.Тоглоом болон байгалийн материал, дахин ашиглах материалаас сонгож шинэ загвар бүтээнэ.</p>	<ul style="list-style-type: none">- Сонссон зүйлээ дахин давтан ярих, агуулгыг онцолж ярих, шинэ үгийг тайлбарлах зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцох- Юмсын багтаамжийг (харьцуулах)- 4-5 нугалаасыг зааврын дагуу эвхэж бүтээл урлах	Ааруул хийе
<p>ХЭМ4.2в. Хүнсний бүтээгдэхүүний төрлийг мэдэж, насанд хүрэгчтэй хамтран хялбар зууш бэлтгэнэ.</p> <p>ЗУ4.2а. Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон зурна.</p>	<ul style="list-style-type: none">- Эрүүл мэндэд тустай болон сөрөг нөлөөтэй хоол хүнсийг ялгах- Хүн, амьтны дүр төрхийг илэрхийлж зурах	Миний дуртай амттан
<p>ХӨГ4.1а. Хөгжмийн энгийн зэмсгийг дуугаралтаар ялгаж, аялгууны өнгө аясыг мэдэрнэ</p> <p>ХӨГ4.1г. Хэмнэл, хурд, өнгө аясад тохируулан хөдөлгөөнөө илэрхийлнэ.</p> <p>ХЭМ4.1а. Гарын сарвуу, хөлийн, тавхайн хэсгээр хийх зохиомжит дасгалыг босоо, суугаа байрлалд дарааллын дагуу гүйцэтгэнэ.</p>	<ul style="list-style-type: none">- Аяыг сонсоод ямар хөгжмийн зэмсгээр тоглосныг таньж, нэрлэх- Дууны аяны хурд хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө зохицуулах- Гарын сарвуу, хөлийн тавхайн хөдөлгөөнтэй хослуулан хийх	Хуурын татлагат биелгээ
<p>НСХ4.2б. Бусдын нөхцөл байдалд тохируулан энэрэх үйлдэл үзүүлдэг болно.</p> <p>ХЯ4.3в. Дармал үсгийг дуурайж бичнэ.</p>	<ul style="list-style-type: none">- Бусдад туслах тухай үлгэр зохиолтой танилцаж, өөрийн хэмжээнд энэрч туслах- Ханын самбар болон талбай дээр өнгийн шохойгоор бичих	Би чамд туслах уу

<p>ХЭМ4.2ж. Цаг агаарын үзэгдлийг ажиглан өөрийгөө болон бусдыг хамгаалах үйлдэл санаачлан хийнэ.</p> <p>БНО4.2а. Өөрийнхөө тухай танилцуулж, бусдын сонирхол, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандана.</p>	<ul style="list-style-type: none"> - Гал гарах, газар хөдлөх, үер ус, шуурга бусад гамшгийн үед хэрхэн өөрийгөө хамгаалах талаар дасгал сургуулилт хийх (Жишээ нь: СУУ, НУУГД, ХҮЛЭЭ дүрэм, тусламж дуудах, цэцэрлэгийн ослын гарц руу очих гэх мэт) - “Найзуудын ялгаатай болон ижил тал” тоглоом 	<p>Суу, нуугд, хүлээ</p>
-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	--------------------------

Албан хэрэгцээнд

2 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Хичээгээрэй найзаа	Тойргийн цаг	Хүүхдүүд өөрийн сайн чаддаг зүйлийнхээ талаар ярина. Хүүхдүүд өөрийн чадахгүй зүйлийг яагаад чадахгүй байгаагаа ярихад сонсогч хүүхдүүд хэрхэн хичээвэл чаддаг болох тухай хэлж найзыгаа дэмжинэ.	Ярилцлага	Чиний хамгийн сайн хийж чаддаг зүйл юу вэ? Чамд хийж чадахгүй зүйл байгаа юу? Чадахгүй зүйлээ чаддаг болохын тулд чи юу хийх хэрэгтэй вэ?	Харилцах: Үзсэн зүйлийн талаар ярих, асуултын дагуу санаа бодлоо илэрхийлэх	Өөрийн чадахгүй чадахгүй зүйлийг хэлдэг.
Ааруулын амт	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Т.Юмсүрэн “Ааруулын амт” зохиолыг уншиж танилцуулна. Зохиолд гарсан шинэ үгийг тайлбарлаж, асуултын дагуу ярилцана. Зурагт картон дээр ажлыг хараад хийж чадах бол баруун, хийж чадахгүй бол зүүн тийш эргэж цувааны ард очиж зогсохыг тайлбарлана. Багш хөгжим эхлэхэд зургийг харуулж сонголт хийлгэнэ.	“Ааруулын амт” зохиол- Үлгэр Ааруулын амт , төрөл бүрийн ажил хийж байгаа зурагт карт 4-5ш (хог шүүрдэх, аяга угаах, аргал оруулах гэх мэт.)	Зохиолд ямар үйл явдал гарсан бэ? Бадрах ямар ажил хийж чаддаг вэ? (усанд явах, аргал оруулах, хонио хариулах) Яагаад Бадрахад ааруул амттай санагдсан бэ?	Харилцах: Үзсэн зүйлийн талаар ярих, асуултын дагуу санаа бодлоо илэрхийлэх	Зохиолыг үйл явдлыг дарааллыг дагуу ярьж чаддаг.
Тэнцвэрээ олоорой	Хөгжөөн баясгах цаг	Хүүхдүүдийг хоёр, хоёроороо гэх заавар өгч хүүхдүүд хосоороо болно. Багшийн үзүүлсэн зурган картын дагуу тэнцвэрээ олж зогсоно.	Тэнцвэрийн дасгалын хувилбаруудын зураг	Хөдөлгөөнт тоглоом	ХЭМ, ХӨГ: Хэмнэл, хурдад тохируулан хөдөлгөөнөө зохицуулах. Тэнцвэр хадгалах.	"Хараацай" зогсолтоор тэнцвэр хадгалан зогсдог. Хөгжмийн хэмнэл, хурдад тохируулан

						биеийн хөдөлгөөнөө зохицуулдаг.
Амттан хийцгээе	Төвийн үйл ажиллагаа	Туршилт танин мэдэхүйн төв: Хүнсний бүтээгдэхүүнээс (жимс, зөгийн бал, элсэн чихэр гэх мэт) сонгож ааруул хийнэ. Математикийн төв: Хэвлэсэн ааруулаа төрөл бүрийн жимснээс сонгон чимэглэн бүтээлчээр зохиомжилно. Зураг, урлалын төв: Хүүхдүүд хэвлэсэн ааруулаа хадгалах, “Ааруулын үзэсгэлэн”-д бэлтгэх зорилгоор цаасан уут хийнэ.	Аарц, жимсний өтгөрүүлсэн шүүс, бор элсэн чихэр, зөгийн бал, сүү, Өнгийн цаас, цавуу, усан будаг, гуаш, Жимс, ааруулын хэв, дэлгэц мод, халбага, бээлий	Ааруулыг юугаар хийдэг вэ? Ааруул хийхэд юу хэрэгтэй вэ? Та нарын хийсэн ааруул ямар өнгө, амттай болсон бэ? Яагаад зарим нь тод өнгөтэй, амттай болсон бэ?	Шүүн тунгаах: Туршилт хийх, ажиглах, харьцуулах, тэмдэглэл хөтлөх. Бүтээлчээр сэтгэх: Зохиомжлон чимэглэх. Бүтээлчээр сэтгэх: Тоглоом болон дахин ашиглах материалаас шинэ загвар бүтээх.	Хүнсний төрлийг мэдэж, хялбар зууш бэлтгэдэг. Өрөх, барих, наах, эвлүүлэх, угсрах, аргаар тоглоом, эд юмс бүтээдэг.
Хамтдаа хөгжилдье	Хөгжөөн баясах цаг	Дээрх зүйлсийг урт утсаар уяж, амттаныг хүүхдэд харагдахгүйгээр байрлуулна. Бүх хүүхэд утаснаас татаж амттан авсны дараа хэн, юу сугалсан тухай ярилцана. Хамтдаа амттанаа иднэ.	Үрлэн ааруул, хурууд, витамин, зөв аарц, алим, банана, луувангийн шүүс гэх мэт (хүүхдийн тоогоор)	Хөгжөөнт тоглоом	Шүүн тунгаах: Эрүүл мэндэд тустай хоол хүнсийг ялгах.	Юунд яагаад дуртай, дургүй вэ гэдгээ тайлбарлаж сонголт хийдэг.
Эрүүл хүнс	Тойргийн цаг	Хүний биед тустай болон сөрөг хүнсний тухай ярилцана.	Ярилцлага.	Эрүүл мэндэд сайн ямар хүнсний бүтээгдэхүүн мэдэх вэ? Яагаад?	Шүүн тунгаах: Эрүүл мэндэд тустай хоол хүнсийг ялгах.	Хүний биед тустай болон тусгүй хүнсийг мэддэг.

Бидний дуртай амттан	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Зурсан зургаа тойрог хэлбэрээр бүх хүүхдэд харагдахуйц газарт байрлуулж ажиглан, хүний биед хэрэгтэй амттаны зургийг сонгон хайчилж аваад хананд байрлуулж ярилцана.	Бийр усан будаг, тосон харандаа, хуудас цаас, хайч	Яагаад энэ зургийг сонгосон бэ? Биед хэрэгтэй хүнс хэрэглэх нь ямар ач холбогдолтой вэ?	Шүүн тунгаах: Эрүүл мэндэд тустай хоол хүнсийг ялгах. Бүтээлчээр сэтгэх: Сэдвийн хүрээнд зохиомжлон зурах.	Сэдвийн хүрээнд зурдаг.
Ширээний театр	Хөгжөөн баясах цаг	“Ааруулын амт” зохиолыг ярьж өгнө. Зохиолын үйл явдлын тухай ярилцана	Ширээний театр, ээж, хүүхэд бүхий загвар үзүүлэн, аргал, хувинтай ус, ааруул гэх мэт.	Чи аав, ээждээ хэрхэн тусалдаг вэ? Ямар хүнийг ажилд гэж нэрлэдэг вэ?	Харилцах: Үзсэн зүйлийн талаар ярих, асуултын дагуу санаа бодлоо илэрхийлэх	Зохиолыг үйл явдлыг дарааллыг дагуу ярьж чаддаг.
Хуурын татлага	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Багш морин хуурын татлагын хэмнэл, аялгууг тайлбарлана. <i>Бий биелгээ:</i> Бий биелгээний бичлэгийг тоглуулан харуулна. Биелгээний талаар ярилцана.	Хуурын татлагын бичлэг: https://www.youtube.com/watch?v=vw3iGGfPzqA Бий биелгээ видео бичлэг: https://www.youtube.com/watch?v=lifROeTmcU	Бий биелгээ хийнэ.	Үндэсний өв соёл: Морин хуур, бий биелгээг танин мэдэх. ХӨГ: Аялгууны өнгө аясыг мэдрэх, хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө зохицуулах.	Хөгжмийн зэмсгүүдийн дуугаралтыг ялгаж, нэрлэж, харьцуулан тайлбарлаж чаддаг. Зохиомжит дасгалыг (гарын сарвуу, хөлийн тавхайн хөдөлгөөн) даган дуурайж гүйцэтгэдэг.
Чанга уншлага 1	Номын цаг	Багш номыг урьдчилан судалсан байна. Энэ ном нь бусдын мэдрэмжийг ойлгож сурахад тусалдаг. Одоо бүгдээрээ хэрхэн бусдыг	“Ойлгоё, хайрлая” зурагт ном	Мэдрэмж гэж юу вэ?	Хамтран ажиллах: Бусдад санаа тавьж, энэрэх үйлдэл үзүүлэх.	Бусдын ойлгож туслах үйлдэл хийдэг.

		ойлгож болохыг мэдэж авцгаая. Номыг чангаар уншиж өгнө. Шинэ үгийн товч тайлбарыг зохиол унших зуураа хавчуулна.		Эдгээр хүүхдүүдийн сэтгэл санаа ямар байна вэ? Энэ хүнд ямар мэдрэмж төрж байгаа гэж бодож байна вэ?		
Дуутай сандал	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүдийг ая зогсоход байрандаа зогсож өөрийн урд байрлах сандал дээрх зурган картын хөдөлгөөнийг дуурайж зогсоно.	Зурган карт, сандал	Хөдөлгөөнт тоглоом	ХӨГ: Аялгууны өнгө аясыг мэдрэх, хэмнэлд тохируулан хөдөлгөөнөө зохицуулах	Хөгжмийн хэмнэлд тохируулан хөдөлгөөн хийдэг.
Тусч хүүхэд	Төвийн үйл ажиллагаа	Хэл яриа-номын төв: Элсэн самбар дээр өөрийн нэрийг дуурайж зурна. Зураг урлалын төв: Ааруулын амт зохиолын үйл явдлыг зурж шүхрээр театр хийнэ. Тоглоомын төв: “Надад туслаарай” зурган карт хийнэ.	Хүүхдийн нэрс, элсэн самбар, шүхэр, үлгэрийн үйл явдлын зураг	Төвд ажиллана.	Бүтээлчээр сэтгэх: Үсэг бүтээх, зохиомжлох. ХЯ: Дармал үсгийг дуурайж бичих.	Үсэг, зургийг ялгадаг.
Чанга уншлага 2	Номын цаг	Номыг чангаар уншиж өгөх явцдаа энэ хүүхдэд ямар мэдрэмж төрж байгаа бол? зэргээр 3-4 асуулт асууж ярилцана. Багш номын 32-33 дугаар хуудсанд байгаа	“Ойлгоё, хайрлая” зурагт ном	Хэн нэгэнд ямар мэдрэмж төрж байгааг олж мэдэхийн тулд юу гэж асууж болох вэ?	Хамтран ажиллах: Бусдад санаа тавьж, энэрэх үйлдэл үзүүлэх.	Бусдын ойлгож туслах үйлдэл хийдэг.

		асуултуудаас сонгож бэлдсэн байна.				
Ааруулын үзэсгэлэн	Хөгжөөн баясах цаг	Хүүхдүүд хэвлэсэн ааруул болон хатсаны дараах өөрчлөлтийг ажиглаж, ярилцана. Савласан ууттай ааруулыг үзэсгэлэнд байршуулна.	Ширээ, бүтээлэг, таваг, нэр хаяг	Үзэсгэлэн гаргана.	МАТ: Багтаамжийг таамаглах, тоолох, харьцуулах.	Багтаамжийг таамаглан, туршин харьцуулж тайлбарладаг.
Өөрийгөө хамгаалъя	Тойргийн цаг	Өнөөдрийн цаг агаарын тухай ярилцана. Цэцэрлэгт ирэхэд цаг агаар ямар байсан тухай хүүхдүүд санаа бодлоо хэлнэ. Гэнэтийн осол, аюулын талаар юу мэддэг тухай асуулт асууна.	Зурагт үзүүлэн (гал, ус, цахилгаан, нохой, газар хөдлөлт, халтиргаа, өндөр гэх мэт ослын зураг)	Өнөөдөр цаг агаар ямар байсан бэ? Осол, аюул тохиолдвол хамгийн түрүүнд хэнд хэлэх вэ?	Аюулгүй байдал: Орчныг шалгаж, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх.	Цаг агаарын тухай өөрийн санаа бодлоо хэлдэг.
Газар хөдлөлтийн үед өөрийгөө хамгаалъя	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Туршилтаар газар хөдлөлтийн чичиргээг ажиглаж, ямар өөрчлөлт гарч байгааг ярилцана.	Өрж байгуулах тоглоом, будаа, элсэн чихэр	Сандлыг хөдөлгөхөд юу өөрчлөгдсөн бэ? Газар хөдлөлтийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?	Аюулгүй байдал: “Суу, нуугд, хүлээ” дүрмийг хэвшүүлэх. Хамтран ажиллах: Дүрэм дагах.	Аюултай үзэгдлээс өөрийгөө хамгаалах дүрмийг мэддэг.
Чанга уншлага 3	Номын цаг	Номыг чангаар уншиж өгөх явцдаа хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарна. Бид бусдыг хэцүү байгаа үед ойлгож, энэрч туслахыг мэдэж авсан талаар дүгнэнэ.	“Ойлгоё, хайрлая” зурагт ном	Бусдыг ойлгохын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?	Хамтран ажиллах: Бусдад санаа тавьж, энэрэх үйлдэл үзүүлэх.	Бусдын ойлгож туслах үйлдэл хийдэг.

2 дугаар сарын I долоо хоног

БИ ЧАДНА

Шинэ үгс: Илэрхийлэх, сонголт

Үйл ажиллагаа 1. Хичээгээрэй найзаа (Тойргийн цаг)

Аргачлал: Хүүхдүүд өөрийн сайн чаддаг зүйлийнхээ талаар ярина. Хүүхдүүд өөрийн чадахгүй зүйлийг яагаад чадахгүй байгаагаа ярихад сонсогч хүүхдүүд хэрхэн хичээвэл чаддаг болох тухай хэлж найзыгаа дэмжинэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чиний хамгийн сайн хийж чаддаг зүйл юу вэ?
- Чамд хийж чадахгүй зүйл байгаа юу?
- Чадахгүй зүйлээ чаддаг болохын тулд чи юу хийх хэрэгтэй вэ?

Үйл ажиллагаа 2. Ааруулын амт (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: “Ааруулын амт” зохиол-Үлгэр Ааруулын амт, төрөл бүрийн ажил хийж байгаа зурагт карт 4-5ш (хог шүүрдэх, аяга угаах, аргал оруулах гэх мэт.)

Аргачлал: Т.Юмсүрэн “Ааруулын амт” зохиолыг уншиж танилцуулна. Зохиолд гарсан шинэ үгийг тайлбарлаж, асуултын дагуу ярилцана.

Зурагт картон дээр ажлын зургийг хараад хийж чадах бол баруун, хийж чадахгүй бол зүүн тийш эргэж цувааны ард очиж зогсохыг тайлбарлана. Багш хөгжим эхлэхэд зургийг харуулж сонголт хийлгэнэ. Хүүхэд зургийг хараад хийж чаддаг бол баруун тийш, чадахгүй бол зүүн тийш эргэх байдлаар тоглоом үргэлжилнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Зохиолд ямар үйл явдал гарсан бэ?
- Бадрах ямар ажил хийж чаддаг вэ? (усанд явах, аргал оруулах, хонио хариулах)
- Яагаад Бадрахад ааруул амттай санагдсан бэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 16, дасгал №16](#)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 51, дасгал №51](#)

Үйл ажиллагаа 3. Тэнцвэрээ олоорой (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Тэнцвэрийн дасгалын хувилбаруудын зураг

Аргачлал: “Хүүхдүүд ээ гүйгээрэй” гэж хэлээд гүйлгэнэ. “Хүүхдүүдээ зогсоорой” гэх заавраар бүх хүүхэд хөдөлгөөнгүй зогсоно. Хүүхдүүдийг хоёр, хоёроороо гэх заавар өгч хүүхдүүд хосоороо болно. Багшийн үзүүлсэн зурган картын дагуу тэнцвэрээ олж зогсоно. Тэнцвэрээ хадгалан зогсож хөдөлгөөнөө гүйцэтгэж чадаагүй хүүхдүүд хасагдах дүрмээр тоглоомыг цааш үргэлжлүүлэн тоглож үлдсэн хүүхэд ялагч болно.

ААРУУЛ ХИЙЕ

Шинэ үг: Багтаамж, зохион бүтээх

Хэрэглэгдэхүүн: Сав, өнгийн цаас, бичлэг

<https://www.facebook.com/gerteee/videos/569612893390484>

Үйл ажиллагаа 1. Амттан хийцгээ (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Аарц, жимсний өтгөрүүлсэн шүүс, бор элсэн чихэр, зөгийн бал, сүү, Өнгийн цаас, цавуу, усан будаг, гуаш, Жимс, ааруулын хэв, дэлгэц мод, халбага, бээлий

Аргачлал: “Ааруулыг юугаар хийдэг вэ? Ааруул хийхэд юу хэрэгтэй вэ?” гэсэн асуултаар ярилцана.

Туршилт танин мэдэхүйн төв: Хүнсний бүтээгдэхүүнээс (жимс, зөгийн бал, элсэн чихэр гэх мэт) сонгож ааруул хийнэ. Аарц дээрээ элсэн чихэр, жимсний шүүс, зөгийн бал, сүүг сонгон хийж хутгаад амсаж үзнэ. Өнгө, амт, үнэр хэрхэн өөрчлөгдсөн талаар ярилцаж ажлын хуудсанд тэмдэглэнэ.

Математикийн төв:

Хүүхдүүд ааруул хийх хэвээ дэлгэц дээр байрлуулж, хэдэн ааруул багтахыг тооцоолж таамаглана. Өөрийн сонгосон хивэнд аягатай аарцаа хийж ааруул хэвлэнэ. Хосоороо ажиллаж, хэвлэсэн ааруулаа тоолж дүнг хэлнэ. Ижил хэмжээний аарц ашигласан ч ааруулын тоо өөр байгааг ярилцаж, яагаад өөрчлөгдөж байгааг тайлбарлуулна. Хэвлэсэн ааруулаа

төрөл бүрийн жимснээс сонгон чимэглэн бүтээлчээр зохиомжилно. Хэлбэрт оруулсан аарцаа хатах орчинд байрлуулж тавина.

Зураг урлалын төв: Хүүхдүүд хэвлэсэн ааруулаа хадгалах, “Ааруулын үзэсгэлэн”-д бэлтгэх зорилгоор цаасан уут хийнэ. Уутнуудыг ажиглаад хэний уут хамгийн урт, богино байгааг харьцуулж ярилцана.

- Өнгийн цаасыг ашиглан төрөл бүрийн хэлбэр, хэмжээтэй уут хийнэ.
- Уутны өнгө, хэмжээ, чимэглэлийг хүүхэд өөрөө сонгож бүтээлчээр ажиллана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Та нарын хийсэн ааруул ямар өнгө, амттай болсон бэ?
- Яагаад зарим нь тод өнгөтэй, амттай болсон бэ?

Дасгал ажлын дэвтэр хуудас 53, дасгал №53

Үйл ажиллагаа 2. Хамтдаа хөгжилдье (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Үрлэн ааруул, хурууд, витамин, зөв аарц, алим, банаана, луувангийн шүүс гэх мэт (хүүхдийн тоогоор)

Аргачлал: Дээрх зүйлсийг урт утсаар уяж, амттаныг хүүхдэд харагдахгүйгээр байрлуулна. Хүүхдүүд ээлжлэн гарч ирж аль нэг утсыг татна. Гарч ирсэн амттаныг бусдадаа харуулна. Бүх хүүхэд утаснаас татаж амттан авсны дараа хэн, юу сугалсан тухай ярилцана. Хамтдаа амттанаа иднэ.

МИНИЙ ДУРТАЙ АМТТАН

Шинэ үг: Хүнсний бүтээгдэхүүн, эерэг сөрөг (эрүүл мэнд)

Үйл ажиллагаа 1. Эрүүл хүнс (Тойргийн цаг)

Аргачлал: Хүний биед тустай болон сөрөг хүнсний тухай ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Эрүүл мэндэд сайн ямар хүнсний бүтээгдэхүүн мэдэх вэ? Яагаад?
- Эрүүл мэндэд сөрөг ямар хүнсний бүтээгдэхүүн мэдэх вэ? Яагаад?

Үйл ажиллагаа 2. Бидний дуртай амттан (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Бийр усан будаг, тосон харандаа, хуудас цаас, хайч

Аргачлал: Миний дуртай амттан сэдвийн хүрээнд зургийн багаж хэрэгслээс сонгож зурна. Зурсан зургаа тойрог хэлбэрээр бүх хүүхдэд харагдахуйц газарт байрлуулж ажиглан, хүний биед хэрэгтэй амттаны зургийг сонгон хайчилж аваад хананд байрлуулж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Яагаад энэ зургийг сонгосон бэ?
- Биед хэрэгтэй хүнс хэрэглэх нь ямар ач холбогдолтой вэ?

Дасгал ажлын дэвтэр хуудас 55, дасгал №55

Дасгал ажлын дэвтэр хуудас 63, дасгал №63

Үйл ажиллагаа 3. Ширээний театр (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Ширээний театр, ээж, хүүхэд бүхий загвар үзүүлэн, аргал, хувинтай ус, ааруул гэх мэт

Аргачлал: “Ааруулын амт” зохиолыг ярьж өгнө. Зохиолын үйл явдлын тухай ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Чи аав, ээждээ хэрхэн тусалдаг вэ?
- Ямар хүнийг ажилсаг гэж нэрлэдэг вэ?

2 дугаар сарын II долоо хоног

ХУУРЫН ТАТЛАГАТ БИЕЛГЭЭ

Шинэ үг: Аялгуу, хурд, зохиомжит дасгал

Үйл ажиллагаа 1. Хуурын татлага (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хуурын татлагын бичлэг:

<https://www.youtube.com/watch?v=vw3iGGfPzqA>

Бий биелгээ видео бичлэг: <https://www.youtube.com/watch?v=lifROeTmcU>

Аргачлал: Морин хуурын татлагын богинохон хэсгийг тоглуулж, тайван чимээгүй сонгоно. Юу сонссон бэ? ямар хөгжим тоглосон бэ? Хэмнэлд ямар өөрчлөлт гарсан бэ? ямар сэтгэгдэл төрсөн талаар хүүхдүүдтэй харилцан ярилцана. Төрсөн сэтгэгдлээ зураарай. Багш морин хуурын татлагын хэмнэл, аялгууг тайлбарлана.

Бий биелгээ:

- Бий биелгээний бичлэгийг тоглуулан харуулна. Биелгээний талаар ярилцана.
- Морин хуурын аялгуунд тохируулан биелгээний хөнгөн хөдөлгөөнүүдийг хамтдаа хийхэд бэлэн үү?"
- Хөгжмийг тоглуулан багш хүүхдүүдэд бий биелгээний үндсэн хөдөлгөөнийг хийж үзүүлнэ. Хүүхдүүд хөдөлгөөнийг хуурын аянд тохируулан хийнэ.

Үйл ажиллагаа 2. Чанга уншлага 1 - Ойлгоё, хайрлая (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: "Ойлгоё, хайрлая" зурагт ном

Аргачлал: Багш номыг урьдчилан судалсан байна. Энэ ном нь бусдын мэдрэмжийг ойлгож сурахад тусалдаг. Одоо бүгдээрээ хэрхэн бусдыг ойлгож болохыг мэдэж авцгаая. Номыг чангаар уншиж өгнө. Шинэ үгийн товч тайлбарыг зохиол унших зуураа хавчуулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Мэдрэмж гэж юу вэ?
- Эдгээр хүүхдүүдийн сэтгэл санаа ямар байна вэ? (6-р хуудас)
- Энэ хүнд ямар мэдрэмж төрж байгаа гэж бодож байна вэ? (24-р хуудас)

Үйл ажиллагаа 3. Дуутай сандал (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурган карт, сандал

Аргачлал: Хүүхдүүдийг сандлын ард зогсооно. Ая эхлэхэд алхалтыг гарын янз бүрийн хөдөлгөөнтэй хослуулан сандлаа тойроод алхана. Ая зогсоход байрандаа зогсож өөрийн урд байрлах сандал дээрх зурган картын хөдөлгөөнийг дуурайж зогсоно.

БИ ЧАМД ТУСЛАХ УУ?

Шинэ үг: Энэрэх, дармал үсэг, дуурайх

Хэрэглэгдэхүүн: Элсэн самбар, бүлгийн хүүхдийн цээж зураг, хүүхдүүдийн нэртэй карт, маркер, шүхэр, цаас, эсгий бал, хайч, цавуу

Үйл ажиллагаа 1. Тусч хүүхэд (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хүүхдийн нэрс, элсэн самбар, шүхэр, үлгэрийн үйл явдлын зураг

Аргачлал:

Хэл яриа-номын төв: Багш хүүхэд бүрийн нэрийг хэвлэж бэлтгэсэн байна. Элсэн самбар дээр өөрийн нэрийг дуурайж зурна. Өөрийн нэрийн үсгийг хуруугаараа элсэн дээр дуурайн бичнэ.

Зураг урлалын төв: Ааруулын амт зохиолын үйл явдлыг зурж шүхрээр театр хийнэ.

- Гэр дээр тавьсан хатааж буй ааруул
- Аргалын зураг
- Голоос ус зөөж байгаа зураг
- Хонь хариулж буй зураг
- Ээж нь хүүдээ аруул өгч буй зураг
- Хүүхэд ааруул идэж байгаа зураг гэх мэт.

Шүхрэн театрыг хөгжөөн баясгах цагт ашиглаж болно.

Тоглоомын төв: "Надад туслаарай" зурган карт хийнэ. Хэрэв хэн нэгний тусламж хэрэгтэй бол зурган картыг өргөнө. Зурган картыг өргөсөн хүүхэд дээр очиж, зургийг ажиглаад юу тохиолдсон, ямар тусламж хэрэгтэй байгаа талаар ярилцана. Найздаа тусалж байгаагаар тоглоно.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 62, дасгал №62](#)

Үйл ажиллагаа 2. Чанга уншлага 2 - Ойлгоё, хайрлая (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: "Ойлгоё, хайрлая" зурагт ном

Аргачлал: Номыг чангаар уншиж өгөх явцдаа энэ хүүхдэд ямар мэдрэмж төрж байгаа бол? зэргээр 3-4 асуулт асууж ярилцана. Багш номын 32-33 дугаар хуудсанд байгаа асуултуудаас сонгож бэлдсэн байна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Хэн нэгэнд ямар мэдрэмж төрж байгааг олж мэдэхийн тулд юу гэж асууж болох вэ? (25-р хуудас)
- Чи яагаад бусад хүмүүсийн мэдрэмжийг ойлгохыг хүсэж байна вэ? (30-р хуудас)
- Хүмүүс биднийг өөр ямар үед өөрсдийг нь ойлгож, санаа тавиасай гэж хүсдэг бол? (31-р хуудас)

Үйл ажиллагаа 3. Ааруулын үзэсгэлэн (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Бүлгийн өрөөний тохиромжтой хэсэгт үзэсгэлэнгийн орчин бэлтгэнэ (ширээ, бүтээлэг, таваг, нэр хаяг).

Аргачлал: Бүлгийн өрөөний тохиромжтой хэсэгт “Ааруулын үзэсгэлэн” гаргах орчин бэлтгэсэн байна. (ширээ, бүтээлэг, таваг, нэр хаяг) Хүүхдүүд хэвлэсэн ааруул болон хатсаны дараах өөрчлөлтийг ажиглаж, ярилцана. Хатаасан ааруулыг зориулж хийсэн цаасан уутны хэмжээнд тохируулан тоолж хийгээд тоо, ширхгийг цэгээр тэмдэглэнэ. Савласан ууттай ааруулыг үзэсгэлэнд байршуулна. Ааруулыг оролцож байгаа хүүхдийн тоонд харгалзуулан хуваарилах, бусдад бэлэглэх, зэргээр үйл ажиллагааг өргөжүүлээрэй.

СУУ, НУУГД, ХҮЛЭЭ

Шинэ үг: Хамгаалах, үзэгдэл

Үйл ажиллагаа 1. Өөрийгөө хамгаалъя (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэн (гал, ус, цахилгаан, нохой, газар хөдлөлт, халтиргаа, өндөр гэх мэт ослын зураг),

Аргачлал: Өнөөдрийн цаг агаарын тухай ярилцана. Цэцэрлэгт ирэхэд цаг агаар ямар байсан тухай хүүхдүүд санаа бодлоо хэлнэ. Гэнэтийн осол, аюулын талаар юу мэддэг тухай асуулт асууна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Өнөөдөр цаг агаар ямар байсан бэ?
- Осол, аюул тохиолдвол хамгийн түрүүнд хэнд хэлэх вэ?

Үйл ажиллагаа 2. Газар хөдлөлтийн үед өөрийгөө хамгаалъя (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өрж байгуулах тоглоом, будаа, элсэн чихэр

Аргачлал: Тоглоомоор эд зүйлс бүтээж, цаасан дээр будаа, элсэн чихэр тавьж, сандлын тавцанд байрлуулаад сандлын хөлийг хөдөлгөж туршина. Туршилтаар газар хөдлөлтийн чичиргээг ажиглаж, ямар өөрчлөлт гарч байгааг ярилцана. Өөрийгөө хамгаалах, орчноо аюулгүй болгоход юу хийх талаар ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Сандлыг хөдөлгөхөд юу өөрчлөгдсөн бэ?
- Газар хөдлөлтийн үед өөрийгөө хэрхэн хамгаалах вэ?

Зөвлөмж:

- Газар хөдлөхөд шүүгээ зэрэг нурж унах аюултай. Энэ бол газар хөдлөлтийн үед анхаарах ёстой 1 дэх аюул юм. Хүүхдүүд ээ! Гараараа толгойгоо хамгаалаад доош сууж үзээрэй.
- Газар хөдлөхөд аяга таваг, цонхны шил хагарах аюултай. Энэ бол газар хөдлөлтийн үед анхаарах ёстой 2 дахь аюул юм.
- Гар, хөлөө гэмтээхгүйн тулд хагархай зүйлд ойртохгүй байх хэрэгтэй. Хөл нүцгэн явж болохгүй нь.
- Газар хөдлөх үед дээрээс унаж ирэх ном, чийдэн бол 3 дахь аюул юм. Гутлын шүүгээ шиг байрнаасаа хөдлөх зүйл бол 4 дэх аюул юм.
- Гэртээ байхдаа, цэцэрлэг, дэлгүүр эсвэл гадаа гэх мэт хаана ч байсан энэ 4 аюулыг анзаарч өөрийгөө хэрхэн хамгаалж болох талаар ярилцана.
- Багш газар хөдлөлтийн үед “Суу, Нуугд, Хүлээ” дүрэм мөрддөгийг хэлж өгнө.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 77, дасгал №77](#)

Үйл ажиллагаа 3. Чанга уншлага 3 - Ойлгоё, хайрлая (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: “Ойлгоё, хайрлая” зурагт ном

Аргачлал: Номыг чангаар уншиж өгөх явцдаа хүүхдүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарна. Номын 32-33 дугаар хуудсанд байгаа асуултуудаас өмнө сонгоогүйгээс сонгож 5-6 асуулт бэлдсэн байна. Бэлтгэсэн асуултын дагуу ярилцана. Номыг ярьж өгч дууссаны дараа бусдыг ойлгохын тулд бид юу хийх хэрэгтэй вэ тухай ярилцана. Бид бусдыг хэцүү байгаа үед ойлгож, энэрч туслахыг мэдэж авсан талаар дүгнэнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Бусдыг ойлгохын тулд бид юу хийх хэрэгтэй вэ?
- Чамд бусдаас тусламж хүсэх үе байдаг уу?

Сонсьё, дэмжье

- Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг зураг, хөдөлгөөн, ухаалаг төхөөрөмж ашиглан ойлголтоо гүнзгийрүүлэхэд дэмжинэ. Хэл яриа, анхаарал, сэтгэл хөдлөлийг

тоглоомоор дамжуулан хөгжүүлж, бие бялдрын хөгжилд энгийн хөдөлгөөн, иллэг хослуулна.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Бусдад туслах, хуваалцах, зөвшөөрөл хүсэх зэрэг зөв зан үйлийг дэмжиж урамшуулна.
- Аав, ээжтэйгээ хамт унших, зурах, тоглох, хөдөлгөөн хийх орчныг бүрдүүлж, бүтээлч үйлээр унших, бичих чадварыг хөгжүүлнэ.
- Багш, эцэг эх хамтран хүүхдийн сонирхолд тулгуурлан дуу, хөгжим, дүрд тоглох, урлах үйлээр бие даасан байдлыг дэмжинэ.

Багшийн эргэцүүлэмж

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн:</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p>

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- III САР

БЯЦХАН САНХҮҮЧ

Хүүхдийн эзэмших чадамж:

Шүүн тунгаах: Сонирхсон зүйлээ ажиглах, юмс үзэгдлийн холбоо хамаарлын талаар асуулт тавьж эргэцүүлэн бодох, дүгнэх

Хамтрах: Хамтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, шийдвэр гаргах, ээлж дарааллаа хүлээх

Суралцахуйд суралцах: Бие даан ангилж ялгасан эд зүйлийг тэмдэглэж, хэмжих

Харилцах: Өөрийн санаа бодлоо илэрхийлэх, үзсэн, оролцсон зүйлийнхээ талаар бусдадаа ярих

Аюулгүй байдлын зөвлөмж:

Зугаалга, аяллаар явахдаа насанд хүрэгчидтэй хамт явах, тэднээс холдохгүй байхыг анхааруулаарай. Хайч, нэг удаагийн хутга хэрэгслийг болгоомжтой ашиглахыг сануулаарай. Орчныг бүрдүүлэхдээ зоогийн газар, банк, үсчин ажил мэргэжлийн онцлогт тохируулан бүрдүүлээрэй. Жишээ нь: Зоогийн газар нээж тоглоход хаяг, лого, ажлын хувцас, багаж хэрэгсэл, хувцас хэрэгсэл, ажлын цагийн хуваарь, тэмдэг тэмдэглэгээ гэх мэт цэцэрлэгийнхээ тоглоом, хэрэглэгдэхүүний нөөцөөр баяжуулах боломжийг судлаарай.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Өөрийн мэдсэн, үзэж харсан зүйлсийн талаар танилцуулах, бусадтай харилцах чадварыг нь дэмжиж, асуултаар чиглүүлээрэй.

Чиглүүлэгтэй, тоглоом, үйл ажиллагаа:

- Хүүхдийн дуулах, хамтдаа тоглох, орчноо өөрсдөө бүрдүүлэхийг урамшуулан дэмжээрэй.
- Сонирхолд нийцсэн тоглоом, үйл ажиллагааг сонгох боломж олгож, харилцан яриа өрнүүлээрэй.

Төвийн үйл ажиллагаа:

- “Банк”, “Үсчин”, “Зоогийн газар” сэдвийн хүрээнд сонголтоор тоглох боломжийг олгоорой. Эдгээр орчинд хэрхэн үйлчлүүлдэг талаар ярилцаж, дүрд хувиран, дуурайж тоглохыг нь чиглүүлэн дэмжээрэй.

Зугаалга:

- Ойр орчны үйлчилгээний газруудтай танилцах, ажиглалт хийх, тэмдэг тэмдэглэгээг мэдэхэд нь дэмжлэг үзүүлээрэй.

- Хүүхэдтэйгээ хамт үйлчилгээний газраар үйлчлүүлж тэмдэглэл хөтөлж, мэдээлэл цуглуулах талаар эцэг эхчүүдэд чиглэл, зөвлөгөө өгч тэдний оролцоог нэмэгдүүлээрэй.

Хөгжөөн баясах ажил:

- Дүрд хувирч тоглох, сэтгэл хөдлөлөө илэрхийлэхэд нь дэмжээрэй.

Боломжууд:

Хүүхэд өөрийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх боломж олгож, өөрөөр нь сонголт хийлгээрэй. Хамтран тоглох үед зөрчилдөөн үүсвэл өөрсдөөр нь эергээр шийдвэрлэх боломж олгоорой. Сонголт хийх, санаачилга гаргах боломжийг хүүхэд бүрд тэгш олгоорой.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
Алхам-1. Төслийн санаа олох		
<p>БНО4.2в. Амьдардаг орчныхоо соёл, дурсгалт газрыг нэрлэж, нийтийн орчинд бусдыг хүндэтгэн харилцана.</p> <p>ХЯ4.2г. Үзсэн, оролцсон, болсон явдлыг нийлмэл өгүүлбэрээр ярина.</p>	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийнхаа түүх дурсгалт газар, үйлчилгээний газруудтай танилцах аялалд оролцох, харилцан ярилцах (банк, үсчин, зоогийн газар гм) - Үзсэн зүйлийнхээ талаар зураг болон чиглүүлэг асуултын дагуу бусдадаа ярьж танилцуулах 	<p>"Бяцхан үйлчлүүлэгч"</p> <p>"Үйлчилгээний газарт"</p>
Алхам-2. Бүтээгдэхүүний шинжилгээ хийх		
<p>МАТ4.3а. Тоглоом юмсын ижил ялгаатай шинжийг нэрлэж, ангилж, тайлбарлана.</p> <p>БНО4.2в. Амьдардаг орчныхоо соёл, дурсгалт газрыг нэрлэж, нийтийн орчинд бусдыг хүндэтгэн харилцана.</p> <p>ЗУ4.3б. Сэдвийн хүрээнд өөрийн бодол төсөөллөөр наамлын бүтээл урлана.</p>	<ul style="list-style-type: none"> - Ангиас сэдвийн хүрээнд шаардлагатай зүйлсийг цуглуулж төрлөөр нь, ижлээр нь ангилах. - Тоглоом, үйл ажиллагаанд оролцохдоо хэрхэн оролцомоор байгаагаа (жүжигчлэн тоглохдоо дүрээ сонгох) илэрхийлэх - Орон нутгийнхаа үйлчилгээний газруудтай танилцах аялалд оролцох, харилцан ярилцах (үсчин, банк, зоогийн газар гм) - Хийсэн бүтээлээрээ бусадтай хамтран тоглох; - Өөрийн бүтээлээ бусдад тайлбарлах (төрөл, материал, хэрэглээ, хийсэн арга); 	<p>"Сонирхолтой орчин"</p> <p>"Бүтээлч хүүхдүүд"</p>
Алхам-3. Мэдлэг бүтээх		
<p>БНО4.2в. Амьдардаг орчныхоо соёл, дурсгалт газрыг нэрлэж, нийтийн орчинд бусдыг хүндэтгэн харилцана.</p> <p>НСХ4.3в. Өдөр тутмын үйл ажиллагаанд тодорхой дүрэм баримтлан хамтран оролцдог болно.</p> <p>МАТ4.3а. Тоглоом юмсын ижил ялгаатай шинжийг нэрлэж, ангилж, тайлбарлана</p> <p>ХЯ4.2г. Үзсэн, оролцсон, болсон явдлыг нийлмэл өгүүлбэрээр</p>	<ul style="list-style-type: none"> - Банк, үсчин, зоогийн газар сэдэвт тоглоомоор тоглох. - Юмсыг зориулалтаар нь ангилж тоглох; - Үйлчилгээний газраар үйлчлүүлэхдээ мөрддөг дүрэм журмыг баримтлан ээлж дарааллыг хүлээх. - Үйлчилгээний газар ажилладаг хүмүүсийн ажил үүргийн талаар ярилцаж, өөрийн сонирхлоор дүрд хувирч тоглох. 	<p>"Хамтдаа тоглоё"</p> <p>"Хөгжимчин больё"</p>

ярина.		
ХӨГ4.1а. Хөгжмийн энгийн зэмсгийг дуугаралтаар ялгаж, өнгө аясыг тодорхойлно. ХӨГ4.1в. Дуу, аялгууны хэмнэлийг хөгжмийн энгийн зэмсгээр хамтран хөгжимдөнө.	<ul style="list-style-type: none"> - Аяыг сонсоод ямар хөгжмийн зэмсгээр тоглосныг таньж, зургийг заах - 2 ба 3 хувьт хэмнэлтэй аялгуунд зураглалын дагуу, хөгжмийн энгийн зэмсгээр хэсэг хэсгээрээ ээлжлэн, хамтарч тоглох; 	
ХЭМ4.1г. Алхалт, гүйлтийг хөгжмийн хэмнэлд тохируулан чиглэл, хурдаа өөрчилж гүйцэтгэнэ. ХЭМ4.1д. Алхалт, гүйлт бүхий хөдөлгөөнт тоглоомыг дүрд орж хамтран тоглоно.	<ul style="list-style-type: none"> - Алхалт, гүйлтийг гарын янз бүрийн хөдөлгөөнтэй хослуулан даалгавар гүйцэтгэх (зүгээ өөрчлөн, чиглэлээ өөрчлөн, хэмнэлээ өөрчлөн) - Хөгжимт гимнастик, бие хөгжүүлэх цогц дасгалыг хөгжмийн хэмнэлд тохируулан бие даан гүйцэтгэх (7-8 тоот); 	<p>“Халбагатай дасгал”</p> <p>“Дасгалаа хийгээрэй”</p>
Алхам-4. Шинэ санаа боловсруулах		
ХЭМ4.2в. Хүнсний бүтээгдэхүүний төрлийг мэдэж, насанд хүрэгчтэй хамтран хялбар зууш бэлтгэнэ. ХЯ4.2г. Үзсэн, оролцсон, болсон явдлыг нийлмэл өгүүлбэрээр ярина.	<ul style="list-style-type: none"> - 1 удаагийн хутгаар жимсний чанамал (масло, цөцгий)-г талхан дээр түрхэж, хөнгөн зууш бэлтгэх - Оролцсон үйл явдлын талаар чиглүүлэх асуултын дагуу ярих 	<p>“Бяцхан тогооч”</p> <p>“Миний зууш”</p>
Алхам-5. Эргэцүүлэх		
ХЯ4.2г. Үзсэн, оролцсон, болсон явдлыг нийлмэл өгүүлбэрээр ярина. ЗУ4.3б. Сэдвийн хүрээнд өөрийн бодол төсөөллөөр наамлын бүтээл урлана.	<ul style="list-style-type: none"> - Хамтдаа бүтээлийн үзэсгэлэн гаргах - Төслийн хүрээнд хийсэн бүтээл, оролцсон үйл ажиллагааны фото зургаар үзэсгэлэн гаргаж бусдад танилцуулах, тайлбарлаж ярих 	<p>“Бидний амжилт”</p> <p>“Бидний бүтээл”</p>

3 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Бяцхан үйлчлүүлэгч	Тойргийн цаг	Хүүхдүүд эцэг эх, асран хамгаалагчтайгаа хамт банк, зоогийн газар, үсчин зэрэг газруудаас сонгон очиж үйлчлүүлэн, ямар үйлчилгээний газарт очсон талаар ярилцана.	Үйлчилгээний газарт очсон талаар ярилцана.	Тухайн газар хаана байрладаг вэ? Ямар үйлчилгээ үзүүлдэг вэ? Ямар дүрэм, журам мөрддөг вэ? Төлбөрийг хэрхэн төлсөн бэ?	Харилцах: Эцэг эхчүүдтэй хамтран мэдээлэл цуглуулж, хүмүүстэй ярилцсан талаарх мэдээллээ хуваалцах	Амьдардаг орчныхоо дурсгалт газрыг таньж нэрлэдэг. Олон нийтийн газарт баримтлах дүрэм, тэмдэг тэмдэглэгээг таньж мөрддөг.
Үйлчилгээний газарт / Сонирхолтой орчин	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүд очсон газрынхаа зургийг харж, бусдадаа танилцуулна.	Дэлгэц, компьютер, цахим үзүүлэн	Чиний очсон газар хаана байрладаг вэ? Очоод юу хийсэн бэ? Тэнд ямар дүрмүүд мөрддөг вэ? Төлбөрийг хэрхэн төлсөн бэ?	Харилцах: Үзсэн, оролцсон зүйлийнхээ талаар зураг болон асуултын дагуу нийлмэл өгүүлбэрээр ярьж танилцуулах	Хоёр өгүүлбэрийг холбоо үгсээр холбож, харилцан уялдаатай нийлмэл өгүүлбэрээр ярьдаг. Асуултад хариулдаг.
Бүтээлч хүүхдүүд	Төвийн үйл ажиллагаа	Хүүхдүүдийг очсон газруудаар нь багт хуваарилж, тухайн газарт хэрэгтэй зүйлсийг жагсаалтаар гаргаж, орчноос цуглуулна. Цуглуулсан зүйлээ төрлөөр нь, ижлээр нь ангилна. Шавар болон цаасаар мөнгө, багаж хэрэгсэл, хоол хүнс зэргийг хийж бэлтгэнэ.	Баримлын шавар, өнгийн цаас, цаасан хайрцаг, цавуу, хайч, ажлын хувцас, багаж хэрэгсэл	Өөр юу юу хэрэгтэй байгаа болон хэрхэн хийж болох талаар ярилцана уу. (Багш чиглүүлнэ).	Шүүн тунгаах: Сэдвийн хүрээнд шаардлагатай зүйлсийг сонгох, цуглуулсан зүйлээ төрлөөр нь, ижлээр нь ангилах	Өнгө хэлбэрээрээ ижил болон ялгаатай зүйлсийг ангилдаг. Юмсыг зориулалт хэрэглээгээр нь ялгаж, шинээр ангилал зохиож тайлбарладаг. Өөрийн бодол төсөөллөөр наамлын бүтээл урладаг.
Хамтдаа тоглоё	Төвийн үйл ажиллагаа	Хүүхдүүд банк, үсчин, зоогийн газар гэсэн төвүүдэд өөрийн сонголтоор дүрийг сонгож тоглоно. Үйлчлүүлэхдээ дарааллыг баримтлах, ээлжээ хүлээх, соёлтой	Ажил мэргэжлийн зураг, хаяг, ажлын хувцас, хэрэгсэл, өнгийн цаас, хайч	Хүүхдүүд банк, үсчин, зоогийн газар гэсэн төвүүдэд өөрийн сонголтоор дүрийг сонгож тоглоно.	Шүүн тунгаах: Үйлчилгээний газраар үйлчлүүлэхэд мөрдөх дүрэм журмыг мэддэг болох, зориулалтаар нь	Бусадтай тоглох, хамтрах үйл ажиллагаанд тодорхой дүрмийг баримталдаг. Олон нийтийн газарт бусдыг хүндэтгэн харилцдаг.

		харилцах зэрэг дүрмийг мөрдөнө.			юмсыг ангилж тоглох	
Хөгжимчин больё	Хөгжөөн баясах цаг	Аяыг сонсоод ямар хөгжмийн зэмсгээр тоглосныг таньж, зургийг заах/өргөнө. 2 ба 3 хувьт хэмнэлтэй аялгуунд зураглалын дагуу хөгжмийн энгийн зэмсгээр хамтарч тоглоно.	Хөгжмийн тэмдэгт, ая, зурагт хуудас	Энгийн хөгжмийн зэмсгээр тоглоно.	Шүүн тунгаах: Хөгжмийн энгийн зэмсгийг дуугаралтаар нь ялган таних, хэмнэлийг ялгах	Хөгжмийн зэмсгүүдийн дуугаралтыг ялгаж, нэрлэж, харьцуулан тайлбарлаж чаддаг. Дуу, аялгууны хэмнэлийг мэдэрч зураглалын дагуу хөгжмийн энгийн зэмсгээр бусадтайгаа хамтран хөгжимддөг.
Халбагатай дасгал/	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Халбагаар тоглох хурдан, удаан хэмнэлд тохируулан зүгээ өөрчлөх, алхах гүйх хөдөлгөөн хийнэ.	Хөгжим, ая, Халбага 2 ширхэг	Хэмнэлд тохируулан хөдөлгөөнийг гүйцэтгэнэ.	Харилцах: Дүрд орж, энгийн дүрэм, тэмдэг тэмдэглэгээг мэдэх, дагах чадварыг хөдөлгөөнт тоглоомын үеэр дэмжих	Алхалт, гүйлтийн төрлүүдийг 3-4 хэрэглэл ашиглан чиглэл, хурдаа өөрчлөн гүйцэтгэдэг.
Дасгалаа хийгээрэй	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хөгжмийн хэмнэлд тохируулан бие хөгжүүлэх цогц дасгалыг бие даан гүйцэтгэнэ (7-8 тоот).	Хөгжим, ая.	Хэмнэлд тохируулан хөдөлгөөнийг гүйцэтгэнэ	Харилцах: Дүрд орж, энгийн дүрэм, тэмдэг тэмдэглэгээг мэдэх, дагах чадварыг хөдөлгөөнт тоглоомын үеэр дэмжих	Алхалт, гүйлтийн төрөл бүрийн хөдөлгөөнт тоглоом, дасгал, буухианд оролцохдоо тоглоомын дүрмээр, хамтран тоглодог.
Бяцхан тогооч	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	1 удаагийн хутгаар жимсний чанамал (масло, цөцгий)-г талхан дээр түрхэж, хөнгөн зууш бэлтгэнэ.	Талх, жимсний чанамал, масло, 1 удаагийн хутга, Зурагт ном	Хүүхдүүд номын харж зохиож зургийг өгүүлбэр ярина.	Харилцах: Үзсэн зүйлийн талаар ярих, асуултын дагуу санаа бодлоо илэрхийлэх	Хүнсний төрлийг мэдэж, хялбар зууш, өглөөний цайг зурагт дараалал, зааврын дагуу бие даан болон бусадтай хамтран бэлтгэдэг.
Би өлсөөд байна	Номын цаг	Номын зургийн дагуу өгүүлбэр зохиож ярина.	“Би өлсөөд байна” /зурагт ном/		Харилцах: Үзсэн зүйлийн талаар ярих, асуултын дагуу санаа бодлоо илэрхийлэх	Оролцсон үйл явдлын талаар асуултад хариулдаг.

Бидний амжилт	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Бусад бүлэг болон эцэг эхчүүдэд танилцуулж, тайлбарлаж ярина.	Бүтээлүүд, фото зургууд, хөгжим	Хийсэн бүтээлүүдээ хаана байрлуулах вэ? Хэн хэн аль хэсгийг танилцуулах вэ?	Харилцах: Төслийн хүрээнд хийсэн бүтээлээ бусдад тайлбарлах	Үзсэн, оролцсон, болсон явдлыг нийлмэл өгүүлбэрээр ярьдаг.
Бидний бүтээл	Тайлант өдөрлөг	Төслийн хүрээнд хийсэн бүтээл, оролцсон үйл ажиллагааны фото зургаар үзэсгэлэн гаргаж,	Хөгжим, ая.	Тайлан, тоглолт	Харилцах: Төслийн хүрээнд хийсэн бүтээлээ бусдад танилцуулна.	Өөрийн бүтээлийг үзэсгэлэн гаргаж танилцуулдаг.

Албан хэрэгцээ

3 дугаар сарын I долоо хоног

СОНИРХОЛТОЙ АЯЛАЛ

Төслийг эхлүүлэхийн өмнө багш эцэг эх, асран хамгаалагчдад хүүхэдтэйгээ хамт тухайн орон нутгийн онцлогоос шалтгаалан банк, зоогийн газар, үсчин зэрэг үйлчилгээний газруудаас сонгож, үйлчлүүлэн, очсон газрынхаа талаар мэдээлэл цуглуулж, бусад хүүхдүүдэд танилцуулах даалгавар өгнө. Багш эцэг эхчүүдтэй уян хатан байдлаар хамтран ажиллаарай. Жишээлбэл, үйлчилгээний газраар очиж амжаагүй хүүхдүүдэд зурагт материал, цахим контент ашиглан мэдээлэл авах, банк (үсчин, зоогийн газар гэх мэт)-ны ажилтныг цэцэрлэгтээ урьж уулзалт хийх зэрэг нэмэлт үйл ажиллагаа зохион байгуулж болно. Эцэг эх, асран хамгаалагч нар хүүхэдтэйгээ хамт үйлчилгээний газарт очихдоо дараах мэдээллийг цуглуулан, фото зургаар баримтжуулж, ирэхийг санал болгоно.

- Очсон газрын нэр, ямар мэргэжилтэй хүмүүс ажилладаг болох, үзүүлдэг үйлчилгээ, мөрддөг дүрэм журмыг ажиглана.
- Тухайн газраар хүмүүс үйлчлүүлэхдээ төлбөрөө ямар хэлбэрээр (карт, бэлэн мөнгө гэх мэт) төлсөн талаар мэдээлэл цуглуулж ирэхийг сануулна.

Багш фото зургийг эцэг эх, асран хамгаалагч нараас урьдчилан авч цахим үзүүлэн хэлбэрээр бэлтгэсэн байна.

Шинэ үг: Үйлчилгээний газар

Үйл ажиллагаа 1. Бяцхан үйлчлүүлэгч (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Цахим үзүүлэн, дэлгэц, компьютер

Аргачлал: Эцэг эх, асран хамгаалагчдаас авч бэлтгэсэн зурган танилцуулгыг дэлгэцээр харуулж ямар газраар үйлчлүүлсэн, юу хийсэн талаар асуулт асууж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Та нар ямар үйлчилгээний газар очсон бэ?
- Очоод юу хийсэн бэ?
- Үйлчлүүлэхэд чамд юу хэрэг болсон бэ?

Үйл ажиллагаа 2. Үйлчилгээний газар (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цаас, эсгий бал, цавуу, өнгийн цаас, хайч, баримлын шавар, хулдаас

Аргачлал: Хүүхэд бүр өөрийн очиж танилцсан газрын доторх зураглалыг (Жишээ нь: үсчний сандал, толь, тавиур, өлгүүр гэх мэт хаана байрлаж байсан, хүмүүс ямар үйлчилгээ авч байсан зэргийг төрөл бүрийн аргаар бүтээнэ) наах, барих, зурах, зохион бүтээхээс сонгож хийнэ. Бүтээсэн зураглалыг нийлмэл өгүүлбэрээр (тэгээд, тиймээс, учраас, харин, гэнэт, тэгэхэд гэх мэт холбоос үгс ашиглана. Жишээлбэл: Би музейд очоод анх удаа том араг яс харсан тийм учраас их сонирхолтой байсан гэх мэт.) ярина.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Ямар газрыг сонгож зураглал гаргасан бэ?
- Тухайн газар ямар дүрмийг дагаж байсан бэ?

ХАМТДАА ХИЙЦГЭЭ

Шинэ үг: Тэмдэглэгээ

Үйл ажиллагаа 1. Сонирхолтой орчин (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Цахим үзүүлэн, ангийн орчин дахь тоглоом, сургалтын хэрэглэгдэхүүн

Аргачлал:

Банк(үсчин, зоогийн газар гэх мэт) үйлчилгээний газарт юу юу байдаг, хэн хэн ажилладаг, ямар дүрэм журам мөрддөг болон тэмдэг, тэмдэглэгээний талаар ярилцана. Хүүхдүүд тухайн газраар үйлчлүүлэхэд юу хэрэгтэй болсон тухайгаа ярилцаж жагсаалт гаргана. Орчноос хэрэгтэй зүйлээ цуглуулна. Цуглуулсан зүйлээ төрлөөр нь, ижлээр нь ангилна. Өөр юу юу хэрэгтэй байгаа болон хэрхэн хийж болох талаар ярилцана.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 88, дасгал №88](#)

Үйл ажиллагаа 2. Бүтээлч хүүхдүүд (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Баримлын шавар, өнгийн цаас, цаасан хайрцаг, цавуу, скоч, эсгий бал, хайч

Аргачлал: Хүүхдүүдийг очсон газруудаар нь багт хуваарилна.

Банк: Хүүхэд бүр мөнгөн дэвсгэртийг хийж бэлтгэнэ. (Компьютер, мөнгө тоологч төхөөрөмж, мөнгө хадгалах хайрцаг, орчны болон ажилтныг таних энгэрийн тэмдэг, банкны хаяг, дугаар авдаг машин, тамга буюу төрөл бүрийн зурагтай дардас, үзэг, цаас, сандал, ширээ гэх мэт)

Үсчин: Сам, хайчийг картон цаас ашиглан хийнэ. (Нэр, хаяг-лого, ажиллах цагийн хуваарь, үнийн тариф (зургаар), толь сандал, тавиур, хормогч, багаж хэрэгсэл, энгэрийн зүүлт гэх мэт).

Зоогийн газар: Хоол хүнсний бүтээгдэхүүнийг цаас болон баримлын шавраар хийж бэлтгэнэ. (Хормогч, малгай, нэг удаагийн таваг, хутга, сэрээ, кассын машин, сандал, ширээ, хоолны цэс гэх мэт)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 60, дасгал №60](#)

3 дугаар сарын II долоо хоног

МИНИЙ ДУРТАЙ МЭРГЭЖИЛ

Шинэ үгс: Үйлчилгээ, багаж хэрэгсэл, бүтээгдэхүүн

Үйл ажиллагаа 1. Хамтдаа тоглоё (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ажил мэргэжлийн зураг, хаяг, багаж хэрэгсэл, тэмдэг тэмдэглэгээ, ажлын хувцас, хэрэгсэл

Аргачлал: Хүүхдүүд банк, үсчин, зоогийн газар гэсэн төвүүдэд өөрийн сонголтоор тоглоно.

Банк. Хүүхдүүд өөрийн сонирхлоор банкны ажилтан, үйлчлүүлэгч, зохион байгуулагч, хамгаалагч зэрэг дүрийг сонгож банкнаас мөнгө авах, мөнгөө хадгалуулах гэх мэтээр тоглоно. (Энэ хэсгийн үйл ажиллагаанд ээлжээ хүлээх, дугаарын дагуу үйлчлүүлэх зэрэг үйлийг хийнэ)

Үсчин. Хүүхдүүд дүрээ сонгож, үс угаах, будах, индүүдэх, самнах, сүлжих зэргээр тоглоно.

Зоогийн газар. Тогооч, зөөгч, кассчин, үйлчлүүлэгч гэсэн дүрүүдээс сонгож тоглоно.

Зоогийн газраар үйлчлүүлэхдээ:

- Зоогийн газрын ажилтантай мэндэлнэ.
- Дарааллыг баримтална.
- Чанга дуугаар ярихгүй байна.
- Бүдүүлэг үг хэллэг хэрэглэхгүй, соёлтой байна.
- Хооллож дуусаад хоолны хэрэгслээ хураана.
- Талархлаа илэрхийлнэ гэх мэт дүрэм баримтлахыг хүүхдүүдэд анхааруулна.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 65, дасгал №65](#)



Үйл ажиллагаа 2. Хөгжимчин болъё (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжмийн тэмдэгт, ая, зурагт хуудас

Аргачлал: Багш тоглоомын дүрмийг танилцуулна. Хүүхэд бүрт хөгжмийн тэмдэгт тарааж өгнө. Даалгавар бүрийг амжилттай гүйцэтгэсэн хүүхдүүд хөгжмийн тэмдэгттэй болно.

- Аяыг сонсоод ямар хөгжмийн зэмсгээр тоглосныг олж, зургийг өргөнө.
- Дасгалыг ажиглаад хөгжмийн энгийн зэмсгээр өгөгдсөн хэсгийг тоглоно.



1-р дасгал



, 2-р дасгал

дараа нүд амрах хөнгөн дасгал хийнэ.

Бүх хүүхдүүд хийж гүйцэтгэсний

[Дасгал ажлын дэвтэр хуудас 93, дасгал №93](#)

Үйл ажиллагаа 3. Халбагатай дасгал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн:

- Хэрэгсэл: Компьютер, ая
- Хэрэглэл: Халбага 2 ширхэг

Аргачлал: Багш (<https://www.pinterest.com/pin/79376012178404139/>) бичлэгийг үзүүлж, тоглоомын дүрмийг тайлбарлана. Хүүхдүүд хоорондоо зайтай, чөлөөтэй зогсож багшийн чиглүүлгийг анхааралтай ажиглана. Хэмнэлд тохируулан баруун, зүүн, арагш, урагш хөдөлгөөнийг гүйцэтгэнэ. Дахин давтан тоглохдоо урагш, арагш, баруун, зүүн тийш алхалтыг гарын хөдөлгөөнтэй хослуулна. Мөн гүйхдээ 2 гарыг цээжний 2 талд авч гарын хөдөлгөөнтэй хослуулан, чиглэл, хурдаа өөрчлөн гүйцэтгэнэ.

Үйл ажиллагаа 4. Дасгалаа хийгээрэй (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, дасгалын аргачлал

Аргачлал: “Дагаад хийгээрэй” <https://www.youtube.com/watch?v=EFrtSLlwmb&t=13s> дасгалыг дуурайн, хийнэ.

АМТАТ ЗУУШ

Шинэ үг: Мэргэжил

Үйл ажиллагаа 1. Бяцхан тогооч (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: талх, жимсний чанамал, масло, жимс, улаан лооль, өргөст хэмх, 1 удаагийн хутга, амны цаас, аяга, таваг, сэрээ

Аргачлал: Ширээ бүрд хүүхдийн тоогоор зүссэн талх, жимсний чанамал, масло, цөцгий, усан үзэм, угаасан улаан лооль, өргөст хэмх, нэг удаагийн хутга, халбага, сэрээг бэлтгэсэн байна. (шаардлагатай тохиолдолд эцэг эхчүүдээр бэлтгүүлж болно.)

Хүүхдүүд 1 удаагийн хутгаар улаан лооль, өргөст хэмхийг зүснэ. Жимсний чанамал (масло, цөцгий)-г талхан дээрээ түрхэж, таваг дээр тавина. Хажууд нь усан үзэм, зүссэн улаан лооль, өргөст хэмхийг тавьж, чимэглэнэ. Багш аюулгүй, болгоомжтой ажиллах талаар сануулна.

Үйл ажиллагаа 2. Би өлсөөд байна (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: “Би өлсөөд байна” зурагт ном

Аргачлал: Багш [Би өлсөөд байна ном - Кимико](#) номыг уншиж өгнө. Хүүхдүүд номын зургийн дагуу өгүүлбэр зохиож ярина. Багш зохиосон өгүүлбэрийг нийлмэл өгүүлбэр болгоход чиглүүлнэ. Тухайлбал: Би өлсөж байсан учраас зууш хийж идсэн.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 71, дасгал №71](#)

СОНИРХОЛТОЙ ҮЗЭСГЭЛЭН

Шинэ үг: Үзэсгэлэн

Үйл ажиллагаа 1: Бидний амжилт (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: “Бяцхан санхүүч” төслийн хүрээнд хийсэн үйлд оролцож буй зургууд, хамтын бүтээлүүд

Аргачлал: “Бяцхан санхүүч” үйл ажиллагааны явцад хийсэн бүтээлүүдээ хаана байрлуулах вэ?, Хэн хэн аль хэсгийг танилцуулах вэ, хэнийг урих вэ? асуултын дагуу ярилцаж үзэсгэлэндээ бэлтгэнэ. Хүүхэд бүр урилга хийж, урих хүндээ өгнө.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 91, дасгал №91](#)

Үйл ажиллагаа 2: Бидний бүтээл (Тайлант өдөрлөг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, ая

Аргачлал: “Бяцхан санхүүч” төслийн хүрээнд хийсэн бүтээл, оролцсон үйл ажиллагааны фото зургаар гаргасан үзэсгэлэнгээ бусад бүлгийн хүүхдүүд, эцэг эх, асран хамгаалагч, багш ажилчдад танилцуулна.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 90, дасгал №90](#)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 92, дасгал №92](#)

Сонсьё, дэмжье

- Хүүхэд өөрийн үзсэн харсан зүйлийн талаар ярих, хэрэглэгдэхүүнийг өөрсдөө хийж тоглож байгаа зэрэг нь тэдний бүтээлч байдлыг илэрхийлж байгаа тул урамшуулж, чиглүүлээрэй.
- Төвд ажиллуулах, дүрд хувирч сэдэвт тоглоомоор тоглуулахдаа хүүхдийн тоог анзаарч, тэнцвэртэй байдлаар хуваарилаарай.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Гэр бүлээрээ хамтдаа хийсэн зүйлээ ярилцах
- Хамтран энгийн зууш бэлтгэх
- Хүүхэдтэйгээ гадаа тоглож, баруун, зүүн, баруун ба зүүн тийш чиглэлд байгаа зүйлсийг харьцуулах.
- Хүүхэдтэйгээ хамт үйлчилгээний газраар үйлчлүүлж, мэдээлэл цуглуулах
- Сэдвийн хүрээнд сургалтын орчин бүрдүүлэхэд оролцох

Багшийн эргэцүүлэмж

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./
Амжилттай хэрэгжүүлсэн:
Сул хэрэгжүүлсэн:.....
Цаашид сайжруулах:.....
Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- IV сар

4 дүгээр сар I долоо хоног

АЖИГЛАЯ СУДАЛЪЯ

Хүүхдийн эзэмших чадамж:

Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санааг зурах, барих, зураглал хийж илэрхийлэх

Суралцахуйд суралцах: Сонирхсон зүйлээ асууж, анхааралтай сонсох, төвлөрөх

Хамтран ажиллах: Бусдад туслах, хуваалцах, хүндлэх, хүлээцтэй байх

Нийгэм, сэтгэл хөдлөл: Бусадтай харилцан хамааралтай, ижил төстэй байдлаа тайлбарлах, эрх тэгш харилцаж аливаа үйл ажиллагаанд санаачилгатай оролцох

Аюулгүй байдлын зөвлөмж:

- Цэцгийн савны бүрэн бүтэн байдлыг анзаарч, хэмжээний хувьд жижгэвтэр байхад анхаараарай.
- Зугаалгын цагаар бөмбөгтэй гарах тул хоорондоо мөргөлдөх эрсдэлээс сэргийлээрэй.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Өнөөдөр ямар гараг болох, юу хийх тухай ярилцаарай.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Зохиолын үйл явдал болон шидэт цэцгийн дэлбээнүүдийг юу юунд зарцуулсан тухай яриа өрнүүлээрэй.
- Хүүхдийн зурах чадвараас шалтгаалан үйл явдлыг дүрслэхэд хүнд байвал сонин, сэтгүүлээс зураг хайчилж наах боломжоор хангаарай.
- Хүүхэд зохиолын зураглалыг бие даан хийж сурахад нь дэмжлэг үзүүлээрэй.

Төвийн үйл ажиллагаа:

- Хүүхэд төвийн үйл ажиллагааг сонгосон бол тэдний хийх зүйлийг ажиглаж, шаардлагатай бол нэмэлт чиглүүлэг өгч идэвхжүүлээрэй.
- Төвийн үйл ажиллагаанд хүүхэд бүр хамрагдаж байгаа эсэхийг анзаараарай.

Зугаалга:

- Хүүхэд хоорондын зайг чөлөөтэй байлгаж, бөмбөг шидэх, барьж авах орон зай гаргаж өгөхөд анхаараарай.

Номын цаг:

- “Долоон дэлбээт цэцэг” зохиолын эхлэл хэсгийг ярьж, дараагийн үйл ажиллагааны дээр өрнөл, төгсгөлийг үргэлжлүүлэн ярихаар төлөвлөсөн.
- Хүүхдийн анхаарлаас шалтгаалан өрнөл, төгсгөлийг салгаж болохыг анхаарна уу. Зохиолын дүрүүд болон үйл явдлын талаар ярилцаж, ойлголтыг бататгаарай.

Хөгжөөн баясах цаг:

- Энгийн хөгжмийн зэмсгийг хангалттай бэлтгэж өгч, хоорондын зайг анзаараарай.

Боломжууд:

- Багш цэцгийн долоон дэлбээний өнгөөр үйл ажиллагаагаа идэвхжүүлээрэй. Даваа гарагт-шар, Мягмар гарагт-улаан хуудас гэх мэтээр хамтдаа юу хийх хүслээ бичээд биелүүлж болно. Тухайлбал, Даваа гарагт-шар хуудсан дээр найздаа тусалж байгаа хүүхдэд урам өгөх байдлаар дэмжээрэй.
- Хүүхдээс гарч буй санаа, бодож төсөөлөн хийсэн зүйлийг нь дэмжиж, үйл ажиллагаандаа тусган ашиглаарай.
- Багш та ангийнхаа ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, хэрэгцээнд тулгуурлан тохируулга хийж хэрэгжүүлээрэй.
- Зохиолд суурилсан арга зүйгээр сургалт, үйл ажиллагааг зохион байгуулсан бол төгсгөлд нь жүжигчилсэн тоглолт, тайлант өдөрлөг, зохиолын зураглал гэх мэт бодит ажил өрнүүлэх байдлаар төгсгөж, бүх хүүхэд зохиолоос суралцсан байхад төвлөрөөрэй.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>ХЯ4.3а. Номын агуулга, үйл явдлыг тайлбарлан ярина.</p> <p>ЗУ4.2а. Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон зурна.</p> <p>БНО4.16. Ургамлын ургалтад юу хэрэгтэй болохыг тодорхойлж, тарьж ургуулах үйлд оролцоно.</p>	<p>- Үлгэр, түүх, богино өгүүллэг, сонирхол татахуйц дүрүүдтэй номын утга агуулга, үйл явдлыг тайлбарлан ярих идэвхтэй үйлүүдэд оролцох</p> <p>- Эд юмсыг дүрсэлж зурах</p> <p>- Өөрийн ургуулж буй ургамлын өсөлтийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх, байгалийн булан, туршлагын талбайд хөдөлмөрийн үйл хийх</p>	Шидэт цэцэгс
<p>МАТ4.2б. Долоо хоногийн өдрийг дарааллаар нь нэрлэж, тухайн өдрүүдэд хийдэг танил үйл явдалтай холбож танилцуулна.</p> <p>ЗУ4.2а. Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, хүн, амьтан, эд юмсыг зохиомжлон зурна.</p> <p>БНО4.16. Ургамлын ургалтад юу хэрэгтэй болохыг тодорхойлж, тарьж ургуулах үйлд оролцоно.</p>	<p>- Долоо хоногийг гарагийн нэрээр нэрлээд нэг нэгээр нь “энэ бол Даваа. Даваа гараг бол цэцэрлэгтээ очих эхний өдөр “ зэргээр өдрүүдийг дүртэй болгон танилцуулах</p> <p>- Үлгэрийн үйл явдлыг зохиомжлон зурах</p> <p>- Өөрийн ургуулж буй ургамлын өсөлтийг ажиглаж, тэмдэглэл хөтлөх, байгалийн булан, туршлагын талбайд хөдөлмөрийн үйл хийх</p>	Долоо хоног
<p>ХӨГ4.1б. Дуу, аялгууг гарын дохиогоор дуулж, аялна.</p> <p>ХӨГ4.1д. Дүрийн зан чанар, харилцааг илэрхийлж хамтран тоглоно.</p> <p>ХЭМ4.1м. Бөмбөгийг хана руу шиднэ, барьж авна.</p>	<p>- Багшийн гарын дохиог анхаарч аялгуу, хэмнэлийг алдалгүй, бусадтай хамтарч дуулах</p> <p>- Өгөгдсөн дүрийг сэтгэл хөдлөл, хөдөлгөөн, дуу авиа, үг яриа, нүүрний хувирлаар илэрхийлэх</p> <p>- Босоо болон хэвтээ бай руу 2м зайнаас бөмбөг шидэх</p>	Бяцхан цэцэг
<p>БНО4.16. Ургамлын ургалтад юу хэрэгтэй болохыг тодорхойлж, тарьж ургуулах үйлд оролцоно.</p> <p>БНО4.1г. Улирлын онцлогоос хамаарч амьтан, ургамал, хүмүүсийн амьдралд гарч буй өөрчлөлтийг тайлбарлаж, өөрийн хийх үйлийг тохируулан сонгоно.</p>	<p>- Байгалийн буланд ургамал тарих, цэцэг шилжүүлэн суулгах, үрслүүлэх, арчлах, ургуулах үйлд оролцох, туршилт хийх</p> <p>- Улирлын онцлогоос шалтгаалж, хүмүүсийн амьдрал, амьтан ургамалд гарч буй өөрчлөлтийг ажиглах, судлах, мэдээлэл цуглуулж, ярилцлага хийх</p> <p>- “Цэвэр, бохир хувцас” ярилцлага зохион байгуулах</p>	Яагаад ургамлыг хайрлах хэрэгтэй вэ?

<p>ХЭМ4.2б. Хувцасны цэвэр, бохир байдлыг ялгаж ойлгон, бохирдсон үед өөрийн санаачилгаар цэвэр хувцсаар сольж өмсдөг болно.</p>		
<p>НСХ4.3а. Хүмүүс хоорондоо хэрхэн харилцан хамааралтай байдгийг тайлбарладаг болно. ЗУ4.3б. Сэдвийн хүрээнд өөрийн бодол төсөөллөөр наамлын бүтээл урлана. ХЯ4.1б. Үгийн эхэнд болон төгсгөлд орсон авиаг сонсоод ялгаж хэлнэ.</p>	<ul style="list-style-type: none"> - Баг болж хамтын бүтээл хийж, хэн юуг нь хийсэн тухай тайлбарлах - Зохиолын дагуу сэдэвт наамал хийх - Сонсож анхаарал хөгжүүлэх, авиаг ялгах чадварыг хөгжүүлэх авиа таах, ялгах, ангилах тоглоом тоглох. Тухайлбал: Зурган карт болон зурагт самбар дээрх үгсийг нэрлэж, хэлсэн үгийн эхний болон төгсгөлийн авиаг сонсож ялгах дасгал ажиллах, орчны дуу чимээг сонсоод эхний болон төгсгөлийн авиаг ялган хэлж тоглох 	<p>Зохиолоо ярилцъя</p>
<p>МАТ4.2б. Долоо хоногийн өдрийг дарааллаар нь нэрлэж, тухайн өдрүүдэд хийдэг танил үйл явдалтай холбож танилцуулна. НСХ4.2б. Бусдын нөхцөл байдалд тохируулан энэрэх үйлдэл үзүүлдэг болно. ХЯ4.3а. Номын агуулга, үйл явдлыг тайлбарлан ярина.</p>	<ul style="list-style-type: none"> - Долоо хоногийн нэг өдрийг алгасаад ямар өдөр байхгүй байгааг олж нэрлэх - Бусдад туслах тухай үлгэр зохиолтой танилцаж, өөрийн хэмжээнд энэрч туслах - Үлгэр, түүх, богино өгүүллэг, сонирхол татахуйц дүрүүдтэй номын утга агуулга, үйл явдлыг тайлбарлан ярих идэвхтэй үйлүүдэд оролцох 	<p>Би үүнийг сурсан</p>

4 дүгээр сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Долоон дэлбээт цэцэг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Долоон дэлбээт цэцэг" зохиолын эхний хэсгийг ярьж өгч ярилцах. Аюулгүй байдлын тухай (Боль гэж хашхирах, зугтах, тусламж хүсэх) ярилцана.	Дэлгэц, зохиол.	Женя хэн хэнд, ямар цагариган боов авахаар явсан бэ?; Хэрэв танихгүй хүн чамайг авч явах гээд байвал чи юу хийх вэ?.	Суралцахууд суралцах Анхааралтай сонсох Харилцах Ярилцах Нийгэм, сэтгэл хөдлөл Аюулгүй байдлын талаар ойлголттой болох	Номын агуулга, үйл явдлыг тайлбарлан ярьдаг.
Зохиолын үргэлжлэл	Номын цаг	Зохиолын өрнөл, төгсгөл хэсгийг ярьж өгч, ярилцлага өрнүүлэх. Долоон өнгийн дэлбээгээр юу юу хийснийг дүрслэн зурж, ярилцана.	Дэлгэц, үлгэр, бэлдэц цаас, балын харандаа, тосон харандаа.	Чи Женягийн оронд байсан бол ямар зүйлс хүсэх байсан бэ?; Ямар өнгөтэй дэлбээг хамгийн хэрэггүй/зөв зүйлд зарцуулсан бэ?.	Бүтээлчээр сэтгэх Дүрсэлж зурах Шүүн тунгаах Сонголтын үнэ цэнийг ялгах	Сэдвийн хүрээнд эд юмсыг зохиомжлон зурдаг. Номын агуулгыг тайлбарлан ярьдаг.
Ид шид	Төвийн үйл ажиллагаа	Зураг урлал төв: Ид шидтэй 7 дэлбээт цэцэг өгвөл юу хүсэхээ зурж будаад, тайлбарлах. Туршилт төв: Нэг цэцгийг сонгож услах, тоосыг арчих, ургамлын өсөлтийг ажиглаж, тэмдэглэл хөтлөнө.	Зургийн дэвтэр, гуаш, ном, утас, савх, бөглөөнүүд.	Чамд ид шидтэй 7 дэлбээт цэцэг өгвөл чи хүсэх вэ?.	Бүтээлчээр сэтгэх Хүслээ зургаар илэрхийлэх Суралцахууд суралцах Тэмдэглэл хөтлөх, Төвлөрөх	Ургамлын өсөлтийг ажиглаж, тэмдэглэл хөтөлдөг.
Гарагийн нэртэй дэлбээ	Тойргийн цаг	Цэцгийн дэлбээ бүр дээр 1-7 цифрийг дараалуулан байрлуулна. Долоон гарагийн тухай болон аль	Зурагт үзүүлэн (долоон дэлбээтэй	Аль гарагт цэцэрлэгтээ ирдэг вэ? Ямар өдрүүдэд амардаг вэ?.	Суралцахууд суралцах Төвлөрч сонсох	Долоо хоногийн өдрийг дарааллаар нь нэрлэж, танил үйл

		гарагт ямар үйл явдал болдог тухай ярилцана. (цэцэрлэгт явах 5 хоног, амрах 2 хоног).	цэцэг), 1-7 хүртэлх цифр.			явдалтай холбож ярьдаг.
Миний 7 хоног	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхэд бүр Даваагаас-Ням гараг хүртэлх өдрүүдийн хамгийн таалагдсан хэсгээ дүрслэн зурах. Зурсан зургаар үзэсгэлэн гаргаж, найзууддаа тайлбарлана.	Бэлдэц цаас, зургийн хэрэгсэл.	Таны зурсан хэсэг аль гарагт болсон бэ? Яагаад таалагдсан бэ?	Бүтээлчээр сэтгэх Дүрслэн зурах, Харилцах Тайлбарлах	Сэдвийн хүрээнд хүрээлэн буй орчин, эд юмсыг зохиомжлон зурдаг.
Ургамал гэж юу вэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Ургамлыг үрслүүлэхэд юу хэрэгтэй болох, хөрс гэж юу болох талаар таамаглал дэвшүүлэн ярилцах. Хөрсөнд үрийг суулгах дарааллыг тэмдэглэнэ.	Үрсэлгээ, усны сав, шороо, шүршигч сав.	Ургамлыг үрслүүлэхдээ юу хийж болох вэ?; Хөрс гэж юу вэ?.	Суралцахууд суралцах Таамаглал дэвшүүлэх, дараалал тэмдэглэх Хамтран ажиллах Тарьж ургуулах үйлдэлд оролцох	Ургамлын ургалтад юу хэрэгтэй болохыг тодорхойлж, тарьж ургуулах үйлд оролцдог.
Өнгөт бөмбөг шидэлт	Зугаалга	Бөмбөг шидэх, барьж авах аргачлалыг заах. Дэлбээний өнгөөр (Шар-зөөлөн, Улаан-хүчтэй, Ногоон-дунд) шидэх хүчийг зааж өгөх. Хүүхдүүд хана руу шидэж, буцааж барьж авна.	Бөмбөг, хананд наасан цэцгийн дэлбээ (шар, улаан, ногоон).	Бөмбөгийг ямар хүчээр шидэх вэ? (Дагуулах асуулт).	Суралцахууд суралцах Зааврыг сонсох, дагах Хамтран ажиллах Хоорондын зайг чөлөөтэй барих	Бөмбөгийг хана руу шидэх, барьж авдаг.
Долоон дэлбээг хэрхэн зарцуулсан бэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Долоон дэлбээт цэцэг" үлгэрийн дэлбээг хэрэгтэй (зөв)/хэрэггүй (буруу) зүйлд зарцуулсныг ажлын хуудас дээр тэмдэглэнэ.. Хамгийн хэрэгтэй сонголтыг дэлгэрүүлэн ярилцана.	Ажлын хуудас, зөв буруу тэмдэглэгээ.	Ваарыг бүтэн болгох нь яагаад хэрэггүй сонголт вэ?	Шүүн тунгаах Үйл явдлын ялгах Харилцах Багууд даалгаврыг гүйцэтгэж дууссаны дараа ярилцах	Зохиолын үйл явдлыг ойлгож, зөв бурууг ялгадаг.

Бяцхан цэцэг	Хөгжөөн баясах цаг	С.Ууганбаатарын "Бяцхан цэцэг" дууг сонсох, дууны утгыг хөдөлгөөнөөр илэрхийлж, гарын дохиогоор дуулах. Хөгжмийн зэмсэг сонгон авч, хэмнэлийн зураглалыг харж, хэмнэлд тохируулан тоглоно.	Хөгжим, дууны бичлэг, хэмнэлийн зураглал, энгийн хөгжмийн зэмсэг.	Хөдөлгөөнөөр дууны утгыг хэрхэн илэрхийлэх? (Дагуулах асуулт).	Бүтээлчээр сэтгэх Дүрийн зан чанар, харилцааг хөдөлгөөнөөр илэрхийлэх Суралцахууд суралцах Хэмнэлийг анхааралтай ажиглах	Дуу, аялгууг гарын дохиогоор дуулж, аялдаг.
Цэцэг ямар бүтэцтэй вэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Цэцгийн бүтцийг ажиглах (үндэс, иш, навч, дэлбээ), үрээс цэцэг хэрхэн ургадаг болохыг ярилцах. Үрийг норгож уутанд хийж цонхон дээр байрлуулж ажиглах. Таамаглал туршилттай харьцуулна.	Үрсэлгээ, хөрс, үрсэлгээ уут, ажлын хуудас.	Үрээс цэцэг хэрхэн ургадаг вэ? (Дагуулах асуулт).	Суралцахууд суралцах Ажиглах, тэмдэглэх, таамаглах Бүтээлчээр сэтгэх Бүтцийг тэмдэглэх	Ургамлын ургалтад юу хэрэгтэй болохыг тодорхойлж, тарьж ургуулах үйлд оролцдог.
Сонирхолтой цэцэг	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Hologramm ашиглан (Growing seeds in 3d hologram) цэцгийг 3D хэмжээсээр харах туршилт хийх. Ургамал арчлах үйлд оролцох. Хувцасны цэвэр, бохир байдлыг ярилцаж, бохирдсон үед өөрийн санаачилгаар цэвэр хувцсаар солих тухай ярилцана.	Үрсэлгээ, хөрс, ажлын хуудас.	Цэцгийг хэрхэн арчлах ёстой вэ? (Дагуулах асуулт).	Суралцахууд суралцах Туршилт хийх, арчлах Нийгэм, сэтгэл хөдлөл Бие даан цэвэрлэх, Санаачилгатай оролцох.	Улирлын онцлогоос хамаарч өөрчлөлтийг тайлбарладаг. Хувцасны цэвэр, бохир байдлыг ялгадаг.
Ургамлыг ажиглая	Зугаалга	Цэцэрлэгийн ойр орчмын болон ангид байгаа ургамлыг томруулдаг	Томруулдаг шил.	Гадаах ургамал хатсан байхад тасалгааны ургамал яагаад сайн ургаж байна вэ?.	Суралцахууд суралцах Байгалийн өөрчлөлтийг ажиглах	Улирлын онцлогоос хамаарч өөрчлөлтийг тайлбарладаг.

		шилээр ажиглаж, ялгааг нь ярилцана.				
Шидэт цэцэгс	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Өөрийн шидэт цэцгийг төсөөлж, үндэс, мөчир, навчийг зурна. Долоон дэлбээгээр хүсэл мөрөөдлөө дүрсэлж наах (ЗУ4.3Б). Бүтээлээ бие биедээ танилцуулна.	Өнгийн цаас (7 өнгө), хайч, цавуу, жижиг навч, үр.	Таны цэцэг ямар хүсэл биелүүлэх вэ?	Бүтээлчээр сэтгэх Төсөөлөх, Наамлын бүтээл урлах, Хамтран ажиллах Хамтын бүтээл хийх Нийгэм, сэтгэл хөдлөл Хүмүүс хоорондоо хэрхэн харилцан хамааралтай байдгийг тайлбарлах	Өөрийн бодол төсөөллөөр наамлын бүтээл урладаг. Хүмүүс хоорондоо хэрхэн харилцан хамааралтай байдгийг тайлбарладаг.
Зохиол яриад өгөөч	Хөгжөөн баясах цаг	"Долоон дэлбээт цэцэг" үлгэрийг ширээний театраар ярьж, дараагийн үйл явдлыг асуун ярилцана. Женя охины сайхан сэтгэлийн тухай ярилцах. Үгийн эхэнд болон төгсгөлд орсон авиаг ялган сонсож хэлнэ.	Ширээний театр, зурагт карт (өнгө, үг).	Женя охин яагаад сайхан сэтгэлтэй вэ?	Харилцах Авиаг ялгах, Нийгэм, сэтгэл хөдлөл Сайхан сэтгэл, энэрэнгүй байдлын тухай ярилцах	Үгийн эхэнд болон төгсгөлд орсон авиаг сонсоод ялгаж хэлдэг.
Зохиолын зураглал	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Долоон дэлбээт цэцэг" зохиолын зураглал (story map) хийнэ. Хэн, хэзээ, хаана, юу, яаж гэсэн асуултад хариулан зураглал гарган бусдадаа ярьж өгнө.	Ажлын хуудас, балын харандаа, өнгийн харандаа, тосон харандаа.	Хэн? Хэзээ? Хаана? Юу? Яаж?.	Бүтээлчээр сэтгэх Зураглал хийх Шүүн тунгаах Үйл явдлыг логик дарааллаар ярих, Харилцах Тайлбарлан ярих	Номын агуулга, үйл явдлыг тайлбарлан ярьдаг.

Хамтдаа бүтээе	Төвийн үйл ажиллагаа	Хүүхэд дараах үйлүүдээс сонгоно: 1. Цагариган боов зурах/хийх. 2. Цагаан баавгайны сэтгэл хөдлөлийг нүүрний хувирлаар үзүүлэх. 3. Хүрдэн дээр цифр болон гарагийн нэрийг тааруулж тавих.	Зургийн дэвтэр, баримлын шавар, дахин ашиглах материал, хүрд, цифр, гарагийн нэр.	Ямар сэтгэл хөдлөлийг үзүүлэх? (Дагуулах асуулт).	Бүтээлчээр сэтгэх Урлах, дүрслэх, Нийгэм, сэтгэл хөдлөл Бусдын нөхцөл байдалд тохируулан энэрэх үйлдэл үзүүлэх	Сэтгэл хөдлөлийг нүүрний хувирлаар үзүүлдэг.
----------------	----------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------

4 дүгээр сар II долоо хоног

ШИДЭТ ЦЭЦЭГС

Шинэ үг: Цэцгийн дэлбээ, ид шид

Үйл ажиллагаа 1. Долоон дэлбээт цэцэг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Дэлгэц, зохиол

Аргачлал: “Долоон дэлбээт цэцэг” зохиолын эхний хэсгийг ярьж өгч ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Женя хэн хэнд, ямар цагариган боов авахаар явсан бэ?
- Хэдэн ширхэг цагариган боов авсан бэ?
- Женя яагаад гэнэт уйтгартай болсон бэ?
- Чи нохойноос айдаг уу? Яагаад?
- Хэрэв танихгүй хүн чамайг авч явах гээд байвал чи юу хийх вэ?
- “Боль” гэж хашхирах, зугтах, насанд хүрэгчдээс тусламж хүсэх тухай ярилцах
- Женя одоо гэртээ хариад юу гэж хэлэх бол?
- Зохиол цаашаа хэрхэн үргэлжлэх бол?

Үйл ажиллагаа 2. Зохиолын үргэлжлэл (Номын цаг)

Хэрэглэгдэхүүн: Дэлгэц, үлгэр, бэлдэц цаас, балын харандаа, тосон харандаа

Аргачлал: Зохиолын өрнөл болон төгсгөл хэсгийг ярьж өгнө. Зохиолын хүрээнд ярилцлага өрнүүлнэ. Долоон өнгийн дэлбээгээр юу юу хийснийг дүрслэн зурж, ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Зохиолын аль хэсэг хамгийн их таалагдсан бэ?
- Чи Женягийн оронд байсан бол ямар зүйлс хүсэх байсан бэ?
- Ямар өнгөтэй дэлбээг хамгийн хэрэггүй зүйлд зарцуулсан бэ?
- Ямар өнгөтэй дэлбээг хамгийн зөв зүйлд зарцуулсан бэ?

Үйл ажиллагаа 3. Ид шид (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зургийн дэвтэр, балын харандаа, өнгийн харандаа, тосон харандаа, гуаш, “Долоон дэлбээт цэцэг” ном, нэхмэлийн утас, савх, эв долоо, бөглөөнүүд

Аргачлал:

Зураг урлал төв: Чамд ид шидтэй 7 дэлбээт цэцэг өгвөл чи хүсэх вэ? Зурж будаад, тайлбарлана.

Хэл яриа-номын төв: Эд зүйлс ашиглан үсэг бүтээж тоглоно. (утас, савх, чүдэнз, тууз, үдээс, бөглөө гэх мэт)

Туршилт, танин мэдэхүйн төв: Нэг цэцгийг сонгож услах, тоосыг арчих, ургамлын өсөлтийг ажиглаж, тэмдэглэл хөтөлнө.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 79, дасгал №79](#)

ДОЛОО ХОНОГ

Шинэ үг: Долоон гараг, Даваа, мягмар, лхагва, пүрэв, баасан, бямба, ням, цифр

Үйл ажиллагаа 1. Гарагийн нэртэй дэлбээ (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэн (долоон дэлбээтэй цэцэг), 1-7 хүртэлх цифр

Аргачлал: Цэцгийн дэлбээ бүр дээр 1-7 хүртэлх цифрийг дараалуулан байршуулна. Долоон гарагийн тухай яриа өрнүүлнэ. 1 дэх өдөр Даваа гараг, 2 дахь өдөр Мягмар гараг... зэргээр тайлбарлана. Аль гарагт ямар үйл явдал болдог тухай ярилцана. Тухайлбал, даваагаас баасан гараг хүртэл 5 хоног цэцэрлэгтээ явдаг. Бямба, ням гарагт амардаг гэх мэт.

Үйл ажиллагаа 2. Миний 7 хоног (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Бэлдэц цаас, зургийн хэрэгсэл

Аргачлал: Хүүхэд бүрд даваагаас-ням гараг хүртэлх тухайн өдрийнхөө хамгийн таалагдсан хэсгээ зурах бэлдэц цаас (нэг нүүрэнд харагдахуйц) өгнө. Даваа гарагт хийсэн зүйлээсээ өөрт таалагдсан хэсгээ дүрслэн зурна. Мягмар-Ням гараг хүртэлх зургийг хүүхэд өөрийн чөлөөт цагаар зурна. Эцэст нь зурсан зургаар үзэсгэлэн гаргаж, найзууддаа тайлбарлаж, ярилцах боломж олгоно.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 76, дасгал №76](#)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 72, дасгал №69](#)

Үйл ажиллагаа 3. Ургамал гэж юу вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Үрсэлгээ, усны сав, ус, шороо, алчуур, шүршигч сав, үрслэгээний сав

Аргачлал: Туршилтын багаж хэрэгслийг бэлтгэсэн байна. Ургамлыг үрслүүлэхдээ юу хийж болох вэ? Юу юу хэрэгтэй болохыг ярилцана.

- Хөрс гэж юу вэ? хүүхдүүд таамаглал дэвшүүлэн ярилцана.
- Хуванцар саванд байрлуулсан хөрсөнд ус хийж туршина.
- Хөрсөнд үрийг суулгахад ямар дарааллаар хийсэн тухай ярилцана.
- Ургамлыг ургуулахад юу юу хэрэгтэй болох дарааллыг тэмдэглэнэ.
- Цэцгийн үрийг юунд суулгаж болох вэ? төлөвлөгөө гаргана.
- Үрсэлгээ хийсэн он сар өдрийг бичиж тогтооно.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 82, дасгал №82](#)

БЯЦХАН ЦЭЦЭГ

Шинэ үг: Дүрд тоглох

Үйл ажиллагаа 1: Өнгөт бөмбөг шидэлт (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: Бөмбөг, хананд наасан цэцгийн дэлбээ (шар, улаан, ногоон)

Аргачлал: Багш бөмбөг шидэх, барьж авах аргачлалыг биечлэн хийж үзүүлэн харилцан ярилцана. Дэлбээнүүдийн өнгийг харуулан “Шар-зөөлөн шид”, “Улаан-хүчтэй шид”, “Ногоон-дунд шид” гэж зааж өгнө. Хүүхдүүд дэлбээний өнгийг харж бөмбөгөө хана руу шидэж, буцааж барьж авна.

Үйл ажиллагаа 2. Долоон дэлбээг хэрхэн зарцуулсан бэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ажлын хуудас, зөв буруу тэмдэглэгээ эсвэл маркер

Аргачлал: Баг бүрд тэмдэглэл хийх ажлын хуудас өгсөн байна. Ажлын хуудсыг тайлбарлаж өгнө. “Дэлбээг хэрэгтэй зүйлд зарцуулсан бол зөв, хэрэггүй зүйлд зарцуулсан бол буруу гэсэн тэмдэглээг тавиарай” хэмээн чиглүүлнэ. Хүүхдүүд үлгэрээ санан ярилцаж зөв, бурууг тэмдэглэнэ. Багууд даалгаврыг гүйцэтгэж дууссаны дараа ярилцана. Хамгийн их хэрэгтэй сонголтыг дэлгэрүүлэн ярилцана.

№	Өнгө	Хүсэл	Хэрэгцээтэй эсэх
1	Шар дэлбээ	Цагирган боов аваад гэртээ харих	Хэрэгтэй
2	Улаан дэлбээ	Ваарыг бүтэн болгох	Хэрэггүй
3	Хөх дэлбээ	Хойд туйлд очих	Хэрэггүй
4	Ногоон дэлбээ	Хойд туйлаас буцаж харих	Хэрэгтэй
5	Улбар шар дэлбээ	Дэлхийн бүх тоглоомыг авах	Хэрэггүй
6	Ягаан дэлбээ	Бүх тоглоомыг дэлгүүрт буцаах	Хэрэгтэй
7	Цэнхэр дэлбээ	Витя хүүгийн хөлийг эдгээх	Хэрэгтэй

[Дасгал ажлын дэвтэр хуудас 84, дасгал №84](#)

Үйл ажиллагаа 3. Бяцхан цэцэг (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Хөгжим, утга санааг илэрхийлсэн зураг, зурган картууд, хэмнэлийн зураглал, дууны бичлэг

Аргачлал:

1. Үг, Ая С.Ууганбаатар “Бяцхан цэцэг” дууг багш дуулж (хоолойтой бичлэг) сонсоно. Дууны утгыг мөр бүрийг хөдөлгөөнөөр илэрхийлэн ярилцана. Хөгжмийн аялгуунд тохируулан дүрийг илэрхийлсэн хөдөлгөөнийг хийж, гарын дохиогоор дуулна. Дууны болон хөдөлгөөний бичлэг <https://www.youtube.com/watch?v=mqfPEjDLt-U>
2. Өөрийн дуртай хөгжмийн зэмсгээ сонгон авна. Аюулгүй байдлаа хангаж зайтай зогсоно. Дууг сонсонгоо хэмнэлийн зураглалыг харж хэмнэлээ анхааралтай ажиглана. Хэмнэлийн зураглалыг харж, хэмнэлд тохируулан хөгжмийн зэмсгээр тоглоно. Хэмнэлээ бүрэн хийж дууссаны дараа дуугаа дуулаад хэмнэлээ тоглоно.



Хэмнэл тоглох аргачлал

<https://www.youtube.com/watch?v=MFQ8nswmntg>

4 дүгээр сарын II долоо хоног

ЯАГААД УРГАМЛЫГ ХАЙРЛАХ ХЭРЭГТЭЙ ВЭ?

Шинэ үг: Ургамлын бүтэц, иш, үрсэлгээ

Үйл ажиллагаа 1. Цэцэг ямар бүтэцтэй вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Үрсэлгээ, хөрс, үрсэлгээ уут, ажлын хуудас

Аргачлал: Цэцэг ямар бүтэцтэй байгааг ажиглана. Үрээс цэцэг хэрхэн ургадаг болохыг ярилцана. Цэцгийн үрийг цаасанд ороож норгоод уутанд хийж цонхон дээр байрлуулж ажиглана. Ургамалд гарч буй өөрчлөлтийг ажиглан ярилцана. Ургамалд үрслэгээнд гарч буй өөрчлөлтийг таамаглал туршилттай харьцуулна. Цэцгийн бүтцийг ажиглаж хуудас цаасан дээр тэмдэглэнэ. Үндэс, иш, навч, дэлбээ гэх мэт.

Үйл ажиллагаа 2. Сонирхолтой цэцэг (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Үрсэлгээ, хөрс, үрслэгээний уут, ажлын хуудас

Аргачлал: Hologramm ашиглан цэцгийг [Growing seeds in 3d hologram](#) 3D хэмжээсээр харах туршилт хийнэ. Цэцэг ургах явцыг ажиглан ярилцана. Цэцгээр амьтад хооллодог болохыг тайлбарлан ярилцана.

- Хүүхэд ургамлын навч арчих, наранд тавих, тохируулж услах, савны амсрыг арчих, ажиглалт хийх, тэмдэглэх зэргээр ургуулах, арчлах үйлд оролцоно.

- Хүүхдүүдийн хувцас цэвэр, бохир байгаа эсэхийг ярилцана. Бохирдсон хэсгийг гэвж цэвэрлэнэ. Бохирдсон хувцсыг угааж цэвэрлэх шаардлагатай. Бид хувцсаа бохирдсон үед нь солих хэрэгтэй зэргээр ярилцана.

Үйл ажиллагаа 3. Ургамлыг ажиглая (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: Томруулдаг шил

Аргачлал: Цэцэрлэгийн ойр орчмоор ургамал ургасан эсэхийг ажиглаж, ярилцана. Ангид байгаа тасалгааны ургамлаас сонгож ялгааг ярилцана.

Багшийн чиглүүлэг асуулт:

- Ургамал ямар өнгөтэй байна вэ?
- Хүрч үзсэн үү? Ямар санагдсан бэ?
- Ургамалд юу юу хэрэгтэй байдаг вэ?
- Гадаах ургамал хатсан байхад тасалгааны ургамал яагаад сайн ургаж байна вэ?

ЗОХИОЛОО ЯРИЛЦЬЯ

Шинэ үг: Сайхан сэтгэл

Үйл ажиллагаа 1: Шидэт цэцэгс (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Өнгийн цаас (7 өнгө), хайч, цавуу, жижиг навч, цэцгийн зураг, үр

Аргачлал: Хүүхдүүд өөрийн шидэт цэцгийг бодитоор төсөөлж, үндэс, мөчир, навчийг зурж бэлдэнэ. Долоон дэлбээг бодитоор өнгөөр ялгаж нааж, өөрийн хүсэл мөрөөдлийг жижиг дүрс буюу зураг, тэмдэглэлээр илэрхийлнэ. Хүүхдүүд бие биедээ бүтээлээ танилцуулж, дэлбээ бүрд юу хүсэж байгаагаа ярьж өгнө. Бүтээлээ ангийн хананд байрлуулж, “Шидэт цэцэгс” үүсгэн, найзуудтайгаа ярилцана.

Үйл ажиллагаа 2: Зохиол яриад өгөөч (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: “Долоон дэлбээт цэцэг” ширээний театр, зурагт карт (өнгө, үг)

Аргачлал: Долоон дэлбээт цэцэг үлгэрийг ширээний театраар ярьж өгөх явцдаа хүүхдүүдээс дараагийн үйл явдлыг асууж, харилцан ярилцангаа үргэлжлүүлнэ. Женя охины сайхан сэтгэлийн тухай ярилцана. Шар, улаан, ногоон, хөх, улбар шар, ягаан, цэнхэр өнгийг нэрлэнгээ үгийн эхэнд болон төгсгөлд орсон авиаг сонсоод ялгана. Хос болж нэг нэгэндээ үгийг тод хэлж, уруул, амны хөдөлгөөний ажиглана, үгийн эхэнд орж байгааг авиаг ялгаж сонсоно. Үгийн төгсгөлд орж байгаа авиаг ялгаж сонсоно, хэлнэ. Хамтдаа [СӨБ | Интерактив | Бэлтгэл | Үгийн эхэн, дунд, адагт орсон авиаг ялгаж сонсьё](#) тоглоом тоглоно.

Үйл ажиллагаа 3: Бүгд долоо (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зурагт карт 7 цагариган боов, 7 цагаан баавгай, 7 тоглоом, 7 өнгийн дэлбээ, 7 өнгө (зохиолд гарсны дагуу)

Аргачлал: Үлгэрт гарсан долоон ширхэг зүйлсийг ярилцангаа самбарт байрлуулна. Эхлээд цагариган боов, харалдаа доор нь цагаан баавгай гэх мэт. Цагаан баавгайнуудыг сэтгэл хөдлөл ямар байсан тухай ярилцана.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 86, дасгал №86](#)

БИ ҮҮНИЙГ СУРСАН

Шинэ үг: Цагалбар

Үйл ажиллагаа 1: Долоон гараг (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Цагалбарын үзүүлэн, 1-31 хүртэлх цифр, долоон гарагийн нэр, цаг агаарын тэмдэглэгээний зураг

Аргачлал: Өнөөдөр хэдэн сарын хэдний өдөр, ямар гараг болохыг ярилцаж тэмдэглэнэ. Гадаах цаг агаарын байдлыг ажиглаж, ямар байгааг ярилцаж тэмдэглэнэ.

Үйл ажиллагаа 2. Хамтдаа бүтээе (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Зургийн дэвтэр, балын харандаа, тосон харандаа, баримлын шавар, дахин ашиглах төрөл бүрийн материалууд, долоо хуваасан хүрд, 1-7 хүртэлх цифр, долоон гарагийн нэр

Аргачлал: Хүүхэд дараах үйлүүдээс сонгож хийнэ.

- Цагариган боов зурна, хийнэ.
- Цагаан баавгайны сэтгэл хөдлөлийн талаар ярилцаж, нүүрний хувирлаар үзүүлнэ.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 85, дасгал №85](#)

- Хүрд хэлбэрээр бэлдсэн хэрэглэгдэхүүн дээр цифр болон гарагийн нэрийг тааруулж тавина. Долоон гараг тасралтгүй эргэлддэг тухай ярилцана.

Үйл ажиллагаа 3: Зохиолын зураглал (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ажлын хуудас, балын харандаа, өнгийн харандаа, тосон харандаа

Аргачлал: Хүүхэд “Долоон дэлбээт цэцэг” зохиолын зураглал (story map) хийнэ. Зохиолын хүрээнд хэн, хэзээ, хаана, юу, яаж гэсэн асуултад хариулан зураглал гарган бусдадаа ярьж өгнө.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 101, дасгал №101](#)

Сонсьё, дэмжье

- Үлгэрийн хэмжээ урт тул ярьж өгөх явцдаа хүүхдийн асуултыг анзаарч, заавал хариу ярилцаарай.

- Цэцгийн дэлбээний өнгийг үлгэрийг анх ярьж өгөхдөө самбарт дарааллын дагуу байрлуулаарай.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Үлгэрийг гэрт нь ярьж өгөх даалгавар өгөөрэй. “Долоон дэлбээт цэцэг” үлгэр-ийг эндээс сонсгож болно.
- “Миний долоо хоног” үйл ажиллагаагаар эхлүүлсэн зургийг бямба, ням гарагт зурж ирэхээр тайлбарлаж явуулаарай.

Багшийн эргэцүүлэмж

<p>Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./</p> <p>Амжилттай хэрэгжүүлсэн:</p> <p>Сул хэрэгжүүлсэн:.....</p> <p>Цаашид сайжруулах:.....</p> <p>Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:</p>

СУРГАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ- V САР

СУДЛААЧ ХҮҮХДҮҮД

Хүүхдийн эзэмших чадамж

Шүүн тунгаах: Сонирхсон зүйлээ ажиглах, асуух, асуултын хариултыг эрж хайх өнгө хэмжээгээр харьцуулах

Бүтээлчээр сэтгэх: Өөрийн санааг янз бүрийн аргаар илэрхийлэх (зургаар, наамлаар, харилцан яриагаар гэх мэт)

Нийгэм, сэтгэл хөдлөл: Өөрийн болон бусдын сэтгэл хөдлөл, мэдрэмжийг ойлгох, тайлбарлах, сэтгэл хөдлөлөө удирдан зохицуулах

Аюулгүй байдлын зөвлөмж:

Хүүхэд аалзнаас айж байвал хэт ойртуулах шаардлагагүй. Зугаалгаар гарахдаа томруулдаг шилийг хагалахаас сэргийлж, хүүхдүүдэд сануулж хэлээрэй.

Өдрийн хуваарьт үйл ажиллагаа:

Тойргийн цаг:

- Хамтдаа аалзыг судалцгаая хэмээн уриалж, хүүхдэд аалз судлах гэж байгаа талаар ойлголт өгч ярилцана.

Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа:

- Аалзны тухай бичлэг, ном үзэж илүү сайн судлаарай.
- Хүүхэд төрөл бүрийн аалз үзэж судалсны дараа өөрт байгалийн материал ашиглан зохион бүтээнэ.
- Хэн ямар аалз сонгосон тухай ярилцаж, яагаад гэсэн асуултыг тавиарай.

Төвийн үйл ажиллагаа:

- Хүүхдийн хийх үйлийг ажиглаж, шаардлагатай бол нэмэлт чиглүүлэг өгч идэвхжүүлээрэй.
- Хүүхдийн хийх үйлүүдийг тодорхой болгон хэлж өгч, сонголт хийх боломжийг олгоорой.

Зугаалга:

- Цаг агаарын байдалд тохируулан хувцаслаж байгаа эсэхийг анхаарч хараарай. Аалзыг юугаар хооллож байгааг ажиглаарай.

Номын цаг:

- Аалзтай холбоотой сонирхолтой видео бичлэгүүд сонгон үзэж ярилцаарай. Зурагт номоор дамжуулж шавж, тэдний ялгааг ажиглаж, яриа өрнүүлээрэй.

Хөгжөөн баясах цаг:

- Амьтадтай холбоотой төрөл бүрийн тоглоом тоглоорой. Хүүхдийн иог хийлгэж амьтдын байрлалыг хэр удаан, тэнцвэртэй барихыг ажиглаарай.

Боломжууд:

- “Судлаач хүүхдүүд” сэдвийн хүрээнд шинжлэн судлах арга зүйгээр сургалт, үйл ажиллагааг зохион байгуулж болох жишиг санааг 5Е загвараар гаргаж оруулсан. Хүүхдийн сонирхлоос шалтгаалж сургалт, үйл ажиллагааг 4 долоо хоног үргэлжлүүлэн зохион байгуулах боломжтой.
- Хүүхдээс гарч буй санаа, бодож төсөөлөн хийсэн зүйлийг нь дэмжиж, үйл ажиллагаандаа тусган ашиглаарай.
- Туршилтын явцад заавар дүрмээ дагаж мөрдөхөд чиглүүлж, сануулаарай.
- Хүүхэд ажиглах, турших, асуулт асуух, тайлбарлах, үнэлэх үе шат алхмаар зохион байгуулахад багш чиглүүлэгчээр хүүхэд өөрөө турших замаар мэдлэгийг бүтээхэд гол үйл ажиллагаа чиглэнэ.

Үйл ажиллагааны төлөвлөлт

Сургалтын чиглэл ба суралцахуйн үр дүн	Суралцахуйн үйл ажиллагаа	Үйл ажиллагааны нэр
<p>БНО4.1а. Амьтдын үр төл, идэш тэжээл, амьдрах орчны ялгааг тайлбарлаж, хайрлан хамгаалах үйлд оролцоно.</p> <p>НСХ4.1в. Тайвшрах аргаас насанд хүрэгчийн тусламжтай хэрэглэдэг болно.</p> <p>МАТ4.1а. 20 хүртэлх тоог цээжээр тоолох, 10 хүртэлх тооны юмсыг оноож тоолох, тоог таних, өгсөн тооноос эхэлж 1-ээр нэмэгдүүлэн, хорогдуулан тоолох, тоог жишнэ.</p>	<p>- Амьтдын үр төл, идэш тэжээл, амьдрах орчныг ялгааг сонирхон судлах, ижил төстэй ба ялгаатай талыг харьцуулах, ангилах, бүлэглэх тоглоом тоглох</p> <p>- Тоглоом, зугаалга, уралдаан тэмцээний үед уурласан, гомдсон, бухимдсан, сэтгэлээр унасан үедээ өөрийгөө тайвшруулах аргаас хэрэглэх; (урт амьсгаа авах, тоо тоолох, энгийн иог хийх)</p> <p>- 1-10 хүртэл цифрийг бичих, тэмдэглэх тоглоом (бөмбөлгийг тоолоод тэнцүү тооны цэг, зураас зурах, зурагт байгаа юмсыг тоолоод тохирох цифрийг бичих гэх мэт) тоглох</p>	Аалзнаас айдаг уу?
<p>ЗУ4.3в. Тоглоом болон байгалийн материал, дахин ашиглах материалаас сонгож шинэ загвар бүтээнэ.</p> <p>МАТ4.2а. Юмсын урт, хүнд, багтаамжийг таамаглаад, харьцуулж, тайлбарлана.</p> <p>БНО4.1г. Улирлын онцлогоос хамаарч амьтан, ургамал, хүмүүсийн амьдралд гарч буй өөрчлөлтийг тайлбарлаж, өөрийн хийх үйлийг тохируулан сонгоно.</p>	<p>- Зохион бүтээх үйлд ашиглах материал, багаж хэрэгсэл, тоглоомоо бие даан сонгож хэрэглэх</p> <p>- Юмсын урт, богиныг харьцуулах</p> <p>- Улирлын онцлогоос шалтгаалж, хүмүүсийн амьдрал, амьтан ургамалд гарч буй өөрчлөлтийг ажиглах, мэдээлэл цуглуулж, ярилцлага хийх</p>	Аалз хаана амьдардаг вэ?
<p>ХЭМ4.1в. Гараа алдлан нэг хөлөө арагш шулуун өргөн тэнцвэр хадгалан (хараацай) зогсоно.</p> <p>НСХ4.1в. Тайвшрах аргаас насанд хүрэгчийн тусламжтай хэрэглэдэг болно.</p>	<p>- Нэг хөлийг арагш өргөж, гараа алдлан тэнцвэр хадгалан бие даан зогсох (хараацай)</p> <p>- Тоглоом, зугаалга, уралдаан тэмцээний үед уурласан, гомдсон, бухимдсан, сэтгэлээр унасан үедээ өөрийгөө тайвшруулах аргаас хэрэглэх; (урт амьсгаа авах, тоо тоолох, энгийн иог хийх)</p>	Амьтад яаж хөдөлдөг вэ?
<p>БНО4.1а. Амьтдын үр төл, идэш тэжээл, амьдрах орчны ялгааг тайлбарлаж, хайрлан хамгаалах үйлд оролцоно.</p>	<p>- Амьтдын үр төл, идэш тэжээл, амьдрах орчныг ялгааг сонирхон судлах, ижил төстэй ба ялгаатай талыг харьцуулах, ангилах, бүлэглэх тоглоом тоглох</p>	

<p>ХЭМ4.1в. Гараа алдлан нэг хөлөө арагш шулуун өргөн тэнцвэр хадгалан (хараацай) зогсоно.</p>	<p>- Тоглоом, зугаалга, уралдаан тэмцээний үед уурласан, гомдсон, бухимдсан, сэтгэлээр унасан үедээ өөрийгөө тайвшруулах аргаас хэрэглэх; (урт амьсгаа авах, тоо тоолох, энгийн иог хийх)</p>	<p>Аалз юугаар хооллодог вэ?</p>
<p>БНО4.1г. Улирлын онцлогоос хамаарч амьтан, ургамал, хүмүүсийн амьдралд гарч буй өөрчлөлтийг тайлбарлаж, өөрийн хийх үйлийг тохируулан сонгоно. ХЯ4.2а. Тодорхой сэдвээр санаа бодлоо илэрхийлж, идэвхтэй ярилцана.</p>	<p>- Улирлын онцлогоос шалтгаалж, хүмүүсийн амьдрал, амьтан ургамалд гарч буй өөрчлөлтийг ажиглах, мэдээлэл цуглуулж, ярилцлага хийх - Сэдвүүдээс чөлөөтэй сонгуулан, ярилцлага өрнүүлэх, үзсэн харсан үйл явдлаа тайлбарлан ярих дасгал ажил хийх, бусдын яриаг сонсоод, яагаад, юуны учир вэ? зэрэг асуулт тавьж, үзэл бодлоо хэлэлцэх, харилцан яриаг үргэлжлүүлэн ярилцах тоглоом тоглох</p>	<p>Аалз бидэнд тус болдог уу?</p>
<p>ХӨГ4.1в. Дуу, аялгууны хэмнэлийг хөгжмийн энгийн зэмсгээр хамтран хөгжимдөнө. НСХ4.1в. Тайвшрах аргаас насанд хүрэгчийн тусламжтай хэрэглэдэг болно.</p>	<p>- Энгийн хөгжмийн зэмсгээр тоглох аргыг мэдэх - Тоглоом, зугаалга, уралдаан тэмцээний үед уурласан, гомдсон, бухимдсан, сэтгэлээр унасан үедээ өөрийгөө тайвшруулах аргаас хэрэглэх; (урт амьсгаа авах, тоо тоолох, энгийн иог хийх)</p>	<p>Хамтдаа хөгжилдөцгөө</p>

5 дугаар сарын сургалт, үйл ажиллагааны төлөвлөлтийн нэгтгэл

Үйл ажиллагааны нэр	Өдрийн хуваарьт үйл ажиллагаа	Үйл ажиллагааны товч агуулга	Хэрэглэгдэхүүн	Чиглүүлэх асуулт	Эзэмших чадамж	Үнэлгээ
Аалзнаас айдаг уу?	Тойргийн цаг	Шилэн саванд бэлтгэсэн аалз (эсвэл бичлэг/ном) үзүүлэн ярилцах. Айдсын тухай ярилцаж, тайвшруулах үүднээс найзыгаа тэвэрнэ.	Бодит үзүүлэн (аалзны тухай ном), шилэн саванд аалз (эсвэл бичлэг).	Энэ ямар амьтан бэ? Та нар аалз харахаараа айдаг уу?	НСХ Айдсыг ойлгох, тайвшрах арга хэрэглэх. Харилцах Ярилцлагад оролцох	Айдсын тухай ярилцаж, сэтгэл хөдлөлөө илэрхийлдэг.
Аалз хэдэн хөлтэй вэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Томруулдаг шил ашиглан аалзны биеийн бүтэц (толгой, хэвлий, хөл, сүүл) -ийг ажиглах. Зургийг тохирох хэсэгт байрлуулж зурагт ном бүтээнэ.	Саванд бэлтгэсэн амьтан, томруулдаг шил, дасгал ажлын дэвтэр хуудас 98.	Аалзны биеийн хэсгүүд ямар бүтэцтэй вэ? Аалз бусад амьтнаас юугаараа ялгаатай вэ?	Шүүн тунгаах Ажиглах, бүтэц ялгааг харьцуулах. Бүтээлчээр сэтгэх Зурагт ном бүтээх	Амьтны биеийн бүтцийг таньж, ялгааг тайлбарладаг.
Аалз бүтээцгээ	Төвийн үйл ажиллагаа	МАТ төв: Ажлын хуудсанд аалзны хэсгүүдийг 1-10 хүртэлх цифрээр тэмдэглэнэ. Зураг урлалын төв: Баримлын шавраар амьтад хийж, байгалийн материалаар чимэглэнэ. Туршилт төв: Аалзыг томруулдаг шилээр ялган харьцуулна. (8 хөлтэй, 6 хөлтэй гэх мэт).	1-20 хүртэл тоогоор бэлдсэн цаас, хайч, нэхмэлийн утас, баримлын шавар, байгалийн материал, хиймэл шавж үзүүлэн, ажлын хуудас.	(Хүүхдүүд өөрсдийн бүтээлээ танилцуулна).	Шүүн тунгаах Харьцуулах, ангилах МАТ Тоо тоолох, тэмдэглэх Бүтээлчээр сэтгэх Загвар бүтээх, чимэглэх	Бүтээлээ тайлбарладаг.
Самбарт байрлуулаарай	Хөгжөөн баясах цаг	Цуглуулсан мэдээлэл болон бүтээлүүдийг мэдээллийн самбарт байрлуулж, аалзны биеийн бүтцийн тухай дэлгэрүүлэн тайлбарлана.	Мэдээллийн самбар, хүүхдийн хийсэн бүтээл.	Мэдээлэлд тулгуурлан тайлбарлан ярих	Харилцах Тайлбарлан ярих, мэдээлэл хуваалцах	Мэдээллийг хэрхэн нэгтгэж ярьдаг.

					Шүүн тунгаах Мэдээлэлд тулгуурлан дүгнэх	
Амьтад хаана байна вэ?	Тойргийн цаг	Аалзны амьдардаг орчны бичлэгийг үзэж, ярилцана. Тор нэхдэг шалтгаан, торны хортой эсэх тухай чиглүүлнэ.	Аалзны амьдардаг орчныг харуулсан бичлэг.	Аалз хаана амьдардаг вэ? Аалз яагаад тор нэхдэг вэ?	Шүүн тунгаах (Асуултын хариултыг эрж хайх).	Таамаглал дэвшүүлж, ярианд оролцдог.
Аалз яагаад тор нэхдэг вэ?	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Цаасан таваг ашиглан цоолсон нүхэнд нэхмэл утас бэхэлж, урт богино хэмжээтэй аалзны тор зохион бүтээх. Утасны хэмжээний тухай ярилцана.	Цаасан таваг, нэхмэлийн утас, хайч, аалз.	(Хийсэн тороо хэрхэн, ямар хэмжээтэй утас ашиглан хийснээ танилцуулна).	Бүтээлчээр сэтгэх Шинэ загвар бүтээх МАТ Урт, богиныг харьцуулах	Бүтээлээ танилцуулж, хэмжээний ялгааг тайлбарладаг.
Хэмжилт хийцгээе (Төвийн ажил)	Төвийн үйл ажиллагаа	МАТ төв: Модон шоогоор тор бүтээж, хамгийн урт болон богино хэсэгт орсон шооны тоог цифрээр тэмдэглэх. ХЯ төв: Аалзны торыг гүйцээж зураад, цаасаар аалз хийж чимэглэх, бүтээлээ тайлбарлана.	Модон шоо, цифр бүхий хуудас, цаас.	(Бүтээсэн тороо тайлбарлах).	МАТ Хэмжилт хийх, тоогоор тэмдэглэх Бүтээлчээр сэтгэх Тор зурах, бүтээлээ чимэглэх	Шооны тоог зөв тэмдэглэж, бүтээлээ тайлбарладаг.
Хамтдаа хөгжилдье	Зугаалга	Гадаах цаг агаар, улирлын өөрчлөлт ажиглах. Нэрлэсэн амьтдын хөдөлгөөнийг дуурайх (шувуу – хараацай зогсолт, аалзны хөдөлгөөн). Уртаар амьсгал авч тайвшрах дасгал хийнэ.	Томруулдаг шил, зузаан хувцас, тэмдэг тэмдэглэгээний зураг.	Ургамал амьтанд ямар өөрчлөлт гарсан байгаа тухай ярилцана.	Бүтээлчээр сэтгэх: Нааж урлаг, зохион бүтээх	Хараацай зогсолтыг бие даан тэнцвэртэй барьдаг.
Тэнцвэрээ хадгалъя тоглоом	Хөгжөөн баясах цаг	Иогийн дасгал хийх (завь, нохой, мод, эрвээхэй). Хараацай зогсолтыг хэн	Зурагт үзүүлэн (хүүхдийн иог).	(Асуулт байхгүй).	Бүтээлчээр сэтгэх: Нааж урлаг, зохион бүтээх	Хараацай зогсолтыг бие даан тэнцвэртэй барьдаг.

		удаан хийж чадах вэ? тоглоом тоглоно.				
Юугаар хооллодог вэ?	Тойргийн цаг	Аалзны хоол тэжээлийн тухай асуудал дэвшүүлэн, таамаглал хэлэлцэх. Шавжаар хооллож буй бичлэгийг үзнэ.	(Хэрэглэгдэхүүн заагаагүй).	Аалз юугаар хооллодог вэ? Аалзны торонд наалдвал юу болох тухай үргэлжлүүлнэ.	Шүүн тунгаах: Таамаглал дэвшүүлэх	Таамаглалаа хэлдэг.
Наалдамхай тор (Тоглоом)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Хүүхдүүдийг аалз, ялаагаар хувааж, хөгжимтэй хөдөлгөөнт тоглоом тоглох. Хөгжим зогсоход торонд үлдсэн хүүхэд хасагдах дүрэмтэй тоглоом.	Аалз болон ялааны баг, утас.	(Асуулт байхгүй).	Хамтран ажиллах: Дүрэм дагах, багаар ажиллах	Тоглоомын дүрмийг мөрддөг.
Аалзны тор усанд норох уу? (Туршилт)	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	Туршилт: Хиймэл торыг саванд байрлуулаад, ус шүршиж ажиглах. Ус тогтох/урсахыг томруулдаг шилээр харах. Тор ус нэвтрүүлэхгүй, наалдамхай бүтэцтэй болохыг дүгнэх. Бороонд хүн өөрийгөө хэрхэн хамгаалдагтай холбоно.	Жижиг сав, ус шүршигч сав, аалзны тор (цавуу/утас), хиймэл аалз, томруулдаг шил.	Аалзны тор бороо орвол норох уу? Аалз бороонд норохгүй байхын тулд юу хийдэг бол?	Шүүн тунгаах: Таамаглал дэвшүүлэх, туршилт хийх Суралцахууд суралцах: Туршилтаас мэдлэг бүтээх	Туршилтыг дүгнэлт гаргаж, тайлбарладаг.
Аалзны ач тус	Тойргийн цаг	Өмнөх мэдлэгт тулгуурлан, аалз шавж барьж, байгаль дэлхийг хамгаалж байгаа тухай ярилцаж дүгнэлт хийнэ.	(Хэрэглэгдэхүүн заагаагүй).	Аалз шавжийг яагаад барьсан бэ? Байгаль хамгаалагч гэж хэнийг хэлэх вэ?	Шүүн тунгаах: Үр дагаврыг бодох Харилцах: Дүгнэлт гаргах, ярилцах	Өмнөх мэдлэгтээ тулгуурлан дүгнэлт хийдэг.

Амьтад бүтээгээрэй (Төвийн ажил)	Төвийн үйл ажиллагаа	Зураг урлалын төв: Уян утас ашиглан хөдөлгөөнт тоглоом бүтээнэ. Их биеийг хайчилж, хөлийн тоогоор цоолбор хийж утсыг бэхэлнэ. Тоглоомын төв: Блок тоглоомоор амьтан хийж, өнгийг зохиомжлон тайлбарлах.	Уян утас, хайч, блок тоглоом, ажлын хуудас.	(Ямар амьтан бүтээснээ тайлбарлана).	Бүтээлчээр сэтгэх: Хөдөлгөөнт загвар бүтээх Хамтран ажиллах: Багаар тоглох	Шинэ загвар зохиомжлон бүтээдэг.
Бид юу мэдэж авсан бэ?	Хөгжөөн баясах цаг	Мэдээллийн самбар болон ажлын хуудсыг нэгтгэн, юу судалж мэдсэнээ дүгнэж, байгаль хамгаалахын тулд юу хийх талаар ярилцах.	Мэдээллийн самбар, ажлын хуудас.	Аалзыг судлахад юу хамгийн сонирхолтой санагдсан бэ? Аалз байхгүй бол юу болох вэ?	Суралцахууд суралцах: Мэдлэгээ нэгтгэх Шүүн тунгаах: Дүгнэлт хийх, үнэлэх	Мэдээллийг нэгтгэн, дүгнэлт болон санаагаа хэлдэг.
Алаг эрээн аалз	Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа	"Аалз борооны дараа юу хийдэг вэ?" гэж асуух. Дууны бичлэг сонсож, багшийн зааснаар хөдөлгөөнөөр даган хийнэ.	Аалзны жижиг тоглоом, дууны хоолойгүй бичлэг.	Аалз борооны дараа юу хийдэг гэж бодож байна вэ?	Бүтээлчээр сэтгэх: Хөдөлгөөнөөр илэрхийлэх.	Хөдөлгөөнийг дуурайн хийдэг.
Хөгжилтэй аялгуу	Хөгжөөн баясах ажил	Хөгжмийн зэмсэг (өнгөт хоолой, эгшигт хонх, төмөр царгил) сонгож, хэмнэлд тааруулан хамтарч тоглоно.	Дууны ая, өнгөт хоолой, эгшигт хонх, төмөр царгил.	Хэрхэн тоглож байгааг ажиглаад ярилцаарай.	Хамтран ажиллах: Найзуудтайгаа хамтарч тоглох	Хэмнэлд тохируулан, хамтарч тоглодог.

ААЛЗНААС АЙДАГ УУ?

Шинэ үг: Айдас, шавж

Үйл ажиллагаа 1. Оролцох үе шат - Аалзнаас айдаг уу? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Бодит үзүүлэн (аалзны тухай ном)

Аргачлал: Шилэн саванд аалз хийж бэлтгэнэ. (Аалзны хөдөлгөөн харуулсан бичлэг ном зэргийг ашиглаж болно.) Та нар аалзны тухай юу мэдэх вэ? сэдвээр ярилцлага хийнэ. Аалзнаас айдаг уу? Айдсын тухай ярилцсаны дараа хажууд байгаа найзыгаа тэвэрч тайвшруулна.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Энэ ямар амьтан бэ?
- Та нар энэ амьтныг өмнө нь харьж байсан уу?
- Ямар өнгө хэлбэртэй байна?
- Та нар аалз харахаараа айдаг уу?
- Бүгдээрээ хамтдаа аалзыг судлах уу?

Үйл ажиллагаа 2. Шинжлэн судлах үе шат - Аалз хэдэн хөлтэй вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Саванд бэлтгэсэн амьтан, томруулдаг шил

Аргачлал: Саванд бэлтгэсэн амьтныг ажиглаад ямар өнгөтэй, биеийн хэсгүүдийг асууж ярилцана. Толгой, нүд, хэвлий, хөл, сүүлний хэлбэрийг хүүхэд бүр томруулдаг шил ашиглан аалзны биеийн бүтэцтэй танилцана. Амьтны биеийн бүтцийг харуулсан зургийг тохирох хэсэгт байрлуулж зурагт ном бүтээнэ.

Багшийн чиглүүлэх асуулт:

- Аалзны биеийн хэсгүүдийг ямар бүтэцтэй байсан бэ?
- Аалзны хэрхэн хөдөлж байна вэ?
- Аалзны өсөлт хөгжил хэрхэн явагддаг вэ?
- Аалз бусад амьтнаас юугаараа ялгаатай байна вэ?

[Дасгал ажлын дэвтэр хуудас 98, дасгал №98](#)

Үйл ажиллагаа 3. Тайлбарлах ба нарийвчлан боловсруулах үе шат - Аалз бүтээцгээе (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: 1-20 хүртэл тоогоор бэлдсэн бэлдэц цаас, хайч, хуванцар зүү, нэхмэлийн утас, аалзны өсөлт хөгжилтийн загвар

СӨБ | Хичээл | Хүн ба байгаль 5 | Шавж, аалз хэлбэртэн ялган таних

Аргачлал:

Математикийн төв: Ажлын хуудас бүхий цаасан дээр аалзны толгой, хөл сүүл хэд байгааг 1-10 хүртэлх тооны цифрээр тэмдэглэнэ.

Зураг урлалын төв: Төрөл бүрийн амьтад барих аргачлалаас сонгож, аргачлалын дагуу баримлын шавраар амьтад зохиомжлон хийнэ. Нүд хөлийг байгалийн материал ашиглан чимэглэнэ. Өөрийн зохиомжлон хийсэн амьтныг танилцуулна.

Туршилт танин мэдэхүйн төв:

Төрөл бүрийн шавжийн хиймэл үзүүлэнгээс сонгож аалз бусад шавжаас юугаараа ижил болон ялгаатай болохыг томруулдаг шил ашиглан ажиглана. Ажлын хуудсанд биеийн хэсгийг харьцуулж тэмдэглэнэ. (Жишээ нь аалз 8 хөлтэй шоргоолж 6 хөлтэй гэх мэт)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 58, дасгал №60](#)

[Дасгал ажлын дэвтэр хуудас 90, дасгал №87](#)

Үйл ажиллагаа 4. Үнэлэх үе шат - Самбарт байрлуулаарай (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Мэдээллийн самбар, хүүхдийн хийсэн бүтээл

Аргачлал: Өөрсдийн цуглуулсан мэдээллийг самбарт байрлуулж ярилцана. Хүүхдүүд өөрсдийн судалж мэдсэн зүйлийг самбарт байрлуулсан мэдээлэлд тулгуурлан тайлбарлан ярина. (Аалзны биеийн бүтэц ямар хэсгүүдтэй болох тухай дэлгэрүүлэн олж авсан мэдээллээ хуваалцана)

ААЛЗ ХААНА АМЬДАРДАГ ВЭ?

Шинэ үг: Урт, богино, аалзны тор

Үйл ажиллагаа 1. Амьтад хаана байна вэ? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн: Аалзны амьдардаг орчныг харуулсан бичлэг

Аргачлал: Бичлэгийг үзээд аалз хаана амьдардаг тухай асууж ярилцана.

Багшийн чиглүүлэх асуулт

- Аалз хаана амьдардаг вэ?

- Аалз яагаад тор нэхдэг вэ?

- Аалзны тор хортой юу гэх мэтээр асууж чиглүүлнэ.

Үйл ажиллагаа 2. Аалз яагаад тор нэхдэг вэ? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Том жижиг нэг удаагийн цаасан таваг, нэхмэлийн утас, хайч, аалз

Аргачлал: Нэг удаагийн цаасан таваг ашиглан цоолсон нүхэнд нэхмэл утас бэхэлж, урт богино хэмжээтэй аалзны торыг зохион бүтээнэ. Өөрийн хийсэн аалзны торыг хийхэд ямар хэмжээтэй утас хэд орсон тухай ярилцана. Хүүхдүүд бие биедээ өөрийн бүтээсэн аалзны торыг танилцуулна.

Үйл ажиллагаа 3. Хэмжилт хийцгээе (Төвийн үйл ажиллагаа, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Модон шоо, цифр бүхий хуудас, <https://youtu.be/ILEEq9JL4Kk>

Аргачлал:

Математикийн төв: Модон шоогоор аалзны тор бүтээнэ. Аалзны тор хийхэд хамгийн урт болон богино хэсэгт хэдэн шоо орсон болохыг цифрээр тэмдэглэнэ. Ямар аалзны тор нэхсэн тухайгаа бусдадаа тайлбарлаж танилцуулна.

Туршилт танин мэдэхүйн төв: Амьтдын амьдрах орчныг зөв холбож зурах дасгал хийнэ.

Хэл яриа- номын төв: Хуудас цаасыг 4 тэнцүү хэсэгт хувааж зураад цаасны гол долгион зураасаар аалзны торыг гүйцээж зурна. Зурсан тороо цаасаар аалз хийж чимэглэнэ. Өөрийн хийсэн бүтээлийг самбарт байрлуулж тайлбарлана.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 96, дасгал №96](#)

АМЬТАД ЯАЖ ХӨДӨЛДӨГ ВЭ?

Шинэ үг: Тэнцвэр, тайвшрах

Үйл ажиллагаа 1. Хамтдаа хөгжилдье (Зугаалга)

Хэрэглэгдэхүүн: Томруулдаг шил, зузаан хувцас, тэмдэг тэмдэглэгээний зураг

Аргачлал:

- Гадаа цаг агаар ямар байна вэ? бидний эргэн тойронд юу байгааг ажиглаарай. Ургамал амьтанд ямар өөрчлөлт гарсан байгаа тухай ярилцана.
- Нэрлэсэн хөдөлгөөнийг дуурайж тоглоно. Шувууны зургийг гаргахад нэг хөлийг арагш өргөж, гараа алдлан тэнцвэр хадгалан бие даан зогсоно. Аалзны зураг гаргахад хөл гарыг ээлжлэн хөдөлгөх хөдөлгөөн гэх мэтээр тоглоомыг үргэлжлүүлнэ. Тоглоомын үед бие биеэ ажиглаж хөдөлгөөнийг хийж дуусгаад уртаар амьсгаа авч тайвшрах дасгалыг хийнэ.

Үйл ажиллагаа 2. Тэнцвэрээ хадгалъя тоглоом (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Зурагт үзүүлэн (хүүхдийн иог)

Аргачлал: Тэнцвэр хадгалах дасгал хийнэ. Завь, нохой, мод, эрвээхэй гэх мэт. Хараацай зогсолтыг хэн удаан хийж чадах вэ? тоглоом тоглоно.

ААЛЗ ЮУГААР ХООЛЛОДОГ ВЭ?

Шинэ үг: Шавж

Үйл ажиллагаа 1. Юугаар хооллодог вэ? (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн:

Аргачлал: Аалз юугаар хооллодог тухай асуудал дэвшүүлэн ярилцана. Хүүхдүүд таамаглалаа хэлнэ. Аалз шавжаар хооллож буй бичлэгийг үзнэ.

Багшийн чиглүүлэх асуулт

- Аалз юугаар хооллодог вэ?
- Аалзны торонд наалдвал юу болох тухай үргэлжлүүлнэ.

Үйл ажиллагаа 2. Наалдамхай тор (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Аалз болон ялааны баг, утас

Аргачлал: Хүүхдүүд 2 хэсэг болон багт хуваагдана. 1-р хэсгийн хүүхдүүд аалз болно. 2-р хэсгийн хүүхдүүд ялаа болно. Чиглүүлэгч хүүхэд болон багш дүрмийг танилцуулна. Ангид аалзны торыг байрлуулаад хөгжим эхлэхэд хүүхдүүд торон дээгүүр явна. Хөгжмийн ая зогсоход торонд үлдсэн хүүхдүүд хасагдана. Тоглоомыг үргэлжлүүлэн хамгийн сүүлд үлдсэн оролцогч ялагч болно.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 100, дасгал №100](#)

Үйл ажиллагаа 3. Аалзны тор усанд норох уу? (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Ус хийхэд тохиромжтой жижиг сав, ус шүршигч сав, аалзны тор (цавуу, утсаар хийж болно), жижиг хиймэл аалз, томруулдаг шил

Аргачлал: Хүүхдүүдэд аалзны зураг үзүүлж, “Аалзны тор бороо орвол норох уу?” таамаглал дэвшүүлж ярилцана. Хүүхдүүдийн тусламжтайгаар жижиг саванд хиймэл тор байрлуулна. Шүршигчээр ус цацаж, юу болохыг ажиглана. Зарим хэсэгт ус бөмбөлөг үүсэж, бусад хэсэгт урсаж буйг харуулна. Томруулдаг шилээр харж, Ус аалзны торон дээр ус тогтдог уу?, Аалз бороонд норохгүй байхын тулд юу хийдэг бол? гэж асууж ярилцана. Хүүхдүүдийн хариултыг нэгтгэж “Аалзны тор” ус нэвтрүүлэхгүй, наалдамхай бүтэцтэй байдаг тул шавж барихад тусалдаг” гэж дүгнэнэ. Бид бороотой үед яаж хамгаалдаг вэ? хүүхдүүд өөрийн үйлдлийг хэлж холбож ярилцана.

ААЛЗ БИДЭНД ТУС БОЛДОГ УУ?

Шинэ үг: Байгаль, дэлхий

Үйл ажиллагаа 1: Аалзны ач тус (Тойргийн цаг)

Хэрэглэгдэхүүн:

Аргачлал: Өмнөх үзсэн мэдлэг дээр тулгуурлан дүгнэлт ярилцлага хийнэ. Аалз шавжийг байгаль дэлхий ургамлыг хамгаалж байгаа тухай танилцуулна.

Багшийн чиглүүлэх асуулт

- Аалз шавжийг яагаад барьсан бэ?
- Аалз байхгүй байсан бол юу болох байсан бэ?
- Байгаль хамгаалагч гэж хэнийг хэлэх вэ?

Үйл ажиллагаа 2: Амьтад бүтээгээрэй (Төвийн үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: <https://www.facebook.com/reel/1352446466501603>

Хэл яриа-номын төв: Амьтдын хоол тэжээлийг зөв холбож харгалзуулж наах дасгалыг хийнэ.

Зураг урлал төв: Уян утас ашиглан хөдөлгөөнт тоглоом бүтээнэ. Их биеийг хайчлан хөлийн тоогоор цоолбор хийж, цоолсон нүхэнд уян утсыг бэхэлнэ. Нүд их биеийг зохиомжлон чимэглэнэ.

Тоглоомын төв: Блок тоглоом ашиглан амьтад хийж бүтээнэ. Өнгийг зохиомжлон угсарна. Ямар амьтан бүтээснээ тайлбарлана.

[Дасгал ажлын дэвтэр хуудас 94, дасгал №94](#)

Дасгал ажлын дэвтэр хуудас 95 дасгал №95

Үйл ажиллагаа 3: Бид юу мэдэж авсан бэ? (Хөгжөөн баясах цаг)

Хэрэглэгдэхүүн: Мэдээллийн самбар, ажлын хуудас

Аргачлал: Хүүхдүүд мэдээллийн самбарт байрлуулсан зураг тэмдэглэсэн ажлын хуудсыг нэгтгэн санаагаа илэрхийлнэ.

- Аалзыг судлахад юу хамгийн сонирхолтой санагдсан бэ?
- Аалз байхгүй бол шавжийн тоо нэмэгдэх үү?
- Байгаль хамгаалахын тулд бид юу хийх хэрэгтэй болохыг ярилцана.

ХАМТДАА ХӨГЖИЛДӨӨРЭЙ



Шинэ үг: Хөгжимдөх, цавуулаг

Үйл ажиллагаа 1. Алаг эрээн аалз (Чиглүүлэгтэй тоглоом, үйл ажиллагаа)

Хэрэглэгдэхүүн: Аалзны жижиг тоглоом эсвэл хурууны хүүхэлдэй, дууны хоолойгүй бичлэг <https://www.youtube.com/watch?v=wEluh6pY6BE> ,

Аргачлал: Багш хүүхдүүдэд аалзны тоглоом үзүүлээд асууна. Аалз борооны дараа юу хийдэг гэж бодож байна вэ? Хүүхдүүдийн хариултыг сонсоно. Багш дууны бичлэгийг нэг удаа тоглуулж өгнө. Юу сонсов? гэж асууж, аалз, бороо, нарны үгийг онцолж хэлнэ. Багш мөр бүрийг хөдөлгөөнөөр харуулж, хүүхдүүдийг хамтран хийнэ.

Үйл ажиллагаа 2. Хөгжилтэй аялгуу (Хөгжөөн баясах ажил)

Хэрэглэгдэхүүн: Дууны ая <https://www.youtube.com/watch?v=wEluh6pY6BE>

эгшигт хонх, төмөр царгил



Аргачлал: Бичлэгийг үзээд хэрхэн тоглож байгааг ажиглаад ярилцаарай. Өөрийн дүрмийг хөгжмийн зэмсгээ сонгон аваарай. Хэмнэлд тохируулан тохирох өнгийг цохиж дууны аялгууг тоглоорой. Найзуудтайгаа хамтарч тоглоорой.

Сонсьё, дэмжье.

- Хүүхдэд зурган болон бичлэг хэлбэрээр үзүүлэх боломжийг олгоорой. Амьтнаас айж байгаа хүүхдийг тайвшруулах, дасгалыг хийлгэнэ.

Эцэг эхтэйгээ хамтаръя

- Бусдыг энэрч хайрлах, зөрчилдөөнийг эергээр шийдвэрлэх тухай ном уншиж, учир шалтгааныг тайлбарлаж ярилцах
- Хүүхдийнхээ хийж буй үйл, орчны аюултай зүйлээс болгоомжлох, олон нийтийн газарт байрлах тэмдэг тэмдэглэгээ, дүрмийг хэрхэн мөрддөг талаар багшид мэдээлэл өгөх, зөвлөгөө авах, хамтран ажиллах

Багшийн эргэцүүлэмж

Эргэцүүлэл /өөрийн амжилттай болон сул хэрэгжүүлсэн, цаашид сайжруулах зүйлсээ бичнэ./

Амжилттай хэрэгжүүлсэн:

Сул хэрэгжүүлсэн:

Цаашид сайжруулах:

Дараагийн 2 долоо хоногт төлөвлөх суралцахуйн үр дүн ба үйл ажиллагаа:

